

Бурхан Чайтаньягийн сургаал

Шри Шримад А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада
Олон улсын Кришнагийн ухамсрын нийгэмлэгийг үнэдслэгч - āchārya

1896 онд буюу миний төрсөн жил Барууны орнуудад(Мак Гиллийн Их сургууль, Канад) Шрї Чāитанья Махāпрабхугийн сургаал номлолын эхлэлийг тавьсан ШРИЛА САЧЧИДĀНАНДА БХАКТИВИНОДА ТХĀКУР танаа цэвэр ариунаар үйлчлэн зүтгэхүйд ЗОРИУЛВАЙ.

А.Ч.БХАКТИВЕДАНТА СВАМИ

Индира Ганди Шрї Чайтаньяд хүндэтгэл
үзүүлэв.

*Ерөнхий сайд орчин үеийн нийгмийн бэрхшээлт асуудлуудыг шийдвэрлэхэд
бхакти буюу бурханлаг амьдрал зайлиггүй чухлыг цохон тэмдэглэв.*

НЬЮ-ДЕЛИ – 1983. Индира Ганди Шрї Чāитанья Махāпрабхугийн заларсны 500 жилийн ойд зориулсан баяр ёслолын арга хэмжээнд оролцлоо. Тэрээр энэхүү ёслолын үйл ажиллагааг Шрї Чāитанья Махāпрабхугийн өндөртэй тэнцэхээр зурсан хөргөнд цэцгийн эрхи болон зул өргөснөөр нээв. Үүний дараа Чайтанья Махāпрабхуд зориулан тэрээр үг хэллээ.

Шрї Чāитанья Махāпрабху Панч-Шати Самитигийн(Чāитанья Махāпрабхугийн 500 жилийн ойд зориулсан баяр ёслолыг зохион байгуулах түүхт ойн албан ёсны комисс) удирдагч, Парламентын гишүүн, доктор Карана Сингхийн шууд удирдлаган дор зохион байгуулагдсан энэхүү баяр ёслол дээр Дели хотын олон оршин суугчид ирсэн байлаа.

Д-р Сингх өөрийн өмнөтгөл үгэндээ Энэтхэгт хайрын ба чин бишрэлийн уур амьсгалыг бүрдүүлэхийн чухлыг онцлон тэмдэглээд Шрї Чāитанья Махāпрабху хэрэгцээ шаардлага гарагсадад хэрхэн туслаж байсан тухай жишээ татав. Тэрээр Энэтхэгийн сая сая иргэд Шрї Чāитаньяг Кршṇагийн хувилгаан гэдгийг хүлээн зөвшөөрдөг тухай тэмдэглэн хэлээд Чайтаньягийн амьдралаас хэд хэдэн түүхийг

ярилаа. Үүний дараагаар ерөнхий сайд Индира Ганди хуран цугласан олонд хандаж нэн чухал үг хэлэв:

“... Би *бхакти* буюу Бурханыг хайрлах хайрыг хүмүүсээс булаан авч болно гэдэгт огтхон ч итгэдэггүй. *Бхакти* хэзээ ч устаж үгүй болохгүй. *Бхакти нь* бид ямар байр сууринд оршин буйгаас үл хамаарч мөнхөд оршин байх ёстой юм. Би дэлхийн Конгресс дээр нэгэнтээ хэлсэн үгээ энэ орны бүх хүмүүст хандаж энд хэлэхийг хүсэж байна: амьдралыг хязгаарлаж болохгүй. Бүгдийг энэ нь шинжлэх ухаан, энэ нь шашин, энэ нь боловсрол гэх мэтээр ангилан хуваах хэрэггүй. Хэрэв бид амьдралын хуваагдашгүйн тухай хүлээн зөвшөөрөхгүй бол бид муу үйлийг хийчихээд сүмд очих, эсвэл Гангын усанд угаал үйлдчихнэ, тэгээд л үр дагавар нь үгүй болчихно доо хэмээн боддог хуучны хоцрогдсон төсөөллийнхөө зууш болно”. Бидний үйлийн үр дагавар тасралтгүйгээр биднийг дагаж байдаг гэж би үздэг. Бид цаг үргэлж бидний явж буй зам зөв үү буруу юу, бидний гаргасан шийдвэр зөв үү буруу юу гэж бодож байх ёстой...

Ямар үгээр Шри Чaitанйаг дүрсэлж болох тухай би бодож байна л даа. .. Манай эх орон дэлхий нийтэд олон олон ариун гэгээнтнүүдээ хайрласан. Тэдний заримыг нь бид өөрсдийн тэнэг мунхагийн улмаас муутган гутаасан. Хэдэд нь багагүй хувь хүртээж, хэдийг нь муучлан, доромжилж, бид тэдний сурган үлдээснийг нухацтайгаар хүлээн авсан эсэхийг үл мэдэн хэд нь явж одсон. Гэвч энэ бүхэн тэдний оролдлого чармайлтыг зогсоогоогүй. Зөвхөн өчүүхэн хүмүүсийг л сүрдүүлэлт, доромжлолоор айлгаж болох ч өөрийн үүрэг хариуцлагын чухлыг ухамсарласан хүмүүс нь дэлхий ертөнцийн зүгээс тэдэнд учруулж буй ямар ч зовлон зүдгүүрээс хүч сэлбэж авдаг. Тэдний бие махбодид хор хохирол учруулж болох, бүр алж устгаж болох ч харин тэдний үзэл бодол, үүрэг зорилгыг устгаж хэзээ ч чадахгүй юм.

Шри Чaitанйа хэзээ ч тийм нөхцөл байдалд орж байгаагүй. Түүний үзэл санааг шууд л хүлээж авч байсан юм. Энэтхэгчүүд бид өөрсдийгөө бурханлаг үндэстэн хэмээн тооцдог ч үнэндээ бол бид бусад ард түмнээс тийм ч илүү шударга бусаа. Мөнгөнд шунах шунал болон өөр бусад шунал хүслүүд ямар ч өөр бусад орны хүмүүст байдаг шиг энэтхэгчүүдэд ч мөн бий. Гэвч биднийг бусад ард түмнээс ялгаруулах бас бус юм байдаг. Энэ ялгаа нь юу вэ гэхээр бидний шашныг хүндэтгэх хүндлэлд оршдог. Түүнийг өдөр тутмынхаа амьдралд мөрдлөг болгодоггүй байсан ч. Бид дээд идеалын өмнө мөргөн залбирдаг. Материаллаг амьдралаас огоорон хөндийрч, бурханлаг эрэл хайгуулд өөрийгөө зориулан даатгасан, эгэл амьдралд дур сонирхол нь үгүй болсон ариун гэгээд нь манай ард түмний дунд хүндэтгэлийг олсон байдаг. Ялангуяа ядуу хүмүүсийн дунд. Энэ нь *бхакти* манай нутаг оронд оршин байх нэг шалтгаан юм.

Энэ мэт бурханлаг уулзалтын утга учир нь, чухам ямар байдлаар *бхактиг* практик байдлаар хүлээж авах вэ, ямар байдлаар тэрээр хүн бүрийн зүрхэнд нэвтрэн ордог болохыг тодорхойлохын тулд оршино. Чухамхүү ийм учраас би өнөөдрийн баяр ёслолд мөн оролцож буй юм. Миний энд байх болон эс байх нь хүмүүсийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхгүй. Гэвч би орчин үеийн дэлхий ертөнц нь ямар ч материаллаг тав тухтай байдал, материаллаг хөгжил дэвшлээр тайлж болдоггүй өлсгөлөн ба тэсч ядсан хүслийнхээ улмаас зовж шаналан буй юм шүү гэдэг өөрийн хатуу итгэл үнэмшлийг илтгэхийг хүссэн юм. (...)

Энд бид мөргөн залбирч, адис авахын тулд толгой гудайн зогсох гэж цугласан. Мөнхийн гэрэл гэгээ бидэнд огоорлыг хайрлаж, биднийг аугаа үндэстэн болгоно. Бид ядуурал гуйланчлал үгүй болохыг үнэн сэтгэлээсээ хүсч байна. Түүнтэй хамт баян хоосны ялгаа алга болж мөн өөр бусад бидний амьдралын элдэв асуудлууд үгүй болно. Гэвч үүний зэрэгцээ бид дээд идеал буюу бурханлаг үнэт зүйлс нь хавьгүй илүү чухал гэдгийг ямагт санаж байх ёстой. Зөвхөн тэр цаг мөчид л бид өөрсдийн үүргээ биелүүлж чадах болно”.

Өмнөх үг

Энд толилуулан буй Бурхан Чайтаньягийн сургаал ба Бхагавад-гита дахь Бурхан Крш᳚агийн сургаал хоёрын хооронд ямар ч ялгаа үгүй. Бурхан Чайтаньягийн сургаал бол Бурхан Крш᳚агийн сургаалын практик хэлбэр юм. Бхагавад-гита дахь Бурхан Крш᳚агийн эцсийн сургаал зөвлөгөө нь хүн бүр Түүнд буюу Бурхан Крш᳚ад өөрийгөө даатгах ёстой гэдэгт оршино. Түүнд өөрийгөө даатгасан сүнсийг шууд халамжлан анхаарах үүргийг Өөртөө авна хэмээн Крш᳚а амлаж байна. Бүтээлийг тогтоон барих үүргийг Тэрээр Өөрийн бүрэн илрэл К᳚и́родакашāйй Ви᳚᳚угаар дамжуулан гүйцэтгэдэг ч Тэрээр үүнийг шууд Өөрөө гүйцэтгэдэггүй. Харин Бурхан Өөрийн цэвэр чин бишрэлтэндээ санаа тавих тухай өгүүлж байгаа нөхцөлд Тэрээр түүнд санаа тавих ажлыг үнэхээр шууд Өөр дээрээ авдаг. Цэвэр чин бишрэлтэн гэдэг нь бүхнийг цаг ямагт Бурханд найдан даатгасан тэр сүнс юм. Энэ нь яг л жаахан хүүхэд бүгдийг эцэг эхдээ даатгадаг шиг, адгуус амьтад эзэндээ бүхнийг даатган орхидог шиг л зүйл. Түүний таалалд нийцүүлэн өөрийгөө даатгах процесст дараахь зүйлүүд ордог: (1) чин бишрэлийн алба үйлийг гүйцэтгэхэд тааламжтай бүхнийг хүлээн авах, (2) чин бишрэлийн үйлэнд таагүй бүхнээс зайлсхийх, (3) Бурханы хамгаалалтанд хатуу итгэх, (4) Бурханы өршөөлөөс өөрийгөө бүрэн хамааралтай болохыг мэдрэх, (5) Бурханы сонирхолтой үл нийцэхүйц ямар нэг сонирхол үгүй байх, (6) үргэлжид өөрийгөө төлөв, даруу, хүлцэнгүй байгааг мэдрэх.

Эдгээр зургаан дүрэм журмыг биелүүлж, хүн өөрийгөө Түүнд даатгахыг Бурхан шаарддаг. Гэвч оюун ухаан үгүй энэ ертөнцийн эрдэмтэд хэмээн нэрлэгдэгчид

эдгээр шаардлагыг буруугаар ойлгож олонхи хүмүүсийг эдгээрийг хүлээж авахгүй байхыг итгүүлж үнэмшүүлдэг. Бхагавад-гитагийн есдүгээр бүлгийг дүгнэлт болгож Бурхан Кршṇа: “Үргэлжид Миний тухай бод, Миний өмнө сөгдөн Надад хүндэтгэлээ илэрхийл, Надад мөргөн залбирагтун. Тийнхүү Надад бүрнээ автсанаар чи эргэлзээгүйгээр Над руу ирмүй”. (Бг. 9.34) хэмээн шуудхан айлдсан байна. Гэвч боловсрол бүхий демонууд нь ихэнхи хүмүүсийг төөрүүлж будилуулан, тэднийг Бурханы Бодгаль тийш бус бодгаль бус, илрээгүй, мөнхийн төрөөгүй үнэн тийш хөтөлдөг. Гүн ухаантан имперсоналистууд буюу майāvādī нар нь Туйлын Үнэний дээд хэлбэр нь Бурханы Дээд Бодгаль гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Нарыг бүрэн бүтнээр нь танин мэдэхийг хүссэн хүн нь эхлээд нарын гэрэл дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй ба дараа нь нар хэмээх гариг дээр дараа нь нарыг ноёлогч сахиулсан тэнгэртэй нүүр нүүрээрээ учрах хэрэгтэй. Өөрсдийн хомсхон мэдлэгийн харгайгаар гүн ухаантан-майāvādīгууд нь нарны гэрэлтэй зүйрлүүлж болох Брахманы цацраг туяанаас цааш нэвтэрч чадахгүй. *Упанишад*ууд батлахдаа, хүн Брахманы нүд сохлом энэ гэрэл туяаг нэвтрэн гарах ёстой гэжээ. Зөвхөн үүний дараагаар тэрээр Бурханы Бодгалийн жинхэнэ нүүр царайг харж чадна.

Ийм учраас Бурхан Чайтанья Вражийн хааны өргөмөл хүү болон заларсан Бурхан Кршṇад шууд мөргөн залбирахыг сурган номложээ. Мөн тэрээр чухамдаа Бурхан Кршṇа Өөрөө бөгөөд Врндāван гэж нэрлэгдэх газар нутаг тийш бидний санаа бодлыг хөтөлж байна. Учир нь Бурхан Кршṇагийн нэр, чанар, дүр хэлбэр, тоглоом наадам, хүрээлэл, гол шинж зэрэг нь Бурхан Кршṇагаас Өөрөөс нь ямарч ялгаагүй юм. Энэ нь Туйлын Үнэний туйлын мөн чанар бөлгөө.

Бурхан Чайтанья мөн дээд төгс төгөлдрийн түвшин дэхь мөргөлийн дээд хэлбэр болох Вражийн бүсгүйчүүдийн замнаж асан тэрхүү аргыг санал болгожээ. Эдгээр бүсгүйчүүд(*гопī* буюу малчин бүсгүйчүүд) нь Кршṇаг зүгээр л ямар нэг материаллаг болон бурханлаг ашиг хонжоо олж хожих хүсэлгүйгээр үнэн зүрхнээсээ хайрлаж байсан юм. Түүнчлэн Чайтанья трансцендент мэдлэгийг агуулсан *Шрīмад-Бхāгаватамын* тухай өө сэвгүй хүүрнэл хэмээн өгүүлээд хүний амьдралын дээд зорилго бол Дээд Бурханы Бодгаль, Кршṇаг хайрлах цэвэр хайранд хүрэх явдал хэмээн онцлон тэмдэглэжээ.

Бурхан Чайтаньягийн сургаал нь *сāṅкхйа-йог* буюу *санкхйан* гүн ухааныг системийг өгүүлсэн нэгдүгээр Бурхан Капилагийн айлдсан сургаалаас огтхон ч ялгаа үгүй. Энэхүү нэр хүнд бүхий *йогийн* систем нь Бурханы трансцендент дүр хэлбэр дээр бясалгахыг зөвлөсөн байдаг. Хий хоосон буюу бодгаль бус зүйл дээр бясалгах тухай ганц ч үг үгүй. Бурхан Вицṇугийн трансцендент дүр хэлбэр дээр бүр тусгай тогтсон суултыг/асана/ үйлдэлгүйгээр бясалгаж болдог. Энэ бясалгалыг төгс төгөлдөр *самāдхи* гэдэг. Энэ төгс төгөлдөр *самāдхийн* жинхэнэ бодитойн тухай *Бхагавад-гитагийн* зургаадугаар бүлгийн төгсгөлд Бурхан Кршṇа: “Бүхий л *йогчид* дотроос асар их итгэл бишрэлтэйгээр үргэлжид Надад оршин байж,

трансцендент хайраар үйлчлэн зүтгэн Надад мөргөх, *йогт* оршин бүхнээрээ Надтай бат бөхөөр холбогдсон тэр *йогч* бусдаасаа илүүтэй билээ” хэмээн өгүүлжээ. (Бг.6.47).

Бурхан Чаитанья хүмүүст *санкхьян* гүн ухааныг *ачинтия-бхедāбхеда-таттва* хэлбэрээр сурган таниулжээ. Тэр нь Дээд Бурхан Өөрийн бүтээлтэй нэгдмэл боловч үүний хамт нэгэн цаг хугацаанд ялгаатай гэж баталдаг. Бурхан Чаитанья энэ гүн ухаанаа Бурханы ариун нэрсийг дуулах ба давтан унших байдлаар сурган номлосон юм. Тэрээр Бурханы ариун гэгээн нэр нь Бурханы авианд хувирсан хувилгаан бөгөөд Бурхан нь туйлын бүрэн бүтэн тул Түүний нэр алдар Түүний трансцендент дүр хоёрын хооронд ялгаа үгүй хэмээн сургажээ. Тийнхүү хүн Бурханы ариун нэрийг давтан уншихын тусламжтайгаар авиан чичиргээгээр дамжуулан Дээд Бурхантай шууд харьцаж болно. Энэ авиан чичирхийллээр хичээллэгч нь хөгжлийн гурван үе шатыг дамжин өнгөрдөг: алдас эндлийн үе, ариусахуй үе, трансцендент түвшин. Алдсын түвшинд хүн материаллаг аз жаргалыг хүсэх бүх төрлийн хүсэл нь хадгалагдан үлдсэн байдаг. Харин хоёр дахь шатанд хүрснээр тэрээр материаллаг бохирдол бузардлаасаа ангижирдаг ба трансцендент түвшинд хүрснээр хүн өөрийн хүсч байсан байр суурь болох Бурханыг хайрлах хайрын түвшинд хүрдэг. Энэ нь хүний хүрч болох төгс төгөлдрийн хамгийн дээд шат юм хэмээн Бурхан Чаитанья сургажээ.

Йогийн практик нь мөн чанартаа мэдрэхүйг хянахад зориулагдсан байдаг. Мэдрэхүйг хянах үүргийг гүйцэтгэдэг үндсэн хүчин зүйл нь ухаан юм. Иймээс юуны өмнө түүнийг Крш᳚агийн ухамсарт төвлөрүүлэн ухаанаа хянахыг оролдох нь чухал. Ухааны бүдүүлэг хэлбэрийн үйл нь мэдрэхүйн гадаад байдлаар илэрдэг. Тэр нь нэг бол мэдлэг олж авах юмуу эсвэл хүний хүсэлтэй тохирсон мэдрэхүйн үйлдлээр илэрдэг. Ухааны нарийн үйл нь эргэцүүлэн бодох, мэдрэх, хүсэх зэрэг юм. Хүн бохир, цэвэр байх нь түүний ухамсраас хамаардаг. Хэрэв хүний ухаан нь Крш᳚а дээр (Түүний нэр, шинж чанар, дүр хэлбэр, тоглоом наадам, хүрээлэл, үндсэн чанарууд) төвлөрөн байвал түүний хийсэн бүх зүйл, тэр нь нарийн байдлаар эсвэл бүдүүлэг байдлаар хийгдэх зэргээс үл хамаарч, сайн сайхан болдог. *Бхагавад-гитад* сурган номлосон ухамсрыг ариусгах аргачлал нь ухаанаа Түүний трансцендент үйлийг хэлэлцэх дээр төвлөрүүлэхийн тусламжтайгаар, мөн Түүний сүмийг угааж цэвэрлэх, Түүний сүмд очих, ёс горимоор нь чимэглэн гоёсон Бурханы трансцендент дүр хэлбэрийг толидон харах, Түүний трансцендент алдар сууг сонсох, Түүнд өргөсөн хоол хүнсийг хүртэх, Түүний чин бишрэлтэнтэй харьцах, Түүнд өргөсөн цэцэг болон *туласийн* навчийг үнэрлэх, Бурханы төлөө үйлдэж буй үйлэнд оролцох гэх мэт дээр төвлөрөх процесс юм. Ухаан болон мэдрэхүйн үйлийг хэн ч таслан зогсоож чадахгүй ч энэ үйлийг харин ухамсраа өөрчилснөөр ариусган цэвэрлэж болно. Энэ өөрчлөлтийн тухай *Бхагавад-гитад* заан өгсөн байдаг. Крш᳚а Аржунад йогийн мэдлэгийн тухай өгүүлж, түүний туслалцаатайгаар хүн кармын үр дагаваргүйгээр үйлдэж болох тухай тайлбарлан хэлж өгсөн. “Ай Пртхийн хүү минь ээ, чиний үйлдэл тийм оюун ухаанаар тодорхойлогдож байгаа цагт чи үйлийн боолчлолоос ангижирч чадна”. (Бг.2.39). Өвчин болон өөр бусад тодорхой нөхцөл байдал нь заримдаа хүний мэдрэхүйн

цэнгэлийг хязгаарладаг. Гэвч энэ нь *Бхагавад-гита*д заасан тэр зүйл биш юм. Өөрийн ухаан ба мэдрэхүйгээ удирдаж чадах жинхэнэ аргачлалыг мэдэхгүйгээр тийм ч их ухаалаг бус хүмүүс нь ухаан ба мэдрэхүйн үйлийг нэг бол хүчээр таслан зогсоохыг оролдож байхад нэг бол түүнд ялагдаж мэдрэхүйн цэнгэлийн давалгаанд автагддаг.

Зохицуулах зарчмууд, йогийн дасгалууд, янз бүрийн суултууд, мэдрэхүйг мэдрэхүйн объектоос салган хөндийрүүлэхийн тулд гүйцэтгэдэг амьсгалын дасгалууд нь бие махбодийн үзэл төсөөлөлд хэт их автагсдад зориулагдсан байдаг. Крш᳚агийн ухамсарт оршигч оюун ухаант хүн нь мэдрэхүйг үйлээс хүчээр хөндийрүүлэн барьж байхыг чармайдаггүй. Харин ч эсрэгээр тэрээр өөрийн мэдрэхүйгээ Крш᳚ад үйлчлэн зүтгэхүйд чиглүүлдэг. Жаахан хүүхдийн дүрсгүй занг түүнийг үйл үл хийлгэн хориглон барьж болдоггүй ч хэрэв түүний үйлийг дээд хэлбэрийн үйлэнд хандуулваас түүний дүрсгүй байдлыг хялбархан тогтоон барьж болно. Мэдрэхүйн үйлийг йогийн найман зарчмаар хүчээр хориглон барих нь хөгжлийн доод шатанд буй хүмүүст тохиромжтой. Илүү өндөр түвшний хүмүүс нь Крш᳚агийн ухамсарт дээд түвшний үйлийг үйлдэн энгийн байдлаар доод түвшний материаллаг үйлээс холдон хөндийрдөг.

Ингэж Бурхан Чаитанья Крш᳚агийн ухамсрын эрдэм ухааныг заан номлосон билээ. Энэ туйлын эрдэм ухаан юм. Ухааны хоосон хуурай гүн ухааны цэцэрхийллээр хөөцөлдөгч хүмүүс нь материаллаг уягдал татагдлаас ангижрахыг оролдож байдаг ч ихэвчлэн энэ үед тэдний ухаан тэднийг өөрсдийг нь удирдахуйц хүчтэй ба тэрээр хүнийг мэдрэхүйн үйл рүү дахин татан оруулдаг болох нь тэдэнд тодорхой болно. Харин Крш᳚агийн ухамсарт оршигч хүнд ийм аюул тулгардаггүй. Өөрийн ухаан ба мэдрэхүйгээ Крш᳚агийн ухамсарт автуулах хэрэгтэй ба Бурхан Чаитанья үүнийг практик амьдрал дээр хэрхэн гүйцэтгэхийг сургасан.

Санниāси болохоосоо өмнө Бурхан Чаитанья Вишвамбхара хэмээх нэртэй байв. *Вишвамбхара* гэдэг үг нь бүх орлонг тогтоон барьж байдаг, тэтгэн хадгалж байдаг, бүхий л амьд оршнолуудыг тэргүүлэгчийг заадаг. Энэхүү тэтгэн хадгалагч, бүх амьд оршнолуудын удирдагч нь хүн төрөлхтөнд энэхүү дэвшилтэт сургаалаа хайрлахаар Бурхан Шри Крш᳚а Чаитанья дүрээр заларчээ. Бурхан Чаитанья нь хүмүүнд эн тэргүүнд хэрэгтэй үлгэр жишээ номын багш юм. Тэрээр бүгдэд Крш᳚аг хайрлах хайрыг өгөөмрөөр хүртээж байдаг. Тэрээр бүхий л сайн сайхныг хайрлагч ба аз хийморийн цогц юм. *Шри᳚мад-Бхāгаватам*, *Бхагавад-гитā*, *Махāбхāрата*, *Упани᳚адуудад* батлан айлдсанаар Тэрээр Дээд Бурханы Бодгаль буюу Кришна Өөрөө ба Тэрээр энэхүү олон янзын үзэл бодлын энэ эрин дэхь хүн бүрийн мөргөлийн объект гэжээ. Ямар ч хүн Түүний *санкīртаны* хөдөлгөөнд нэгдэж болно. Үүний тулд ямар нэг онцгой шинж чанаруудтай байх шаардлагагүй. Зүгээр л Түүний сургаалтай нийцэхүйц үйлийг үйлдсэнээр хүн бүр төгс төгөлдөр нэгэн болж болно. Түүний чанарт дур татагдах хангалттай аз хийморьтой хүн гарцаагүй амжилтанд хүрэх ба өөрийн амьдралын үүрэг зорилгоо биелүүлнэ. Өөрөөр хэлбэл Бурхан Чаитаньягийн өршөөлөөр бурханлаг амьдралыг олж авахыг хүссэн хүн бүр

маш хялбараар *майагийн* савраас мултарч чадна. Энэхүү номонд өргөн барьж буй сургаал нь Бурханаас Өөрөөс нь ялгаа үгүй юм.

Материаллаг бие махбодид автан шингэсэн болзолт сүнс нь олон төрлийн материаллаг үйлийн шинэ шинэ түүхийн хуудсуудыг бичсээр байдаг. Бурхан Чаитанягийн сургаал нь энэхүү үр ашиггүй, хэврэгхэн үйлийг таслан зогсоож хүний нийгэмд жинхэнээсээ туслаж чадна. Бурханлаг үйл нь чухамдаа материаллаг боолчлолоос ангижирсны дараагаар эхэлдэг. Кршңагийн ухамсрын энэ чөлөөт үйл нь хүний төгс төгөлдөрийн зорилгыг бүрдүүлдэг. Хүн өөрийн дэмий хоосон оролдлогоор материаллаг байгалийг ноёрхохоор санаархсан хуурмаг алдар хүнд нь цаг зуурын юм . Бурхан Чаитанягийн сургаалаас гэрэл гэгээг тээн авчрах мэдлэгийг олж хүртэж болох ба энэ мэдлэгийн туслалцаатайгаар бурханлаг амьдралдаа төгөлдөржиж болно.

Ямартай ч өөрийн үйлийн үрээс хамаарч цэнгэн жаргах эсвэл зовж зүдрэх хэрэгтэй; хэн ч түүнийг удирдан байдаг материаллаг байгалийн хуулиудыг сөрөн зогсож чадахгүй. Хүн кармын үйлэнд автан байсан цагт түүний амьдралын эцсийн зорилгод хүрэхээр тэмүүлж чармайн буй оролдлого нь нуран унах нь гарцаагүй юм. Бурхан Чаитанягийн сургаалыг ойлгосноор хүний нийгэм нь бурханлаг амьдралын шинэ туршилгыг олж авах ба тэр туршлага нь тэдний өмнө цэвэр сүнсний үйлийн талбарыг нээн өгнө гэдэгт би үнэн сэтгэлээсээ найдаж байна.

ом тат сат

А.Ч.Бхактиведанта Свами

1968 оны гуравдугаар сарын 14.
Бурхан Чаитанягийн заларсан өдөр.
Шрї-Шрї-Радхā- Кршңагийн сүм
Нью-Йорк.

Эхлэл

Бхактивинода Тхāкур

/Энэхүү найруулал нь анх удаа Шрїла Бхактивинода Тхāкурын “Шри Чаитанья Махāпрабху: Түүний амьдрал ба сургаал” нэртэй багахан бүтээл байдлаар гарч байжээ.(1896 оны наймдугаар сарын 20)/

Чаитанья Махāпрабху нь Христийн тооллоор 1486 оны хоёрдугаар сарын 18-нд буюу Шакабда календариар 1407 онд Пхāлгуна сарын 23ны орой нар жаргасны яг дараа Надий хотод Майāпурт төржээ. Түүнийг төрөх үед сар хиртэж байсан ба

Надийн оршин суугчид ийм тохиолдол бүрд үйлддэг заншлаараа “Харибол” хэмээн чангаар хашгирч орчны агаарыг доргион, Бхāгйратхй голын уснаа угаал үйлдэж байв. Түүний эцэг, ведийн нийгмийн ядуу *брāхман*, Жаганнāтха Мишра, Түүний эх буянлаг эмэгтэйчүүдийн хэв загвар болсон Шачй-девй хоёр хоёулаа Сйлхет тойргоос гаралтай брахманы ураг төрөлд хамаардаг байжээ. Түүний ээжийн эцэг нэр алдарт зурхайч Паңдит Нйлāмабара Чакравартй жаахан хүүг өөрийнхөө цаг үед аугаа хүн болно гэж зөгнөн хэлж байв. Иймээс ч тэрээр түүнд Вишвамбхара гэдэг нэрийг өгчээ. Хөрш зэргэлдээ амьдардаг эмэгтэйчүүд түүний арьсны өнгө нь алтлаг учраас Гаурахари гэж нэрлэдэг байсан ба харин ээж нь Түүнийг ойролцоохон нь төрсөн *нимба* модыг бодож Нимāи хэмээн нэрлэсэн байна. Жаал хүү маш үзэсгэлэнтэй байсан учраас хүмүүс Түүнийг хараад хараад ханадаггүй байв. Өсч том болсоор Тэрээр өөрийн дур зоргоор, цовоо сэргэлэн нэгэн болж хувирав. Таван нас өнгөрмөгцөө *пāтхашāлд* явах болж тэнд тэрээр богино хугацаанд бенгали хэлийг сурчээ.

Түүний намтрыг өгүүлэгч-нэгэн үеийнхэн нь Түүний амьдралын нэг тохиолдол үйл явдлыг бүгд дурсан өгүүлсэн байдаг. Энэ нь мөн чанартаа түүний гайхамшгуудын анхных нь байсан юм. Түүнийг бүр хөхүүл жаахан байхад тасралтгүй уйлах үед хөрш бүсгүйчүүд нь “Харибол!” хэмээн хашгирахуйд тэрээр тэр дорхноо уйлахаа больдог байсан гэж ярьцгаадаг. Ийм учраас түүний эцэг эхийн гэрт манай баатрын ирээдүйн үүрэг даалгаврыг зөгнөн “Харибол” хэмээх уухайлал байнгад сонсогддог байв. Зарим нэг нь ийм түүхийг ярьцгаадаг. Мөн нэгэн удаа ээж нь түүнд чихэр өгчээ. Харин тэрээр түүнийн идэхийн оронд шавар идсэн байна. Ээж нь түүнээс чухам яагаад ингэж буйг нь асуухад тэрээр чихэр гэдэг бол өөр төлөвт хувирсан шавар л юм. Тийм болохоор шавар идэж болно гэж тайлбарлажээ. Гэвч ээж нь мөн *паңдит* хүний эхнэр байсан тул бүх зүйлийг тодорхой төлөвт тодорхой байдлаар хэрэглэж болно гэж тайлбарласан байна. Шороог хувин хэлбэрээр усны сав болгон ашиглаж болох ба харин шороог тоосго хэлбэрт байх үед нь бус. Иймээс чихэр хэлбэртэй шороог идэж болох ба харин өөр хэлбэрүүдийг нь идэж болохгүй. Энэ нь жаалхүүг итгүүлж дөнгөсөн бөгөөд тэрээр шороо идэх нь тэнэг хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрч, цаашид энэ мэт алдаа гаргахгүйгээ хүлээн зөвшөөрсөн байна. Мөн өөр нэгэн гайхамшгийн тухай ярьцгаадаг. Нэгэн *брāхман*-мөргөлчин тэдний гэрт саатжээ. Тэрээр хоолоо бэлтгэж түүнийгээ Кршṇад өргөн залбирч уншиж эхлэв. Энэ мөчид жаалхүү хүрч ирээд бэлдсэн цагаан будааг нь идчихэв. *Брāхман* ч жаалын үйлдэлд ихэд гайхжээ. Ингээд тэрээр Жаганнāтха Мишрын хүссэнээр дахин будаа бэлдэж гэнэ. Гэтэл *брāхман*ыг бясалгал үйлдэн хоолоо өргөх үед нь жаалхүү дахиад л будааг нь идчихэв. *Брāхман*ыг гуравдахь удаагаа хоол бэлдэхийг хүсэж ятгав гэнэ. Тэр үеэр гэрийн бүх хүмүүс унтсан байсан ба харин жаалхүү энэ удаа мөргөлчний өмнө Кршṇа дүрээр заларч, түүнийг адислажээ. Өөрийн мөргөл бишрэлийн объектыг харсан *брāхман* ч онгод хөөрөлд автав. Өөр бас нэгэн түүхийг ярьцгаадаг. Хоёр хулгайч жаалхүүгийн үнэтэй гоёл чимэглэлийг хулгайлахаар түүнийг эцгийнх нь гэрээс хулгайлан авч явжээ. Замдаа

тэд жаалыг амттанаар дайлж гэнэ. Жаал өөрийн хуурмаг эрчмийг гаргаж, буруу замаар нөгөө хоёр хулгайчийг буцаагаад өөрийнхөө гэрийн хаалган дээр аваад иржээ. Хулгайчид баригдахаас эмээн жаалхүүг орхиод арилж өгсөн байна. Мөн жаалхүүгийн тухай өөр нэгэн гайхамшгийн тухай ярьцгаадаг. Нэгэн удаа тэрээр Хираñйа, Жагадйша нараас тэдний Экāдешййн өдөр Кршңад мөргөхөөр цуглуулж хуримтлуулсан өргөл хандивыг нь шаардсаар байгаад авчихжээ. Тэрээр дөрвөн настай байхдаа ээж нь бузар хэмээн хаясан гал тогооны хаягдал ваар саван дээр суудаг байв. Тэрээр ээждээ, хоол хийхээ больсон ваар сав хаягдал болсныхоо дараа бохир ч байж чадахгүй, цэвэр ч байж чадахгүй хэмээн тайлбарлаж байжээ. Энэ бүх тохиолдлууд түүнийг таван нас хүрэхээс өмнө их жаахан байх үеийн үйл явдлууд юм.

Найман настайдаа тэрээр Мāйāпур гацаанаас холгүй орших Гангāнагарт Гангāдās Пандитаас *тол* авчээ. Хоёр жилийн туршид санскрит хэлний дүрэм ба дуудлагыг сайтар эзэмшсэн байна. Цаашдаа тэрээр сурах ажлаа өөрийнхөө гэрт үргэлжлүүлсэн бөгөөд эцэг нь *пандит* хүн байсан тул түүний олон чухал номыг тэндээс олжээ. Тун магадлалтай нь тэрээр өөрөө бие даан *смртийг* судласан байж болох ба мөн *нийāйаг* үзэж, алдар нэрт Пандит Рагхунāтха Широмаñи удирдлаган дор суралцаж байсан өөрийн найз нөхөдтэйгээ мэтгэлцдэг байв.

Ингээд арван нас хүрмэгц тэрээр дүрэм, дуудлага, *смрти*, *нийāйагийн* нэн том мэдлэгтэн болсон байлаа. Чухам тэр үед түүний ах Вишварūпа гэрээ орхиж, *саннийāсийн āшрамд* шилжив. Чаитанйа тэр үед бяцхан жаалхүү байсан ч эцэг эхдээ хандан Бурханд ханамж өгөхийн тулд тэдэнд үйлчлэх болно хэмээн тайвшруулж байжээ. Энэ үйл явдлаас хойш удалгүйгээр эцэг нь таалал төгсөв. Түүний ээжид энэ байдал гүн гүнзгий туссан байна. Харин үргэлжид сэтгэл амгалан мэт харагдах Махāпрабху бэлэвсэрч хоцорсон ээжийгээ тайвшруулж, сэтгэлийг нь засаж байжээ.

14-15 насандаа Махāпрабху мөн Надийн удам гаралтай Валлабхāчāрийн охин Лакшмйдевитэй гэрлэв. Тэр тед тэрээр *нийāйан* гүн ухаан болон санскрит хэлний мэргэн ухааны нийслэл гэж алдаршсан Надийн шилдэг эрдэмтдийн нэг хэмээн тооцогдож байлаа. Тэр бүү хэл *смāрта пандитууд* байтугай *наййāчууд* түүнтэй дүрэм зүйн талаар мэтгэлцээн хийхээс айх болжээ. Гэр бүлтэй болсон учраас тэрээр хөлжиж чинээлэгжихээр Падма голын эрэг дэхь Дорно Бенгалийг зорив. Тэнд тэрээр өөрийн эрдэм ухаанаа нээн үзүүлж тодорхой хэмжээний мөнгө олжээ. Энэ үед мөн үе үехэн *вишңуизмыг* номлож байв. Тапанамишраг *вишңуизмын* зарчимд сургаж тэрээр түүнийг Бенарест очин тэнд суурьшихыг тушаан даалгажээ. Түүнийг Дорно Бенгалид байх үед эхнэр Лакшмйдеви нь могойнд хатгуулан нас нөгчив. Гэртээ буцан ирж уй гашууд автсан ээжтэйгээ уулзаж хүний амьдралын хэврэгхэн тухай өгүүлж аргадан тайтгаруулав. Ингээд түүний хүсэлтээр тэрээр Рāжа Пандит Санāтана Мишрын охин Вишңуприйатай гэрлэжээ. Түүний найз нөхөд түүнийг *праваса* буюу гэрээсээ түр явах үйлээсээ буцан ирмэгц нь түүнтэй ирж нэгдэв. Аугаа их Дигвижайя хэмээн өөрийгөө нэрлэсэн Кашмирын Кешава Мишра

эндэхийн *паңдиттай* ном хаялцахаар Надийд ирсэн байна. Ялагдашгүй *паңдит* гэж нэрлэгдсэн этгээдээс айж Надийн *толын* профессор хэн нэгнээс урилга заллага авсан хэмээх нэрээр хотыг орхин оджээ. Кешава Мāйāпур дахь Барокона-гхāтāд Махāпрабхутай учирчээ. Богинохон хугацааны мэтгэлцээний эцэст залуу хүү бүрэн дүүрэн ялалтыг олов. Ичиж зовсон *паңдит* нуугдахаас өөр аргагүй болсон ба энэ цаг үеэс эхлэн Нимāи Паңдит өөрийн цаг үеийнхээ хамгийн нэртэй томоохон *паңдит* болжээ.

Тэрээр 16-17 настай байх үедээ өөрийн олон шавь нарын хамтаар Гайаг зорин аялсан бөгөөд алдар цуут Мāдхавендра Пурйгийн шавь *саннийāсй-ваицнава*, Йшвара Пурйгээс бурханлаг сахилыг хүртжээ. Ингээд Надийн зүгт буцах үед Нимāи Паңдит шашны номлогч болон хувирсан бөгөөд түүний бишрэл сүсэгт дүр төрх хурцаар илэрч байлаа. Чаитанйагаас насаар ахмад Адвайта Прабху, Шрйвāса болон бусад ваицнавын итгэл үнэмшлийг номлогч асан бусад хүмүүс залуу хүүгийн өөрчлөгдөн хувирсныг хараад туйлын ихээр гайхав. Тэрээр аль хэдийнээ *наийāк* нартай мэтгэлцэхэд хэзээд бэлэн мэтгэлцэгч, *смāрта* нартай улайран ном хаялцагч, хорон үгтэй яруу илтгэгч биш болсон байлаа. Харин Кршṇагийн нэрийг сонсмогц онгод хөөрөлд ордог өөрийн шүтлэг бишрэлт мөн чанарынхаа улмаас бурханаас урамшуулагдсан нэгэн мэтээр биеэ авч явах болжээ. Энэ бүхнийг өөрийн нүдээр харсан Мурāри Гупта, Тэрээр Шрйвāсā Паңдитын гэрт дийлэнхи нь эрдэм боловсролт *паңдит* нараас бүрдсэн өөрийн олон зуун дагалдагч нарын нүдэн дээр бурханлаг хүч чадлаа үзүүлсэн тухай дүрслэн өгүүлсэн байдаг. Чухам энэ үед тэрээр Шрйвāсā Паңдит болон түүний үнэнч шавь нартай хамтран *кйртаны* оройн сургуулийг нээжээ. Тэр сургуульд тэрээр багшилж, дуулж, бүжиглэж, шашны олон янзын мэдрэмжийг үзүүлж байв. Энэ үед түүн дээр вицṇуизмыг номлогч, бүх Энэтхэгээр зорчих аялалаа дуусч байсан Нитйāнанда Прабху ирж нэгджээ. Үнэн хэрэгтэй, чин үнэн сэтгэлтэй, цэвэр ариун зүрхтэй *паңдитууд* буюу Бенгалийн өнцөг булан бүрээс ирсэн вицṇуизмын номлогчид түүнтэй нэгдсэн байсан ба Нади хот, үүрэг зорилго нь хүн төрөлхтөнийг вицṇуизмын итгэл үнэмшлийн дэвшилтэт нөлөөллөөр ариусган бурханлагжуулах олон олон *āчāрйа ваицнавуудын* байнгын оршин амьдрах газар мэт болсон байлаа. Түүний Нитйāнанда Прабху, Харидāс нарт өгсөн анхны даалгавар нь ийм байлаа: “Явцгаа, найзуудаа, хотын гудамжаар явагтун. Байшин болгоны үүд хаалган дээр байгсадтай танилц. Тэднийг Харигийн ариун нэрийг дуулж, ариун гэгээн амьдралаар замнахыг хүс. Дараа нь над дээр ирж, орой бүр номлолынхоо үр дүнгийн талаар надад мэдэгд”. Энэ тушаалаар зэвсэглэсэн хоёр номлогч хот руу орж, хамгийн булай бузрын илэрхийлэл болсон Жагāи, Мāдхāи нартай учрав. Энэ хоёр этгээд тэдний гүйлт захиасыг сонсмогц номлогч нарыг дайран доромжилсон боловч удалгүй Бурханы илгээсэн *бхакти*(чин

бишрэл)-ийн нөлөөгөөр ваицнавууд болцгоосон юм. Энэ нь надийн бүх оршин суугчдыг гайхашралд оруулав. Надийн суугчид өөр хоорондоо: “Нимāи Паᅇдит зүгээр ч нэг аугаа суут хүн биш ажээ. Тэр гарцаа байхгүй Бүхнийг чадагч Бурханы элч байж таарна” хэмээн шагшин ярьцгаана. Энэ цаг мөчөөс эхлэн хорин гурван нас хүртлээ Махāпрабху өөрийн зарчим номлолоо зөвхөн Нади төдийгүй энэ хоттой хөрш зэргэлдээ оршдог бүхий л чухал хот, тосгодоор номлосон юм. Өөрийн шавь нарын гэрт гайхамшгийг үзүүлж, *бхактийн* эзотерик зарчмыг заан сургаж, бусад *бхакта* нартай хамтран *санкйртан* дуулдаг байв. Түүний Надийн шавь нар Харигийн ариун нэрийг хотын гудамж талбай, худалдааны захаар дуулан явдаг байжээ. Энэ нь нүсэр их дуулианыг дэгдээж, олон янзын айл өрхөд өөр өөр мэдрэмжийг төрүүлж байв. *Бхактагууд* үүнд нэн их сэтгэл ханамжтай байсан ба харин *смārта брахманууд* Нимāи Паᅇдитын амжилтанд атаархаж, түүнийг *индуизмын* зарчим суртахуунтай харшилсан үйл үйлдэж байна хэмээн буруутгаж Чханд Казид алтан хошуу өргөв. Кази, Шрйвāsā Паᅇдитын гэрт очиж тэнд байсан *мрдангийг*(кхол бөмбөр) хэмхэлж, хэрэв Нимāи Паᅇдит эргэн тойронд болж буй өөрийн эргэлзээ төрүүлсэн шашны номлолныхоо дуулиан шуугианыг зогсоохгүй бол түүнийг болон түүний шавь нарыг мусульман шашинд оруулах болно хэмээн занажээ. Энэ мэдээ Махāпрабхуд хүрсэн байна. Тэр даруйдаа тэрээр хотын оршин суугчдыг орой гартаа дэнлүү барьж цуглахыг хүсэв. Тэд ч хэлснийг нь биелүүлсэн ба Нимāи 14 бүлэгт хуваасан өөрийн *санкйртаны* жагсаалыг удирдан толгойлжээ. Казийн байшинд хүрээд түүнтэй маш удаан ярилцсан бөгөөд эцэст нь тэрээр Казийн биед хүрсэн нь тэрхэн даруйдаа түүний зүрхэнд нөлөөлж Кази нулимс урсган уйлж тэрээр түүний эргэлзэн тээнгэлзэж байсан бүхнийг арилгаж, түүнийг эгэл бус онгод хөөрөлд оруулсан бурханлаг мэдрэмжийг сэрээсэн гүн гүнзгий бурханлаг цочирдлыг мэдэрснээ хүлээн зөвшөөрсөн байна. Ийнхүү Кази *санкйртан* хөдөлгөөнтэй нэгджээ. Бүх ертөнц даяараа Аугаа Бурханы бурханлаг хүч чадлыг шагшин гайхсан ба энэ үйл явдлын дараагаар олон зуун тэрс үзэлтнүүд Вишвамбхарын талд орсон байна.

Энэ явдлын дараагаар Кулийн хэд хэдэн атаач, хөөрхийлөлтэй *брахманууд* Махāпрабхутай маргалдах шалтаг хайж, түүний эсрэг хуйвалдаан зохиов. Мөн чанарынхаа хувьд Нимāи Паᅇдит хэдий өөрийн зарчимд маш хатуу гэлээ ч өрөвч зөөлөн зүрх сэтгэлтэй нэгэн байв. Тэрээр хагарал бутралын сэтгэл, анги сектээр ялгах үзэл нь хөгжил дэвшлийн хоёр том дайсан юм хэмээн тайлбарлаад түүний үйл хэрэг бүрэн дүүрэн амжилттай болтол тодорхой овог удамд харъяалагдах Надийн оршин сугч байсаар байх болно гэжээ. Ингээд тэрээр гэр бүл, каст, шашин шүтлэгийн хэлбэр зэрэг бүх холбоогоо таслаж ертөнцийн иргэн болохоор шийдсэн ба энэ шийдвэрээ өвөрлөн хорин дөрвөн насандаа Катвад ирж энэ хотод амьдарч асан Кешава Бхāратйгаас *саннийāsийн* сахил хүртжээ. Ээж болон эхнэр нь түүнээс хагацан салсны улмаас гашуунаар уйлан хайлан байсан ч манай баатар хэдий өрөвч зөөлөн сэтгэлтэй ч өөрийн зарчимдаа нэн хатуу байсан юм. Тэрээр үй түмэн хүнтэй

Крш᳚агийн хязгааргүй бурханлаг ертөнцийн тулд өөрийн гэр хэмээх бяцхан ертөнцийг орхижээ.

Саннийāсийн сахил хүртсэнийх нь дараагаар Адвайта Прабху Шāнтипур дахь өөрийн гэртээ түүнийг морилон саатахыг хүсэв. Адвайта тэдний зүгт Надийн Чаитанйагийн найз нөхөд, хүндэлж бишрэгсэдийг болон хүүгээ харахыг хүссэн Шачйидевийг аваачих ажлыг зохион байгуулсан байлаа. *Саннийāсийн* хувцас өмссөн хүүгээ хараад баяр жаргал, зовлон гуниг нэгэн зэрэг зүрхэнд нь оволзов. Крш᳚а Чаитанйад яг л *саннийāсй* хүнд байдагчлан зөвхөн *каупйна*, *бахирвāса* л байлаа(дээгүүр өмсөх өмсгөл). Толгойдоо үс үгүй болсон байсан хийгээд гартаа *дан᳚да*(таяг), *кама᳚дала*(огоорогч нарын хэрэглэдэг усны сав) барьсан байв. Гэгээн хүү нь хайрт ээжийнхээ хөлд сөхрөн унаж, өгүүлсэн нь: “Эж минь ээ! Энэ бие маань таных билээ. Би таны заавар тушаалыг даган биелүүлэх ёстой. Та намайг бурханлагаар төгөлдөржихийн тулд Врндāван явахыг зөвшөөрөөч” гэв. Эж нь Адвайта болон бусад хүмүүстэй зөвшилцөн хүүгээ Пурй᳚д(Жаганнāтха хот дахь) байхыг хүсэв. Махāпрабху ч энэ хүсэлтийг хүлээн авч, хэдэн хоногийн дараагаар Шāнтипурийг орхиж Ориссийг зорилоо. Шāнтипуриэс Пурй᳚ хүртэл хийсэн Крш᳚а Чаитанйагийн(*саннийāсй* болсноор тэрээр ийм нэрийг авчээ) аялалын тухай түүний намтарт дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Тэрээр Бхāгйратхйин эрэг дагуу явж одоогийн Тхāнā Матхурāпур(Алмазан Гавань, 24 Парган) орших Чхатрабхоги хүрчээ. Тэндээс нэгэн завь хөлсөлж түүгээр Миднапурын хязгаарт орших Прайāга-гхāтa хүрсэн ба дараа нь замдаа Бхūванешварын сүмийг үзээд Баласор, Пурй᳚гийн Каттакт хүрч ирэв. Пурй᳚д ирэх үедээ тэрээр сүмийн Жаганнāтха шүтээнийг үзсэн бөгөөд сүүлчийнх нь хүсэлтээр Сārвабхаумын гэрт саатав. Сārвабхаума нь өөрийн цаг үеийнхээ аугаа *па᳚дит* байсан ба түүний уншсан зүйлд хязгаар үгүй байлаа. Тэрээр тэр үеийн шилдэг *наийāк* байсан бөгөөд хамгийн төгс мэдлэгтэй эрдэмт гүн ухаантан, Шанкарāчāрйин сургуулийн *ведāнтын* гүн ухааны их мэдлэгтэн хэмээн алдаршсан нэгэн байв. Тэрээр Надийд(Видйāнагар) төрсөн ба өөрийн *тол᳚д* хязгааргүй олон тооны шавь нарыг сурган боловсруулжээ. Дараа нь Нимāи Па᳚дитыг төрөхөөс өмнөхөн тэрээр Пурй᳚д нүүн ирсэн ажээ. Түүний хүргэн, Гопйāнāтха Мишра Сārвабхаумад манай шинэ *саннийāсийг* танилцуулжээ. Сārвабхаумаг түүний гоо үзэсгэлэн гайхашруулсан бөгөөд ийм залуу хүний хувьд бүхий л амьдралынхаа туршид *саннийāсийн дхармаг* баримтлах нь амар биш хэмээн айн болгоомжлов. Махāпрабхуг аль Надид байхаас нь мэдэх Гопйāнāтха түүнийг ихээр хүндэтгэдэг ба энэ *саннийāсй* нь эгэл жирийн нэгэн бус хэмээн мэдэгдэв. Энэ үндэслэлээр Гопйāнāтха Сārвабхаума нарын хооронд халуухан маргаан дэгджээ.

Дараа нь Сārвабхаума тэрээр Ведāнта-сūтрыг хэрхэн уншихыг сонсооч хэмээн Махāпрабхугаас хүссэн бөгөөд тэрээр түүнийг нь санаатайгаар зөвшөөрсөн байна. Чаитанйа маш чухал, няхуур царай гарган долоо өдрийн туршид Сārвабхаумын ярьсан болгоныг нь сонсов. Долоо дахь өдөр болоход Сārвабхаума хэлсэн нь: “Кршṇа Чаитанйа! Чи Ведāнтыг ойлгохгүй л байх шиг надад санагдаж байна. Учир нь миний уншлага болон тайлбарыг сонссон атлаа ганц ч үг хэлсэнгүй шүү дээ” гэв. Үүнд хариу болгож Чаитанйа, тэрээр *сūтрыг* сайтар ойлгодог ч Шаṅкарāчāрийа өөрийн тайлбараараа юу хэлэх гээд байгааг нь ойлгодоггүй хэмээн хариу өчжээ. Энэ хариултанд цочирдон гайхсан Сārвабхаума: “Чи *сūтрыг* ойлгодогч харин түүний тайлбарлан өгүүлсэн тайлбарыг ойлгодоггүй гэдэг чинь байж болох уу? За яахав, хэрэв чи *сūтрыг* тийм сайн ойлгодог юм бол надад өөрийн тайлбараа хэлж өгнө үү” хэмээн өгүүлэв. Ингээд Махāпрабху Шаṅкарын пантеист тайлбарыг хөндөлгүйгээр бүхий л *сūтрыг* өөрийнхөөрөө тайлбарласан байна. Сārвабхаумын хурц ухаан, Чаитанйагийн тайлбараас үнэн байдал, аргументчлалын гоо сайхан, хэв зохицлыг олж ажсан агаад *Брахма-сūтрыг* тийм энгийнээр тайлбарлаж чадах хүнийг анх удаагаа харж буйгаа хүлээн зөвшөөрөв. Тэрээр Шаṅкарын тайлбар нь Махāпрабхугаас хүлээн авсан Ведāнта-сūтрын тийм энгийн тайлбарыг агуулаагүй гэдгийг мөн хүлээн зөвшөөрсөн юм. Эцэст нь тэрээр өөрийгөө ялагдсаныг хүлээж, түүний дагалдагч болж Чаитанйагийн талд оров. Энэ тухай бүгдэд тодорхой болмогц бүх Орисс даяар Кршṇа Чаитанйаг магтан шагшигцаасан байна. Зуу зуун хүмүүс түү рүү хүрэлцэн ирж түүний шавь болсон бөгөөд тэр үеэр Махāпрабху Өмнөд Энэтхэгийн зорин явахыг бодолхийлэх болсон ба тэрээр Кршṇадāс Брāхман гэгчийг дагуулан энэ аялалдаа гарчээ.

Түүний намтарт энэхүү аялалыг дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Эхлээд тэрээр уяман өвчнөөр өвдсөн Вāсудева нэрт хүнийг эмчилж гайхамшгийг үзүүлсэн Кūrмакṣетрад ирэв. Годāварй голын эрэг дээр тэрээр Видйāнагарын амбан сайд Рāmāнанда Рāйтай уулзсан ба тэдний хооронд *према-бхактийн* тухай гүн ухааны яриа хүүрнэл өрнөсөн юм. Тэрээр бас нэгэн гайхамшгийг үзүүлсэн нь: нэг хүрэлтээрээ *тāла* нэрт долоон модыг ор үндэсгүй алга болгосон ба тэр модны араас Дашаратха хааны хүү Рāmачандра сумаа харваж, аугаа демон Бāли Ражийг устган дарж байсан ажээ. Тэрээр өөрийн бүхий л аялалын туршид вицṇуизм ба *нāма-санкйртаныг* номлож байсан юм. Тэрээр борооны улирлыг өнгөрүүлэхийн тулд Рāйгакṣетрад Вейката Бхатṭын гэрт саатсан байна. Тэнд тэрээр Рāmāнужийн вицṇуизмын дагалдагч Вейкатын бүхий л гэр бүлийг тэр ч бүү хэл түүний арван настай жаалхүү Гопāлыг ч Кршṇа-*бхактийн* зам мөрт хандуулав. Тэр жаалхүү

хожим нь Врндāванд ирж, Шрї Кршᅇа Чаитанйагаар толгойлуулсан зургаан Госвāмйин нэг болсон юм. Өөрийн авга ах Прабодхāнанда Сарасватйгаар санскрит хэлийг заалгаж Гопāl вицᅇуизмын чиглэлээр хэд хэдэн ном бичжээ.

Чаитанйа Өмнөд Энэтхэгийн хэд хэдэн газар нутгаар явж Коморины булан хүртэл аялав. Хоёр жилийн дараагаар Бхйма голын Пандепураар дамжин Пурйд буцан иржээ. Энэ хотод тэрээр нэгэн Тукārāма гэгч хүнд бурханлаг гэгээрлийг хайрласан ба тэрээр энэ цаг мөчөөс эхлэн шашны номлогч болон хувирсан байна. Тэрээр энэ тухай баримтаа өөрийн *ābhāᅇgadaa* хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ нь бомбейгийн Иргэний Үйлчилгээний ажилтан мистер Сатйендра Нātх Тагорын нэгэн номонд орсон байсан. Энэ аялалынхаа үеэр тэрээр буддын шашинтан, жаинууд *māyāvāduudтай* ярилцаж, өөрийн сөргөлдөгч нарыг вицᅇуизмд татан оруулж байлаа.

Пурй тийш буцах замдаа Чаитанйа Махāпрабху нэрийн дор Рāжа Пратāпарудра-дева ба хэд хэдэн *pañᅇит-брāхмануудтай* тулгарсан байдаг. Энэ үед тэрээр хорин долоон настай байв. Хорин найман насандаа тэрээр Бенгали руу аялж Малда дахь Гауда хүртэл аялсан юм. Тэнд тэрээр Рўпа, Санātана нэрт гаргуун хоёр бодгалийг олсон юм. Энэ ах дүү хоёр хэдий тэд *карᅇātын брāхмануудаас* гаралтай байсан ч, хожмоо Гаудын эзэн хаан болсон Хуссейн Шахтай байнгад харьцдаг байсны улмаас бараг л мусульман шашинтан болсон байв. Эзэн хаан тэдний нэрийг өөрчилж Дабир Кхās, Сāкар Маллик нэрүүдийг өгсөн ажээ. Эзэн нь тэднийг ихэд хайрладаг байсан бөгөөд учир нь тэд хоёул перс, араб, санскрит хэлийг сайтар мэддэг, төр засагтаа үнэнчээр зүтгэдэг байжээ. Энэ хоёр буянлаг хүмүүнд энэтхэгийн нийгэмд эргэн орох хаалга нь хаалттай болсон байсан ба тэд Махāпрабхуг Пурйд байх үед бурханлаг тэтгэлгийг хүсэн захидал бичсэн байна. Махāпрабху тэдэнд хариу болгон тэдний зүгт заавал очиж, бүх бурханлаг асуудлуудыг нь арилгана хэмээн бичиж байжээ. Ингээд түүнийг Гаудад ирмэгц ах дүү хоёр хоёул өмнө хүсч байсан мөргөл залбирлаа өргөн түүнтэй золгожээ. Махāпрабху тэднийг Врндāван тийш зорчихыг даалгасан ба тэнд тэдэнтэй дахин уулзсан юм.

Чаитанйа Шāнтипурээр дамжин тэнд өөрийн хайртай ээжтэйгээ дахин уулзсан ба Пурйин зүгт буцав. Пурйд нэг их удалгүйгээр Врндāваныг зорив. Энэ удаа түүнийг Балабхадра Бхатᅇtāчārйа гэгч дагалдан явсан юм. Тэрээр Врндāванд очиж, дараа нь Прайāгт(Аллахабад) ирэв. Тэнд тэрээр олон тооны мусульман шүтлэгтнүүдийг Коран судраас иш татан вицᅇуизмд оруулав. Ингэж татан оруулсан мусульманы удам судар одоог хүртэл Патхана Ваицᅇавууд гэж алдаршсан байдаг. Рўпа Госвāмй түүнтэй Аллахабадад учрав. Чаитанйа арван өдрийн туршид бурханлаг эрдэм ухаанд заан сургаад үүний дараагаар түүнд хэд

хэдэн үүрэг даалгавар өгөн Врндāван тийш илгээжээ. Нэг дэхь үүрэг даалгавар нь цэвэр *бхакти* буюу *премаг* эрдэм мэдлэг талаас нь тайлбарлан шашин номын бүтээл туурвих, хоёр дахь нь Двāпара йугийн төгсгөлөөр Кршṇачандра Өөрийн бурханлаг *лйлаг* бүх шүтлэг бишрэлт ертөнц дахины сайн сайхны тулд зориулан илрүүлсэн газар нутгуудыг сэргээн тогтоох байсан юм. Рӯпа Госвāmй Аллахабадаас Врндāваныг зорьсон ба харин Махāпрабху өмнө зүгийг чиглэн Бенаресыг зорив. Тэнд тэрээр Чандрашекхарын гэрт саатан зочилж, харин хоол хүнсийг(*бхикшиа*) өдөр бүр Тапана Мишрын гэрт зооглож байлаа. Энд түүн дээр Санāтана Госвāmй ирж нэгдсэн бөгөөд хоёр сарын туршид түүнээс бурханлаг сэдвээр сургаал номлол сонсов. Намтрууд, ялангуяа Кршṇадās Кавирāжийн бичсэн намтар Чаитанйагийн Рӯпа Санāтана нарт өгсөн сургаалыг нарийвчлан бидэнд тайлбарлан үлдээжээ. Кршṇадās жирийн нэг намтар бичигч-үе нэгтэн байсан төдийгүй мөн тэрээр Махāпрабхугийн шавь Госвāmй нараас өөрсдөөс нь баримт нотолгоог олж авч байжээ. Рӯпа, Санāтана нарын ач болохуйц Жйва Госвāmй өөрийн аугаа багшийн номлол сургалын тухай өгүүлсэн гүн ухааны үндсийг хөндөж бидэнд *Шат-сандарбха* хэмээх үнэ цэнэтэй бүтээлээ туурвисан юм. Бид энэхүү аугаа зохиолчийн номонд агуулагдаж буй Чаитанйагийн номлолыг цуглуулж, товчлон өгүүлсэн болно.

Бенарест байх үесдээ Чаитанйа бүхий л *саннийāсийудыг* хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулдаг Маратхийн брāхмаṇы гэрт эрдэмт *саннийāсийудтай* уулзав. Энэ уулзалтын үеэр Чаитанйа тэднийг өөртөө татсан гайхамшигийг үзүүлсэн ба үүний дараагаар яриа хөөрөө өрнөлөө. *Саннийāсийудыг* эрдэм ухаанаараа тэдэн дундаас гоц ялгарах Пракāшāнанда Сарасватй толгойлж байв. Нэг их удаан бус хугацаанд ном хаялцсаны эцэст тэд Махāпрабхуд ялагдсанаа хүлээн, Шаṅкарāчāрийн тайлбарт төөрч явснаа зөвшөөрсөн байна. Тэр бүү хэл хамгийн эрдэм номтой эрдэмтэн ч удаан хугацаанд Чаитанйагийн номлолыг сөргөлцөж чаддаггүй байсан бөгөөд учир нь тэрээр ямар нэг ид шидийг эзэмшсэн байсан ба түүгээрээ тэдний зүрх сэтгэлийг хөндөж бурханлаг төгс төгөлдөрт хүрэхийг хүсэн нулимс унагатал нь эзэмддэг байжээ. Бенаресын *саннийāсийуд* тун удалгүй Чаитанйагийн хөлд сөхрөн унаж, тэдэнд өршөөл(*крпа*)-өө хайрлахыг хүсэв. Үүний дараагаар Чаитанйа тэдэнд цэвэр *бхактийн* тухай номлож, энэ нь аажмаар тэдний зүрхэнд анги сектийн үзэл төсөөллөөс нь татгалзуулсан Кршṇаг хайрлах бурханлаг хайрыг хөглөж өгсөн юм. Энэхүү *саннийāсийудыг* өөрчилсөн гайхамшигт хувислын дараагаар Бенаресын бүх суугчид ваицṇавууд болцгоосон ба тэд өөрсдийн шинээр олж авсан Бурханы хамтаар аугаа нүсэр *санкйртаныг* зохион байгуулжээ. Санāтанаг Врндāван тийш илгээгээд Махāпрабху бас дахин ширэнгэн ойгоор

дамжин өөрийн найз Балабхадраг дагуулан Пурйин зүгт хөдлөв. Пурй орох замдаа Махāпрабху маш олон гайхамшгийг үзүүлсэн тухай Балабхадра ярьсан байдаг. Жишээ нь тэрээр Кршṇагийн ариун нэрийн авиагаар бар, заан гэх амьтдыг дэвхцүүлэн бүжиглүүлж ч байжээ.

Энэ үеэс буюу 31 наснаас өөрийн буцан одсон дөчин найман насыг хүртэл *санкйртан* хийхдээ Тṭагаопйнātхын сүмд байсан ба Махāпрабху хаашаа ч явалгүй Пурйд байж Каши Мишрын гэрт амьдарч байжээ. Энэ 18 жилийн туршид түүний амьдрал байнгын хайр ба буянлаг үйлийн алдар гавъяагаар дүүрэн байлаа. Тэрээр жирийн хүмүүсээс өөрсдийн цэвэр ариун байдал, эрдэм мэдлэг, хатуу шашны зарчим жаяг, Рādхā-Кршṇаг хайрлах бурханлаг хайр зэргээр онцгойрон ялгарах, хэн нь ч ялгаагүй бүгд өндөр түвшний ваицṇавуудаас бүрдсэн олон тооны шавь нараараа хүрээлүүлэн байв. Махāпрабхуг Надид байх үед Пуруцоттамāчāрйа нэрээр алдаршсан Сварūпа Дāмодар Бенаресаас Пурйд ирж бичиг хэрэг хариуцсан ажлыг өөр дээрээ авч тэдэнтэй нэгдсэн байна. Хэрэв Сварūпа энэ бүх бүтээлүүдийн цэвэр ариун, ашиг тустайг хүлээн зөвшөөрөөгүйсэн бол яруу найргийн болон гүн ухааны нэг ч бүтээл тэдний өмнө байхгүй байхсан. Түүний хоёр дахь залгамжлагч бол Рāmāнанда Рāй байсан юм. Чаитанйаг мөргөлийн аль нэг аспекттай холбоотой өөрийн мэдрэмжийг илтгэн гаргах үед тэрээр Сварūпын хамтаар дуулдаг байв. Парамāнанда Пурй шашны асуудлаархи асуудлуудыг хөтлөн явуулдаг байжээ. Түүний намтар үүнтэй холбоотой зуу зуун түүхээр баян бөгөөд бид тэдгээрийг энд нуршин өгүүлэхгүй. Махāпрабху маш бага унтдаг байсан бөгөөд өдөр шөнийн алинд ч түүний хөөрөл догдлол түүнийг алс холын бурханлаг тэнгэрийн мандалд аваачдаг байсан юм. Тэрээр сүмд мөргөн залбирдаг байсан ба өөрийн Врндāванд үүрэг гүйцэтгэгч нартай холбоо харьцаатай байж, түүн дээр анх удаагаа ирж буй шашин номын хүмүүстэй хүүрнэн ярилцдаг байжээ. Тэрээр өөртөө анхаарал үл хандуулан дуулан бүжиглэж, тийн цэнгэл жаргалд автдаг байсан юм. Түүн рүү хүрэлцэн ирсэн хүн бүр, тэрээр хүн төрөлхтөнд сайн сайхныг авчрахаар энэ ертөнцөд буун заларсан бүхнээс үзэсгэлэнтэй Бурхан юм гэсэн итгэл үнэмшил төрдөг байв. Энэ бүх хугацаанд тэрээр ээжийгээ хайрлах хайраа орхисонгүй. Нади явсан хүн болгоноор түүнд *махāпрасад* илгээдэг байлаа. Мөн чанарынхаа хувьд тэрээр дээд зэргийн өгөөмөр уяхан нэгэн байсан ба номхон хүлцэнгүй байдал түүнд биелэн шингэсэн байсан юм. Түүний гайхамшигтай гадаад байдал учирсан хүн болгонд баяр баяслыг хайрладаг байжээ. Тэрээр Бенгалид үйлдэх номлолын үүрэгт ажлыг Нитйāнандад хариуцуулан даалгасан ба мөн өөрийн зургаан шавийг Врндāванд илгээж тус нутгийн хойд хэсгээр бурханлаг хайрыг номлохыг даалгасан юм. Тэрээр шударга явдалт ариун гэгээн амьдралын зам мөрөөс гарахыг өөртөө зөвшөөрсөн өөрийн бүх шавь нарыг цээрлүүлэн шийтгэсэн байдаг. Ялангуяа энэ байдлыг жижиг Харидасын тохиолдол дээр ажиглаж болно. Тэрээр хэзээ ч түүнээс сургаал номлолыг хайрлахыг гуйн хүссэн хүмүүст сургаалаа айлдахаас

татгалздаггүй байв. Үүнийг Рагхунātха дās Госвāmид өгсөн сургаалын жишээн дээрээс харж болно. Түүний том Харидāст хандаж буй хандлага нь бурханлаг хүмүүсийг хэрхэн хайрладаг, бурханлаг ах дүүсийн ёсон дахь анги кастын ялгааг үл хэрэгсэж байсан жишээг илтгэн харуулдаг юм.

Бурхан Чаитанягийн үүрэг зорилго

Бурхан Чайтанья Махапрабху Өөрийн шавь нартаа Кршṇагийн тухай эрдэм ухааныг таниулан нээсэн ном судрыг бичихийг захин даалгасан ба Түүний энэхүү захиасыг шавь нар нь өнөөдрийг хүртэл даган биелүүлсээр байна. Бурхан Чайтаньягийн сургаал, номын талаар өгүүлсэн бүтээлүүд нь маш их өргөн цар хүрээтэй, өгүүллийн хатуу дэг жаяг хийгээд дэс дарааллаараа ялгардаг. Учир нь тэдгээрийн зохиогчид нь багш шавийн хэлхээг хатуу баримтлан дагадаг. Бурхан Чайтанья Махапрабху Өөрөө их залуу үедээ эрдэмт мэргэн хэмээн алдаршсан ч “*Шикṣāṣṭака*” хэмээн нэрлэгдэх ердөө найман шүлгийг туурвин үлдээсэн байдаг. Энэ шүлгүүд Түүний үүрэг зорилго, сургаалын мөн чанарыг нээн өгсөн билээ. Доор энэхүү нэн чухал ач холбогдолтой мөргөл залбирлын орчуулгыг толилуулъя.

Үхэх төрөхийн дахин дахин давтагдах хүрд хийгээд болзолдсон материаллаг ахуйн дүрэлзэн буй аймшигт түймрийг даран унтраах, зүрхэнд он удаан жилээр хуралдан хуримтлагдсан бохир буртаг болгоныг ариусган цэвэрлэх Шрй-Кршṇа-*сaнкīртаны* яруу алдар бадартугай. Энэхүү *сaнкīртаны* хөдөлгөөн нь хүн төрөлхтөнд хэмжиж баршгүй сайн сайхны адислалыг тээн авч ирэх бөгөөд яг л сарны ялдам зөөлөн туяа мэт гэрэл гэгээг сацруулмуй. Тэрээр трансцендент эрдэм мэдлэг бүхний амь сүнс нь хийгээд трансцендент жаргал цэнгэлийн далайг улам улмаа лавшруулан гүнзгийлж, бид бүхний ямагт хүсэн байх тэр ариун рашаанаар цэнгэн жаргах боломжийг олгодог билээ.

Ай Бурхан минь ээ, зөвхөн Таны ариун гэгээн нэр алдар л бүхий л амьд оршнолуудад адис өршөөлөө хайрлаж чадах билээ. Иймээс ч Танд Кришна, Говинда гэх мэт сая, сая нэр бий. Эдгээр трансцендент нэрүүддээ Та Өөрийн бүх трансцендент эрч хүчээ шингээн өгсөн бөгөөд энэ ариун нэрсийг давтан дуудах хатуу дэг жаяг үгүй билээ. Ай Бурхан минь ээ, Өөрийн өршөөл энэрлээр Таны ариун гэгээн нэр алдрыг давтан дуудсанаар Танд хялбараар хүрч болох сайхан бололцоог бидэнд хайрласан билээ.

Өөрийгөө зам дээр хэвтэж буй өвснөөс ч доор тавьж, ухаан санааны номхон хүлцэнгүй төлөвт Бурханы ариун гэгээн нэрийг давтан унших хэрэгтэй бөлгөө. Нэг байрандаа хөдөлгөөнгүй зогсох модноос ч тэвчээртэй байж, хуурмаг нэр алдарт тэмүүлэх хүсэл сонирхлоос ангид оршин, бусдад хүндэтгэл үзүүлэхэд үргэлж бэлэн байх ёстой амой. Зөвхөн ухаан санааны ийм төлөв байдалд Бурханы ариун гэгээн алдар нэрийг байнга давтан уншиж чадмуй.

Ай Бүхнийг Чадагч Бурхан минь ээ, би эд баялаг, хөрөнгө мөнгийг хураан хуримтлуулахыг хүсэхгүй, мөн надад үзэсгэлэнтэй сайхан эмэгтэй, үй олон дагалдагч шавь хэрэггүй билээ. Би цорын ганц зүйлийг л хүсэн мөрөөднөм: хариуд нь юу ч хүсч горилолгүйгээр, амьдралаас амьдралд Танд чин бишрэлээр үйлчлэн зүтгэхийг болгоон соёрхоно уу.

Ай Нанда Махāрāжийн хүү минь ээ(Крш᠑а), Би хэдийгээр Таны мөнхийн албат ч гэлээ үхэх, төрөхийн аймшигт далайд хэдийнээ унаж ойчсон билээ. Намайг энэ үхлийн харанхуй далайгаас татан гаргаж, Таны бадамлянхуан өлмийн дор мөнхөд орших өчүүхэн тоосонцруудын нэгэн болгож соёрхоно уу.

Ай Бурхан минь ээ, Таны ариун гэгээн нэрийг давтан дуулах үеэр тасралтгүйгээр цуван асгарах хайрын сувдан нулимс чухам хэзээ, миний харах нүдийг чимэхсэн болоо ? Чухам хэзээ Таны ариун гэгээн нэр алдрыг давтан уншсанаар хоолой минь чичирхийлэн, хамаг биений минь үс өрөвхийлөн босох вэ?

Ай Говинда! Чамаас салан хагацах мөч бүхэн надад бүхэл бүтэн галав эрин мэт санагдах бөлгөө. Уй гашууд автсан миний нүднээс нулимсан гол цувран асгарах ба Чамгүйгээр хорвоо дэлхий тэр чигээрээ хов хоосон мэт бодогдмуй.

Надад Крш᠑агаас өөр ямар ч Эзэн Захирагч гэж үгүй билээ. Тэр намайг чангаар тэвэрч байсан ч эсвэл надтай үл учран зүрхийг минь хэдэн хэсэг тасар татан хаясан ч Чи миний хувьд энэ л хэвээрээ мөнхөд оршмуй. Тэрээр юу л хүснэ түүнийгээ хийг. Учир нь тэрээр юунаас ч үл хамааран үргэлжид миний мөнхөд мөргөн залбирах Эзэн Захирагч минь хэвээр үлдэх бөлгөө.

Оршил

(Анхлан *Чаитанья-чаритāmрта* буюу *Кришнадās Кавирāжа Госвāmийн* бичсэн *Бурхан Чаитаньягийн баттай намтраар хийсэн таван өглөөний лекц*, - Нью-Йорк дахь Олон Улсын *Кришнагийн Ухамсрын нийгэмлэг*, 1967 оны дөрөвдүгээр сарын 10-14.)

Чаитанья хэмээх үг нь “амьдралын хүч” гэсэн утгатай. Амьд бодгалиуд учраас бид хөдөлж чадах ба харин ширээ чадахгүй. Учир нь түүнд амьдралын хүч үгүй юм. Хөдөлгөөн ба үйлийг амьдралын хүчний илрэл ба шинж тэмдэг хэмээн тооцож болно. Чухамдаа бол амьдралын хүчгүйгээр үйл байх боломжгүй гэж хэлж ч болох юм. Хэдийгээр амьдралын хүч нь материаллаг нөхцөл дунд оршдог ч тэрээр амрта буюу үхэлгүй биш билээ. Тиймээс мэдээжээр *чаитанья-чаритāmртаг* “үхэлгүй мөнх дэхь амьдралын хүчний ялгарах шинж” хэмээн орчуулж болно.

Гэвч энэхүү амьдралын хүч нь хэрхэн яаж үхэлгүйг илрүүлдэг юм бэ? Түүнийг хүн ч, манай материаллаг орчлон дээр орших өөр ямар нэг бүтээгдсэн амьд бодгаль үзүүлж харуулж чадахгүй бөгөөд биднээс хэн маань ч энэ бие махбодиороо үхэлгүй байж чадахгүй. Бид амьдралын хүчтэй, бид ямарваа нэг үйлийг үйлддэг бөгөөд бид мөн чанар төлөв байдлынхаа хувьд үхэлгүй ч бидний оршин буй материаллаг нөхцөл байдал нь энэхүү үхэлгүй байдлыг илрүүлэх боломжийг олгодоггүй. Катха-Упанишадад батлан өгүүлснээр, үхэлгүй байдал хийгээд амьдралын хүч нь бидэнд болон Бурханд байдаг гэжээ. Үнэхээр бид болон Бурхан нь үхэлгүй хэдий ч бидний хооронд ялгаа бий. Амьд бодгаль бид олон янзын үйлийг эрхэлдэг ч материаллаг байгаль руу унах хандлагатай байдаг. Харин Бурханд тийм хандлага үгүй юм. Бүхнийг чадагч Тэрээр хэзээ ч материаллаг байгалийн нөлөөнд ордоггүй. Түүнээс гадна материаллаг байгаль Түүний ойлгогдошгүй эрч хүчний илрэлүүдийн ердөө нэг нь л билээ.

Дэлхий дээр амьдран ахуйдаа бид тэнгэр дэхь үүлсийг харж чадах ч үүлсийн дээр гарвал бид цацран гэрэлтэх нарыг харж болно. Тэнгэрээс аварга өндөр байшин барилгууд, хот суурин өчүүхэн жижиг мэт санагдана; үүнтэй адилаар Бурханы байр сууринаас энэ материаллаг бүтээл нь өчүүхэн юм. Болзолт амьд бодгаль нь бүхий л зүйлсийг жинхэнэ байдлаар нь харж чадахуйц тэр өндөр дээрээс унах зуршилтай. Гэвч энэ хандлага Бурханд үгүй юм. Дээд Бурхан нь нар үүлэнд халхлагддаггүйгээс ч илүүтэй худал хуурмагт(мāйā) автдаггүй. Дээд Бурхан нь худал хуурмагт автдаггүй учраас Тэрээр болзолт бус. Харин бид хязгаарлагдмал амьд бодгалиуд учраас худал хуурмагт автах хандлагатай ба иймээс ч биднийг болзолт хэмээн нэрлэдэг. Имперсоналист-гүн ухаантнууд нь(мāйāvādī) амьд бодгаль ба Бурхан Өөрөө энэ материаллаг ертөнцөд ирснээр мāйāгийн нөлөөнд ордог хэмээн баталдаг. Гэвч энэ баталгаа нь амьд бодгалийн хувьд шударга үнэн байж болох ч Бурханы хувьд алдаатай үзэл юм. Учир нь материаллаг эрчим нь ямар

ч нөхцөлд Түүний хяналтан доор явагддаг. Дээд Бурханыг материйн нөлөөнд ордог хэмээн тооцогчийг Кршңа Өөрөө Бхагавад-гйтад тэнэг мунхагууд хэмээн нэрлэжээ:

аважāнанти мām мūdхā
мāнуцийm танум āшритам
парām бхāвам ажāнанти
мама бхūта-махешварам

“Тэнэгүүд Намайг хүний дүрээр морилон залрахуйд элэглэн дооглодог. Тэд Миний трансцендент мөн чанар хийгээд оршин буй бүхний захирах Дээд ноёрхлыг үл мэдэх билээ”. (Бг-9.11)

Бурхан Чаитанйа Махāпрабхуг бидний нэг хэмээн бүү тооцогтун. Тэрээр Кршңа Өөрөө бөгөөд дээд амьд оршнол юм. Иймээс Түүнийг хэзээ ч *мāйāгийн* үүл халхлан харануйлдаггүй. Кршңа, Түүний илрэлүүд, тэр ч бүү хэл Түүний хамгийн төгс төгөлдөр чин бишрэлтэнгүүд хэзээ ч худал хуурмагийн саварт өртдөггүй. Бурхан Чаитанйа нь Дэлхий дээр зөвхөн Кршңа-*бхакти* буюу Кршңаг хайрлах хайрыг номлохын тулд л заларсан юм. Өөрөөр хэлбэл Тэрээр бидэнд жинхэнэ зам мөрийг заан сургасан Кршңа Өөрөө юм. Тэр замаар замнавал бид Кршңад ойртон дөхөж чадна. Тэрээр шавь нь ямар нэг зүйлийг дутуу дулимаг хийхийг хараад харандаа авч: “Ингэж хий: А, Б, В” хэмээн зааж буй багштай адил. Эндээс харин багш өөрөө цагаан толгойг сурч байна гэсэн мунхаг дүгнэлтийг хийж болохгүй. Хэдий Тэрээр чин бишрэлтний дүрээр заларсан ч Бурхан Чаитанйа нь биднийг хэрхэн Кршңаг ухамсарлан танихыг заан сургаж буй Кршңа Өөрөө юм гэдгийг ямагт санаж байх ёстой. Чухамхүү тэгж ч харах учиртай.

Бхагавад-гйтад Бурхан Кршңа шашны дээд хууль дүрмийг:

сарва-дхармāн паритйажйā
мām экам шараṇām вража
ахам твām сарва-пāнебхйо
моқцайцийāми мā шучах

“Шашны бүх хэлбэр, зам мөрийг орхиж зүгээр л Надад өөрийгөө даатга. Би чамайг бүхий л нүгэл хилэнцийн чинь үр дагавраас ангижруулах болно. Юунаас ч бүү ай”. (Бг.18.66)

Эхлээд харахад энэ сургаал нь биелүүлэхэд хүнд мэт санагдаж болох ч бидний түүнд хандах хандлага нэг л байдаг: “Даатгах аа? Бүгдийг орхи гэнээ? Харин надад маш олон үүрэг хариуцлага бий” гэгцгээнэ. *Мāйā* буюу худал хуурмаг нь бидэнд: “Үүнийг бүү хий эс тэгвэл чи миний савраас мултрад гарчихна. Эндээ л байж бай. Харин би чамайг өшиглөж байя” хэмээн өгүүлдэг. *Мāйā* биднийг байнгад өшиглөж

байдагт эргэлзэх зүйл үгүй. Энэ нь эр илжиг үржилд орох гээд эм илжгэндээ ойртох үеэрээ өшиглүүлэхтэй адил. Үүнтэй мөн адилаар муур болон ноход ороо нь орж үржилд орох үеэрээ нэг нэгэнтэйгээ зодолдож, хазалцдаг. Тэр ч бүү хэл ширэнгэн ойд амьдардаг заануудыг тусгайлан сургасан эм зааны тусламжтайгаар урхи занганд оруулж барьж авдаг. *Майād* маш олон арга хэрэгсэл бий. Материаллаг ертөнцөд түүний хувьд эмэгтэй хүнээс илүү найдвартай гинж хүлээс үгүй юм. Мэдээжээр үнэн хэрэгтээ бид эрэгтэй ч биш, эмэгтэй ч биш ба энэ бүх тодорхойлолтууд зөвхөн бидний гадаад хувцас буюу биед хамаардаг. Эрэгтэй хүн бүр эр эмийн харьцаанд ордог. Иймээс материалаг гав гинжнээс мултран ангижрахыг хүсч тэмүүлж буй хүн нь юуны өмнө өөрийн сексийн хүслээ хазаарлан барьж сурах хэрэгтэй. Огтхон ч хориглож хязгаарлаагүй бэлгийн харьцаа нь хүнийг худал хуурмагийн боолчлолд бүрнээ барьж өгдөг. Ёс төдийгөөр, Бурхан Чаитанья Махāпрабху нь хэдий Түүний эхнэр нь арван зургаан настай, ээж нь далан настай байсан хийгээд Тэрээр гэр бүл дотроо цорын ганц эрэгтэй нь байсан ч хорин дөрвөн настайдаа энэхүү худал хуурмагаас татгалзан анигжирсан юм. Хэдий Тэрээр *брāхман* байсан, баян чинээлэг бус нэгэн байсан ч *саннийāси* болж, орчлонгоос огоорсон юм. Тийнхүү гэр бүлийн урхи торноос ангижирсан байдаг.

Хэрэв бид бүрэн дүүрэн Кршṇаг ухамсарлагч болохыг хүсвэл *майāгийн* уяа хүлээсийг тайлж хаях ёстой ба эсвэл хэрэв бид *майāтай* хамт үлдвэл бид түүний буюу худал хуурмагийн нөлөөнд орохгүй байхаар амьдрах ёстой. Гэр бүлээ заавал орхих албагүй. Учир нь Бурхан Чаитаньягийн ойрын дагуулуудын дунд олон тооны гэр бүлтэн байсан юм. Бидний огоорон татгалзах ёстой тэр зүйл бол бидний материаллаг цэнгэл жаргалд тэмүүлэх дур сонирхол. Бурхан Чаитанья хэдий гэр бүлийн хүрээнд зохистой эр эмийн харьцааг гэр бүтнүүдэд хүлээн зөвшөөрсөн ч Тэрээр огоорлын сахил хүртэгсдийн хувьд энэ асуудлаар их хатуу хандаж байв. Тэр ч байтугай залуу бүсгүйг шунал тачаалын нүдээр харснаас нь болж жижиг Харидāсыг хөөж байсан юм. Хүн тодорхой зам мөр дээр гарч, түүнээсээ гажилгүйгээр бурханлаг амьдралдаа амжилтанд хүрэхийн тулд шаардлагатай бүхий л дүрэм журам, хязгаарлалтыг дагахад мөн чанар нь оршино. Үүнд л Бурхан Чаитаньягийн үүрэг зорилго оршиж байсан агаад Тэрээр үхэлгүй мөнхийн бурханлаг амьдралд хандах боломжийг олгон бүхий л хүмүүсийг Кршṇагийн ухамсрын зам мөрд сургасан юм.

Чаитанья-чаритāmртагаас бид Чаитанья хүмүүсийг хэрхэн үхэлгүй мөнхийг олоход сургасан болохыг мэдэж болно. Иймээс ч энэ номын нэрийг “амьдралын хүчний үхэлгүй мөн чанар” хэмээн орчуулж болох юм. Амьдралын дээд хүч нь Бурханы Дээд Бодгаль юм. Тэрээр мөн дээд оршнол ч мөн. Тоогүй олон амьд оршнолууд бий бөгөөд тэд бүгд бие даан оршдог. Үүнийг хялбараар ойлгож болно: бидний өөрсдийн санаа бодол болон хүсэл өөр өөр буюу бие даасан байдаг ба Дээд Бурхан ч мөн бие даасан бодгаль юм. Гэвч энэ цаг мөчид тэрээр бусдаас ялгаатай бөгөөд Тэрээр тэдний анхдагч нь. Түүнийг даван гарах хэн ч үгүй. Бүтээгдсэн амьд оршнолууд нь нэг нь нөгөөгөө өөрийн ямар нэг чадвараараа даван гарч болох л юм. Бурхан яг амьд оршнол мэт бие даан оршдог ч тэдний хоорондох ялгаа нь гэвэл Тэрээр дээд бие даан оршигч. Түүнээс гадна Бурхан нь алдаа эндэл үл гаргадагба

Бхагавад-гитад Түүнд хандахдаа Ачйута хэмээн нэрэлсэн байдаг ба энэ нь “хэзээ ч алдаа эндэлд өртдөггүй” гэсэн утгатай. Бхагавад-гита энэ нөхцөл байдлыг учрыг тодруулан зааж байна. Учир нь Аржуна худал хуурмагийн нөлөөнд автсан байдаг бөгөөд харин Кршṇа үгүй. Бид Бурхан нь алдаа эндэл үл гаргагч гэдгийг байнгад сонсдог. Бхагавад-гитад Кршṇа өгүүлэхдээ:

нāнийām гуṇебхйāх картāрам

йадā драцтāнупашият

гуṇебхйāш ча парām ветти

мад-бхāвам со’дхигаччхати

“Чи бүхий л үйлийн цаад талд гуṇаас өөр юу ч үгүй ба Дээд Бурхан нь энэ бүх *гуṇагийн* хувьд трансцендент гэдгийг харсан цагт чи Миний бурханлаг мөн чанарыг танин ойлгож чадна”. (Бг.14.19)

Тийм байдлаар бид материаллаг эрчим нь Кршṇаг энэ материаллаг ертөнцөд залрах цагт Түүний дээр оршдог гэж бодох ёсгүй. Кршṇа ба Түүний хувилгаанууд нь материаллаг байгалийн нөлөөнд оршдоггүй. Тэд туйлаас чөлөөтэй. Үнэн хэрэгтээ Шрймад-Бхāгаватам бурханлаг мөн чанарыг шингээсэн хүнийг түүнд материаллаг байгалийн гуṇууд үл нөлөөлж буй байдлаар нь тодорхойлдог. Хэрэв бүр чин бишрэлтэн ч тийм чөлөөт байдалд хүрч чадаж байхад Бүхний Дээдийн тухай юу ч ярих билээ дээ?

Жинхэнэ бэрхшээлт асуудал нь материаллаг ертөнцөд оршин байхын зэрэгцээ материт бохирдож бузардалгүйгээр үлдэх вэ гэдэгт оршино. Үүнийг Рӯпа Госвāми тайлбарласан байдаг. Тэрээр, хэрэв бид зүгээр л Кршṇад үйлчлэн зүтгэхүйгээ өөрийн зорилгоо болговол бид материаллаг ертөнцөд оршин ахуйдаа ч түүний бохирдол бузардалд үл автаж чадна хэмээн тайлбарлажээ. Энд ухаалгаар: “Би харин хэрхэн яаж үйлчлэн зүтгэх вэ?” гэж асууж болно. Мэдээжээр энд зүгээр нэг бясалгалын тухай яриа явагдаагүй. Учир нь бясалгал гэдэг бол ердөө ухааны үйл юм. Харин практик үйл биш. Кршṇад үйлчлэн зүтгэх хайранд зөвхөн Кршṇагийн тулд ямар нэг зүйлийг хийж байж гэмээнэ хүрч чадна. Тийм үйлэнд боломжтой бүх үйл хамаарах ёстой. Юу ч байсан, бид юуг ч эзэмшдэг байсан бүгдийг Кршṇагийн тулд ашиглах ёстой. Бид бүх зүйлийг ашиглаж болно: хэвлэх төхөөрөмж, автомашин, нисэх онгоц, пуужин гэх мэт хэрэгтэй бүхнийг. Хэрэв бид тэр ч байтугай зүгээр л хүмүүст Кршṇагийн ухамсрын тухай яривал энэ нь аль хэдийнээ үйлчлэн зүтгэл болж байгаа юм. Хэрэв бид ухаан, мэдрэхүй, хэл яриа, мөнгө, эрч хүчээ тийм байдлаар Кршṇагийн тулд ашиглавал материаллаг байгальд оршин буйдаа бид сэтгэл түгших хэрэггүй. Бурханлаг ухамсрын тумламжтайгаар буюу Кршṇагийн ухамсрын тусламжтайгаар бид материаллаг байгалийн түвшнээс дээш

өгсөн гарч чадна. Хэдий мөхөсхөн мэдлэгтэй хүмүүс үүнийг ойлгон ухамсарлаж чадахгүй ч Кршңа ба Түүний илрэлүүд, Түүний чин бишрэлтэн нар өөрөөр хэлбэл Түүний тулд ажиллаж буй хүмүүс нь материаллаг байгальтай ямар ч холбоо харьцаагүй байдаг.

Чайтанья-чаритāmрта, бурханлаг сүнс нь үхэшгүй мөнх, бурханлаг ертөнц дахь бидний үйл мөн үхэшгүй гэдгийг заан сургадаг. Туйл буюу Үнэмэлэхүй нь бодгаль бус, хэлбэр үгүй хэмээх үзлийг баримтлагч *майāvādī* нар нь өөрийгөө танин ухамсарласан сүнснүүд нь ярих шаардлага байхгүй хэмээн зарлан тунхагладаг. Гэвч Кршңагийн чин бишрэлтэн, *ваишңавууд* нь хүн зөвхөн өөрийгөө танин ухамсарлахуйн түвшинд хүрмэгц жинхэнээрээ ярьж эхэлдэг хэмээн баталдаг. “Үүнээс өмнө бид ердөө ямар ч хэрэгцээгүй зүйлийг чалчдаг байжээ. – хэмээн *ваишңавууд* нь өгүүлээд, -Харин одоо жинхэнээрээ ярьж эхэлье, Кршңагийн тухай ярья” гэдэг. Мөн *майāvādī* нар нь усны ваар савны тухайг иш татах их дуртай.

Вааранд ус үгүй болохоор тэрээр авиа гаргадаг гээд гэвч усаар дүүргэмэгц дуугарахаа больдог хэмээн өгүүлдэг. Гэвч бид ваар сав гэж үү? Биднийг түүнтэй хэрхэн адилтгаж болох билээ? Сайн зүйрлэлд харьцуулж буй хоёр зүйлийн хооронд ерөнхийдөө нийцэх зүйл их байж гэмээнэ ашиглаж болдог. Ваар нь биднээс ялгаатай нь амьдралын хүчний үйл үгүй. Устай ваар хангалттай дуугүй бясалгал үйлддэг байж болох ч бидэн шиг биш. Үнэн хэрэгтээ, хүн Кршңагийн тухай ярих ярих ёстойгоо ухамсарламагц түүнд хоногийн хорин дөрвөн цаг ч хангалттай бус байдаг. Эдгээр тэнэг амьтсыг амаа хамхиастай тэр цаг мөчид нь л магтан сайшааж болох юм. Гэвч дуугүй байдлаа орхимогц түүний эрдэм мэдлэг дутуу дулимаг болох нь бүгдэд тодорхой болдог. *Чайтанья-чаритāmрта*, Бүхний Дээдийг алдаршуулах үед хэдий хэмжээний гайхамшигтай зүйлсийг олж илрүүлж болохыг бидэнд нээн харуулж өгдөг.

Чайтанья-чаритāmртагийн эхэнд Кршңадās Кāвиража Госвāmй: “Би вээр өөрийн хүндэтгэл мөргөлийг номын багш нар танаа өргөмүү” хэмээн бичжээ. Тэрээр багш шавийн барилдлагыг заан олон тоог ашигласан байна. Тэрээр гүн хүндэтгэлтэйгээр өөрийн номын багшийн өмнө төдийгүй Бурхан Кршңагаас Өөрөөс нь эхлэлтэй бүх багш шавийн хэлхээ буюу *парампарагийн* өмнө мөргөн залбирч байна. Тийнхүү тэрээр бүх *ваишңавуудад* өөрийн асар их хүндэтгэлээ илэрхийлэхийн тулд олон тоон дээр *гуруд* ханджээ. Багш шавийн хэлхээнд хүндэтгэлээ илэрхийлээд зохиогч бусад бүх чин бишрэлтний өмнө, өөрийн номын ахан дүүс, Бурханы илрэлүүд, Кршңагийн эрч хүчний анхдагч илрэл бүхний өмнө мөргөн залбирсан байна. Бурхан Чайтанья Махāпрабху(заримдаа Түүнийг Кршңа Чайтанья ч гэдэг) энэ бүгдийн бэлэгдэл: Тэрээр Бурхан, *гуру*, чин бишрэлтэн, Бурханы илрэлүүд. Өөрийн дагалдагч дүрд буюу Нитйāнандын дүрд Тэрээр эрч хүчний анхдагч илрэл болсон; Адваитын дүрээр Бурханы хувилгааны илрэл болсон; Гадāдхарын дүрээр дотоод эрч хүчний илрэл болсон; Шрйвāсын дүрээр Тэрээр хязгаарлагдмал амьд оршнол дүрийн илрэл болсон. Тийнхүү Кршңаг цор

ганцаар оршигч хэмээн бодох хэрэггүй ба Түүнийг Рāmāнужāчāрийагийн өгүүлсэнчлэн Өөрийн илрэлүүдийн хамтаар мөнхөд оршдог хэмээн тооцох хэрэгтэй. Вишицтāдвaйтын гүн ухаанаар бол Бурханы эрч хүч ба Түүний илрэлүүд, хувилгаануудыг олон янз зүйлсийн нэгдэл хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл Бурхан бол энэ бүх оршнолоос тусдаа оршдог зүйл биш; энэ бүгдийг хамтад нь авсныг Бурхан гэдэг.

Чухамдаа, *Чаитанйа-чаритāмрта* нь эхлэгч нарт зориулагдаагүй. Учир нь тэрээр бурханлаг мэдлэгийн дээд шат юм. Ном ёсоороо бол хүн *Бхагавад-гйтагаас* эхлээд, дараа нь *Шрймад-Бхāгаватамыг* судлаад дараа нь *Чаитанйа-чаритāмртаг* уншин судлах хэрэгтэй. Хэдий энэ бүх ариун судар бичээсүүд нэгэн адил туйлын түвшинд оршдог ч харьцуулан судлах зорилгын тухайд *Чаитанйа-чаритāмрта* хамгийн өндөр байр сууринд оршдог. Бурхан Чаитанйа ба Нитйāнанда нарыг нар болон сартай зүйрлэдэг. Учир нь Тэд энэ материаллаг ертөнцийн харанхуйг сарниасан билээ. Бидний тохиолдолд нар болон сар нь нэгэн зэрэг гарсан юм. Ийм учраас Бурхан Чаитанйа ба Нитйāнанда нарын өмнө нэгэн зэрэг гүн хүндэтгэлтэйгээр мөргөн залбирах хэрэгтэй.

Барууны орнуудад Бурхан Чаитанйагийн алдар гавъяаны талаар харьцангуй тодорхой бус ба “Энэ Кршңа Чаитанйа гэж хэн бэ?” гэж асууж болох юм. Ариун Ном судрууд энэ асуултанд Тэрээр Бурханы Дээд Бодгаль гэж батлан хариу өгч байна. Ялангуяа Упаницадад Бурханы Дээд Бодгалийг бодгаль бус хэмээн өгүүлсэн байдаг ч Туйлын Үнэний бодгаль хэлбэр байдлыг дурдсан байдаг Йшопаницадад бүгдэд нэвчигч байдлынх нь тухай өгүүлсний дараагаар бид дараахь шүлгийг олж болно:

хираңмайена пāтрена

сатйасйāпихитам мукхам

тат твам пўщанн апāврну

сатйа-дхармāйа дрцтāйе

“Ай бүхий л амьд оршнолуудыг тэжээн тэтгэгч Бурхан минь ээ, Таны үнэн дүр төрх нүд гялбам туяанд тань нуугднам бүлгээ. Өршөөн энэрч, энэ бүрхүүлээ авч, Өөрийн цэвэр чин бишрэлтэндээ Өөрийгөө илрүүлэн харуулаач”(Шрй Йшопаницад, Мантра 15)

Имперсоналистууд нь Бурханы цацраг туяаны хил хязгаарыг даван даран гарч энэ цацраг туяа үүсэн гарч буй тэр бодгальд ойртон дөхөх боломж үгүй байдаг. Гэвч Йшопаницадын төгсгөлд Бурханы Дээд Бодгалийг магтан алдаршуулсан дуулал бий. Энэ нь бодгаль бус Брахманыг тэр чигт нь үгүйсгэж буй хэрэг биш. Гэхдээ харин энэхүү Брахманыг Чаитанйагийн биеийн нүд гялбам цацраг туяа хэмээн өгүүлжээ. Өөрөөр хэлбэл, Кршңа Чаитанйа нь бодгаль бус Брахманы үндэс

юм. Бхагавад-гитад Кршṇа түүнчлэн бодгаль бус Брахман нь Түүнд оршдог хэмээн баталжээ(брахмаṇо хи пратицṭхāхам, Бг. 14.27) Амьд бодгаль болгоны зүрхэнд мөн орчлонгийн атом бүрд оршдог Парамāтмā буюу Дээд Сүнс нь Чаитанягийн ердөө хэсэгхэн илрэл нь юм. Ийм учраас Кршṇа Чаитаня нь Брахманы үндэс хийгээд Бурханы Дээд Бодгаль юм. Бүхний Дээд Тэрээр зургаан давуу чанарыг шингээсэн байдаг: эд баялаг, алдар нэр, хүч чадал, гоо сайхан, эрдэм мэдлэг, огоорол. Товчхон хэлвэл, бид Тэр бол Кршṇа, Бурхан ба Түүнтэй эн тэнцүү хийгээд Түүнийг даван гарах хэн ч үгүй гэдгийг мэдэж байх ёстой. Танин ойлгож болох илүү өндөр түвшний зүйл үгүй. Тэрээр Дээд Бодгаль юм.

Бурхан Чаитаня онцгойлон итгэж, түүнийг арав гаран хоногийн туршид сурган номлосон чин бишрэлтэн Рӯпа Госвāmī бичсэн нь:

намо махā-вадāнийāйа кришṇа-према-прадāйа те

кришṇāйа кришṇа-чаитаня-нāmне гаура-твице намах

“Би вээр бусад бүх аватār буюу Бурханы хувилгаад, бүр Кршṇагаас Өөрөөс нь ч илүү өгөөмөр Дээд Бурхан Чаитанягийн өмнө гүн хүндэтгэлтэйгээр мөргөн залбирмуу. Учир нь Тэрээр Түүнээс өмнө хэн ч, хэзээ ч өгч байгаагүй Кршṇаг хайрлах цэвэр ариун хайрыг түгээнэм бүлгээ”.

Чаитаня урт удаан, нухацтайгаар бодож боловсруулсан Бурханыг танин ухамсарлах зам мөрд сургадаг хэмээн буруугаар дүгнэдэг байсан. Тэр зам мөр нь бүрэн дүүрэн бурханлаг ба хүн Кршṇад өөрийгөө даатгасан тэр мөчөөс эхлэдэг. Тэр нь карма-йог, жнāна-йог, хатṭха-йогийн замаар явдаггүй ба харин хүн өөрийн бүх материаллаг уягдал татагдлаа бүрэн орхин, материаллаг ахуй төгссөн тэр цаг мөчөөс эхлэдэг. Бхагавад-гитад Кршṇа өөрийн сургаалаа сүнс ба материйн хоорондох ялгааг өгүүлэхээс эхлэсэн ба арваннаймдугаар бүлэгт сүнс нь хэлбэрэлт гуйвалтгүйгээр Түүнд өөрийгөө даатгадаг хэмээн төгсдөг. Майāvādī нар энэ хэсэгт өөрсдийн бүх хэл яриагаа зогсоодог ч үнэн хэрэгтээ яг энэ хэсгээс жинхэнэ яриа хөөрөө эхлэдэг. атхāто брахма-жижнāсā буюу “Одоо Туйлын Үнэний тухай асуултаа тавьж эхлэе” хэмээх үгнээс Ведāнта-сӯтра эхлэдэг. Иймээс Рӯпа Госвāmī Бурхан Чаитаняг хамгийн өгөөмөр сэтгэлт Бурханы хувилгаан гэж магтаал өргөж байа. Учир нь Тэрээр чин бишрэл зүтгэлийн дээд хэлбэрийг заан өгч, аугаа өгөөмөр бэлгийг тараан түгээж байсан юм. Өөрөөр хэлбэл Тэрээр хүний асууж болох хамгийн чухал асуултын хариуг өгсөн.

Чин бишрэл зүтгэл ба Бурханыг танин ухамсарлахуйн янз бүрийн үе шатууд бий. Хатуухан хэлбэл Бурханы оршин буйг хүлээн зөвшөөрдөг хүн бүр аль хэдийнээ чин бишрэл зүтгэлийг үйлдэж буй юм. Бурханы аугааг хүлээн зөвшөөрөх нь байдаг л нэг зүйл ч тийм их биш. Аугаа номын багш буюу āчāрия байдлаар номлогч Чаитаня нь бид Бурхантай харьцаанд орж болох ба үнэндээ Бурханы найз

ч болж болох тухай сурган номлосон юм. *Бхагавад-гитад* Кршṇа Аржунад Өөрийн орчлонгийн дүр хэлбэрийг харуулсан ба учир нь Аржуна Түүний “маш дотнын найз” байв. Гэвч үнэн хэрэгтээ Кршṇагийн орчлонгийн дүр хэлбэрийг хараад Аржуна найз нөхрийн харьцаатай байхыг өөртөө зөвшөөрсөн өөрийн төрөлсүү занг уучлан хэлтрүүлэхийг Кршṇагаас гуйн залбирдаг. Чаитанья үүнээс ч цааш явж байна. Бурхан Чаитаньягийн тусламжтайгаар бид Кршṇагийн найз нөхөд болж болох ба энэ нөхөрлөлд хязгаар үгүй. Бид Түүнд хандан хүндэтгэл бишрэлийн айдас, хүндлэлгүй хэдий ч бүрэн эрх чөлөөг мэдрэн Кршṇагийн найзууд болж болно. Бид мөн тэр ч бүү хэл Бурханд эцэг хүн өөрийн хүүдээ хандаж буй байдлаар хандаж болно. Энэ гүн ухаан нь зөвхөн *Чаитанья-чаритāmрта* төдийгүй *Шрīмад-Бхāгаватамд* ч өгүүлэгдсэн буй. Ертөнц дахинаа Бурханд хандахдаа Түүний чин бишрэлтэнгийн хүү хэлбэрээр ханддаг нэг ч зохиол бүтээл үгүй. Ихэвчлэн Бурханыг хүүгийнхээ бүхий шаардлагыг биелүүлдэг бүхнийг чадагч Эцэг байдлаар хардаг. Гэвч аугаа чин бишрэлтнүүд нь өөрсдийн Бурханд үйлчлэх бишрэл зүтгэлийг үйлдэх үедээ заримдаа Бурханд яг өөрийн хүүд хандаж буй мэтээр хандаж харьцдаг. Хүү шаардаш харин эцэг түүнийг нь биелүүлдэг; Кршṇагийн хүслийг биелүүлснээр чин бишрэлтэн заримдаа Түүний эцэг нь болдог. Бурханаас ямар нэг зүйлийг авахын оронд бид Бурханд өгдөг. Түүнтэй тийм харьцаанд оршин ахуйд Кршṇагийн ээж Йашодā Бурханд хандаж: “Алив үүнийг ид, тэгэхгүй бол Чи өлсөж үхнэ. Сайн идээрэй” гэдэг байв. Энэ утгаараа хэдий Түүнд бүх зүйлс харьяалагддаг ч Кршṇа нь Өөрийн чин бишрэлтний өршөөл адислалаас хамааралтай болчихож байна. Энэ бол өөрийн төрөл байдлын хувьд цорын ганц, хамгийн өндөр түвшний нөхөрлөл ба энэ нөхөрлөлд чин бишрэлтэн өөрийгөө Кршṇагийн эцэг хэмээн үнэхээр тооцдог.

Гэвч Бурхан Чаитаньягийн аугаа адислал нь гэвэл Кршṇад өөрийн амраг хайрт байдлаар хандаж болно гэсэн сургаал нь юм. Энэ харьцааны хувьд Бурхан Өөрийн чин бишрэлтэнд нэн хайртай бөгөөд тэр ч байтугай Түүнд хайрыг нь эргүүлэн барьж үл чадахаа илэрхийлдэг. Кршṇа *Врндāваны* малчин бүсгүйчүүд буюу *гопī* нарт тэднийг хайрынх нь төлөөнөө шагнаж урамшуулж чадахгүй болохоо мэдэрч байв. “Би та нарын хайрыг төлж чадахгүй, - хэмээн Тэрээр тэдэнд өгүүлээд, - Би түүний чинь хариуд юу ч өгч чадахгүй” гэжээ. Ингэж чин бишрэл зүтгэл нь төгс төгөлдрийн дээд тавцан дээр үйлдэгддэг ба чин бишрэлтэн ба Кршṇагийн хоорондох холбоо харьцааны тухай мэдлэг нь хоёр хайр сэтгэлтэй хүмүүсийн харьцаа мэтээр Чаитанья Махāпрабху бидэнд хайрлан хүртээсэн юм. Урьд өмнөх ямар ч илрэл болон *āчāрийа* түүнийг хайрлан хүртээж байгаагүй юм. Иймээс Рūпа Госвāmī Чаитаньягийн тухай: “Чин бишрэл зүтгэл нь өөрөө өөрөө үйлийн дээд тавцан бөгөөд аугаа тавцан юм. Үүнийг Та л авч ирсэн билээ. Та бол арьс тань шаргал өнгөтэй Кршṇа ба Шачй ээжийн хүү Шачйнандана юм. *Чаитанья-чаритāmртаг* сонсогч нь Таныг өөрийн зүрхэндээ хадгалах болно. Тийнхүү Танаар

дамжуулан Кршнаг хялбархан танин ойлгож болно” хэмээн бичжээ. Тийнхүү Чаитанья Махāпрабху нь хүмүүст Кршнаг өгөхөөр ирсэн юм. Тэрээр Түүнийг бясалгал, кармын үйл, ариун Судар бичээсийг судлаж таних биш харин Түүний арга нь хайр байв.

Бид “Бурханыг хайрлах хайр” хэмээх үгийг байнгад сонсдог. Хэдий хир гүн гүнзгийгээр энэ хайрыг үнэн хэрэгтээ хөгжүүлж болохыг *вишнуизмын* гүн ухаанаас танин мэдэж болно. Бурханыг хайрлах хайрын тухай онолын мэдлэгийг олон ард түмний ариун Судар номуудаас олж авч болох ч *ваишнаватуудын* ном бүтээлүүдээс харин чухамдаа Бурханыг хайрлах хайр гэж юу болох түүнийг өөртөө хэрхэн хөгжүүлж болохыг олж чадна. Чаитанья Махāпрабху нь Бурханыг хайрлах хайрыг хөгжүүлэх эгнэшгүй аугаа түвшнийг хайрлан хүртээсэн билээ.

Тэр ч байтугай энэ материаллаг ертөнцөд бид бага зэрэг хайрын мэдрэмжийг амсаж болно. Яагаад энэ нь боломжтой гэж ? Бурханд байдаг хайрын ачаар. Бидний болзолт амьдралдаа амсаж буй бүхэн бүхий л зүйлсийн анхдагч шалтгаан Дээд Бурханд буй юм. Дээд Бурхантай холбоотой бидний анхдагч харьцаа хайраар дүүрэн ба энэ хайр нь гажуудсан хэлбэрээр материаллаг нөхцөл байдалд тусдаг. Бидний жинхэнэ хайр байнгад оршдог төгсгөл үгүй ч материаллаг ертөнцөд энэ хайр нь гажуудсан хэлбэрээр тусдаг болохоор тэрээр байнгын бус бөгөөд бидэнд согтоон мансууруулах нөлөөг үзүүлдэг. Хэрэв бид жинхэнэ трансцендент хайрыг олж авахыг хүсч буй бол бид өөрсдийн хайраа бүхий л хайрын дээд объект Бурханы Дээд Бодгаль руу шилжүүлэх ёстой. Үүнд Кршнагийн ухамсрын үндсэн зарчим нь оршдог.

Материаллаг ухамсарт бид хайрлахад огтхон ч үл тохирохуйц тийм зүйлийг хайрлахаар чармайдаг. Бид үхэх агшиндаа тэдний тухай бодож, тэгснээр муур, нохойн гэр бүлд төрөх аз сорисон үйлдлийг хийн өөрсдийн хайрыг муур, нохойд хандуулдаг. Ийнхүү хайрын объект нь Кршна бус харин уруугаа хөтлөгддөг.

Кршна буюу Бурхан нь ямар манантсан тодорхой бус зүйл биш мөн зөвхөн сонгогдсон хэдхэн хүн л хүрч болох тийм зүйл гэдэг нь худал үг. Нутаг орон бүрд, ариун судар Ном бүрд Бурханыг хайрлахын тодорхой нэг хандлага байдаг тухай Чаитанья Махāпрабху бидэнд мэдээлж байна. Гэвч харамсалтай нь Бурханы хайрлах гэж чухамдаа юу болохыг хэн ч мэддэггүй. Ведийн судар бичсээс нь хүнийг Бурханыг хайрлах хайранд хөтөлдөг жинхэнэ мөрт хандуулж чаддагаараа ялгагддаг. Өөр бусад Судар бичсээсүүд нь Бурханыг хэрхэн хайрлах тухай ямар ч мэдээлэл өгдөггүй; тэнд мөн Бурхан гэж юу болох, хэн болох тухай өгүүлээгүй байдаг. Тэд Бурханыг хайрлах хайрыг хэлбэр төдий өгүүлэвч хэрхэн үүнийг гүйцэлдүүлэх ойлголт байдаггүй. Гэвч Чаитанья Махāпрабху амраг хайрын харьцаан дахь Бурханыг хайрлах хайр гэж юу болохыг практик дээр харуулсан юм. Рādхārāñийн дүрийг Өөртөө аваад Чаитанья нь Рādхārāñийн Кршнаг хайрлаж байсан шигээр Түүнийг хайрлаж байв. Кршна цаг үргэлж Рādхārāñийн хайрыг гайхан шагшиж байсан юм. “Рādхārāñийн хэрхэн яаж Надад ийм цэнгэл жаргалыг авч ирж байнаа?”-хэмээн Тэрээр асуудаг байлаа. Рādхārāñийг танин ойлгохын тулд

Кршңа Түүний дүр ролийг Өөр дээрээ авч Өөрөө Өөрийгөө ойлгохыг оролдсон юм. Үүнд л Бурхан Чаитанягийн хувиан заларсны нууц оршино. Ийм учраас Түүнд: “Би вээр Радхараңийн бодол санаанд бүрнээ автсан Дээд Бурхан Таны өмнө гүнээ хүндэтгэн мөргөмүү” хэмээх үгээр хандан мөргөдөг.

Энэ нь Радхараңий гэж хэн болох, Радха- Кршңа гэж юу болохыг асуултыг үүсгэдэг. Чухамдаа бол Радха- Кршңа нар нь хайрын харьцаа юм. Энэ бол жирийн нэг хайр биш; Кршңа хэмжиж тоолшгүй эрч хүчнийг агуулдаг бөгөөд тэдгээрийг дотоод, гадаад, завсрын хэмээн гурав ангилж болно. Дотоод эрч хүчнийг мөн гурав ангилдаг: *самвит*, *хлāдинī*, *сандхинī*. *Хлāдинī* эрч хүч нь цэнгэл жаргалын эрч хүч юм. Бүхий л амьд амьтас нь цэнгэл жаргалыг тэсч ядан хүсэх энэ эрч хүчийг шингээсэн байдаг. Тиймээс тэд бүгд цэнгэн жаргахаар чармайдаг. Энэ бол амьд оршнолын гүн гүнзгийн мөн чанар юм. Одоо цаг үед бид энэхүү материаллаг тойрон хүрээлэл дунд бие махбодийнхоо туслалцаатайгаар цэнгэл жаргалынхаа эрч хүчээр цэнгэл эдлэхийг оролдож буй билээ. Мэдрэхүйн материаллаг объектуудтай бие махбодиороо хүрэлцэн бид тэднээс цэнгэл жаргалыг олж авахыг ихэд чармайн байдаг. Гэвч үргэлжид бурханлаг байх Кршңа нь бидний адил материаллаг түвшинд цэнгэл жаргалыг олохыг чармайдаг хэмээн бүү бодогтун. Кршңа материаллаг орчлонг бүх зүйлс нь цаг зуурын бөгөөд зовлонгоор дүүрэн хэмээн өгүүлжээ. Үүнийг хэлснийхээ дараагаар Тэрээр материаллаг хэлбэртэйгээр цэнгэл жаргалыг хайна гэж үү? Тэр бол Дээд Сүнс ба Түүний цэнгэл жаргал нь цэнгэл жаргалын материаллаг төсөөллийн гадна оршдог.

Кршңагийн цэнгэл жаргалыг хэрхэн яаж олж авдгийг ойлгохын тулд бид Шрїмад-Бхагаватамын Аравдугаар Дууллыг унших ёстой. Түүнд Кршңагийн цэнгэлийн эрч хүч нь Радхараңий ба *Вражийн* малчин бүсгүйчүүдтэй наадан тоглосон тоглоом наадмаар илэрдэг. Харамсалтай нь мөхөсхөн ухаант хүмүүс нь *Дашама-скандха* буюу Аравадугаар Дуулалд өгүүлсэн Кршңагийн зугаа цэнгэлд шууд ханддаг. Жирийн хүмүүс нь мэдээжээр Кршңагийн малчин бүсгүйчүүдтэй хийсэн *раса*-бүжиг болон Радхараңийтай харилцан тэврэлцлийг ойлгодоггүй. Учир нь тэд энэ тоглоом наадмыг дэлхийн шунал тачаалын нүдээр хардаг. Тэд Кршңаг тэдэнтэй адил, Тэрээр гопī нарыг жирийн нэг эр залуухан бүсгүйг тэвэрч буй мэтээр бодож төөрөлддөг. Зарим хүмүүст энэ нь Кршңад татагдах нэг шалтгаан болдог. Учир гэвэл тэд Түүний шашин эр эмийн харьцааны эрээ цээргүй байдлыг зөвшөөрдөг хэмээн бодно. Гэвч энэ бол Кршңа-бхакти буюу Бурханыг хайрлах хайр биш, харин *пракṛта-сахажийā*-материаллаг шунал тачаал юм.

Ийм мэт алдаа эндэгдлээс зайлсхийхийн тулд бид үнэн хэрэгтээ Радха- Кршңа гэж юу болохыг ойлгох ётой. Радха ба Кршңа нь Өөрийн тоглоом наадмаа Кршңагийн дотоод эрч хүчний туслалцаатайгаар илрүүлдэг. Кршңагийн дотоод эрчмийн цэнгэл жаргалын далд хүч нь ойлгоход хамгийн бэрхшээлтэй зүйл ба хүн

Кршңа гэж чухам хэн болохыг ойлгох хүртлээ түүнийг ойлгож чадахгүй. Кршңа нь энэ материаллаг ертөнцөд ямар ч цэнгэл жаргалыг амсдаггүй ч Тэрээр цэнгэл жаргалын далд хүчийг өөртөө шингээсэн байдаг. Бид бүгд Кршңагийн бүрдүүлэгч хэсгүүд учраас бидэнд мөн цэнгэл жаргалын далд хүч бий юм. Гэвч бид цэнгэлийн энэхүү далд хүчээ материт илрүүлэхээр чармайдаг. Гэвч Кршңа хэзээ ч азгүй оролдлого дахь эдгээр дүүрсэн амьтдыг хүлээн авдаггүй. Кршңагийн цэнгэл жаргалын далд хүчний объект нь Радхāрāñй ба Тэрээр Өөрийн далд хүч буюу Өөрийн эрч хүчээ Радхāрāñй хэлбэрээр илрүүлдэг ба харин дараа нь Түүнтэй хайрын харьцааг өрнүүлдэг. Өөрөөр хэлбэл Кршңа гадаад эрч хүчнээс цэнгэл жаргалыг амсдаггүй боловч Өөрийн дотоод эрч хүч буюу Өөрийн далд хүчээ Радхāрāñй хэлбэрээр илрүүлдэг. Тийнхүү Тэрээр Өөрийн цэнгэл жаргалын дотоод далд хүчийг илрүүлэхийн тулд Радхāрāñй дүрээр Өөрийгөө илрүүлжээ. Бурханы тооны илрэлүүд, хувилгаад, түгэлтүүдээс цэнгэл жаргалын энэ далд хүч нь нэгдүгээрт орших нь ба хамгийн чухал нь юм.

Радхāрāñйг Кршңагаас тусад нь тооцох хэрэггүй. Радхāрāñй нь мөн л Кршңа юм. Яагаад гэвэл эрч хүч болон эрч хүчний эх үүсвэр хоёрын хооронд ялгаа үгүй. Эрч хүчгүйгээр эрч хүчний эх үүсвэр нь утга үгүй юм. Харин эх үүсвэр үгүй бол эрч хүч үгүй билээ. Үүнтэй адилаар Радхāгүйгээр Кршңа утга учиргүй ба Кршңагүйгээр Радхā утга учраа алдана. Ийм учраас вицңуизмын гүн ухаан нь юуны өмнө Дээд Бурханы цэнгэлийн дотоод эрч хүчинд мөргөдөг ба хүндэтгэлээ илэрхийлдэг. Ингэж Бурхан ба Түүний далд хүчний тухайд Радхā- Кршңагийн тухай яриа явагддаг. Үүнтэй адилаар Нāрāйаңад мөргөж буй хүн нь эхлээд Лакцмийн нэрийг дууддаг - Лакцмй-Нāрāйаңа. Харин Рāмад мөргөгч хүн нь эхлээд Сйтагийн нэрийг хэлдэг. Аль ч тохиолдолд Сйта-Рāма, Радхā- Кршңа, Лакцмй-Нāрāйаңагийн алинд нь ч цэнгэл жаргалын далд хүч нь үргэлж эхэнд нь байна.

Радхā ба Кршңа нь нэг бүхэл бүтэн ба Кршңад цэнгэл эдлэх хүсэл төрөхөд Тэрээр Өөрийгөө Радхāрāñй хэлбэрээр илрүүлдэг. Радхā ба Кршңагийн хоорондох бурханлаг хайр сэтгэлийн харьцаа нь Кршңагийн цэнгэл жаргалын дотоод далд хүчний жинхэнэ илрэл юм. Хэдий бид “Кршңа хүсэхэд” хэмээн ярьж буй боловч Тэр хэзээ хүсдгийг нарийн тодорхой хэлж бид чадахгүй. Бид болзолт амьдралд бүх зүйлс эхлэлтэй учраас чингэж ярьж буй юм; гэвч туйлын буюу бурханлаг амьдралд эхлэл ч төгсгөл ч байдаггүй. Радхā ба Кршңа Өөрсдөө нэг бүхэл нэгдмэл ч мөн энэ үедээ Тэд хуваагддаг гэдгийг ойлгохын тулд бидний ухаанд аяндаа “хэзээ” хэмээх асуулт үүсдэг. Кршңа Өөрийн цэнгэл жаргалын далд хүчээр цэнгэхийг хүсэхэд Тэрээр Өөрийгөө Радхāрāñйгийн тусгай дүрээр илрүүлдэг. Харин Өөрийгөө

Радхын тусламжтайгаар танин ойгохыг хүсэх үедээ Тэрээр Радхараңитай нэгддэг ба энэ нэгдлийг Бурхан Чаитанья хэмээн нэрлэдэг.

Яагаад Кршна Чаитанья Махпрабхугийн дүрд хувилан буусан юм бэ? Үүнийг Кршна нь Радхын хайрын аугаа байдлыг танин мэдэхийг хүссэн гэж тайлбарлаж болно. “Яагаад Тэрээр Намайг тэгж ихээр хайрлана вэ? хэмээн Тэрээр Өөрөөсөө асуусан ба, - Түүнийг Над руу татах тийм ихээр онцгой юм юу байна?” . Кршна буюу Дээд Бурханыг ямар нэг хайр соронздон татдаг гэхээр хачин жигтэй санагдаж болох юм. Бид эрэгтэй эсвэл эмэгтэй хүний хайрыг хайж байдаг. Учир нь бид төгс төгөлдөр бус бөгөөд бидэнд ямар нэг зүйл дутагдаад байдаг. Эмэгтэй хүний хайр буюу энэ далд хүч, энэ цэнгэл нь эрэгтэйд дутдаг. Тийм учраас эрэгтэй хүн эмэгтэй хүнийг хүсдэг ч үүнийг Өөрөө Өөртөө төгс төгөлдөр байдаг Кршна дээр хэлж болохгүй юм. Иймээс Кршна: “Яагаад Надад Радхараңй тэгж ихээр татагдана вэ? Радхараңй Миний хайрыг мэдрэх үедээ чухамдаа юуг амталдаг юм бол?” хэмээн гайхдаг. Энэхүү хайр сэтгэлийн харьцааг амтлахын тулд Кршна тэнгисийн мандал дээгүүр мандан гарч буй Сар мэтээр илрэн гарч ирдэг. Тэнгисийн усыг хөөсрүүлэн бүлснээс Сар гарч ирдэг шиг Чаитанья Махпрабху хэмээх саран бурханлаг хайрын хутгалт дундаас үүсэн гарч ирсэн юм. Үнэндээ Чаитаньягийн арьс ньалтлаг өнгөтэй ба яг л сарны гэрлийг санагдуулдаг. Хэдий энэ нь зүйрлэлийн хэллэг ч гэсэн энд Чаитанья Махпрабхугийн залран ирэлтийн утга учрыг дамжуулж байна. Түүний илрэл залралын бүхий л шалтгааныг дараагийн бүлэгт тайлбарлах болно.

Чаитанья-чаритамртад мөн Бүхний Дээдийн янз бүрийн илрэлүүдийн тухай тайлбарладаг. Бурхан Чаитаньяд хүндэтгэлээ илэрхийлээд Кршнадас Кавиража дараа нь Нитянандад бишрэл хүндэтгэлээ илэрхийлсэн байдаг. Тэрээр Нитянанда нь Мах-Вишнугийн үндэс Сайкаршаны илрэл хэмээн тайлбарлажээ. Кршнагийн анхдагч илрэл нь Баларама ба дараа нь Сайкарша явах ба Сайкаршаны дараа Тэрээр Прадйумна байдлаар илэрдэг. Ингэж асар олон илрэл экспансууд үүсдэг. Хэдий олон тооны илрэлүүд оршдог ч *Брахма-самхитад* өгүүлсэнчлэн, Бурхан Кршна нь тэд бүгдийн үндэс юм. Тэрээр түүнээс олон мянга, олон сая өөр бусад лааг асааж болох анхдагч лаатай адил юм. Түүнээс ямар ч тооны лааг асааж болох ч анхдагч лаа нь тэд бүгдийн үндэс хэмээх байр сууриа хадгалж үлддэг. Ийнхүү Кршна асар олон тооны галын эхлэлийг хайрлаж Өөрийгөө тархаан түгээдэг ба энэ бүх илрэлүүдийг Вишну-таттва хэмээн нэрлэдэг. Вишну нь асар том гал ба харин бид өчүүхэн жижиг гаанцууд ч бид бүгдээрээ Кршнагийн илрэлүүд юм.

Материаллаг орчлонг бүтээх шаардлага гармагц Вишну нь Мах- Вишнуд эхлэлийг өгдөг. Мах- Вишну нь Учир Шалтгааны далай дээр хэвтэн тухлах агаад хамраасаа орчлонгуудыг гаргаж байдаг. Тийнхүү Мах- Вишну ба Учир

Шалтгааны далайгаас орчлонгууд үүсдэг ба эдгээр орчлонгууд нь Учир Шалтгааны далайн мандал дээр хөвөн байдаг ажээ. Үүнтэй холбогдуулан Вāманы тухай хууч түүх байдаг. Тэрээр гурав алхаад орчлонгийн бүрхүүлийг өлмийгөөрөө цоолжээ. Түүний өлмийгөөрөө цоолсон нүхээр Учир Шалтгааны далайн ус урсан цутгадаг ба энэ цутгалан нь Ганга мөрөн болсон хэмээн ярьдаг. Ийм учраас Ганга нь Вицнугийн хамгийн ариун ус хэмээн тооцдог ба Гималайгаас Бенгалийн булан хүртэл бүх энэтхэгчүүд түүнд мөргөн залбирдаг.

Учир Шалтгааны далай дээр хэвтэн байдаг энэхүү Махā- Вицну нь үнэн хэрэгтээ Кршṇагийн анхдагч илрэл Баларāмын илрэл юм. Харе Кршṇа, Харе Кршṇа, Кршṇа Кршṇа, Харе Харе, Харе Рāма, Харе Рāма, Рāма Рāма - *махā-мантран* дахь Рāма хэмээх үг нь Баларāмаг зааж байгаа юм. Нитйāнанда нь Баларāмын илрэл учраас Рāма нь мөн Бурхан Нитйāнандад хамаарна.

Чайтанйа-чаритāмрта нь юуны өмнө энэ материаллаг бүтээлийн хил хязгаарын чанадад оршино. Сансрын материаллаг илрэлийг *майā* хэмээх бөгөөд иймээс тэр нь мөнх бус. Заримдаа тэрээр илэрсэн хэлбэрт оршдог ба заримдаа илрээгүй төлөвт оршдог. Энэ утгаараа тэрээр хуурмаг юм. Гэвч энэ цаг зуурхны илрэлийн хил хязгаарын чанадад *Бхагавад-гйтад* заасан дээд байгаль оршдог:

парас тасмāт ту бхāво 'нйо

'вйакто 'вйактāт санāтанах

йах са сарвещу бхўтещу

нашйатсу на винашйати

“Гэвч илэрсэн хийгээд үл илэрсэн материт трансцендент мөнхийн, өөр байгаль оршмуй. Энэ дээд байгаль нь хэзээ ч устдаггүй ба энэ ертөнцөд бүх зүйл устаж байхад энэ хэсэг өөрчлөгдөлгүй хэвээр үлдмүй”. (Бг.8.20)

Энэ дээд байгаль нь илэрсэн(*вйактах*) болон илрээгүй(*авйактах*) хил хязгаарын чанадад оршдог. Бүтээл ба усталтын дээр орших энэ дээд байгаль нь бүхий л амьд оршнолуудын биед орших амьдралын хүч юм. Бие махбодь нь өөрөө доод байгаль буюу материас тогтох бөгөөд гэвч биеийг хөдөлгөдөг тэр зүйл нь дээд байгаль юм. Энэ дээд байгалийн шинж тэмдэг нь ухамсар юм. Тийнхүү бүх зүйлс нь дээд мөн чанар бүхий бурханлаг ертөнцөд бүгд ухамсартай. Тэнд байх ширээ, газар, модод бүгд ухамсартай.

Энэ материаллаг илрэл нь хэрхэн алс хол үргэлжилдэгийг төсөөлөх боломжгүй. Материаллаг ертөнц дэхь бүх зүйлсийг төсөөлөл эсвэл өөр бусад төгс бус аргуудаар үнэлж цэгнэдэг ч ведийн Бичээсүүд нь энэ материаллаг орчлонгийн гадна орших зүйлсийн талаарх мэдээллийг агуулдаг. Танин мэдэхүйн турших аргад итгэдэг хүмүүс нь ведийн утга зохиолын дүгнэлтэнд эргэлзэж болно. Учир нь тэд энэ хэдий хир газар үргэлжилдэг, энэ орчлонгийн хязгаарт алслагдсан хэдэн өнцөг буланд нь хүрч болохыг төсөөлж ч чаддаггүй. Ямар ч туршилтын аргууд нь энэ материаллаг орчлонгийн гадна орших ямар ч зүйлийн талаарх мэдээллийг өгөх

чадвар үгүй. Бидний хүртэхүйд өртдөггүй тэр зүйлийг ачинтйа буюу ойлгогдошгүй гэдэг. Ойлгогдошгүй зүйлийн талаар маргах болон эсвэл төсөөлөл зохиох нь утга учиргүй юм. Хэрэв энэ нь үнэхээр ойлгогдошгүй юм бол тэрээр бидний цэцэрхийлэл хийгээд туршилтын объект байж чадахгүй. Бидний эрч хүч хязгаарлагдмал ба яг л бидний мэдрэхүйн хүртэц шиг. Ийм учраас ойлгогдошгүйн категорит хамаарах зүйлсийн тухай яригдаж байвал бид Ведийн дүгнэлтэнд хандах ёстой. Дээд байгалийн тухай мэдлэгийг зүгээр л ямар нэг баталгаа нотолгоогүйгээр хүлээж авах ёстой. Бидэнд нэвтрэн орох боломжгүй юмсын тухай маргаж болох уу? Трансцендент ойлголтыг танин мэдэх аргыг Бурхан Кршңа Өөрөө *Бхагавад-гīтагийн* дөрөвдүгээр бүлгийн эхэнд Аржунад хандан:

имам вивасвате йогам

проктавāн ахам авйайам

вивасвāн манаве прāха

манур икцвāкаве 'бравīt

“Би энэхүү йогийн мөнхийн эрдэм ухааныг нарны тэнгэр Вивасвāнд дамжуулсан ба Вивасвāн түүнийг хүн төрөлхтний өвөг Мануд дамжуулсан юм. Харин Ману өөрийнхөө ээлжинд түүнийг Икцвāкад дамжуулсан билээ”. (Бг.4.1)

Энэ нь *параманара* буюу багш шавийн хэлхээний арга юм. Үүнтэй адилаар *Шрīмад-Бхāгаватамд* өгүүлснээр Кршңа бурханлаг мэдлэгийг орчлонгийн анхны амьд оршнол болох Брахмāд дамжуулжээ. Брахмā энэ хичээлийг өөрийн шавь Нāрадад дамжуулсан Нāрада өөрийн шавь Вйāсадевад, Вйāсадева нь энэ мэдлэгийг Мāдхвāчāрйад, Мāдхвāчāрйагаас энэ мэдэг нь Мāдхавендра Пурйд дараа нь Йшвара Пурйд, түүнээс Чаитанйа Махāпрабхуд дамжин иржээ.

Асуулт үүсч болох юм: хэрэв Чаитанйа Махāпрабху нь Кршңа Өөрөө юм бол Түүнд яагаад номын багш хэрэгтэй гэж? Мэдээжээр, Түүнд номын багш хэрэггүй ч Тэрээр *āчāрйагийн*(өөрийн жишээгээр сургагч) дүрд тоглож байсан учраас номын багштай болсон юм. Тэр ч байтугай Кршңа Өөрөө номын багштай болж байсан юм. Яагаад гэвэл систем нь ийм. Ийм байдлаар Бурхан хүмүүст жишээ үзүүлдэг. Гэвч Түүнд мэдлэг дутагдсан учраас Бурхан номын багштай болдог гэж бодох хэрэггүй. Үүгээрээ Тэрээр зүгээр л багш шавийн барилдлагын чухлыг онцлон тэмдэглэсэн юм. Чухамдаа багш шавийн барилдлагаар дамжин ирсэн мэдлэг нь Бурханаас Өөрөөс нь үүсэлтэй ба хэрэв энэ мэдлэг нь гажуудалгүйгээр дамжвал тэр мэдлэг төгс төгөлдөр болно. Хэдий бид мэдлэг үүсэн бий болсон тэр бодгальтай харьцахгүй байж болох ч бид яг тэр мэдлэгийг багшаас шавьд мэдлэг дамжуулах энэ процессын ачаар хүлээн авч болно. *Шрīмад-Бхāгаватамд*, Кршңа буюу Туйлын Үнэн, Бурханы Бодгаль нь Брахмын зүрхэнд түүнийг суулгаж трансцендент мэдлэгийг дамжуулсан хэмээн баталдаг. Зүрхээр дамжин мэдлэг

дамжих нь мэдлэгийг хүлээн авах нэг арга юм. Тийнхүү мэдлэгийг хоёр аргаар олж авч болдог: нэг нь бүх амьд оршнолуудын зүрхэнд Дээд Сүнс хэлбэрээр орших Бурханы Дээд Бодгалиас хамааралтай ба нөгөө арга нь Кршңагийн илрэл болсон номын багш буюу гуругээс хамаардаг. Ингэж Кршңа мэдээллийг гаднаас болон дотроос дамжуулдаг. Хэрэв энэ аргуудын аль нэгээр мэдлэгийг хүлээж авбал тэрээр ойлгогдох хийгээд ойлгогдохгүй нь ач холбогдолгүй.

Шрїмад-Бхāгаватам энэ материаллаг орчлонгийн хил хязгаарын гадна орших Ваикунтхгийн гаригсын системийн тухай ерөнхий мэдээллийг өгдөг. Танин ойлгогдошгүй зүйлсийн тухай маш их мэдээлэл Чаитанйа-чаритāмрҗадаг агуулагддаг. Энэ мэдээллийг туршилтын аргаар хүлээн авахаар оролдсон ямарч оролдлоо үр дүнгүй. Энэ мэдлэгийг зүгээр л хүлээж авах хэрэгтэй. Ведийн аргаар бол шабда буюу трансцендент авиаг баталгаа хэмээн тооцдог. Авих нь танин мэдэхүйн ведийн үйл ажиллагаанд нэн чухал. Учир нь хэрэв тэрээр цэвэр ариун бол бат ноттой гэж тооцдог. Материаллаг ертөнцөд ч бид хэдэн мянган милийн цаана орших радио болон утсаар дамжин ирдэг маш их мэдээллийг хүлээн авдаг. Хэдий бид бидэнд мэдээлэл дамжуулж буй хүнийг олж харахгүй ч бид түүний мэдээлэл нь авиан дээр суурилсан болоход итгэж болно. Ийнхүү авианы чичирхийлэл нь ведийн мэдлэгийг дамжуулахад нэн чухал.

Ведүүд нь сансрын илрэлийн цаана нэлэнхүй гариг эрхэс хийгээд бурханлаг тэнгэр оршдог тухай мэдээлж байна. Энэ материаллаг илрэл нь бүх бүтээлийн өчүүхэн хэсэг гэж тооцогддог. Материаллаг илрэл нь өөртөө энэ орчлонг төдийгүй өөр бусад тоо томшгүй олон орчлонгуудыг агуулдаг ч бүх материаллаг орчлон нь бүгд нийлээд бүх бүтээлийн багахан хэсгийг бүрдүүлнэ. Бүтээлийн ихэнхи хэсгийг бурханлаг тэнгэр эзэлдэг ба энэ тэнгэрт Ваикунтхалока гэж нэрлэгдэх тоогүй олон бурханлаг гаригууд хөвөн байдаг. Ваикунтхалока бүрийг Нārāйᅇа Өөрийн дөрвөн мутарт илрэл дүрээр захирдаг: Саᅇкарᅇаᅇа, Прадйумна, Анируддха, Вāсудева.

Дээр өгүүлсэнчлэн үүний тулд Махā-Виᅇᅇᅇугийн дүрд хувилсан Бурхан нь материаллаг орчлонгуудыг бий болгодог. Эхнэр, нөхөр хоёр үр удамтай болохын тулд нийлдэг шиг Махā-Виᅇᅇᅇу Өөрийн эхнэр Мāйā буюу материаллаг байгальтай нэгддэг. Үүнийг мөн Кршңа *Бхагавад-гїта*д батлан өгүүлсэн байдаг:

сарва-йониᅇу каунтейа

мўртайаᅇ самбхаванти йāᅇ

тāсāм брахма махад йонир

ахам бйжа-прадаᅇ нїта

“Ай Кунтийн хүү минь ээ, амьдралын бүхий л хэлбэрүүд нь энэ материаллаг байгалиас үүсдэг хийгээд Би бол үр тогтоогч эцэг нь гэдгийг ойлгогтун”.(Бг.14.4)

Виᅇᅇᅇу зүгээр л харц чулуудан материаллаг байгаль буюу *Мāйā*д үр тогтоодог. Энэ нь бурханлаг арга юм. Материаллаг байдлаар үр тогтоохын тулд бид зөвхөн

биеийнхээ тодорхой нэг хэсгийг ашигладаг ч Дээд Бурхан, Кршңа буюу Махā-Вицңу Өөрийн биеийн дурын хэсгээр дурын ямар ч хэсэгт үр тогтоож чадна. Зүгээр л харцаа чулуудаад Бурхан материаллаг байгалийн хэвлийд тоо томшгүй олон амьд оршнолуудыг оруулдаг. Мөн түүнчлэн *Брахмā-самхитāд* Дээд Бурханы бурханлаг бие нь нэн хүчирхэг бөгөөд энэ биеийн дурын хэсэг нь өөр бусад ямар ч хэсгийн үүргийг гүйцэтгэж чаддагийг баталжээ. Бид зөвхөн гар эсвэл арьсаараа хүрэлцэж чаддаг ч Кршңа харцаараа хүрэлцэж чадна. Бид нүдээрээ зөвхөн харж л чадах ч түүгээр хүрэлцэх болон үнэрийг мэдэрч чадахгүй. Гэвч Кршңа үнэрийг мэдэрч чадах ба мөн мэлмийгээрээ зооглож чаддаг. Бид Кршңад зоог гүнцгээ өргөх үедээ Түүнийг хэрхэн идэж буйг хардаггүй ч Тэрээр хоол хүнс рүү зүгээр л харц илгээснээр зооглон хүртдэг. Бид бүх зүйлс нь харьцангуйгаар бурханлаг мөн чанартай бурханлаг ертөнцөд бүхий юмс хэрхэн зохион байгуулагдсаныг төсөөлж ч чадахгүй. Энэ нь Кршңа иддэггүй гэсэн үг биш буюу бид зүгээр л Түүнийг идэж байна хэмээн төсөөлдөг гэсэн үг биш; Тэр үнэхээр иддэг ч бидний иддэгээс өөрөөр. Бид бүрнээ бурханлаг түвшинд оршин байх зөвхөн тэр цагт Түүн шигээр идэж чадна. Энэ түвшинд биеийн аль ч хэсэг өөр бусад ямар ч хэсгийн үүргийг гүйцэтгэж чаддаг.

Вицңуд бүтээл хийхийг юу ч шаардагддаггүй. Түүнд Брахмыг орчлонд төрүүлэхийн тулд цэцэглэн мандахын дарь эх хэрэггүй. Учир нь Брахмā Вицңугийн хүйснээс ургасан бадамлянхуа цэцэгнээс төржээ. Лакшмī дарь эх Вицңугийн өлмийд суун Түүнд үйлчилж байдаг. Энэ материаллаг ертөнцөд хүүхэд төрүүлэхийн тулд эр эмийн харьцаа хэрэгтэй ч бурханлаг ертөнцөд эхнэрийн туслалцаагүйгээр хэд л шаардлагатай байна төдийчинээ хүүхэдтэй болж болно. Бидэнд бурханлаг эрч хүчинд хандах ямар ч туршлага үгүй болохоор Брахмā Вицңугийн хүйснээс төрсөн гэдэг нь зүгээр л үлгэр мэт санагддаг. Бурханлаг эрч хүч нь нэн хүчирхэг бөгөөд хийж болох бүх зүйлийг хийж болно гэдгийг бид мэддэггүй. Материаллаг эрч хүч нь тодорхой хуулиас хамаардаг ч бурханлаг эрч хүч нь бүрнээ бие даасан хамааралгүй юм.

Брахмā нь Махā-Вицңугийн ердөө хэсэгхэн илрэл болох Гарбходакашāйй Вицңугийн хүйснээс төрдөг. Махā-Вицңугийн арьсны шар үсний нүхэнд тоо томшгүй олон орчлонгууд оршдог ба Түүнийг амьсгалаа гаргахад энэ бүх орчлонгууд илэрдэг. Материаллаг ертөнцөд бид түүнтэй ижил төстэй зүйлтэй учирч байгаагүй ч үүний гажуудсан тусгал болох хөлрөх үзэгдэл бидэнд тодорхой. Гэвч бид Махā-Вицңугийн нэг амьсгалын үргэлжлэх хугацааг төсөөлж ч чадахгүй.

Яагаад гэвэл Түүний нэг амьсгалаа гаргах, амьсгалаа авахуйн үргэлжлэх хугацаанд бүх орчлонгууд бүтээгдэж, устгагддаг. Брахмā Тэнгэр нь Түүний зөвхөн нэг амьсгал гаргах хугацаанд л амьдардаг ба бидний хэмжээсээр 4320 000 000 жил Брахмын ердөө арван хоёр цагтай тэнцэх ба Брахмā нь өөрийн зуун жил амьдардаг. Брахмын бүхий л амьдрал бүтнээрээ Махā-Вицңугийн зөвхөн нэг амьсгал гаргах

хугацаанд багтдаг. Тийнхүү бид Дээд Бурханы амьсгал хэдийчинээ хүчирхэгийг төсөөлж ч чадахгүй. Харин энэхүү Махā-Вицңу нь Кршңагийн ердөө хэсэгчилсэн илрэл юм.

Ийн Кршңадās Кавирāжа Госвāmй Бурхан Чаитанйаг Бурханы Дээд Бодгаль Шрй Кршңа Өөрөө мэтээр, харин Бурхан Нитйāнандаг Кршңагийн анхдагч илрэл Баларāма мэтээр өгүүлэн бичжээ. Бурхан Чаитанйагийн өөр нэг гол шавь Адвайтāчāрйаг Махā-Вицңугийн илрэл хэмээн тооцдог. Тийнхүү Адвайтāчāрйа нь мөн л Бурхан бөгөөд нарийвчлан өгүүлвэл Бурханы илрэл юм. Адвайта хэмээх үг нь “хоёрдмол бус” гэсэн утгатай ба тэрээр Дээд Бурханаас ялгаа үгүй учраас энэ нэрийг зүүсэн юм. Түүнийг мөн āчāрйа буюу багш гэж нэрлэх бөгөөд учир нь тэрээр Кршңагийн ухамсрыг түгээдэг. Энэ утгаараа тэрээр Чаитанйа Махāпрабхутай яг адил. Хэдий Чаитанйа нь Кршңа Өөрөө ч Тэрээр бүх хүмүүсийг Бурханыг хэрхэн хайрлахад сургах чин бишрэлтэн мэтээр ирсэн юм. Үүнтэй адилаар Адвайтāчāрйа нь зүгээр л Кршңагийн ухамсрыг түгээхийн тулд заларсан. Мэдээжээр тэрээр мөн л чин бишрэлтний дүрээр заларсан Бурхан юм. Кршңа таван өөр илрэл хэлбэрээр илрэн заларсан ба Тэрээр Өөрөө болон Түүний бүх дагуулууд Шрй Кршңа Чаитанйагийн чин бишрэлтэн байдлаар Нитйāнанда, Адвайтāчāрйа, Гадādхара, Шрйвāса болон бусад чин бишрэлтний дүрээр заларчээ. Бүхий л тохиолдолд Чаитанйа Махāпрабху Өөрийн бүхий л чин бишрэлтэнгүүдийн хувьд эрч хүчнийх нь эх үүсвэр юм. Энэ нь үнэхээр тийм болохоор хэрэв бид Кршңагийн ухамсартаа амжилт гаргахын тулд Чаитанйа Махāпрабхугийн өршөөл ивгээлийн авбал бид урагшаа дэвшихэд эргэлзэхгүй байж болно. Нароттама дāса Тхāкур чин бишрэлийн нэгэн дуундаа: “Миний эрхэм Чаитанйа Бурхан минь ээ, надад өршөөл энэрлээ хандуулаач. Тан шиг өршөөнгүй нь үгүй билээ. Би маш их бат ноттойгоор үүнийг гуйя. Учир нь Таны үүрэг зорилго ангижирсан сүнснүүдийг аврахад орших бөгөөд бүх дэлхий даяар надаас илүү унан доройтсон нь үгүй билээ. Надад эрхэм хайраа үзүүлэхийг гуйн залбирвья би”.

Чаитанйа-чаритāmртагийн зохиогч Врдāваны оршин суугч, аугаа их чин бишрэлтэн байсан юм. Үүнээс өмнө тэрээр гэр бүлтэйгээ Бенгали дахь Бурдваны орчимд орших багахан хот Катвад амьдарч байжээ. Түүний гэр бүл мөн л Рādхā-Кршңад мөргөн залбирдаг байсан ба нэгэн удаа гэр бүлд нь чин бишрэл зүтгэлийн чиглэлээр бага зэрэг үл ойлголцол гарсны дараа Кршңадās Кавирāжийн зүүдэнд Нитйāнанда Прабху үзэгдэж гэрээ орхиж, Врдāваныг зорихыг зөвлөсөн. Хэдий тэрээр маш их өтөл хөгшин ч Врдāванд суурьшихын тулд тэр шөнөө замд гарчээ. Тэнд байх үедээ тэрээр Бурхан Чаитанйа Махāпрабхугийн ойрын шавь хэд хэдэн Госвāmйтай танилцжээ. Врдāваны чин бишрэлтнүүд түүнд хандан *Чаитанйа-чаритāmртаг* бичих хүсэлт тавив. Тэрээр энэ ажилд хэдий нас нилээд хэвийсэн

үедээ орсон ч Бурхан Чаитанягийн өршөөлөөр тэрээр түүнийг дуусгаж чадсан юм. Өнөөдрийг хүртэл энэ ном нь Чаитанягийн амьдрал хийгээд гүн ухааны тухай хамгийн нэр хүндтэй, бат ноттой бүтээл хэвээр үлджээ.

Кршнадас Кавиража Госвāmийг Врндāванд амьдарч байх үед тэнд тийм ч олон сүм байгаагүй юм. Тэр үеийн гурван гол сүм нь Мадана-моханы, Говиндажйин, Гопйнātхийн сүмүүд байв. Врндāваны оршин суугч тэрээр эдгээр сүмүүд дэх Шүтээнүүдэд хүндэтгэлээ илэрхийлж, “Би бурханлаг амьдралдаа хэтэрхий удаанаар урагшлан дэвшиж байна. Ийм учраас Танаас тусламж эрэн мөргөж байна” хэмээн мөргөн залбирдаг байжээ. *Чаитаня-чаритāmрад* Кршнадас Кавиража нь эхлээд өөрийн мөргөлөө Мадана-мохана виграха буюу Кршнагийн ухамсрын замд хөгжин дэвшихэд туслах тэр Шүтээнд мөргөлөө өргөсөн байдаг. Кршнагийн ухамсрын замаар замнаж буй хүн нь юуны өмнө Кршнаг болон Кршнатай холбоотой харьцаагаа танин мэдэх ёстой. Энэ харьцаа нь Мадана-мохана виграхад мөргөх үйл ажиллагааны явцад йолгогдож чадах учраас Кршнадас Кавиража юуны өмнө Түүнтэй холбоо харьцаагаа тогтоожээ.

Тэдэнтэй харьцаа тогтоочихоод Кршнадас функциональ Шүтээн Говиндад мөргөлөө өргөж эхэлсэн. Говинда нь Врндāванд мөнхөд оршдог. Бурханлаг ертөнц дэх Врндāваны байшин барилга нь гүн ухааны чулуудаар хийгдсэн, элбэг баян сүү хайрлагч сурабхийн үнээдээр алдартай ба тэнд ургадаг модод нь хүслийн модод байдаг. Учир нь тэд хүссэн бүгдийг өгдөг. Врндāванд Кршна сурабхийн үнээд хариулж зуу зуун, мянга мянган гопй, малчин бүсгүйчүүдийн хайр хүндэтгэлийг хүлээн байх ба энэ бүх бүсгүйчүүд нь цөм цэцэглэн мандахын дарь эхүүд билээ. Кршнаг энэ материаллаг ерөтнцөд буун залрах үед энэхүү Врндāван нь Түүнтэй хамт залардаг. Энэ нь өндөр албан тушаалт хүнийг бараа бологчид нь дагалдаж явдагтай л адил. Кршнагийн буун залрахтай хамт Врндāван нь хамт ирсэн учраас материаллаг ертөнцөд Врндāван байдаггүй хэмээн бүү тооцогтун. Ийм учраас чин бишрэлтэнгүүд нь Энэтхэгийн Врндāваныг өмөг түшгээ болгодог бөгөөд учир нь тэрээр анхдагч Врндāваны яг адил хуулбар нь юм. Тэнд калпа-вркша буюу хүслийн модод байдаггүй гэж маргаж болох юм. Гэвч Госвāmй нарыг байх цагт тэнд *калта-вркша* байсан билээ. Хүн бүр энэ мод руу очиж түүнээс хүссэнээ шаардаж чадахгүй; юуны өмнө хүн чин бишрэлтэн болох ёстой. Госвāmй нар шөнө бүр нэг шинэ модны дор хоноглодог байсан ба модод тэдний бүх хүслийг биелүүлдэг байв. Жирийн хүний хувьд энэ нь гайхамшиг мэт бодогдовч хүн бурханлаг байдлаар хөгжихийн хирээр энэ бүгд биелэх болно.

Жинхэнэ Врндāван нь үнэн хэрэгтээ материаллаг цэнгэл жаргалаас ханамж таашаал олж авах оролдлогоо таслан зогсоосон зөвхөн тэр хүнд л нээгддэг. “Врндāваныг тольдон харахын тулд материаллаг цэнгэл эдлэх бүхий л хүслээсээ

миний ухаан хэзээ цэвэрлэгдэх бол доо?” хэмээн нэгэн аугаа чин бишрэлтэн асуусан байдаг. Бид хэдий хэмжээгээр Крш᠑аг ухамсарлана төдийчинээ бидэнд алив бүгдийн үндэс бруханлаг байгаль нээгдэх болно. Ийм учраас Крш᠑ад᠗с Кавир᠗жа Госв᠗мй Энэтхэгийн Врнд᠗ваныг бурханлаг тэнгэр дэхь Врнд᠗ванаас ялгаагүй гэж тооцсон ба *Чаитанйа-чарит᠗мртад* тэрээр Р᠗дх᠗, Крш᠑аг Врнд᠗ванд үнэт эрдэнийн чулуудаар чимэглэгдсэн ширээн дээр хүслийн модод доор сууж буйгаар дүрслэн бичсэн байдаг. Крш᠑агийн хамгийн ойр дотнын найзууд, малчин залуус, бүсгүйчүүд Р᠗дх᠗, Крш᠑ад сэрүүн ундаа, бетелийн самар өргөн, Ариун Гэгээн Тэднийг цэцгээр гоёж чимэглэн дуулан, бүжиглэж тэдэнд үйлчилнэ. Тэр ч аугай өнөө үед Энэтхэгт долоон сар болоход хүмүүс ширээ чимэглэж, энэ тайзыг бүтээдэг. Ихэвчлэн өнөө үед хүмүүс муртид хүндэтгэл бишрэлээ илэрхийлэхийн тулд Врнд᠗ван тийш явдаг.

Крш᠑ад᠗с Кавир᠗жа Госв᠗мй нь Р᠗дх᠗, Крш᠑агийн *мурти* нь бидэнд Р᠗дх᠗ болон Крш᠑ад хэрхэн үйлчлэхийг үзүүлдэг хэмээн баталжээ. Мадана-моханы мурти нь зүгээр л: “Би Таны мөнхийн албат” гэдгийг тогтоодог. Гэвч Говинда нь хэдийнээ үнэхээр үйлчлэл зүтгэлийн хүлээн авч байдаг. Ийм ч учраас функциональ Шүтээн гэж нэрлэж байгаа хэрэг. Гопй᠑н᠗тхийн Шүтээн нь гопй нарын захирагч, эзэмшигч Крш᠑а юм. Тэрээр бүх гопй буюу малчин бүсгүйчүүдийг Өөрийн лимбэний эгшгээр соронздон дууддаг ба тэднийг хүрэлцэн ирмэгц Тэрээр тэдэнтэй бүжиглэдэг байв. Энэ бүхний тухай *Шрймад-Бх᠗гаватамын* Аравдугаар Дуулалд өгүүлдэг. Эдгээр гопй нар нь хар багаасаа л Крш᠑агийн найзууд байсан ба бүгд нөхөрт гарсан байсан юм. Учир нь Энэтхэгт охидууд арван хоёр насандаа нөхөрт гардаг ч хөвгүүд арваннайман наснаас өмнө гэрлэдэггүй. Крш᠑а энэ үед арван тав, зургаан настай байсан учраас гэрлээгүй байсан юм. Чингэвч Тэрээр эдгээр бүсгүйчүүдийг гэрээс нь дуудан гаргаж, Тэднийг бүжгэнд урьсан билээ. Энэ бүжгийг р᠗са-лйла бүжиг хэмээдэг ба энэ нь Врнд᠗ваны хамгийн дэвшилтэт тоглоом наадам юм. Иймээс Тэрээр гопй нарын хайртай эзэн байсан учраас Крш᠑аг Гопй᠑н᠗тха хэмээн нэрлэдэг.

Крш᠑ад᠗с Кавир᠗жа Госв᠗мй нь Гопй᠑н᠗тха Бурханаас адислалыг гуйжээ. “*Гопй* нарын эзэн Гопй᠑н᠗тха, Крш᠑а нь танд адис өршөөлөө хайрлах болтугай. Тантай хамт Гопй᠑н᠗тхын адис ерөөл хамт байтугай”. Крш᠑а *гопй* нарыг Өөрийн лимбэний амтлаг авиагаар татаж байсан шиг Чаитанйа-чарит᠗мртагийн зохиогч нь, Тэрээр(Крш᠑а) яг тийм байдлаар уншигчдын ухааныг өөрийн трансцендент авиа чичирхийллээр соронздон татаг хэмээн мөргөн залбирчээ. Үүнд - энэ авиа чичирхийллийн(*Чаитанйа-чарит᠗мртагийн*) гол мөн чанар болсон товч өгүүллээр хялбар уншигдахуйц байдлаар дамжуулан буй - Шрй-Чаитанйагийн сургаал буюу энэ номын маань зорилго оршино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Рӯпа Госвāмид өгсөн Бурхан Чаитанйагийн сургаал

Санāтана Госвāмийн дүү Шрйла Рӯпа Госвāмй Прайāгт(одоогийн нэршил нь Аллахабад) өөрийн дүү Валлабхын хамт иржээ. Ах дүүс Бурхан Чаитанйа Махāпрабхуг хотод байгааг дуулаад хоёул ихэд баярлаж Түүнийг олж харахаар явцгаав. Тэр үед Бурхан үргэлж ганцаар явдаг байсан бөгөөд Биндумāдхавын сүм тийш явдаг замаар мөн л ганцаар явж байлаа. Сүм хүрэх замд Бурхан дуулж, бүжиглэн явж байсан ба мянга мянган хүмүүс Түүнийг дагалдан явж байв. Тэдний зариим нь уйлж, зарим нь инээж, зарим нь дуулж, зарим нь бүжиглэнэ. зарим нь Бурханд хүндэтгэлээ илэрхийлж газарт сунан мөргөнө. Гэвч тэд бүгдээр Кршṇагийн ариун нэрийг дуулан хашгирна. Прайāгт Ганга болон Йамуна мөрөн нэгддэг ч тэрээр хот тэр аяараа Кршṇаг хайрлах хайранд уусан автан байх Чаитанйа Махāпрабхуг залрахаас урьд өмнө хэзээ ч усны үерт автаж байгаагүй хэмээн ярьцгаадаг.

Рӯпа Госвāмй, Валлабха, ах дүү хоёул хүн байхгүй газарт зогсож бужигнан буй энэхүү гайхамшигт дүр зургийг хаж байлаа. Бурхан бүтжглэж байх үедээ гараа өргөн “Харибол!Харибол!” хэмээн дуулан хашгирна. Тойрон хүрээлсэн хүмүүс Түүний хийж буй үйлдэлд гайхан алмайран байв. Сүмд зочилсныхоо дараагаар Бурхан Өмнөд Деканы нэгэн *брāхмаṇы* гэрт *прасāд*(Бурхан Шүтээндээ өргөсөн хоол) зооглов. Бурханыг тэрхүү *брāхмаṇы* гэрт байх үед Түүн дээр Рӯпа Госвāмй, Валлабха нар хүрэлцэн очив. Түүнд дөхөн очмогц ах, дүү хоёр Судар шастираас олон тооны санскрит шүлгийг уншин газарт сунан мөргөв. Түүний өмнө мөргөн буй Рӯпа Госвāмийн байдал төрх Бурханд маш их ханамж таашаал өглөө. Тэрээр Рӯпа Госвāмийг босохыг хүсч үүний дараагаар Рӯпа Госвāмид түүнд хайрласан Кршṇагийн учир шалтгаангүй өршөөлийн тухай ярьж өгөв. Учир нь Тэрээр зөвхөн мөнгөн дээр тогтсон материаллаг амьдралын хэлбэрээс түүнийг ангижруулсан юм.

Бурхан ах дүү хоёрыг хоёуланг нь Өөрийнхөө чин бишрэлтэнгүүд болгосон бөгөөд бүх дөрвөн ведийг судалсан *брāхмаṇыг* Өөрийн чин бишрэлтэн хэмээн хүлээн зөвшөөрөхгүй байж болох ба харин доод удамт гэр бүлээс гаралтай ч Түүний цэвэр чин бишрэлтэн бол хүлээн зөвшөөрч болох тухай өгүүлсэн Судар Бичээсийн нэгэн шүлгээс иш татав.

Дараа нь Бурхан ах дүү хоёрын хоёуланг нь тэвэрч, Өөрийн учир шалтгаангүй өршөөлөөр бадамлянхуан өлмийгөө тэдний толгойд хүргэв. Тийнхүү адислагдсан ах, дүүс Бурханд мөргөл залбирлаа өргөлөө. Энэ залбиралдаа Шрй Кршṇа Чаитанйа Махāпрабху нь Кршṇа Өөрөө ба Тэрээр Чаитанйагийн гэрэлт царайг

авсан учраас Гаурāнга-алтан нэрээр алдаршсан, мөн Тэрээр Кршṇаг хайрлах хайрыг харамгүй түгээж байсан тул Кршṇагийн хамгийн өршөөнгүй хувилгаан хэмээн өгүүлжээ. Шрїла Рӯпа Госвāмї хожим нь Говинда-лїлāмрта номонд (1.2) орсон нэгэн шүлгийг иш татсан байдаг:

*йо' жнāна-маттам бхуванам дайāлур
уллāгхайанн апї акарот праматтам
свапрема-сампат-судхайāдбхутехам
шрї-Кршṇа-чаитанїам амум прападїе*

“Би Бурханы хамгийн өршөөнгүй Бодгаль Шрї Кршṇа Чаитанїа Махāпрабхугийн бадамлянхуан өлмийд мөргөн залбирнам. Тэрээр мунхагийн харанхуйд живсэн унан доройтсон сүнснүүдийг ангижруулж, тэдэнд аугаа их бэлэг болох Кршṇаг хайрлах хайрыг бэлэглэдэг. Тийнхүү тэд Кршṇагийн ухамсарт автан ухаан балартдаг”.

Энэ явдлын дараагаар Валлабха Бхатṭа Бурханыг Ганга мөрний нөгөө эрэгт очихыг урьсан ба Бурхан ч түүнтэй хамт явсан байна. Энэ цаг мөчөөс эхлэн Бурханыг хаашаа ч явсан Рӯпа Госвāмї байнгад хажууд нь дагаж, үргэлж Түүнтэй хамт байдаг байлаа. Бурхан хүн ихтэй газарт тухгүй байсан учраас Тэрээр Рӯпа Госвāмийг Ганга мөрний эрэгт орших Дашāшвамедха-гхāṭ гэж нэрлэгдэх тэр газарт хүртэл Өөрийгөө дагалдан явахыг хүсэв. Арван өдрийн туршид Тэрээр Рӯпа Госвāмид Кршṇагийн тухай үнэн, чин бишрэлийн зарчмууд болон Кршṇатай холбоотой трансцендент харьцааны тухай ярьж сургаал номоо хайрлажээ. Тэрээр Рӯпа Госвāмийг ирээдүйд өөрийн *Бхакти-расāмрта-синдху* номондоо Кршṇагийн тухай мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхийн тулд энэ бүгдийг маш дэлгэрнэгүйгээр өгүүлсэн байна. Үнэхээр ч Рӯпа Госвāмї энэ тухай *Бхакти-расāмрта-синдхугийн* нэгдүгээр шүлэгт өгүүлсэн байдаг ба түүндээ тэрээр түүнд хайрласан Бурханы учир шалтгаангүй өршөөлийн тухай өгүүлжээ.

Дээд Бурхан нь бүгдийг чадагч ба бүхнээс хүчтэй. Өөрийн учир шалтгаангүй өршөөлөөр Тэрээр амьд оршнолуудад Түүний өршөөлийг хүлээн авах боломжийг олгодог. Болзолдсон амьдралд гинжлэгдсэн хүмүүс нь үндсэндээ чин бишрэлийн үйл эрхлэх ба Кршṇагийн ухамсраар хичээллэх хандлагагүй байдаг. Чухамдаа хүмүүсийн ихэнхи нь Бурханы Дээд Бодгальтай холбоотой бидний мөнхийн холбоо харьцааны тухай өгүүлэх Кршṇагийн ухамсрын сургаалын үндэс, Бурхан зүгт буцахад утга нь орших амьдралын эцсийн зорилго зэргийн тухай юу ч мэддэггүй. Бурханлаг ертөнцөд буцахад туслах аргын тухай хүмүүс юу ч мэддэггүй. Эдгээр маш чухал зүйлүүдийг болзолт сүнснүүд мэддэггүй тул Бурхан Чаитанїа Өөрийн

учир шалтгаангүй өршөөлөөр Рӯпа Госвāмид чин бишрэл зүтгэлийн зарчмуудын тухай сургаалаа хайрлажээ. Дараахан нь Рӯпа Госвāмий чин бишрэл зүтгэлийн эрдэм ухааны тухай мэдлэгийг бүх хүмүүсийн сайн сайхны тулд тархаан түгээсэн юм.

Бхакти-расāмрта-синдхугийн(Бх.р.с.1.1.2) өмнөтгөлдөө Рӯпа Госвāмий дараахь шүлгийг өгүүлсэн байдаг:

*хрди йасйа прераñайā правартито ‘хам варāка-рӯпо ‘ни
тасйа харех̄ пада-камалам̄ ванде чаитанйадевасйа*

“Би вээр Бурхан Чаитанйадева нэрт Бурханы Дээд Бодгаль таны бадамлянхуан өлмийн өмнө хүндэтгэлтэйгээр мөргөмүү. Учир нь Түүний урам дэмжлэгт би өөрийн зүрх сэтгэлдээ чин бишрэл зүтгэлийн тухай ямар нэг зүйлийг бичих хүсэл төрсөн юм. Энэ л шалтгаанаар *Бхакти-расāмрта-синдху* гэж хэрлэгдсэн чин бишрэлийн эрдэм ухааны тухай энэхүү номоо бичих ажилдаа орсон билээ”.

Рӯпа Госвāмид өгсөн сургаалаа Бурхан Чаитанйа: “Эрхэм Рӯпа минь ээ, чин бишрэл зүтгэлийн тухай эрдэм ухаан нь аугаа өргөн далай мэт билээ. Түүнийг өргөн хийгээд гүнийх нь хэмжээгээр чамд үзүүлэх боломжгүй. Гэвч Би түүнээс нэгэн дуслыг авч энэ далай мөн чанарыг тайлбарлах гэж оролдоё. Чингэснээр чи түүний амтыг мэдэрччин бишрэл зүтгэлийн далай гээч чухам юу болохыг ойлгож чадна” хэмээсэн үгээр эхэлж байна.

Дараа нь Бурхан энэхүү *брахмāндa* буюу орчлонгийн дотор тоогүй олон амьд оршнолууд байх бөгөөд тэд өөр өөрсдийн кармын үйлтэй тохирсон амьдралын нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт, нэг гаригаас нөгөө гаригт шилжин байдаг тухай тайлбарласан. Тийнхүү тэдний материаллаг ахуйн шорон гянданд оршин байх нь алт эртийн цагаас эхлэлтэй ажээ. Үнэн хэрэгтээ өчүүхэн жижиг амьд оршнолууд нь дээд сүнсний бүрдүүлэгч хэсэг юм. *Шрīмад-Бхāгаватамд*, бие даасан сүнсний урт хийгээд өргөн нь ойролцоогоор үсний үзүүрийг арван мянга хуваасны нэгтэй тэнцэнэ гэжээ. Өөрөөр хэлбэл тэр нь үзэж харахны аргагүй өчүүхэн жижиг. Шветāшватара Упаницадад үүнийг мөн баталсан байдаг. *Шрīмад-Бхāгаватамын* Аравдугаар Дуулалд дөрвөн Кумāрын нэг Санандана аугаа их тахилга өргөлийн өмнөхөн дараахь үгийг хэлсэн байдаг: “Ай Дээд Үнэн минь ээ! Амьд оршнолууд нь дээд сүнсний хязгааргүй өчүүхэн очис байгаагүйсэн бол өчүүхэн жижиг очис бүр бүхэнд нэвчигч байх бөгөөд дээд хяналтанд орохгүй байхсан. Гэвч хэрэв амьд оршнолыг Дээд Бурханы бүрдмэл хэсэг хэмээн хүлээн авбал тэрээр аяндаа дээд эрчим ба хүчний хяналтанд ордог. Энэ төлөв нь түүний жам ёсны төлөв юм. Хэрэв тэрээр энэ байр сууриндаа үлдвэл тэрээр бүрэн дүүрэн чөлөөт байдалд хүрдэг”. (Бхāг.10.87.30) Хэрэв хүн тэрээр Бурханы Дээд Бодгалийн эзлэн байдаг шиг тэр байр төлөвт оршдог хэмээн алдаатайгаар тооцдог бол энэ нь тэрээр хоёрдмол... Байдлын онолоор цэнэглэгдсэн гэсэн үг ба трансцендент амьдралдаа хийсэн түүний хүчин чармайлт нь амжилтанд хүргэхгүй.

Бурхан Чаитанья амьд оршнолын мөнхийн ангижирсан, мөнхийн болзолдсон гэсэн хоёр анги байдаг гэдгийг тэмдэглээд *Шрїмад-Бхāгаватамын* энэ сургаал дээр тогтон дэлгэрэнгүй тайлбарласан. Мөнхийн болзолдсон амьд оршнолууд нь мөн л хөдөлдөг, үл хөдөлдөг хэмээх хоёр ангид хуваагдаж болно. Үл хөдлөгч оршнолууд жишээ нь, модод нэг байрандаа байж байх ба үл хөдлөгчийн ангид хамаардаг. Шувууд, араатнууд гэх мэт хөдөлдөг оршнолуудыг жайнгама буюу хөдлөгч оршнолууд гэдэг. Тэдгээр нь мөн л цаашаа гурван ангид хуваагдана: тэнгэрт нисдэг, усанд сэлдэг, хуурай газар дээгүүр явдаг. Хуурай газарт явдаг сая, тэрбум амьд оршнолуудаас хүмүүс багахан хэсгийг бүрдүүлдэг. Гэвч энэхүү багахан хэсэг хүмүүсийн ихэнхи хэсэг нь бурханлаг амьдралын тухай юу ч мэддэггүй бөгөөд ариун бус зуршлуудтай ба Бурханы Дээд Бодгалийн оршин буйд итгэдэггүй. Товчхон хэлэхэд хүмүүсийн дийлэнхи нь яг л амьтан адгуус мэт амьдарч байна. Чухамдаа хүний буюу амьдралын соёл иргэншил хэлбэрийг бүрдүүлдэг хүмүүсийн тоо хэмжээг үнэлж цэгнээд энэ дүгнэлтэнд хүрч болно. Ариун Судар номд итгэдэг, Бурханы оршнолыг хүлээн зөвшөөрдөг, иймээс ч тийм байдлаар биеэ авч явдаг цөөхөн ч хүнийг олоход бэрх. Энэ бүхний үнэтэй цэнэтэйд итгэдэг *āричууд* гэдэг. Энэ үг нь бурханлаг хөгжилд итгэгчдийг зааж байгаа юм.

Ариун судар номын үнэ цэнэ ба хүний соёл иргэншлийн хөгжил дэвшилд итгэдэг хүмүүсийг зөв үйлтэн, шударга бус хүмүүс хэмээн хоёр ангилдаг. Зөв үйлт хүмүүс нь мэдээжээр мэдрэхүйдээ цэнгэл эдлүүлэх ямар нэг таатай сайн үр дүнд хүрэхийн тулд буянт кармын үйлийг эрхэлдэг. Өөрийн мэдрэхүйгээ хангахын тулд зөв үйл үйлдэж буй олон олон хүмүүсээс зөвхөн ганц нь Туйлын Үнэнийг танин мэдэхүйн тухай ойлголтонд хүрдэг. Тэднийг *жнāни* буюу гүн ухаантан-туршигчид хэмээн нэрлэдэг. Олон зуун, олон мянган ийм гүн ухаантнуудаас цөөхөн нь ангижрал гэгээрэлд хүрдэг. Ангижралд хүрмэгц хүн онолын хувьд амьд оршнол нь материаллаг элементүүдээс бүтдэггүй юм байна, харин материас ялгаатай сүнс юм байна гэдгийг ойлгодог. Энэхүү үзэл баримтлалыг онолын хувьд ойлгох нь ч ангижирсан гэж нэрлэгдэхэд хангалттай ч үнэн хэрэгтээ мукта- буюу ангижирсан сүнс гэдэг нь өөрийн төлөвт байдлын хувьд Бурханы мөнхийн албат гэдгээ ойлгосон хүнийг хэлдэг. Тийм ангижирсан сүнснүүд нь итгэл болоод чин бишрэлтэйгээр Бурханд үйлчлэн зүтгэж байдаг ба тэднийг *крш᳚а-бхакта* нар буюу *Крш᳚аг* ухамсарлагч нар хэмээдэг.

Крш᳚а - бхакта нар нь бүх материаллаг хүслээс ангид байдаг. Онолын хувьд ангижирсан амьд оршнол нь материаллаг бус хэмээх мэдлэгийг зүгээр л эзэмшдэг ба хүсэл нь түүнд үлдсэн байж болно. Хэдийгээр тэд хэлбэр төдийгөөр ангижирсан сүнсний ай бүзлэгт хамаардаг ч. Тэдний гол хүсэл нь Бурханы Дээд Бодгальтай нэгдмэл болох. Жам ёсоороо тийм хүмүүс нь ведийн зан үйл болон материаллаг сайн сайхан зүйлээр цэнгэхийн тулд үйлддэг буянт үйлэндээ уягдсан байдаг. Тэр ч байтугай тэдний зарим нь материаллаг цэнгэл жаргалын дээр гарсан байж болох ч ялгаагүй тэд Дээд Бурханы ахуйд нэгдэн уусч бурханлаг ертөнцөд цэнгэх оролдлогоо орхидоггүй. Тэдний заримд нь ид шидийн йогийн тусламжтайгаар ид шидийн хүчнийг олох хүсэл ч байдаг. Энэ хүслүүд зүрхэнд байсан цагт тэрээр цэвэр чин бишрэл зүтгэлийн мөн чанарыг ойлгож чаддаггүй. Байнгын ийм хүсэлд баригдсан хүн нь амар тайван байж чаддаггүй. Хүнд материаллаг төгс төгөлдрийн

өчүүхэн хүсэл үлдсэн байсан цагт тэрээр тайван байдлыг олж чадахүй. Бурхан Кршңагийн чин бишрэлтэнгүүд нь ямар ч материаллаг хүсэл үгүй байдаг болохоор тэд чухамхүү амар тайван байдал гэдгийг мэдэх энэ материаллаг ертөнц дахь цорын ганц хүмүүс юм. Үүнийг *Шрїмад-Бхāгаватамд*:

муктāнāм апи сиддхāнāм

нāрāйāна-нарāйāнах

судурлабхах прашинтāтмā

котшиве апи махāмуне

“Ай аугаа мэргэн минь ээ, ангижралд хүрсэн эсвэл ид шидийн йогт амжилт олсон олон сая хүмүүсийн дундаас Бурханы Дээд Бодгальд өөрийгөө бүрнээ даатгасан, амар тайван байдлаар дүүрэн хүнийг олох нь ховор”.

Тийнхүү Бурхан Чаитанья энэ материаллаг ертөнцөд төөрч будилж яваа олон мянган, олон сая амьд оршнолуудаас Бурхан Кршңа ба номын багшийн өршөөлөөр чин бишрэл зүтгэлийн үрийг хүртсэн азтантай маш ховор учирч болно хэмээн тайлбарлажээ. Буянлаг, шүтлэг бишрэлт хүмүүс нь ерөнхийдөө янз бүрийн сүм хийдүүдэд шүтээн бурхадад нь мөргөх дуртай байдаг ч хэрэв тохиолдлоор түүнийгээ үл мэдэн Бурхан Вишңугийн өмнө эсвэл Бурханы чин бишрэлтэн ваишңавын өмнө мөргөн залбирвал энэ мөчид тэрээр Бурханы Дээд Бодгаль тийш хүрэлцэн очиход зайлшгүй хэрэгтэй аз хийморийг олж авдаг. Үүнийг их мэргэн Нарaдын амьдралын түүхээс баттай харж болно. Энэ түүх нь *Шрїмад-Бхāгаватамд* өгүүлэгдсэн буй. Өөрийн урьд төрөлдөө Нарaда ваишңавт үйлчилж байсны ачаар тэрээр Бурханы чин бишрэлтний адислалыг хүртсэн бөгөөд их мэргэн болсон юм. Түүнээс гадна түүнийг мэргэдүүдийн хамгийн аугаа нь гэж тооцдог.

Ваишңавууд буюу чин бишрэлтнүүд нь ерөнхийдөө болзолт сүнснүүдэд нэн өршөөнгүй байдаг. Ямар ч урилгга заллагыг хүлээлгүйгээр чин бишрэлтэн нь хүмүүсийг гэгээрүүлж, амьд оршнолуудын төлөвт байр суурь нь Бурхан Кршңагийн мөнхийн албат юм хэмээх мэдлэгийг зүрхэнд нь суулган өгч тэднийг мунхагийн харанхуйгаас гаргахаар хаалганаас хаалга тогшин явах бөлгөө. Тийм чин бишрэлтнийг Бурхан Өөрөө хүмүүсийн дунд Бурханы ухамсар буюу Кршңагийн ухамсрыг түгэн дэлгэрүүлэх бүрэн эрхийг олгодог. Тэд номын багшаас бүрэн эрх шингээгдсэн хэмээн алдаршсан ба зөвхөн түүний өршөөлөөр л болзолт амьд оршнолууд нь чин бишрэл зүтгэлийн үрийг хүлээж авдаг. Нэгдүгээрт хүн, болзолт сүнснийг чин бишрэл зүтгэлийн амьдралын дээд шатанд аваачиж чадах жинхэнэ номын багштай учрах үедээ Бурханы учирр шалтгаангүй өршөөл гэж юу болохыг ухамсарладаг. Ийм учраас Бурхан Чаитанья номын багшийн өршөөлөөр Бурханы учир шалтгаангүй өршөөлийг хүлээн авч болох ба харин Бурханы Дээд Бодгалийн өршөөлөөр жинхэнэ номын багшийн өршөөл адислалыг хүтэж болно гэж айлдсан.

Ингэж номын багшийн болон Кршңагийн өршөөлөөр хүн чин бишрэл зүтгэлийн үрийг олж авдаг. Түүнд зөвхөн цэцэрлэгч үнэ цэнэтэй модны үрийг суулган

ургуулдаг шиг өөрийн зүрхэндээ энэ үрийг суулгах л үлдэж байгаа юм. Энэ үрийг суулгачихаад хүн Дээд Бурханы ариун гэгээн нэрийг давтан, мөн сонсож, цэвэр чин бишрэлтэнгүүдийн хүрээлэлд чин бишрэлийн эрдэм ухааны тухай хүүрнэх хүрнэлд оролцох байдлаар түүнийг усан тордох ёстой. Чин бишрэлийн үр нахиалахад энэ нахиа нь цааша чөлөөтэй ургаж эхэлнэ. Харин чин бишрэлийн энэ нахиа бүрэн дүүрэн ургаж хөгжихөд орчлонг уртаашаа болон өргөөшөө нэвт ургах ба бүх зүйл нв брахмажйотийн туяагаар сүлэлдэн байдаг трансцендент атмосферт нэвтрэн ордог. Энэ ургамал нь брахмажйотийн хязгаарыг ч нэвтэлж аажмаар Голока Врндāван гэж нэрлэгдэх гаригуудад хүрдэг. Энд энэ ургамал Крш᳚агийн бадамлянхуан өлмийд өмөг түшгийг олдог. Энэ нь чин бишрэл зүтгэлийн эцсийн зорилго. Ийм байр сууринд хүрээд ургамал нь Бурханыг хайрлах хайрын үр жимс гэж нэрлэгдэх жимсийг өгдөг. Гэвч чин бишрэлтэн, трансцендент цэцэрлэгч нь өдөр бүр энэ ургамлыг дуулах, ба сонсохуйн усаар услаж байх хэрэгтэй. Хэрэв дуулах, сонсохуйгаар ургамлыг үл уславал мэдээжээр тэр хатан хувхайрна.

Бурхан Чаитанья Рӯпа Госвāmй чин бишрэлийн модны үндсийг усалснаар хүн тодорхой аюул заналтай тулгарч болох тухай сануулан айлдсан. Ургамал бага зэрэг урган өсөөд ирэх үед мал амьтан ирж түүнийг идэх, эсвэл гишгэчихэж болно. Ямар нэг амьтан түүний ногоохон навчийг идэхэд ургамал нь мэдээжээр үхэж орхидог. Араатан амьтдаас хамгийн аюултай галзуурсан заан. Учир нь хэрэв галзуу заан цэцэрлэгт орвол тэрээр ургамал болон модонд маш их хохирлыг авч ирнэ. Бурханы цэвэр чин бишрэлтнийг доромжлон гутаахыг *ваишнавāпарāдха* буюу галзуурсан зааны доромжлол гэдэг. Чин бишрэлийн үйлэнд зүтгэж буй цэвэр чин бишрэлтэн хүний өлмийд алдас доромжлол учрулах нь юу ч үгүй хоосролд хүргэж болно. Иймээс бхактийн ургамлыг арчлан хамгаалж байх нь чухал. Түүнийг арчлан тордож, алдас доромжлолоос няхууар зайлсхийн. Хэрэв хүн хянуур болгоомжтой бол ургамал ном ёсоороо урган хөгжиж чадна.

Ариун гэгээн нэрийг эсрэг үйлдэж олох арван үндсэн алдас бий. Нэгдүгээрт, ариун гэгээн нэрийн алдар сууг бүх дэлхий нийтээр тараан түгээхээр чармайж буй аугаа чин бишрэлтнийг муулах. Крш᳚агийн ариун нэр нь Крш᳚агаас Өөрөөс нь ялгаа үгүй ба Түүний ариун нэрийг бүх дэлхий даяар тараан түгээхийг оролдож буй хүн нь Түүний хайрыг татсан байдаг. Крш᳚а Өөрөө Түүний цэвэр чин бишрэлтнийг доромжлохыг тэвчдэггүй. Хоёр дахь алдас доромжлол нь, Бурхан Виш᳚у нь Туйлын Үнэн гэдгийг үгүйсгэх. Түүний нэр, чанар, хэлбэр, тоглоом, үйл зэргийн хооронд ялгаа байдаггүй ба тийм ялгаатай мэтээр харж буй хүнийг алдас үйлдэгч хэмээн тооцдог. Бурхан бол Бүхний Дээд ба Түүнээс аугаа хийгээд Түүнтэй тэнцэх нь үгүй. Мэдээжээр хэрэв хүн Бурханы нэр нь сахиулсан тэнгэрийн нэрээс ялгаагүй гэж боддог бол тэрээр алдас хийж буй юм. Дээд Бурханыг хэзээ ч сахиулсан тэнгэрүүдтэй адил тэнцүү гэж үзэж болохгүй.

Гурав дахь алдас нь жинхэнэ номын багшийг эгэл жирийн хүн гэж тооцох. Дөрөв дэхь алдас нь ведийн утга зохиол, *Пурāн* гэх мэт нэр хүндтэй судар бичгүүдийг муучлах. Тав дахь алдас нь ариун гэгээн нэрэнд угаас байх алдар сууг хэтрүүлэг хэмээн тооцох. Зургаа дахь алдас нь ариун гэгээн нэрийн тухай хуурамч онол зохиох. Долоо дахь нь ариун гэгээн нэрийн хүч чадалд найдан нүгэлт үйл үйлдэх. Ариун гэгээн нэрийг давтан унших нь хүнийг урьд өмнөх нүгэлт үйлийн үр

дагавраас ангижруулах тодорхой ч энэ нь ариун нэрний хүч чадлад найдан үргэлжлүүлэн нүгэл үйлдэж болно гэсэн огтхон ч биш. Найм дахь нь шашны зан үйл, тэвчил наминчлал, тахилга өргөл болон огоорлын бусад хэлбэрүүдийг ариун гэгээн нэрийг давтан уншихтай адилтгах. Ариун гэгээн нэрийг давтах нь бараг л Бурханы Дээд Бодгальтай шууд харьцсантай бараг адил. Буянт үйл нь Бурханы Дээд Бодгальд ойртон дөхөх арга л бөгөөд түүнийг ямар нэг материаллаг шалтгаан сэдэлтэйгээр ч үйлдэж болно. Ес дэхь алдас нь түүнийг үл сонирхогч үл итгэгч нарт ариун гэгээн нэрийн гайхамшигт алдрын талаар ярих. Арав дахь буюу сүүлчийн алдас нь Бурханы ариун нэрийг давтан унших болон сонссоныхоо дараа ч өөрийн материаллаг уягдал татагдлаа хадгалах. Үүний утга нь ариун гэгээн нэрийг алдасгүйгээр давтан уншсанаар хүн ангижралын түвшин хүртэл өгсөн дээшилж болно гэдэгт оршино. Ангижралын түвшинд хүн бүхий л материаллаг уягдал татагдлаас ангижирдаг. Мэдээжээр, хэрэв хүн ариун гэгээн нэрийг давтах ба үүний хамт материаллаг уягдал татагдлаа хадгалан байвал энэ нь тэрээр ямар нэг алдас үйлдэж байна гэсэн үг юм.

Мөн өөр бусад чин бишрэл зүтгэлийн ургамлын хэвийн өсөлт хөгжилтөнд саад болдог хүчин зүйлүүд бий. Энэ ургамалтай хамтаар материаллаг хүслийн хог ургамлууд ургадаг. Хүнд бхакти хөгжихөд түүнд жам ёсоороо олон тооны хүмүүс шавиа болгож авахыг хүсэн үүний хамт ямар нэг материаллаг ашиг сонирхлыг тээн хүрэлцэн ирдэг. Хэрэв хүнийг олон тооны шавь нар, шавь нарынх нь бүтээн бий босгосон материалаг тав тухтай байдал соронздон татвал тэрээр өөрийн жинхэнэ ноын багшийн үүргээ мартаж ба энэ нь бхактийн модны ургалтанд саад болж болно. Материаллаг тав тухтай байдлыг зүгээр л ашигласнаар хүн хүн өөртөө материаллаг тав тухтай байдлаар цэнгэх дур сонирхлыг хөгжүүлдэг.

Ангижрах хүслийг таатай сайн бус хэмээн тооцдог. Хүсэх хэрэгтэй зүйл бол үйлчлэн зүтгэхүй юм. Хориг болон хязгаарлалтыг үл хэрэгсэх нь мөн таатай бус. Нэр хүндтэй Бичээсүүдэд дараахь хоригуудыг дурдсан байдаг: хууль бус эр, эмийн харьцаанд орох, мансууруулах бодис хэрэглэх, мах идэх, мөрийтэй тоглоомонд оролцох зэргийг үл хийж болно. Эдгээр нь чин бишрэлийг үйлдэхээр оролдож буй хүмүүст хориотой. Хэрэв энэ бүх хоригуудыг хатуу үл баримталвал энэ нь чин бишрэл зүтгэлийн үйлийг хийж гүйцэтгэхэд ихээхэн садаа болно.

Өчүүхэн төдий болгоомжгүй байдал нь тэр ч атугай чин бишрэл зүтгэлийн модыг услаж байсан ч хэрэгцээгүй хог ургамлууд ургах ба тэдгээр нь тэдний хөгжилд саад болдог. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл цэцэрлэгийг ихээр уславал энэ нь хүсүүштэй ургамлууд болоод үл хүсүүштэй ургамлуудыг хурднаар ургах боломж олгодог. Хэрэв цэцэрлэгч эдгээр саадыг харалгүй тэднийг үл зайлуулвал тэд эрх ноёрхлоо тогтоонь чин бишрэлийн мод ургахад саад болнов Гэвч хэрэв хүн маш хянуураар энэхүү хүсэшгүй ургамлын үндсийг ургахгүй байхаар харж хандаж байвал чин бишрэлийн нахиа гоёмсгоор урган цэцэглэж эцсийн зорилго болох Голока Врндāванд хүрдэг. Чин бишрэлээр үйлчлэн зүтгэгч амьд оршнол нь Бурханыг хайрлах хайрын үр жимсний амтыг мэдэрсэн цагт шашны бүхий л зан үйллэг байдал, эдийн засгийн байр сууриа сайжруулах асуудлуудаа бүрнээ мартдаг. Түүний өөрийнхөө мэдрэхүйг хангах гэсэн хүсэл болон Дээд Бурхантай нэгдэж Түүний гэрэл туяанд уусах гэсэн хүсэл ч мөн үгүй болдог.

Бурханлаг мэдлэг болон трансцендент жаргал цэнгэлийн олон янзын шат байдаг. Нэг түвшинд нь *Ведэд* заагдсан зан үйллэг өргөл тахилга, тэвчил

намичлал, буянт үйл, ид шидийн йог оршдог. Эдгээрээр хөөцөлдөгч хүн нь янз бүрийн үр дагавраар шагнагддаг ба энэхүү шагналууд нь хүнийг Бурханыг хайрлах трансцендент хайрын үйлчлэн зүтгэхүйн түвшинд хүртэл маш их дур булаам санагддаг. Бурханыг хайрлах хайр нь хүн бүрт зүүрмэглэн буй бөгөөд могойнд хатгуулсан хүнийг нашатырын спиртээр сэрээдэг шиг цэвэр чин бишрэлээр үйлчлэн зүтгэснээр сэрээж болно.

Чин бишрэлийн тухай энэ бүх зүйлийг яриад Бурхан Чаитанья Рӯпа Госвāmид чин бишрэл зүтгэлийн яг өөрийнх нь тухай болон түүний шинж тэмдгүүдийн талаар өгүүлж эхлэв. Тэрээр цэвэр чин бишрэл зүтгэлийн үйлийн хувьд Кршṇагийн ухамсартаа өсч хөгжих хүслээс өөр ямар ч хүсэл байдаггүй тухай тайлбарлаж байна. Кршṇагийн ухамсрын хувьд ямар нэг сахиулсан тэнгэрт мөргөх юм уу эсвэл Кршṇагийн өөр ямар нэг дүр хэлбэрт мөргөх, цэцэрхийллийн туршилтат гүн ухаанд хандах эсвэл кармын үйлэнд тэмүүлэх ямар нэг орон зай байдаггүй. Чин бишрэлтэн энэ бүх бохирдлуудаас ангижрах хэрэгтэй. Тэрээр сүнсийг биед тогтоон барьж байхуйд шаардагдах зүйлийг л зөвхөн хүлээн авах ёстой ба биеийн хэрэгцээ шаардлагаас даван гарсан бүхнээс татгалзах хэрэгтэй. Биеэ тогтоон хангах хамгийн зайлшгүй чухал зүйлийг л хүлээн авах хэрэгтэй. Бие махбодийн бүх хэрэгцээ шаардлагыг хамгийн бага түвшинд аваачин хүн өөрийн ихэнхи цаг хугацааг Бурханы ариун нэрийг давтан дуулахын тусламжтайгаар Кршṇагийн ухамсраа хөгжүүлэхэд зориулж болно. Цэвэр чин бишрэл зүтгэл гэдэг нь биеийн бүх мэдрэхүй Бурханд үйлчлэхүйд автсан байхыг хэлнэ. Одоо цаг үед бидний болзолдсон байдалд оршин буй тул бидний бие махбодь мөн болзолт төлөвт оршин буй юм. Үүний улмаас бид, бидний бие махбодь ямар нэг тодорхой нийгэм, улс гүрэн, гэр бүлд харьяалагддаг хэмээн боддог. Иймэрхүү байдлаар бие нь маш олон тодорхойлолтуудтай холбоотой болдог. Мэдрэхүй нь биед хамаардаг болохоор бие тийнхүү нөхцөлдсөн байдалд ордог ба энэ нь мөн буцаад мэдрэхүйнүүд дээр ч бий болдог. Энэ нь мэдрэхүйг гэр бүлийн, нийгмийн, үндэстний гэх мэт зүйлсийн ашиг сонирхлын төлөө үйлдэхэд хүргэдэг. Ийм үйлэнд автсанаар тэд Кршṇагийн ухамсраа хөгжүүлж чадахгүй. Мэдрэхүй ариуссан байх ёстой ба энэ нь хүн тэрээр Кршṇад харьяалагддаг, түүний амь амьдрал мөн Кршṇад харьяалагддаг гэдгийг эцсийг нь хүртэл ойлгосон цагт л ойлгомжтой болно. Чин бишрэлтэн нь тэрээр мөн чанартаа Кршṇагийн мөнхийн албат гэдгээ ойлгох ёстой. Тэгж байж тэрээр өөрийн мэдрэхүйнүүдээ Бурханд үйлчлэхүйд зориулж чадах ба үүнийг цэвэр чин бишрэлийн үйл хэмээн нэрлэнэ.

Цэвэр чин бишрэлтэн нь Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйг хүлээн авдаг ч хувийн мэдрэхүйн таашаал авчрах бүх төрлийн ангиралыг үгүйсгэдэг. *Шрїмад-Бхāгаватамд*(3.29.11-13) Бурхан Капила, бүгдийн зүрхэнд залрах Бурханы Дээд Бодгалийн трансцендент чанар ба аугаа байдлын талаар дөнгөж сонсмогц түүний ухаан Гангын ус тэнгсийн тэмүүлэн чиглэдэг шиг тэрхэн даруйд Бурханыг зорин тэмүүлдэг хэмээн тайлбарлажээ. Ийм мэт Бурханы Дээд Бодгальд үйлчлэхүйд аяндаа өөрөө ундран гарах татагдал нь цэвэр чин бишрэлийн үйлэн дэхь хамгийн чухал зүйл юм. Хүн ямар нэг материаллаг ашиг хожоо харалгүйгээр мөн ямар ч материаллаг саад бэрхшээлийг үл ажран Дээд Бурханд

үйлчлэн зүтгэхэд автаж байвал чин бишрэлийн үйл зүтгэл цэвэр ариун болдог. Цэвэр чин бишрэлтэн нь Дээд Бурхантай нэг гариг дээр амьдрах, Бурханы эзэмшдэг шиг тийм баялагийг эзэмших, Бурханд байдаг шиг тийм дүр хэлбэртэй болох, Түүнтэй нүүр нүүрээ харалцан амьдрах, Түүний ахуйд уусан нэгдэх гэх мэт ямар ч хүсэл байдаггүй. Тэр ч байтугай Бурхан Өөрөө чин бишрэлтэнд эдгээр шагнал урамшгууллаудыг өргөн барилаа ч тэрээр эдгээрээс татгалздаг. Хэргийн учир нь чин бишрэлтэн Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйд маш ихээр автсан байдаг учраас түүнд ямар нэг ашиг хонжооны талаар бодох цаг зав байдаггүй. Тэрээр зөвхөн өөрийн шууд үүрэг зорилгын тухай л боддог. Энэ нь жирийн нэг бизнесмен-материалист өөрийн хийж буй ажил үйлэндээ автан өөр бусад зүйлийн талаар бодох сөхөөгүй болсон байдагтай адил Бурханд үйлчлэгч цэвэр чин бишрэлтэн нь өөрийн үйлээс өөр юуны ч тухай боддоггүй.

Хүн ийнхүү өөрийн үйлчлэн зүтгэлд автах нь тэрээр бхактийн өндөр түвшинд оршин буй гэсэн үг. Ганцхан ийм трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйн тусламжтайгаар *майāгийн* нөлөөг даван туулж чадах бөгөөд Бурханыг хайрлах цэвэр ариун хайрыг амсаж чадна. Хүн хууран мэхлэгч хоёр шулам хэмээн нэрлэгддэг материаллаг ашиг хожоо ба ангижралыг хүсч байсан цагт тэрээр Дээд Бурханд трансцендентаар хайраар үйлчлэн зүтгэхүйн сайхан амтыг мэдэрч чадахгүй.

Чин бишрэл зүтгэлийн гурван түвшин байдаг. Анхны эхлэлийн шат нь чин бишрэл зүтгэлийг ургуулж тордох үе, хоёр дахь шат нь үйлчлэл зүтгэлийг хэрэгжүүлэх үе, гурав дахь буюу дээд шат нь Бурханыг хайрлах хайранд хүрэх. Чин бишрэл зүтгэлийг ургуулж тордох есөн янзын арга бий. Эдгээр нь сонсох, давтах, дурсан санах гэх мэт ба энэ бүх аргуудыг эхний шатанд ашигладаг. Хэрэв хүн давтах ба сонсохыг итгэл ба чин бишрэлтэйгээр гүйцэтгэх аваас тэрээр бүх материаллаг эргэлзээ аажмаар даван туулна. Чин бишрэл зүтгэл дэхь итгэлийнхээ хэмжээгээр тэрээр төгс төгөлдрийн дээд шат байдагт эргэлзэхээ болидог. Тийнхүү тэрээр чин бишрэл зүтгэлийн зам мөртөө батаждаг ба түүний чин бишрэл зүтгэлийн үйлэнд тэмүүлэх амт өсөн нэмэгдэж татагдал, оргилсон онгод хөөрлийн мэдрэмж бий болно. Энэхүү онгод хөөрөл нь Бурханыг хайрлах хайрын хөгжлийн эхний үе шатуудад ажиглагдана. Түүнд хүн чин бишрэл зүтгэлийг даган биелүүлснээр хүрдэг. Хэрэв хүн сонсох ба давтахаа үргэлжлүүлэн гүйцэтгэж байх аваас түүнд уягдан татагдах байдал улмаа өсөн нэмэгдэх бөгөөд энэ татагдал нь Бурханыг хайрлах хайр гэсэн нэрийг авдаг.

Гурав дахь шат буюу Бурханыг хайрлах трансцендент хайранд хүрсний дараагаар трансцендент дурлан татагдалт, трансцендент гаслан, үлэмж ихээр уягдан таатгдсаны улмаас хүчтэй онгод хөөрөлд орох гэх мэтээр нэрлэгдэх цаашдын хөгжил явагддаг. Эдгээр төлөв байдлуудыг *рāга*, *анурāга*, *бхāва*, *махāбхāва* гэх зэрэг тусгай нэр томъёонуудаар тодорхойлдог. Нэг шатнаас нөгөө шатанд шилжих шилжилтийг чихрийн шүүсийг өтгөрүүлэх үйлтэй зүйрлэж болно. Чихрийн шүүс нь эхний шатандаа ус мэт шингэн байдаг. Түүнийг ширгээх тусам тэрээр улам улмаа өтгөрч бурам болон хувирах ба эцэст нь элсэн чихэр, мөсөн чихэр зэрэг болон хувирдаг. Чихрийн шингэн шүүс нь нэг шатнаас нөгөө шатанд шилжин элдэв хувирлуудыг дамжин өнгөрдөг шиг Дээд Бурханыг хайрлах трансцендент хайр нь үе шатаар дамжин хөгждөг.

Хүн үнэхээр трансцендент түвшинд хүрэхэд тэрээр хэлбэрэлт гуйвалтгүй болдог. Гэвч тэрээр энэ байр сууринд хүрээгүй байсан цагт түүний төлөв байдал тийм ч тогтвортой бус ба мөн унаж ч болно. Харин хүн үнэхээр трансцендент байр сууринд хүрэхэд тэрээр унахаас айхгүй байж болно. Энэ түвшний ойлголтонд *стхāйи-бхāва* гэсэн тусгай нэр томжөөг ашигладаг. Гэвч энэ түвшнээс дээш *вибхāва, анубхāва, сātвика, вйабхичārī* гэж нэрлэгдэх шатууд байдаг. Зөвхөн хүн эдгээр шатуудад жинхэнээр хүрсний дараагаар расын харилцаа буюу Дээд Бурхантай харьцах трансцендент харьцаа эхэлдэг. Энэхүү дурлагч ба дурлуулагч хоёрын хорондох хайрын харилцааг ерөнхийдөө *Кришṇа-бхакти-раса* гэж нэрлэдэг. Трансцендент хайрын харьцаа нь дээр өгүүлсэнчлэн стхāйи-бхāвын бат бөх суурин дээр суурилдаг гэдгийг тэмдэглэх хээргтэй. Вибхāвын суурь зарчмыг стхāйи-бхāва гэж нэрлэдэг ба харин бусад бүх үйл нь трансцендент хайрыг хөгжүүлэхэд туслах функцийг гүйцэтгэдэг.

Трансцендент хайрын онгод хөөрөл нь нөхцөл байдал, сэргэн хөглөгдөх шалтгаан гэсэн хоёр бүрдмэл хэсгээс тогтдог. Нөхцөл байдал нь мөн цааш тухайн зүйл, зорилго гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Чин бишрэлийн солилцоо нь тухайн зүйл, харин Кришṇа нь зорилго юм. Трансцендент шинж чанар нь сэргэн хөгжихийн шалтгааныг бүрдүүлдэг. Энэ нь Кришṇагийн трансцендент чин бишрэлтнийг Түүнд үйлчлэн зүтгэхэд өдөөн дууддаг гэсэн үг юм. Имперсоналист-гүн ухаантнууд нь (*майāвадууд*) Туйлын Үнэн нь ямар нэг онцгой чанаргүй гэж ярьдаг ч ваицṇав-гүн ухаантнууд нь Туйлын Үнэнийг ниргуṇа(чанаргүй) хэмээн тайлбарладаг. Учир нь Түүнд материаллаг шинж чанар үгүй байдаг. Энэ нь Тэрээр бурханлаг шинж чанарыг агуулдаггүй гэсэн үг биш. Харин ч эсрэгээр Бурханы бурханлаг чанар нь аугаа их, аугаа гайхамшигтай ба тэрхүү чанарууд нь ангижирсан сүнснүүдийг ч өөртөө татаж чаддаг. Энэ тухай *Шрймад-Бхāгаватамын āтмārāма-шлокт*, хэн бээр бүр өөрийгөө танин ухамсарлахуйн түвшинд хүрсэн байлаа ч Кришṇагийн трансцендент чанаруудад татагддаг хэмээн өгүүлжээ. Энэ нь Кришṇагийн чанар материаллаг бус харин цэвэр тунгалаг, трансцендент гэсэн үг юм.

Онгод хөөрлийн дээд шат нь дараахь арван гурван үйлийн хэлбэрээр илэрч болдог: (1)бүжиглэх, (2)газраар өнхрөн хөрвөөх, (3)дуулах, (4)алгаа таших, (5)биеийн үс босох, (6)чангаар хашгирах, (7)эвшээх, (8)хүндээр амьсгаадах, (9)нийгмийн нөхцөл байдлыг огтхон ч үл хэрэгсэх, (10)шүлс гоожих, (11)инээх, (12)...өвчнийг мэдрэх, (13) ханиалгах. Энэ бүх шинж тэмдгүүд нэгэн зэрэг илэрдэггүй; тэд трансцендент харилцаатай харгалзан илэрдэг. Заримдаа эдгээр шинж тэмдгүүдийн нэг нь, зарим үед нөгөө нь гэх мэтээр.

Трансцендент раса буюу харилцааг таван хэлбэрт хувааж болно. Эхлэлийн шатыг *шāнта-рати* гэж нэрлэдэг. Энэ шатанд материаллаг бохирдол бузраас ангижирсан хүн нь Бурханы Дээд Бодгалийн аугаа байдлыг танин ойлгодог. Хатуухан хэлбэл, энэ шатанд хүрсэн ч хүн Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэдэггүй. Учир нь энэ нь идэвхигүй үе шат юм. *Дāсйа-рати* гэж нэрлэгдэх хоёр дахь шатанд хүн өөрийн байр суурины хувьд үргэлж Дээд Бурханы захиргаанд

оршдог ба тэрээр Бурханы Бодгалийн учир шалтгаангүй өршөөлөөс мөнхөд хамааралтай гэдгээ ойлгодог. Үүний зэрэгцээ түүнд, өсч том болсон хүү тэрээр эцгийнхээ өмнө чухамхүү ямархан үүрэг хариуцлага хүлээснээ ойлгож эхэлдэг шиг ердийн уягдал татагдал сэргэдэг. Энэ шатанд амьд оршнол нь худал хуурмаг буюу *майād* үйлчлэхийн оронд Дээд Бурханд үйлчлэхийг хүсдэг. *Сакхйа-рати* хэмээн нэрлэгдэх гуравдахь шатанд трансцендент хайр хөгжих ба хүн Бүхний Дээдтэй ижил тэнцүү мэтээр харьцаж, Түүнийг хайрлаж хүндэтгэж эхэлдэг. Энэ шатны цаашдын хөгжлийн хирээр түүнд тоглоом наргиан болон албадлагын бус инээд, хөхрөөн гэх мэт харилцаа илэрнэ. Энэ нь Дээд Бодгальтай харьцах ах, дүүгийн харилцаа бөгөөд энэ шатанд хүн өөрийгөө ямар нэг уяа хүлээснээс бүрэн ангид болохыгоо мэдэрдэг. Энд тэрээр амьд оршнол болсон тэрээр захирагдагч байр сууринд оршдог гэдгээ бараг л мартаж авч үүний хамт тэрээр Дээд Бодгалийг гүн сэтгэлээсээ хүндэтгэх сэтгэгдэл төрнө.

Вāтсалйа-рати гэж нэрлэгдэх дөрөв дэхь шатанд өмнөх шатанд илэрсэн ах дүүсийн харьцааны мэдрэмж хөгжсөөр эцэг, эхийн хайр болон хувирдаг. Энэ үед амьд оршнол нь Бурханы эцэг нь эсвэл эх нь болхыг тэмүүлнэ. Бурханд мөргөхийн оронд амьд оршнол нь харин Бурханы Бодгалийн мөргөлийн объект болсон Бүхний Дээдийн эцэг нь эсвэл эх нь болдог. Энэ шатанд Бурхан Өөрийн чин бишрэлтнээс хамааралтайгаар орших ба Түүнийг өсгөж хүмүүжүүлтүгэй хэмээн Өөрийгөө цэвэр чин бишрэлтнийхээ халамж анхааралд даатгана. Энэ шатанд хүрсэн чин бишрэлтэн нь Дээд Бурханыг тэвэрч, тэр ч бүү хэл Түүний толгойг нь хүртэл үнсэх тийм байр сууринд оршино. Тав дахь шатыг *мāдхурйа-рати* гэж нэрлэх ба энэ шатанд дурлалт хосуудын хоорондох жинхэнэ амраг хайрын харьцаа эхэлдэг. Энэ шатанд Кршṇа ба Врāжийн малчин бүсгүйчүд бие биенээ нүдээрээ гөлрөн ширтэх бөгөөд учир нь энэ түвшинд харц, их хайр, нүдний хөдөлгөөн, таатай сайхан үг хэл, дур татам инээмсэглэл гэх мэтийн харилцан солилцоо үүснэ.

Эдгээр таван анхдагч *рас* буюу харилцаанаас гадна инээд, сонин үзэгдэл, баатар эрсийн харилцаанд орох, өрөвдөх, уурлах мэдрэмж, айдас болон бүрэн дүүрэн ялагдах гэх мэтээс тогтох өөр хоёрдогч долоон янзын харилцаа бий. Жишээ нь, Бхиṣṣма ба Кршṇа нарын хоорондох харилцаа нь баатар эрсийн *расад* орших хоёр дайчны харьцаа юм. Харин Хираṇйакашипу айдас, бүрэн ялагдлын расыг мэдэрч байв. Анхдагч таван рас нь цэвэр чин бишрэлтний зүрхэнд байнга орших ба харин хоёрдогч долоон рас нь нэг дэхь расуудын амт болон үнэрийг улам баян тансаг болгохын тулд заримдаа илэрч, заримдаа алга болдог. Анхдагч расуудыг баяжуулаад л тэд алга болно.

Шāнта-бхактийн жишээ болсон идэвхигүй харьцаанд орших чин бишрэлтнүүдийн тоонд есөн йогч багтдаг: Кави, Хави, Антарйкша, Прабуддха, Пиппалāйана, Авирхотра, Дравида буюу Друмила, Чамаса буюу Карабхāжана нар юм. Дөрвөн Кумār нь(Санака, Санандана, Санаткумāра, Санāтана) нар нь энэ шатанд оршигчдын жишээ. Хоёр дахь шатанд буюу дасйан харьцаанд оршигч чин бишрэлтнүүдийн жишээ нь Рактака, Читрака болон *Гокула-расад* орших Патрака нар болно. Энэ нь Бурханы албатын функц юм. Двāракад Дāрука, Ваикунṭхийн

гаригуудад Ханумāн ба бусад. Гураю дахь шат буюу найз нөхрийн шатанд оршигч чин бишрэлтэн нар нь Врндāванд Шридāмā, Двāракад болон Курукцетрийн тулааны талбарт Бхйма, Аржуна нар юм. Ийм олон олон чин бишрэлтэнгүүд бий. Кршңатай эцэг, эхийн хайрын харьцаанд оршигчид нь Йашодā, Махāрāжа Нанда буюу Кршңагийн эцэг, эх нар болон Түүний авга, нагац нар болон бусад төрөл төрөгсөд. Түүнтэй амраг хайрын харьцаанд Вражийн буюу Врндāваны малчин бүсгүйчүүд болон мөн Двāрака дахь цэцэглэн мандахын дарь эх нар буюу хатад ордог. Бурхантай энэ расад орших чин бишрэлтнүүдийн асар их тоог хэн ч тоолж барахгүй.

Кршңад уягдан татагдахыг мөн хоёр ангилалалд хувааж болно. Нэг түвшинд нь энэ татагдал тааламжтайхан дайсаар хучигдсан байдаг. Энэ төрлийн татагдал нь эрх чөлөөт байдлын тодорхой нэг дутагдалтай тал ба тэрээр Матхурт болон Ваикунтхгийн гаригууд дээр илэрдэг. Бурханы эдгээр гаригууд дээр трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйн уур амьсгал нь тодорхой хүрээнд хязгаарлагддаг. Гэвч Гокула Врндāванд хайрын харьцаа нь ямар ч хүрээ хязгаарт баригддаггүй. Хэдийгээр Врндāваны малчин бүсгүйчүүд Кршңа нь Бурханы Дээд Бодгаль гэдгийг мэддэг ч тэд Түүнд ямар ч айдас хүйдэс, хүндэтгэлийг илэрхийлдэггүй тийм л дотно харьцаатай байдаг. Анхдагч таван трансцендент харьцааны хувьд айдас, хүндэтгэл нь заримдаа Бурханы жинхэнэ аугаа байдлыг харахад тээр болох саад тотгор болдог ба заримдаа тэдгээр нь үнэхээр Бурханд үйлчлэн зүтгэхүйд саад болдог. Гэвч нөхөрлөл, эцэг, эхийн хайр, амраг сэтгэлийн хайр нь айдас, хүндэтгэлийг султгадаг. Жишээ нь, Кршңа Васудев, Девакй нарын хүү болон төрөхөд Түүний эцэг, эх Түүнд айдас, хүндэтгэлээр дүүрэн мөргөж байсан. Учир нь тэд Дээд Бурхан Кршңа Өөрөөр буюу Вишну өмнө нь тэдний хүүхэд байдлаар харагдаж буй гэдгийг сайтар ойлгож байсан юм. Үүнийг *Шрймад-Бхāгаватамд*(10.44.51) батласан байдаг. Хэдийгээр Дээд Бурхан нь өмнө нь тэдний хүүхэд байдлаар заларсан ч Девакй, Васудев нар Түүнд мөргөн залбирч эхэлсэн. Яг иймэрхүү байдал Аржунад мөн тохиолдсон юм: тэрээр Бурханы орчлонгийн дүр хэлбэрийг хараад Кршңагаас урьд өмнө нь Түүнтэй өөрийн найз мэтээр харьцаж байсандаа уучлалт гуйх хүртлээ айн сандарсан. Түүний найз Аржуна байнга л ямар ч ёслол хүндэтгэлгүйгээр Бурхантай харьцдаг байсан болохоор Бурханы айдас төрүүлэм орчлонгийн дүр хэлбэрийг хараад Аржуна дараахь үгийг хэлсэн:

сакхети матвā прасабхам йад уктам

хе кришңа хе йāдава хе сакхети

ажйāнатā махимāнам таведам

майā прамāдāt праңайена вāпи

*йач чāвахāсāртхам асаткрто си
вихāра-шаййāсана-бхожанецу
эко тхавāпй ачйута тат-самакцām
тат кцйāмайе твāм ахам апрамейам*

“Урьд өмнө нь би Чиний аугаа байдлыг мэдэлгүйгээр Чамайг: “Ай Кршңа”, “Ай Йāдава”, “Ай найз минь” хэмээн дууддаг байсан. Намайг ухаангүй, хайраар дүүрэн болгосон бүхнийг уучлан болгооно уу. Бид хамтдаа амарч байх үед, нэг орон дээр хэвтэж байх үед, эсвэл хамт хооллож байх үедээ Чиний гайхамшигт байдлыг олон удаа доош нь дарагдуулдаг байжээ. Үүнийг би заримдаа Чамтай хоёулхнаа байхад, заримдаа олон нөхдийнхөө өмнө үйлддэг байсан. Чамаас гуйя, миний энэ бүх алдас эндлүүдийг уучилж өршөөнө үү”(Бг. 11.41-42).

Үүнтэй адил зүйл Рукмиңид тохиолдож байв. Кршңа түүгээр тоглоом шоглоон хийхэд нь тэрээр Кршңа түүнийг орхих нь хэмээн ихэд айн, сандран мэгдэж, Кршңаг сэвүүрдэж байсан сарлагийн сүүл гараас нь мултран унаж, шалан дээр ухаан алдан унажээ. Врндāван дахь Кршңагийн ээж Йашодын тухай *Шрймад-Бхāгаватамд*(10.8.45):

*траййā чопаницадбхиш ча
сāнкхйа-йогаиш ча сātватаицх
упагййамāна-мāхātмйам
харим сāmанийатātмажам*

Бүхий л *Ведүүд*, *Упанишадууд* болон *сāнкхйан* гүн ухаан болон бусад бүх бат ноттой ариун судар номууд мөргөдөг Бурханы Бодгаль нь түүний хэвлийгээс төрдөг хэмээн тооцдог. Мөн Йашода ээж жаахан Кршңаг түүний бие махбодиос төрсөн жирийн хүүхэд мэтээр дээсээр хүлсэн гэж (Бхāг.10.9.12) өгүүлсэн байдаг. Кршңаг жирийн хүн мэтээр харьцаж байсан тухай өөр бусад жишээнүүд ч байдаг(Бхāг.10.18.24). Түүнээс гадна Өөрийн найзууд, малчин жаалуудтай тоглож байхдаа Тэрээр тэдэнд ялагддаг байсан хийгээд Кршңа тэднийг ялангуяа, Шрйдāмыг мөрөн дээрээ суулган тоглодог байв.

Врндāван дахь *гопй* нар болон Кршңагийн хоорондох харьцааны хувьд *Шрймад-Бхāгаватамд*(10.30.36-40), Шрй Кршңа *раса* бүжгийн үед зөвхөн Шрймати Рādхикаг авч одсон тухай өгүүлсэн байдаг. Энэ үед харин Тэрээр Кршңа бусад бүх *гопй* нарыг орхисон тухай л бодож байв. Үзэсгэлэн гоогоороо тэд Түүнээс дутахгүй ч Тэрээр Түүнд(Шрймати Рādхикад)маш их ханамж таашаалыг

өгсөн ба Тэрээр бардамхнаар: “Миний эрхэм хайрт Бурхан Кршңа үзэсгэлэнт гопй нарыг орхиж зөвхөн Надтай л цэнгэл эдлэж байна ” хэмээн боддог. Ойн гүнд Тэрээр Кршңад: “Миний эрхэм Кршңа минь ээ, Би байрнаасаа ч хөдлөж чадахгүй нь. Одоо Чи намайг хаа дуртай газар луугаа авч явж болно” гэж хэлдэг. Кршңа: “Миний мөрөн дээр суу” хэмээн хариулаад гэнэт алга болсон. Шрймати Радхика Өөрийн хувь тавиланд харамсан гашуудав.

Раса-бүжгийн үед Кршңа гэнэт алга болсон бөгөөд бүх гопй нар харамсан гашуудаж, “Хайрт Кршңа минь ээ! Бид нөхөр, хүүхэд, төрөл төрөгсөд, ах дүүс, найз нөхдөө орхин нааш ирсэн! Тэдний зөвлөгөөг үл хайхран бид Чамруу ирсэн билээ. Яагаад бид чухам ингэснийг Чи сайтар мэдэж байгаа. Яагаад бидний нааш ирснийг чи мэдэж байгаа шүү дээ. Яагаад гэвэл Чиний лимбэний амттайхан авиа биднийг соронздон татсан юм. Гэвч харин Чи охид, бүсгүйчүүд биднийг гүн харанхуй шөнөөр ганцаархнаар нь орхих тийм л зальтай амьтан юм! Хэн нэгэн рүү биш Чам руу”.

Шама хэмээх үг нь ухаанаа хянах, түүнийг Бурханы Дээд Бодгаль дээр төвлөрүүлэн бүхий л төрлийн хэлбийлт гажуудалгүйгээр тогтоон барих чадварыг хэлдэг. Хүний ухаан Дээд Бурхан дээр төвлөрөн байвал тэрээр шамын төлөвт хүрчээ гэж ярьдаг.

Энэ төлөвт чин бишрэлтэн нь Кршңа бол бидний туршлага туршилтын хүрээний бүх зүйлийн гадна орших анхдагч зарчим юм гэдгийг ойлгоно. Энэ тухай мөн *Бхагавад-гйтад*(Б.г.7.19)гайлбарласан байдаг. Тийм хүн нь Кршңа бүгдэд, бүх сансар огторгуйн илрэлд бүхэлд нь хаа сайгүй оршин байдаг гэдгийг ойлгож чадна. Хэдийгээр бүх зүйлс Дээд Бурханы хяналт ба Түүний эрч хчүний доор оршдог ч бүх зүйлс Түүний бодгаль дүр хэлбэрт орших Кршңагаас ялгаатай. Түүнчлэн *Бхакти-расамрта-синдху*д, үүнийг ухааран ойлгож, оюун ухаан нь Кршңа дээр төвлөрөн байх хүн нь шама төлөвт хүрдэг гэжээ. Түүнээс гадна, Бурханы Дээд Бодгаль: *шамо манництхатāt буддхех:* буюу Хүн Кршңагийн аугаа байдлын тухай мэдлэг, бүх илрэлийн шалтгаан болсон Түүний янз бүрийн эрч хүчний түгэлтийн талаарх мэдлэгийг багтаасан *шāнта-ратийн* түвшинд хүрээгүй байсан цагт тэрээр түүнд батжин бэхжиж чадахгүй хэмээн өгүүлжээ. Энэ тухай мөн Шрймад-Бхāгаватамд(Бхāг.11.19.36)-д:

шамо манництхатā буддхер

дама индрийа-самйамах

титикийā дүхкха-саммарцо

жихвопастха-жайо дхртих

Бурханы Дээд Бодгаль нь бүхий зүйлийн анхдагч эх үүсвэр хэмээх дүгнэлтэнд хүрсэн хүн ухааны бат тогтвортой байдалд хүрч чадна. Харин хүн өөрийн мэдрэхүйгээ хянан барьж чадаж байвал үүнийг мөн шама гэж нэрлэнэ. Мөн хүн мэдрэхүйгээ хянан барих, ухаанаа тэнцвэртэйгээр барьж байхын төлөө ямар ч

зовлон бэрхшээлийг амсахад бэлэн байвал үүнийг *титикциā* буюу тэвчээр гэж нэрлэдэг. Харин хүн өөрийн хэл ба бэлгийн эрхтний шавдалт шаардлагыг хянан барьж чадаж байвал үнийг *дхртих* хэмээн нэрлэнэ. *Дхртих* нь хүнийг *дхйра* буюу амар амгалан болгодог. Амар амгаланд хүрсэн хүн хэл болон бэлгийн эрхтний зүгээс учруулах түгшүүр хөөрлийг амсдаггүй.

Хэрэв хүн өөрийн ухаанаа хаашаа ч хэлбийлгүйгээр Крш᳚а дээр төвлөрүүлж чадна тэрээр Крш᳚агийн ухамсрын тогтвортой төлөвт буюу *шāнта-расын* төлөвт хүрч чадна. *Шāнта-расын* түвшинд хүрэхэд Крш᳚ад итгэх хэлбэрэлт гуйвалтгүй итгэл төрөх ба бүх материаллаг хүсэл үгүй болдог. Крш᳚ад итгэх гуйвалтгүй итгэл, Крш᳚атай холбоогүй бүх хүсэл үгүй болох зэрэг нь *шāнта-расын* үндсэн шинж чанар ба огторгуйн үүсгэсэн авиа нь бүхий л бусад элементүүдэд(хий, гал, ус, шороо) оршдог шиг бусад бүхий расуудад байдаг чанар юм. Үүнтэй адилаар *шāнта-расын* энэ хоёр чанар нь *дāсийа*(үйлчлэн зүтгэхүй), *сакхйа*(найз нөхрийн), *вāтсалия*(эцэг, эхийн) болон *мадхурйа-раса*(амраг сэтгэлийн) гэх мэт бусад бүх трансцендент харилцаанд оршдог.

Бид Крш᳚агийн тухай бус буюу Крш᳚атай холбоогүй хүсэл сонирхлын тухай ярьж байвал энэ нь Крш᳚агаас гадна орших ямар нэг зүйл гэсэн үг биш. Үнэн хэрэгтээ “Крш᳚а бус зүйл” гэж юу ч байдаггүй. Учир нь бүх зүйл Крш᳚агийн эрчмийн бүтээгдэхүүн юм. Крш᳚а болон түүний эрчим нь нэг нэгэнтэйгээ адил ба бүх зүйл тойруу байдлаар Крш᳚а болж буй хэрэг. Жишээ нь, ухамсар нь бүх амьд оршнолуудын мөн чанар боловч ухамсрын төвд зөвхөн Крш᳚а оршин байхуйд(Крш᳚агийн ухамсар) тэрээр цэвэр ариун байдаг ба харин ухамсар Крш᳚агаас өөр ямар нэг зүйл дээр төвлөрөн байвал, эсвэл тэрээр мэдрэхүйн цэнгэл рүү татагдан байвал түүнийг Крш᳚агийн ухамсар гэж нэрлэж болохгүй. Гэвч цэвэр ариун төлөвт Крш᳚агийн ухамсраас өөр юу ч байдаггүй.

Крш᳚ад тэмүүлэх эрч хүчтэй тэмүүлэл нь Крш᳚а надад харьяалагддаг, би Крш᳚ад харьяалагддаг гэсэн ойлголт бөгөөд миний үүрэг бол Крш᳚агийн мэдрэхүйг хангах гэх нь *шāнта-расын* идэвхгүй төлвөөс илүү өндөр түвшний чанар юм. Крш᳚агийн аугаа байдлыг зүгээр л ойлгох нь мөргөлийн объект нь нэг бол бодгаль бус Брахман, нэг бол Парамāтмā болж ч болох *шāнта-расын* түвшинд хүрэхэд хангалттай. Бодгаль бус Брахман хийгээд Парамāтмāд цэцэрхийллийн гүн ухаан болон ид шидийн ойгоор хичээллэгч нар мөргөн залбирдаг. Гэвч Крш᳚агийн ухамсрын буюу бурханлаг ойлголтын цаашдын хөгжлийн явцад хүн Парамāтмā буюу Дээд Сүнс нь мөргөлийн мөнхийн объект ба Түүнд өөрийгөө даатгах хэрэгтэй юм гэдгийг ухамсарлаж эхэлдэг. *Бахүнāм жанманāм анте жнāнавāн мāм*

прападйате(Б.г 7.19): “Брахман болон Парамātмāд мөргөн залбирсан олон олон амьдралын дараагаар хүн Вāсудевт өөрийгөө даатгаж, Түүнийг дээд эзэн, өөрийгөө Вāсудевын мөнхийн албат гэдгийг ойлгосон цагт тэрээр трансцендентыг танисан аугаа сүнс болдог”. Энэ үед Дээд Туйлын Үнэнд итгэх итгэлийн ачаар хүн Бурханы Дээд Бодгальд ямар нэг байдлаар трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйд татагдан ордог. Тийнхүү *шāнта-раса* гэж нэрлэгдэх идэвхигүй харьцаа нь *дāсийа-раса* буюу үйлчлэн зүтгэхүйг үүсгэдэг.

Дāсийа-расын шатанд Дээд Бурханаас тааламжтайхан айх, хүндэтгэн бишрэх нь өндөр хэмжээгээр илэрдэг буюу өөрөөр хэлбэл *дāсийа-расад* хүн Дээд Бурханы аугаа байдлыг ухамсарладаг. *Шāнта-расын* түвшинд бурханлаг үйл байдаггүй ч харин *дāсийа-расын* түвшинд үйлчлэл зүтгэл эхэлдэг. Тийнхүү *дāсийа-расад шāнта-расын* шинж чанар шингэсэн байдаг ба мөн түүн дээр нэмээд үйлчлэхүйн трансцендент амт нэмэгддэг.

Шāнта-раса ба *дāсийа-расуудад* мэдээжээр трансцендент чанарууд бий боловч энэ бүгдийн дээр өөр нэгэн чанар болох цэвэр трансцендент хайр болох тун дотнын уягдал татагдал байдаг. Энэхүү Дээд Бурханыг хайрлах дотнын хайрын хувьд *вишрамбха* хэмээх тусгай нэр томъёо бий. Ах дүүгийн харьцаан дахь *вишрамбхын* түвшинд Бурханы Дээд Бодгалийг хүндэтгэх айх, сөгдөн хүндлэх газар байдаггүй. Тийнхүү *сакхйа-раса* гэж нэрлэгдэх трансцендент ах дүүгийн харьцаа нь гурван онцлог байдалд харгалздаг: аугаа байдал шингэсэн ухамсар, үйлчлэн зүтгэхүй шингэсэн ухамсар, айдас, хүндэтгэлийн хольцгүй ойр дотно ухамсар. Тийм байдлаар, *сакхйа-расад* буюу ах дүүсийн харьцааны хувьд трансцендент чанаруудын тоо хэмжээ цааш үргэлжлэн өсөн нэмэгддэг.

Үүнтэй адилаар эцэг, эхийн татагдлын түвшинд(*вāтсалиа-раса*) дөрвөн шинж чанартай байдаг. Өмнө өгүүлсэн гурав дээр Бурханаас хамаарсан эсвэл Түүний чин бишрэлтний өршөөлөөс хамаарсан ухамсар нэмэгддэг. Дээд Бурханы эцгийн эсвэл эхийн байр сууринд оршин чин бишрэлтэн нь заримдаа Бурханыг шийтгэх ба өөрийгөө Бурханы харж хамгаалагч хэмээн тооцдог. Дээд Хамгаалагчийг харж хамгаалж буй чиний энэхүү трансцендент ухамсар нь чин бишрэлтэн болон Дээд Бурханд асар их таашаал цэнгэлийг амсуулна.

Бурхан чин бишрэл зүтгэлийн эрдэм ухааны тухай өгүүлсэн *Бхакти-расāmрта-синдху* нэртэй трансцендент номыг бичихийг даалгасан ба түүнд эдгээр таван трансцендент харьцаануудын мөн чанарын тухай өгүүлжээ. Энэ аугаа бүтээлд Кршṇад итгэх гуйвашгүй итгэлийн дүр хэлбэрийг олсон трансцендент *шāнта-раса* нь ямархан байдлаар цааш үйлчлэн зүтгэхүйн амьсгал шингэсэн *дāсийа-раса* болон хувирч, дараа нь бүхий л нөхцөлт байдлаас ангид ах, дүүгийн харьцаа буюу *сāкхйа-расад*, цаашлан Бурхан түүний дэмжлэг туслалцаанаас хамааралтайг мэдрэх эцэг, эхийн хайранд шилждэг болохыг тайлбарласан байдаг. Энэ бүх харьцаанууд нь өөрийн хөгжлийн дээд цэг болох амраг хайрын харьцааны(*мадхурйа-раса*) дээд цэгт хүрдэг ба энэ бүх трансцендент харьцаанууд нэгэн мөчид энэхүү амраг хайрын харьцаанд багтан оршдог.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Санātана Госвāmй

*ванде нантāдбхуташишварйām
шрй-чаитанйа-махāпрабхум
нйчо ни йат-прасāдāt сйād
бхакти-шāстра-правартакаx*

Би вээр Бурхан Чаитанйа Махāпрабхугийн өмнө хүндэтгэн мөргөнөм. Түүний өршөөлөөр бүр амьдралын хамгийн доод хэлбэрт төрөгсөд ч Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйн удирдах хүчнийг олж чадах билээ.

Огоорлын (саннийāса) амьдралд ороод Бурхан Чаитанйа бүх Энэтхэгээр аялах аялалд гарсан. Энэ аялалынхаа үеэр Тэрээр Малдахд(Бенгалийн муж) ирсэн ба энэ мужид Наваб Хуссейн Шахын засгийн газрын хоёр сайд амьдардаг Рāмакели тосгон байдаг. Тэдгээр сайдууд нь Дабир Кхāс, Сāкар Маллик нэртэй бөгөөд хожмоо Санātана Госвāmй, Рūпа Госвāmй нэрээр алдаршсан юм. Бурхан Чаитанйагаар урамшуулагдан тэд засагт төрд үйлчлэх ажлаа орхиж, Түүний *сāнкйртаны* хөдөлгөөнд нэгдэхээр шийдэв.

Энэ шийдвэрийг гаргаад ах, дүү хоёр тэр даруй өөрсдийн бүх материаллаг үйл ажлыг орхих алхмыг хийсэн ба Кршṇад чин бишрэлээр үйлчлэн зүтгэх бүрэн дүүрэн эрх чөлөөт байдлыг олж авах боломж олгох ведийн тодорхой зан үйлийг үйлдүүлэхээр хоёр *брāхмаṇыг* урин залав. Эдгээр бэлтгэх үйл ажиллагааг *пурашчарйā* гэж нэрлэдэг. Энэ зан үйллэг ёслолоор бол өдөрт гурван удаа мөргөл үйлдэх хэрэгтэй ба өөрийн өвөг дээдэст хүндэтгэлээ илэрхийлж, галд тахил өргөөд, гүн хүндэтгэлтэйгээр эрдэмт мэргэн *брāхмаṇд* хоол хүнс өргөх хэрэгтэй байдаг. Тийм байдлаар *пурашчарйā* нь цаг хугацаа, мөргөл, хүндэтгэлээ илэрхийлэх, галд өргөл өргөх, *брāхмаṇд* хоол хүнс өргөх зэрэг таван бүрдмэл хэсгээс тогтоно. Энэ ба өөр бусад зан үйлийн тухай Хари-бхакти-виласа нэрт нэр хүндтэй гарын авлага болсон сударт дурдсан байдаг.

Энэхүү шашны үйлийг гүйцэтгээд дүү Сāкар Маллик(Рūпа Госвāmй) нь гэртээ засаг төрд ажиллах байх үесдээ олж хуримтлуулсан асарих мөнгөтэйгээр буцсан. Гэрийн зүгт авч яваа алт, мөнгөн зооснуудаа тэрээр нэгэн том завинд ачсан байна.

Гэртээ ирмэгцээ тэрээр бүх эд баялагаа хоёр тэнцүү хэсэгт хуваан тавин хувийг нь *брāхман* болон *ваицнавуудад* өгөв. Тийнхүү Бурханы Дээд Бодгалийн тааллыг хангахын тулд тэрээр өөрийн хурааж хуримтлуулсан эд баялагийн тал хувийг Дээд Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйд автсан хүмүүст өглөг болгон өгсөн байдаг.

Брāхманууд нь Туйлын Үнэнийг танин ойлгоход зориулагдсан байдаг ба тэд энэ үнэнийг танин ойлгож, Бурханд үнэхээр хайраар үйлчлэн зүтгэж байвал *ваицнава* нэрийг зүүж болох юм. Чухамдаа *брāхман* болон *ваицнавууд* нь трансцендент үйлчлэн зүтгэхүйд бүрнээ автсан байх ёстой ба тэдний трансцендент байр суурийн чухлыг анхааран ойлгож Рӯпа Госвāmī тэдэнд эд баялагийнхаа тавин хувийг өгчээ. Үлдсэн тавин хувиа тэрээр мөн тэнцүү хоёр хувааж нэг хэсгийг нь түүний гэр бүлээс хамааралтай амьдардаг төрөл төрөгсөд, хүмүүст өгч, харин үлдсэн хувийг ямар нэг урьдчилан тодорхойлж болшгүй хэрэгцээнд зориулан өөртөө үлдээжээ.

Өөрийн хувийн эд баялагийг ийнхүү хуваах нь бурханлаг мэдлэгийн оргилд хүрэхийг хүсэгч бүхэнд нэн сургамжтай. Ном жаягаар бол хүн өөрийн хурааж хуримтлуулсан бүх эд баялагаа гэр бүлийн гишүүддээ орхиод бурханлаг мэдлэгт төгөлдөржихийн тулд гэр бүлийн ажил үйлээс хөндийрдөг. Гэвч энд бид Рӯпа Госвāmī өөрийн үлгэрээр сургасан зүйл дууриан дагавал зохих жишээг харж байна: өөрийн эд баялагийн тавин хувийг тэрээр бурханлаг зорилгод хандивласан. Энэ бол хүн бүрийн үлгэрлэн дагавал зохих жишээ юм. Өөрийн хэрэгцээнд зориулан үлдээсэн хуримтлуулсан баялагийнхаа хорин таван хувийг нэр хүндтэй пүүсэнд хадгалуулсан. Учир нь тухайн үед банк гэж зүйл байгаагүй юм. Арван мянган алтан зоосыг өөрийн ах Санātана Госвāmīйн зардалд зориулан хадгалав.

Энэ үед Рӯпа Госвāmī Бурхан Чаитанья Махāпрабху Жаганнātха Пурйгээс Врдāван тийш зорихоор бэлдэж байгаа тухай мэдээ авлаа. Рӯпа Госвāmī Бурханы аялах энэ маршрутын баттай эсэхийг мэдүүлэхээр хоёр элчийг илгээж, Бурхантай Матхурт уулзахын тулд тийш аялах төлөвлөгөө боловсруулав. Рӯпа Госвāmī Бурхан Чаитаньятай нэгдэх зөвшөөрлийг авсан болох нь эндээс тодорхой байна. Харин Санātана Госвāmī үгүй юм. Ийм учраас Санātана Госвāmī өөрийн үйлчлэн зүтгэхүйн бүх ажил үүргээ өөрийн нэгдүгээр туслахдаа даатгаад өөрөө гэртээ суун, *Шрймад-Бхāгаватам* судлах болжээ. Үнэн хэрэгтээ тэрээр арав, арван хоёр эрдэмт *брāхманыг* урьж тэдний хүрээлэлд *Шрймад-Бхāгаватамыг* идэвхийлэн судлах ажилд орсон байна. Үүнийгээ хийх боломж олохын тулд тэрээр өөрийн эзэн Навабт өвдсөн хэмээх мэдээг илгээв. Гэвч удирдлага нь төр улсыг удирдах үйл хэрэгт Санātана Госвāmīйн зөвлөгөө сургамжийг хүлээн ядаад, гэнэт өөрөө гэрт нь хүрээд ирэв. Санātана Госвāmī болон брāхман нарын байрлаж буй байшинд Навабыг ормогц тэд суудлаасаа босоцгоон түүнд хүндэтгэл үзүүлээд түүнийг суухыг урив.

“Чи өөрийгөө өвчтэй байна гэж хэлсэн байсан, -хэмээн Санātана Госвāmīд хандан Наваб эхлээд, -гэвч би чамайг үзүүлэхээр өөрийн эмчээ явуултал тэрээр

чамайг эв эрүүл байна гэсэн. Чухам чи яагаад өвчтэй байгаа тухай мэдээ илгээж, ажилдаа явахгүй байгааг мэдэхгүй болохоор би чамайг харахаар ирсэн юм. Шударга хэлбэл, чиний зан байдал намайг ихэд түгшээж байна. Би чамаас болон чин йзасаг төрд гүйцэтгэдэг хариуцлагатай ажлаас бүрэн хамаардаг гэдгийг чи өөрөө сайн мэднэ. Би өөр асуудлуудыг хэлэлцэж болно. Учир нь би чамаас хамааралтай байдаг. Гэвч хэрэв чи над руу буцаж ирэхгүй бол чиний урьд өмнөх үнэнч байдал сохор зоосны ч үнэгүй шүү. За тэгэхээр чи яах гэж байна даа? Энэ тухайгаа надад хэлж айлд”.

Үүнийг сонсоод Санātана Госвāmī тэрээр ажлаа үргэлжлүүлж чадахгүй ба Наваб өгөөмөр сэтгэл гаргаж түүний хариуцаж буй ажлыг өөр хэн нэгэнд даалгаж болохсон боловуу хэмээн хариулсан. Энэ тухай сонссон Наваб маш ихээр хилэгнэж: “Чиний ах яг л анчин мэт амьдарч байна. Хэрэв чи засаг турийг удирдах ажлаас хойш суувал бүх зүйл төгсгөл болно” хэмээн өгүүлэв. Наваб Санātана Госвāmīд яг өөрийн дүү мэтээр ханддаг байсан хэмээн ярьдаг. Наваб өөрийн ихэнхи цаг мөчөө ан хийх, бусдын газар нутгийг байлдан эзлэх дайны аянд зориулдаг байсан учраас тэрээр улс орныг удирдах үйл хэрэг нь Санātана Госвāmīгаас маш ихээр хамааралтай байсан юм. Ийм учраас тэрээр түүнд хандан: “Хэрэв чи мөн улс орныг удирдах хэргээс хойш суувал удирдан засаглах үйлийг хэрхэн явуулах болж байна?” хэмээв.

“Чи бол Гаудын хаан, - гэж маш нухацтайгаар Санātана Госвāmī хариулаад, - чи янз бүрийн гэмт хэрэгтнүүдийг янз бүрийн байдлаар шийтгэдэг. Ийм учраас хүн бүрийг хийсэнд нь тохирохоор шийтгэх нь таны тааллын хэрэг” гэв. Энэ хариултаараа Санātана Госвāmī, удирдагч нь өөрийн эзэмшлийн хил хязгаарыг өргөтгөхийн тулд ан агнах, хүн ардыг устгах үйлийг хийх нь тэд хоёул адил үйлдсэн үйлтэйгээ тохирохуйц зовлон эдлэх болно гэдгийг ойлгуулахыг хүсчээ.

Наваб тэнэг хүн биш байсан тул тэрээр Санātана Госвāmīйн санааг ойлгов. Уурлан хилэгнэж тэрээр түүний гэрийг орхисон ба үүнээс тун удалгүй Ориссын эсрэг дайн хийхээр хөдөлсөн байна. Санātана Госвāmīйг шүүн шийтгэхийг тушаасан ба түүнийг эргэн ирэхээс өмнө суллаж болохгүй хэмээн зарлиглажээ. Түүний ах Навабд шүүгдэж буйг мэдээд Рӯпа Госвāmī Гаудын(Бенгали) **хүнсний мухлагийн эзэнд** арван мянган алтан зоосыг хадгалуулсан ба энэ мөнгийг ахыгаа суллахад ашиглаж болох тухай мэдээг өгсөн байна. Тэгмэгц Санātана Госвāmī түүнийг харгалзаж байсан шоронгийн хянагчд таван мянган алтан зоосыг өгчээ. Тэрээр энэ таван мянган зоосыг авах эсэх, түүнийг суллан тавих эсэх талаар огт бодож төлөвлөлгүйгээр хянагчаас гуйв. Учир нь мөнгийг авснаар тэрээр материаллаг эд баялагтай болох төдийгүй бурханлаг зорилгыг тээн яваа Санātаныг суллан тависнаар буянт үйлийг хийж буй юм.

“Би мэдээжээр таныг суллан тавьж болно,- хэмээн шоронгийн хуяг хариулаад, - учир нь засаг төрд алба хашиж байхдаа надад тун олон сайн зүйлийг хийж байсан. Гэвч би Навабаас айж байна. Би чамайг суллан тавьсан тухай сонсвол тэр яах вэ? Би энэ бүгдийн тухай түүнд тайлбарлах хэрэгтэй болно. Тэгэхээр би таны саналыг

хэрхэн хүлээн авч болох уу?” гэлээ. Тэгмэгц тэр даруй Санātана шоронгийн хуяг Навабт ярьж өгч болох оргон зайлсан тухай түүхийг зохион бодож олоод, мөнгийг арван мянган зоосонд хүргэв. Хомхой шунаг сэтгэлдээ хөтлөгдсөн шоронгийн харгалзагч энэ саналыг хүлээн зөвшөөрч, түүнийг тавьж явуулав. Энэ үед Рӯпа Госвāmий өөрийн дүү Шрй Валлабхагийн хамтаар Чаитанья Махāпрабхутай уулзахаар Врндāваныг зорижээ.

Үүний дараагаар Санātана Бурханыг харахаар замд гарав. Тэрээр ил задгай замаар явалгүйжунгл, шугуйгаар дамжин Бихарын Пāтадā гэж нэрлэгдэх газарт хүрлээ. Тэнд тэрээр нэгэн зочид буудалд буудалласан боловч буудлын эзэн өөрийн үйлчлүүлдэг зурхайчаас Санātана Госвāmийг биедээ алтан зоос авч явааг мэджээ. Зочид буудлын эзэн энэ мөнгийг авахыг хүсч Санātанад хуурамчаар хүндэтгэл үзүүлэн долигононо.

“Манай буудалд шөнийг өнгөрөөнө үү, - хэмээн тэрээр өгүүлээд, -өглөө би таныг энэхүү гүн ширэнгэн ойн урхи занганаас гарахад тань туслая” гэв. Гэвч Санātанад түүний байдал төрх нэг л сэжигтэй санагдсан тул тэрээр өөрийн албат Йшāнаас түүнд мөнгө буй эсэх талаар асуухад Йшāна долоон алтан зоос авч яваа хэмээн хариулав. Албат нь тийм хэмжээний мөнгө авч яваа нь Санātанад огт таалагдсангүй уурсан түүнд хэлсэн нь: “Чи яагаад замд энэ үхэл дуудах ачааг авч явна?” хэмээн зандрав.

Санātана тэр даруй түүнээс зооснуудыг авч түүнийг дэн буудлын эзэнд өглөө. Үүнийг дараагаар тэрээр буудлын эзнээс ширэнгэн ойг гатлахад туслахыг хүсэв. Тэрээр засаг төрийн онцгой даалгавар гүйцэтгэхээр яваа хэмээн буудлын эзэнд өчив. Ил задгай замаар явж чадахгүй байгаа учраас хэрэв тэрээр ширэнгийг нэвтлэн, уулыг давахад туславал түүнд ихэд талархах болно гэлээ.

“Би чамд найман ширхэг алтан зоос байсныг мэдэж байсан. Тэднийг тань авахын тулд чамайг хөнөөхөөр завдаж байлаа”, - буудлын эзэн үнэнээ хэлэв. “Гэвч одоо би таныг тэр мөнгөө өгч чадах ямархан сайн хүн болохыг тань ойлгож байна”.

“Хэрэв чи энэ мөнгийг авахгүй бол өөр хэн нэгэн нь тэднийг надаас авах байлаа, - гэж Санātана хариулаад, -хэн нэг өөр хүнд тэднээс болж алуулж байснаас тэднийг танд өгчихсөн нь хамаагүй дээр. Би эднийг танд өргөл болгон өгч байна”. Үүний дараагаар буудлын эзэн түүнд бүх талаар үйлчилгээ үзүүлж, тэр шөнөө уулыг гатлан давахад туслав.

Уулнаас буугаад Санātана түүнд үлдсэн нэг алтан зоосоо албатдаа өгөөд түүнийг буцан харихыг хүсэв. Зарцаа явмагц Санātана өөрийгөө бүрэн чөлөөтэй болохыг мэдэрлээ. Ноорхой хувцас эгэлдэгэрлэсэн, устай сав гартаа барьсан тэрээр Бурхан Чаитанья Махāпрабхутай уулзахаар цааш одов. Замдаа тэрээр өөрийн баян чинээлэг хадам ахтай уулзсан ба тэрээр мөн л төр засгийн албанд зүтгэдэн нэгэн байлаа. Санātанагийн цөхрөлтгүй гуйлтыг хүлээн авч хадам ах нь түүнд маш

сайхан ноосон хөнжлийг өргөл болгон өгөв. Дараа нь түүнтэй салах ёс гүйцэтгэж, Чаитанья Махāпрабхутай уулзахаар Бенаресын зүгт хөдлөлөө.

Бенарес хүрээд тэрээр Бурхан тэнд буй тухай олж мэдээд маш ихээр баярлан хөөрөв. Бурхан Чандрашекхара Ачāрийагийн гэрт саатан морилж буй тухай хүмүүсээс дуулаад тийш зүглэлээ. Тэрээр Санāтанаг гадаа хаалган дээр буйг мэдсэн бөгөөд Чандрашекхарагаас үүдэн дээр зогсож буй хүнийг оруулахыг хүсэв. “Энэ бол Бурханы аугаа чин бишрэлтэн, ваицна́в”, -хэмээн Чаитанья Махāпрабху хэлэв. Чандрашекхара тэр хүнийг дуудахаар гадагш шагайвал хаалган дээр нь ямарч ваицна́в байсангүй. Харин тэрээр гуйлгачин бадарчинг санагдуулам нэгэн хүнийг л олж харсан ба өөр хэн ч байсангүй. Бурхан энэ хэрмэл бадарчныг харахыг хүсч байна гээд Санāтанаг хаалгаар орж ирмэгц Бурхан яаран угтан босч тэвэрч авав. Бурхан Санāтанаг тэвэрмэгц түүнийг бурханлаг онгод хөөрөл эзэмдсэн бөгөөд тэрээр: “Миний хайрт Бурхан минь ээ, надад бүү хүрэгтүн” хэмээн өгүүлж байв. Гэвч тэд нэг нэгнийгээ тэврэн уйлцгааж байлаа. Бурхан Чаитанья хийгээд Санāтана нарыг хараад Чандрашекхара хөшин гайхав. Эцэст нь Чаитанья Махāпрабху Санāтанаг Түүнтэй зэрэгцэн сандал дээр суухыг хүслээ. Тэрээр Санāтанагийн биед гараараа дахин хүрсэн ба Санāтана ч мөн л дахин Түүнээс: “Миний эрхэм хайрт Бурхан минь ээ, надад бүү хүрээч” хэмээн гуйв.

“Би зүгээр л чамайг ариусгахын тулд чамд хүрч байна, -хэмээн Бурхан хариулаад, -учир нь чи аугаа чин бишрэлтэн. Өөрийн чин бишрэл зүтгэлээр бүх орчлонг ангижруулан суллаж, бүгдэд Бурхан зүгт буцан харих боломжийг олгож чадна” гэв.

Үүний дараагаар Бурхан, Бурханд чин бишрэл дүүрэн буюу чин бишрэл зүтгэлд бүрэн автсан хүн нь бүх ведийг судалсан хэдий ч Бурханд чин бишрэл зүтгэлээ үл өргөгч *брāхма́наас* хавьгүй дээр хэмээх *Шрймад-Бхāгаватамын* шүлгээс иш татлаа. Чин бишрэлтэн нь Дээд Бурханыг зүрхэндээ тээж явдгийнхаа ач тусаар тэрээр бүгдийг, бүхнийг ариусгаж чаддаг.

Түүнчлэн Ведийн судар номуудад Дээд Бурхан Ведийн бүх салбар ухаанд гаргуун нэгнийг тоодоггүй атал харин доорд гарал язгууртай байлаа ч Түүнд өөрийгөө даатгасан нэгнийг эрхэмд үздэг тухай өгүүлсэн байдаг. Чин бишрэлтэн бус *брāхма́нд* өгсөн өглөгийг Бурхан хүлээж авдаггүй ч Түүний чин бишрэлтэнд өргөсөн ямар нэг зүйлийг Тэрээр хүлээн авна. Өөрөөр хэлбэл, хэрэв хүн Бурханд ямар нэг зүйлийг хандивлахыг хүсвэл тэрээр Түүний чин бишрэлтэнд үүнийгээ өгч болно. Чаитанья Махāпрабху мөн хэрэв *брāхма́н* бүр брахман хүний байвал зохих бүх арван хоёр чанар бүрдсэн байлаа ч, өндөр угсаа гаралтай байлаа ч Бурханд үнэнч бишрэл үгүй бол тэрээр хамгийн доордын доорд хүнээс ч доор хэмээн өгүүлсэн *Шрймад-Бхāгаватамын* хэсгээс иш татав. Харин чин бишрэлтэн нь *чаңдāла*(нохойн мах идэгч)-ын гэр бүлд төрсөн байлаа ч өөрийн чин бишрэл зүтгэлээр өөрийн зуун үе удам хүртэлх төрөл төрөгсдөө ариусгаж чадаж байхад

бардам сэхүүн бр̄ахман нь тэр ч бүү хэл өөрийгөө ч ариусгаж чадахгүй юм. *Хари-бхакти-судходайд*(13.2):

акцинох пхалам тв̄адрша-даршанам хи
танох пхалам тв̄адрша-г̄атрасангах
жихв̄а-пхалам тв̄адрша-к̄иртанам хи
судурлабх̄а бх̄агават̄а хи локе

“Ай Бурханы чин бишрэлтэн минь ээ, таныг харах нь нүдний төгс төгөлдөр байдал юм, таны биед хүрэлцэхүй нь биеэр хийх үйлийн төгс төгөлдөр юм, таны шинж чанарыг магтан алдаршуулах нь хэлний төгс төгөлдөр юм. Учир нь таны мэт цэвэр чин бишрэлтэнтэй учрахуй нь туйлын ховор билээ”.

Дараа нь Бурхан Санāтанад Кр̄шṇа нь маш өршөөнгүй бөгөөд бүх унан доройтсон сүнснүүдийг авран сулладаг гээд “Тэрээр чамайг ч гэсэн Махāраураваас аварсан” гэж Бурхан өгүүлэв. Махāраурав нь там ба *Шр̄ймад-Бх̄агаватамд* өгүүлснээр амьтан алах үйлийг хийгч нарт зориулагдсан газар хэмээн өгүүлжээ. Учир нь тэнд алуурчин буюу махан хоолтнууд нь энэ там руу илгээгддэг гэж баталсан байдаг.

“Би Кр̄шṇагийн өршөөлийг мэдэхгүй л байна, - гэж Санāтана хариулаад, -гэвч надад хандсан Таны өршөөл хязгааргүй гэдэг нь тодорхой. Та намайг материаллаг амьдралын төөрөгдлөөс аварсан” гэлээ.

Дараа нь Бурхан: “Чи хэрхэн яаж шорон гяндангаас суллагдаж чадав? Чамайг шийтгэгдсэн тухай Би мэдсэн” гэж асуухад нь Санāтана өөрийн суллагдан гарсан бүх түүхээ ярьж өгөв. “Би чиний хоёр ахыг харсан, -хэмээн Бурхан өгүүлээд, - тэгээд тэднийг Вр̄ндāван тийш зорихыг зөвлөсөн” гэв.

Үүний дараагаар Бурхан Чаитанйа Санāтанад Чандрашекхара болон Тапанамишра нарыг танилцуулав. Тапанамишра ч Санāтанаг тэдэнтэй хооллохыг дуртайяа хүсэв. Бурхан Санāтанаг үсчин рүү авч очин, “жентльмен” болгохыг Чандрашекхарагаас хүслээ. Учир нь Санāтаны ургуулсан урт сахал үс Шр̄й Чаитанйа Махāпрабхуд таалагдсангүй. Тэрээр Санāтанаг зөвхөн үсээ авахуулах, угаал үйлдэхийг Чандрашекхарагаас хүссөн төдийгүй мөн түүний хувцсыг солихыг Чандрашекхарагаас хүсэв.

Угаал үйлдсэний дараагаар Чандрашекхара түүнд сайхан хувцас хунар өгөв. Санāтана шинэ хувцас өмсөхөөс татаглзсан тухай Чаитанйа Бурханд мэдээлсний дараа л тэрээр Тапанамишрагаас хуучирч муудсан хувцсыг нь авч өмсөхөөр зөвшөөрчээ. Бурхан үүнд сэтгэл ихэд ханамжтай байлаа. Тэрээр Тапанамишрын гэрт хооллохоор явсан ба Санāтанад юухан хээхэн үлдээхийг гуйв. Тапанамишра Санāтанад тэр даруй хоол өгөлгүй байсаар Бурханыг хооллож дуусаад, амарч байх зуурт Бурханы тавганд орхигдсон хоолны үлдэгдлийг түүнд авч ирж өглөө.

Амарч тухласны дараа Бурхан Чаитанья Санāтанад Өөрийн чин бишрэлтэн Махāрāцтрын нэгэн *брāхманьг* танилцуулсан ба энэ *брāхман* нь Санāтаныг Бенарест байх хугацаанд өдөр бүр, ямагт гэртээ түүнийг хооллож ундалж байв.

“Би Бенарест байх хугацаандаа айл айлаас дамжин өглөг хишиг гуйн явах болно” хэмээн Санāтана хэлсэн байна. “Гэвч Бурхан маш өршөөнгүй учраас чиний урилгыг Өөрөө хүлээн аваад өдөр бүр гэрт тань хооллож байна” гэв.

Бурхан Чаитаньад Санāтаны тэрхүү байдал ихэд таалагдсан ч Бенарес орох замд хадам ахынх нь өгсөн үнэтэй ноосон нөмрөг Түүний анхаарлыг татжээ. Хэдийгээр Бурхан Чаитанья энэхүү нөмрөгийг зэрвэсхэн хараад өнгөрсөн авч Тэрээр түүний биед тиймэрхүү үнэ цэнэтэй зүйл байхыг сайшаахгүй байгааг Санāтана ойлгов. Тийм ч учраас тэрээр тэрхэн даруй Ганга мөрний эргийг зүглэсэн ба тэнд өөрийн хуучин нөхөөстэй нөмрөгийг угааж гуйлгачиныг харлаа. Санāтана түүний хуучин нөхөөстэй нөмрөгөөр үнэтэй ноосон нөмрөгөө солихыг хүсэж байгаагаа хэлтэл хэрмэл гуйлгачин Санāтанаг түүгээр тоглож байна хэмээн бодоод “Энэ чинь юу гэсэн үг вэ?” – зэмлэнгүй өнгөөр түүнээс асуув. “Чи харахад энгийн л хүн шиг атал ёс журамгүй байдлаар надаар тоглож байнаа даа”.

“Би танаар тоглоогүй”, - хэмээн Санāтана өгүүлээд, - “Би огт тоглоогүй байна. Та энэхүү ноосон нөмрөгөөр өөрийн уранхай нөмрөгийг солихыг болгоон соёрхоно уу?”. Эцэст нь хэрмэл гуйлгачин өөрийн уранхай нөмрөгөөр ноосон нөмрөгийг солихыг зөвшөөрч, Санāтана ч Бурхан руу буцан ирлээ.

“Чиний нөгөө үнэтэй нөмрөг хаачаа вэ?” гэж Бурхан түүнээс асуув. Санāтана Түнд өөрийн арилжаа, солилцооныхоо тухай хэлсэн ба тэр даруй Бурхан түүнийг хайрлах хайраар бялхаж, үүнийх нь төлөө түүнд талархав. “Чи хангалттай ухаалаг үйл хийжээ. Одоо л чи материаллаг эд баялагт татагдах өөрийн уягдал татагдалдаа цэг тавилаа”. Өөрөөр хэлбэл Бурхан ямар ч материаллаг эд хогшлоос бүрнээ ангид тийм хүний чин бишрэл зүтгэлийг хүлээн авдаг. Дараа нь Бурхан Санāтанад хандан: “Хэрэв чи тийм үнэтэй хувцас өмсчихөөд айлаас айл дамжин өглөг гуйн гуйлгачин мэтээр явбал энэ нь тийм ч сайхан харагдахгүй байлаа. Энэ бол тохирошгүй зүйлүүд байсан юм. Хүмүүс чамайг жигшин харах байв” гэв.

“Бүхий л материаллаг уягдал татагдлаас ангижрахаар хийсэн бүхэн зөвхөн Таны л өршөөл билээ”, - хэмээн Санāтана хариуллаа. Бурхан түүнд смэтгэл ихэд ханасан бөгөөд хоёул бурханлаг хөгжлийн тухай ярилцав.

Санāтанатай учрахаас өмнө Бурхан Чаитанья чин бишрэлтэн грхастха Рāмāнанда Рāйтай уулзсан байлаа. Энэ уулзалтын үеэр энэ ярилцлага болохоос өмнө Бурхан Чаитанья Рāмāнанда Рāйд асуултууд тависан ба Рāмāнанда Рāй ч тэдгээрт нь Бурханы багш мэтээр хариултуудыг өгчээ. Гэвч энэ удаа асуултуудыг Санāтана тависан ба Бурхан тэдгээрт хариулж байв.

Бурхан Чаитаньягийн сургаал хийгээд номлол бүх хүмүүсийн хувьд нэн чухал юм. Тэрээр амьд оршнол бүрийн ердийн ажил үйл болох чин бишрэл зүтгэлийн зам мөрийн тухай сургасан билээ. Учир нь бурханлаг эрдэм ухааныг танин ойлгох нь

хүн бүрийн үүрэг. Санātана Госвāmī болон Бурхан Чаитанйа хоёрын хооронд болсон харилцан ярианд олон асуудлыг нарийвчлан хэлэлцсэн байдаг. Бурхан Чаитанйагийн өршөөлөөр Санātана нэн чухал асуултуудыг тавьж чадсан ба тэдгээртэй бүрэн дүүрэн хариултуудыг авч чадсан юм.

Санātана Госвāmī болон Бурхан Чаитанйа нарын уулзалтаас дараахь сургаалыг олж авч болно: бурханлаг эд зүйлийг ойлгохын тулд Бурхан Чаитанйа Махāпрабху мэтийн номын багшид хандах нь зайлшгүй чухал ба түүнд сэтгэлийн хүлцэнгүй номхон төлөвт байж асуулт тавих хэрэгтэй. Энэ тухай *Бхагавад-гītā*д батлан(4.34) – нэр хүндтэй хүнд хандаж түүнээс бурханлаг эрдэм мэдлэгийг олж мэдэх хэрэгтэй гэсэн байдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Санātана Госвāmīд өгсөн Бурханы сургаал

Санātана Госвāmīд өгсөн Бурхан Чаитанйагийн сургаалаас бид Бурханы тухай эрдэм ухаан болон үүнтэй холбоотойгоор Бурханы дүр хэлбэр, Түүний гоц чанарууд, Түүний чин бишрэл зүтгэлийн тухай ойлгох болно. Үнэн хэрэгтээ энэ бүгдийг Бурхан Өөрөө Санātана Госвāmīд тайлбарлаж өгсөн билээ. Энэ үед Санātана Госвāmī Бурханы өлмийд сөхрөн унаж, маш их номхон хүлцэнгүйгээр Түүнээс өөрийн жинхэнэ мөн чанарын тухай асуув. “Би доорд гаралтай гэр бүлд төрсөн, -гэж Санātана өгүүлээд, -би доорд зэрэглэлийн хүмүүстэй нөхөрлөж байсан бөгөөд хүмүүсийн хамгийн адаг, унан доройтсон нэгэн билээ. Би материаллаг цэнгэл жаргалын харанхуй худагт зовж зүдэрч, миний амьдралын жинхэнэ зорилго юу болох талаар хэзээ ч мэддэггүй байлаа. Үнэхээр миний хувьд юу сайн болохыг ч би мэддэггүй. Хэдийгээр би дэлхий дээрхи асар их мэдлэгтэй хүмүүсийн тоонд багтдаг ч үнэн хэрэгтээ би өөрийгөө эрдэмтэн хэмээн нэрлэх тийм л тэнэг мунхаг нэгэн. Харин Та намайг өөрийн албатаа болгосноор Та намайг материаллаг амьдралын урхи торноос татан гаргалаа. Одоо энэхүү ангижирсан төлөвт миний үүрэг зорилго ямархан байх тухай өгүүж айлд”.

Энэ гуйлтнаас ангижрал нь төгс төгөлдрийн хязгаар биш юм гэдгийг ойлгож болно. Ангижирсан төлөвт ямар нэг үйл байх ёстой. Санātана: “Та намайг материаллаг амьдралаас татан гаргасан. Тэгэхээр ангижралын дараа миний үүрэг одоо юунд орших вэ?” хэмээн тов тодорхой өгүүлж байна. Санātана мөн: “Би хэн бэ? Яагаад гурвалсан зовлон намайг байнгад мөрдөн мөшгинө вэ? Эцэст нь би хэрхэн энэхүү материаллаг урхи занганаас ангижрахыг хэлж өгөөч? Бурханлаг хөгжил дэвшлийн талаар асуултуудыг хэрхэн тавих талаар би мэдэхгүй ч Танаас

гуйн залбирья. Надад өршөөнгүй хандаж миний мэдвэл үохих бүхнийг айлдан соёр” хэмээн асуултуудаа үргэлжлүүлэн тавьж байна.

Энэ бол номын багшийг хүлээж авах процес юм. Хүн хүлцэнгүйгээр түүнд захирагдан, номын багшид ойртон дөтлөх ёстой ба үүний дараагаар өөрийн бурханлаг хөгжлийн тухай асуултуудыг тавих хэрэгтэй.

Бурхан Санātаны байр байдалд ихэд сэтгэл хангалуун байсан хийгээд Түүнд хариулсан нь: “Чи аль хэзээний Бурхан Крш᳚агийн адислалыг хүртсэн. Ийм учраас чи бүгдийг мэдэх ба материаллаг ахуйн бүх зовлон зүдгүүрээс салан ангижрах болно”. Цааш нь Бурхан, Санātана Крш᳚агийн ухамсарт оршин буй болохоор тэрээр жам ёсоороо Крш᳚агийн өршөөлөөр бүгдийг мэдэх болно гэдгийг тэмдэглэн хэлэв. “Гэвч чи хүлцэнгүй төлөв чин бишрэлтэн учраас, -хэмээн Бурхан үргэлжлүүлэн өгүүлээд, -чи Надаас чамд бүх зүйл тодорхой тухай батлахыг хүсэж байна. Энэ бол их сайн”. Энэ бол цэвэр чин бишрэлтний ялгарах онцлог шинж тэмдэг юм. *Нāрада-бхакти-с᳚трад*, хэн бээр өөртөө Крш᳚агийн ухамсрыг хөгжүүлэхэд няхуур хандана вэ тэрээр Бурханы өршөөлөөр тун хурднаар Крш᳚аг танин ойлгох өөрийн хүслийг гүйцэлдүүлэх үйлэнд хүрч чадна гэжээ.

“Чи бол Бурханд чин бишрэлээр үйлчлэн зүтгэх үйлийг хамгаалж чадах тийм хүн”, - гэж Чаитанйа Махāпрабху үргэлжлүүлээд, -“Ийм учраас Миний үүрэг бол Бурханы тухай сургаалыг чамд өгөх ба энэ бүгдийг Би чамд алхам алхмаар тайлбарлах болно” гэв.

Түүний үндсэн байр суурь ямар болох тухай асуултуудыг тавих нь номын багшид хандагч шавь хүн бүрийн үүрэг юм. Санātаны тавьсан асуултууд нь “Би юу юм бэ, яагаад гурвалсан зовлон намайг зовооно вэ?” хэмээх энэхүү бурханлаг процесстой бүрэн тохирч байгаа юм. Гурвалсан зовлонг *адхйātмика*, *адхибхаутика*, *адхидаивика* гэж нэрлэдэг. *Адхйātмика* хэмээх үг нь бие махбодь хийгээд ухааны зүгээс учруулах зовлонг хэлдэг. Заримдаа амьд оршнол нь өөрийн бие махбодиосоо болж зовдог, заримдаа түүний энэ зовлонгийн үндэс нь ухаан нь байдаг ба энэ хоёрын аль алиныг *адхйātмика* гэнэ. Бид эдгээр зовлонг эхийн хэвлийд байхдаа ч амсдаг. Хүний биеийн мэдрэмтгий байдлаар шалтагласан олон төрлийн дайралт довтлолтуудыг бид бүгд сайн мэднэ. Бусад амьд оршнолуудын зүгээс бидэнд учруулах зовлонг *адхибхаутика* гэнэ. Үүний тулд амьд оршнол нь том сүрлэг байх ч шаардлагагүй. Яагаад гэвэл жишээ нь, бүр биднийг орон дээрээ унтаж байхад ч зовлон амсуулж чаддаг шумуул гэх мэт амьтад байна. Ийм шумуул гэх мэт заримдаа бидэнд өвдөлт зовлон учруулдаг өчүүхэн жижиг олон тооны бүтээлүүд бий бөгөөд мөн өөр гариг эрхэс дээр төрсөн өөр олон амьд оршнолууд байдаг. Тэд ч мөн бидэнд зовлон учруулдаг. Харин гурав дахь төрлийн зовлон буюу *адхидаивика* нь дээд гаригсын системээс сахиулсан тэнгэрүүдийн илгээдэг байгалийн гамшиг юм. Жишээ нь, заримдаа айхтар догшин хүйтэн эсвэл халуун, аянга цахилгаанд цохиулах, газар хөдлөлт, хар салхи, ган болон өөр олон бусад байгалийн гамшгаас болж зовдог. Гэвч аль ч тохиолдолд бид эдгээрийн нэгнээс эсвэл ямар нэгэн хослолоос болж зовон байдаг.

Тийнхүү Санātана маш ухаалаг асуултуудыг тависан юм. “Амьд оршнолын байр суурь ямархан бэ?” хэмээн тэрээр асуусан. “Яагаад тэд цаг үргэлж энэ гурван төрлийн зовлонтой учирна вэ?”. Санātана өөрийн хүчин мөхөс байдлаа бүрнээ хүлээн зөвшөөрсөн. Олонхи хүмүүсийн нүдэнд тэрээр өндөр боловсролтой хүн хэдий ч (тэрээр үнэхээр санскрит хэлний гарамгай мэдлэгтэн байв) мөн хэдий тэрээр өөрөө өөрийнхөө тухай тийм бодол санаатай байсан ч чухамдаа тэрээр өөрийн үндсэн байр суурины тухай болон гурвалсан зовлонг амсах хэрэгтэй болдог шалтгаануудын тухай юу ч мэдэхгүй байв.

Номын багшид шавь орох нь зүгээр нэг мода биш юм. Өөрийн материаллаг зовлон зүдгүүрийг тов тодорхой ухан ойлгоод тэдгээрээс ангижрахыг хүсэгч хүний хувьд энэ нь зайлшгүй чухал. Тийм хүний үүрэг нь номын багшид хандах. Үүнтэй холбогдуулан *Бхагавад-гītā*д өгүүлсэн үүнтэй адил төстэй нөхцөл байдлөг тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Аржуна тулалдаанд оролцох уу болих уу гэдгээ үл мэдэн олон асуудалд төөрөн самуурсан байх үедээ Бурхан Кршṇаг өөрийн номын багшаа болгосон. Энэ тохиолдолд мөн дээд номын багш амьд оршнолын үндсэн байр суурины тухай өгүүлэн Аржунаг сурган номлосон юм.

*Бхагавад-гītā*гаас бид амьд оршнол нь өөрийн үндсэн байр суурийн хувьд үхэшгүй сүнс гэдгийг мэднэ. Тэрээр матери биш. Бурханлаг сүнс ба тэрээр дээд сүнс, Гуйлын Үнэн буюу Бурханы Бодгалийн салшгүй бүрдмэл хэсэг юм. Эндээс мөн бурханлаг сүнсний үүрэг нь даатгах юм гэсэн дүгнэлт гарна. Учир нь зөвхөн энэ нь л түүнийг аз жаргалтай болгож чадна. *Бхагавад-гītā*гийн сүүлчийн сургаал нь, сүнс нь дээд сүнсэнд бүрнээ өөрийгөө даатгах хийгээд тийнхүү аз жаргалыг танихад оршдог.

Энд Бурхан Чаитанья Санātаны асуултнуудад хариулан тэрхүү үнэнийг давтаж байна. Гэвч тодорхой ялгаа бий. Энд Бурхан Чаитанья *Бхагавад-гītā*д аль хэдийнээ агуулагдан буй мэдээллийг өгөөгүй. Тэрээр Кршṇагийн Өөрийн сургаалаа төгсгөсөн тэр хэсгээс эхэлж байна. Аугаа их чин бишрэлтэнгүүд Бурхан Чаитаньяг Кршṇаг Өөрөө хэмээн хүлээн зөвшөөрдөг ба энэ үзлийн хүрээнд авч үзвэл Тэрээр Өөрийн Санātанад өгөх сургаалаа *Бхагавад-гītā*д Аржунад Өөрийн сургаалаа өгөөд төгсгөсөн тэр газраас эхэлж байна.

“Өөрийн мөн чанарын хувьд чи цэвэр амьд сүнс юм”, -гэж Бурхан Санātанад өгүүлэв. “Энэ материаллаг бие махбодийг өөрийн жинхэнэ мөн чанартай харьцуулах хэрэггүй; ухаан чинь ч, оюун ухаан чинь ч хуурмаг би чинь ч чиний жинхэнэ “би” биш. Мөн чанарынхаа хувьд Дээд Бурхан Кршṇагийн мөнхийн албат юм. Чиний жинхэнэ байр суурь трансцендент. Кршṇагийн дээд эрчим хүч нь өөрийн мөн чанарын хувьд бурханлаг ба харин доод ба хязгаарын эрчим хүч нь материаллаг юм. Чи бурханлаг ба материаллаг эрчим хүч хоёрын хооронд оршин буй учраас чи завсрын байр суурийг эзлэж буй юм. Кршṇагийн завсрын эрчим хүчинд харъяалагдан байхын хамт Кршṇатай нэгдмэл хийгээд мөн ялгаатай. Чи

бурханлаг учраас Кршңагаас ялгаагүй ч харин Кршңагийн өчүүхэн жижиг хэсэг учраас чи Түүнээс ялгаатай”.

Энэхүү цаг хугацаанд нэгдмэл ба ялгаатай байх нь ердөө Дээд Бурхан болон амьд оршнолуудын хоорондын харьцаан дээр л байдаг. “нэгэн цаг хугацаанд нэгдмэл ба ялгаатай байх” тухайн үзлийг амьд оршнолын завсрын байр суурины үүднээс ойлгож болно. Амьд оршнол нь нарны гэрлийн өчүүхэн молекулаг хэсэгтэй адил ба харин Кршңаг түлэм халуун нартай зүйрлүүлж болно. Бурхан Чаитанья амьд оршнолыг түүдэг галаас үсрэн ойчиж буй шатаж буй очтой, харин Дээд Бурханыг нарны шатаан цооносон түүдэг галтай зүйрлэсэн. Үүнтэй холбогдуулж Бурхан *Вишну Пурāнаас*(В.П.1.22.52) иш татсан:

эка-деша-стхитасйāгнер

жйотснā вистāриңй йатхā

парасйа брахманах шактис

татхедам акихлам жагат

“Энэхүү сансар огторгуйд илрэгч бүхэн ердөө Дээд Бурханы эрчим хүч төдийхөн зүйл юм. Нэг байрнаас үүсэн гарсан түүдэг гал өөрийн эргэн тойронд гэрэл ба дулааныг тархадаг шиг Бурхан хэдийгээр бурханлаг ертөнцөд нэг байрандаа оршивч Өөрийн янз бүрийн бурханлаг эрчим хүчийг хаа сайгүй илрүүлдэг. Үнэн хэрэгтээ бүх сансрын бүтээл нь Түүний эрчим хүчний янз бүрийн илрэлүүдээс л тогтох бүлгээ”.

Дээд Бурханы эрчим хүч нь трансцендент ба бурханлаг бөгөөд амьд оршнолууд нь энэхүү эрчим хүчний бүрдмэл хэсгүүд юм. Гэвч материаллаг эрчим хүч гэж нэрлэгдэх өөр нэгэн эрчим хүч бий ба тэрээр мунхагийн манангаар хучигдсан байдаг. Материаллаг байгаль болсон энэхүү эрчим хүч нь гурван шинж чанарт буюу *гунад*(буяны, шунал тачаалын, мунхаг харанхуйн) хуваагддаг. Бурхан Чаитанья, бүхий л ойлгогдошгүй эрчим хүчнүүд нь Бурханы Дээд Бодгалид оршин байдаг ба бүх сансрын илрэлүүд нь Бурханы ойлгогдошгүй эрчим хүчний ачаар хөдөлдөг хэмээн өгүүлсэн *Вишну Пурāнаас*(В.П.1.3.2) шүлгээс иш татсан.

Амьд оршнолыг *киетражнā* буюу “үйлийн талбарыг мэдэгч” гэж нэрлэдэг хэмээн Бурхан мөн өгүүлэв. Бхагавад-гитāгийн арвангуравдугаар бүлэгт бие махбодийг үйлийн талбар, амьд оршнолыг *киетражнā* буюу энэ талбарыг мэдэгч хэмээн өгүүлсэн байдаг. Хэдийгээр амьд оршнол нь өөрийн анхдагч төвлөөрөө бурханлаг эрчим хүчийг мэддэг ч, өөрөөр хэлбэл бурханлаг эрчим хүчийг танин ойлгох чадвартай хэдий ч тэрээр материаллаг эрчим хүчээр бүрхэгдсэн байдаг ба үүний уршгаар өөрийгөө бие махбодитойгоо адилтгадаг. Энэхүү хуурмаг адилтгахуйг “хуурмаг би” гэдэг. Энэ хуурмаг би-д төөрч, материаллаг амьдралд самуурсан амьд оршнол нь янз бүрийн бие махбодийг сольж, олон янзын зовлон шаналлыг эдэлдэг. Янз бүрийн хэлбэрийн амьд оршнолууд нь амьд оршнолын жинхэнэ байр суурийн тухай мэдлэгийг янз бүрийн хэмжээтэйгээр мэдэж байдаг.

Өөрөөр хэлбэл амьд оршнол нь Дээд Бурханы бурханлаг эрчим хүчний бүрдүүлэгч хэсэг юм гэдгийг ойлгох хэрэгтэй. Материаллаг эрчим хүч нь захирагдагч байр сууринд оршдог болохоор хүн энэхүү материаллаг эрчим хүчний бүрхүүлээс ангижирч, бурханлаг эрчим хүчийг ашиглах чадвартай. Бхагавад-гитэд доод эрчим хүч нь дээд эрчим хүчээ хучин байдаг ба энэ бүрхүүлийн уршгаар амьд оршнол нь материаллаг ертөнцийн зовлонд унах хувьтай байдаг ба тэрхүү зовлонг мунхаг харанхуй, шунал тачаалын пропорциональ хэмжээтэйгээр амсдаг хэмээн өгүүлсэн байдаг. Арай илүү хэмжээтэйгээр ариуссан амьд оршнол нь багахан зовдог ба гэвч бүхэлдээ бүгд материаллаг эрчим хүчээр хучигдсаныхаа улмаас материаллаг зовлон шаналлыг амсдаг.

Чайтанья Махāпрабху мөн газар, ус, гал, агаар, огторгуй, ухаан, оюун ухаан, хуурмаг би эд бүгд нийлээд Дээд Бурханы доод эрчим хүчийг бүрдүүлдэг тухай өгүүлсэн *Бхагавад-гитāгийн* долдугаар бүлгийн шүлгээс иш татав. Гэвч амьд оршнолын жинхэнэ мөн чанар нь дээд эрчим хүч ба чухамхүү энэ эрчим хүчний ачаар бүх материаллаг ертөнц үйл хөдлөлөө хийдэг. Материаллаг элементүүдээс тогтох сансрын илрэл нь дээд эрчим хүч буюу амьд оршнол түүнийг хөдөлгөөнд оруулах хүртэл ямар нэг үйлдэл хийх чадваргүй байдаг. Үнэн хэрэгтээ амьд оршнолын болзолт амьдрал нь тэрээр дээд эрчим хүчинд орших Дээд Бурхантай холбоотой холбоо харьцаагаар мартсанд оршино гэж хэлж болно. Энэхүү харьцааг мартмагц болзолт амьдрал эхэлдэг. Харин хүн өөрийгөө Бурханы мөнхийн албат хэмээн ухасарлаж, өөрийн жинхэнэ мөн чанараа сэргээсэн тэр цагт тэрээр ангижралыг олно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мэргэн

Амьд оршнол хэрхэн материаллаг эрчимтэй орооцолдсон түүхийг хэн ч хөөн мөшгиж чадахгүй болохоор тэрээр эхлэл үгүй хэмээн Бурхан өгүүлж байна. Энэ нь болзолт амьдрал нь бүр бүтээлээс ч өмнө оршин байжээ гэсэн үг. Тэрээр зүгээр л цаг үе нь болоод бүтээлийн дараагаар илрэн гардаг. Амьд оршнол нь хэдийгээр бурханлаг ч өөрийн мөн чанараа мартсаны улмаас материаллаг оршихуйн бүхий л төрлийн зовлон зүдгүүрийг амсдаг. Гэвч энэхүү материаллаг ертөнцийн урхи занганд ороогүй, бурханлаг ертөнцөд оршин байдаг амьд оршнолууд бий гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэднийг ангижирсан сүнснүүд гэх ба үргэлжид Крш᳚агийн ухамсарт чин бишрэлээр зүтгэхүйд автдаг.

Материаллаг мөн чанараар болзолдогсдын бүх үйл нь тооцогддог ба энэхүү үйлтэйгээ тохирохуйц буюу дараагийн амьдралд нь тэдэнд өөр хэлбэрийн материаллаг бие махбодь олгогддог. Материаллаг ертөнцөд болзолдсон бурханлаг

сүнс нь янз бүрийн шагнал урамшууллыг авдаг ба янз бүрийн шийтгэлийг амсдаг. Тэрээр өөрийн зөв үйлийн төлөө шагнагдвал олон тооны сахиулсан тэнгэрүүдийн нэг нь болж дээд гариг эрхэст хүрдэг. Харин буруу үйлийнхээ төлөө шийтгэгдвэл материаллаг амьдралын зовлон зүдгүүрийг илүү хурц байдлаар амсахаар тамын гаригууд руу илгээгддэг. Чаитанья Махāпрабху тийм шийтгэлийн маш сайхан жишээг иш татсан. Урьд өмнө хаан гэмт хэрэгтнүүдийг ийнхүү шийтгэж байжээ: гэмт хэрэгтнийг усанд шунгуулаад, дараа нь балгахан агаар амьсгалуулахын тулд буцааж гаргаж ирээд, буцаагаад дүрдэг байв. Материаллаг байгаль нь амьд оршнолыг яг ийм аргаар шийтгэх ба шагнадаг. Түүнийг шийтгэх үед материаллаг зовлон зүдгүүрийн усанд дүрэх ба харин шагнал хүртэх үед түүнийг тодорхой хугацаанд уснаас татаж гаргадаг. Дээд гаригуудад хүрэх эсвэл энэ амьдралдаа илүү өндөр байр сууринд хүрэх нь тогтвортой бус. Амьд оршнол нь дахин усанд живэх хэрэгтэй болдог. Энэ бүхэн энэхүү материаллаг ахуйд байнгад явагдаж байдаг. Амьд оршнол нь нэг бол дээд гаригууд өөд өгсөн дээшлэх ба нэг бол материаллаг амьдралын тамын нөхцөл рүү дахин доош унадаг.

Үүнтэй холбогдуулж Чаитанья Махāпрабху *Шрїмад-Бхāгаватамд* Нāрада Мунигийн Кршṇагийн эцэг Васудевад өгсөн сургаалаас иш татсан:

*бхайам двитийāбхинивешатах сийāд
ийшāд апетасйа випарйайо смртих
тан-мāййāто будха āбхажет там
бхактйаикайешам гуру-деватātмā*

(Бхāг.11.2.37)

Энэхүү шүлэгт буюу Махāража Нимийг сургасан есөн мэргэдийн үгэнд *мāййāг* “Кршṇатай холбоотой холбоо харьцаагаа мартаг” хэмээн тодорхойлсон байдаг. Үнэхээр ч *мāййā* нь “огт байхгүй тэр зүйл” гэсэн утгатай. Энэ нь огт оршин байдаггүй. Тийнхүү амьд оршнол нь Дээд Бурхантай ямар ч холбоогүй хэмээн тооцох нь төөрөгдөл юм. Тэрээр Дээд Бурханы оршин буйд итгэхгүй байж болох юмуу эсвэл Түүнтэй ямар ч холбоо харьцаа үгүй хэмээн бодож болох боловч энэ бүгд “худал хуурмаг” буюу *мāййā*. Хүн амьдралын тухай энэ хуурмаг үзэл төсөөлөлд автан шингэсэн байдгаас тэрээр байнгад айдас түгшүүрт оршин байдаг. Өөрөөр хэлбэл амьдралын тухай бурхангүй үзэл нь *мāййā* юм. Ведийн судар шастирыг жинхэнээр нь танин мэдэгч хүн үүнд өөрийгөө бүрнээ даатгаж, Түүнийг дээд зорилгоо хэмээн хүлээн зөвшөөрч, Дээд Бурханд өөрийгөө даатган зориулдаг. Амьд оршнол нь Бурхантай холбоотой өөрийн анхдагч холбоо харьцаагаа мартмагц тэр даруй түүнийг гадаад эрчим олзлон авдна. Энэ нь түүний хуурмаг би буюу өөрийгөө хуурмагаар бие махбодтойгоо адилтгагдах үзэл үүсэхийн шалтгаан болдог. Чухамдаа материаллаг орчлонгийн тухай энэ бүх үзэл төсөөлөл нь энэхүү биемахбоитой адилтгахуй үзлээс урган гардаг. Учир нь тэрээр өөрийн биед болон биеийн үйлийн хоёрдогч бүтээгдэхүүнд уягдан татагдана. Энэ урхи занганаас

гарахын тулд тэрээр зөвхөн өөрийн үүргийг биелүүлж, Кршңагийн ухамсартаа үнэнч байж, оюун ухаан, чин бишрэлтэйгээр Дээд Бурханд өөрийгөө даатгах хэрэгтэй.

Болзолт сүнс нь тэрээр энэ материаллаг ертөнцөд аз жаргалтай байна хэмээн тооцдог авч хэрэв тэрээр цэвэр чин бишрэлтэнгийн сургаалыг сонсох өршөөл тохиовол тэрээр өөрийн материаллаг цэнгэл эдлэх хүслийг орхиж, Кршңагийн ухамсрын гэгээрлийг олж хүртэнэ. Хүн Кршңагийн ухамсарт дөнгөж ормогц материаллаг цэнгэл эдлэх хүсэл нь тэр даруй дарагдан алга болох ба тэрээр аажмаар материаллаг орооцолдооноос ангижирдаг. Гэрэл байгаа газарт харанхуй байдаггүй. Кршңагийн ухамсар нь материаллаг мэдрэхүйн цэнгэлийн харанхуйг сарниулах энэхүү гэрэл юм.

Кршңаг ухамсарлагч хүн нь өөрийгөө Бурхантай адил хэмээх хуурмаг төсөөллийн нөлөөнд хэзээ ч автдаггүй. Тэрээр зөвхөн өөрийнхөө төлөө ажилласнаар аз жаргалыг олохгүй гэдгийг мэдээд өөрийн бүхий л эрчмийг Дээд Бурханд үйлчлэхүйд чиглүүлэх бөгөөд тийнхүү хуурмаг материаллаг эрчмийн хумснаас ангижирдаг. Үүнтэй холбогдуулж Чаитанья Махāпрбаху *Бхагавад-гītāгийн* дараахь шүлгээс иш татсан:

даивī хй эцīā гунамайī

мама мāйā дуратйайā

мāм эва йе прападйанте

мāйāм этāм таранти те

“Материаллаг байгалийн гурван гунаас тогтох Миний бурханлаг эрчмийг даван туулах нь нэн хүнд. Гэвч Надад өөрийгөө даатгасан хүн түүний нөлөөнөөс хялбархан мултран гарч чадна”. (Бг.7.14)

Чаитанья Махāпрбаху болзолт сүнс нь ямар нэг кармын үйлэнд автсан агшин бүрд тэрээр өөрийн жинхэнэ “би”-г мартддаг гэж Өөрийн сургаалаа үргэлжлүүлэв. Цагийн эрхээр тэрээр ядарч цуцах үед, тэрээр материаллаг үйлээс болж тэнхэл алдарахад тэрээр ангижралыг хүсч, Дээд Бурхан шиг болохыг хүсдэг ч зарим үед хэрэв тэрээр мэдрэхүйн цэнгэлийн төлөө хүндээр хөдөлмөрлөх нь түүнийг аз жаргалтай болгоно хэмээн боддог. Аль аль тохиолдолд нь тэрээр материаллаг эрчмээр хучигдсан байдаг. Ийм мэт төөрсөн болзолт сүнснүүдийг гэгээрэн сэхээрүүлэхийн тулд Дээд Бурхан ерөнхий ведийн судар номуудыг хайрласан: *Ведүүд, Пурāнууд, Ведāнта-сутра*. Энэ бүгд хүнийг Бурхан зүгт буцаахад зориулагдсан. Өөрийн дараагийн сургаал номлолдоо Чаитанья Махāпрбаху болзолт сүнс нь номын багшийн өршөөлийг хүртэж, Дээд Сүнс болон олон янзын ведийн судар номуудад хандахад тэрээр гэгээрлийг олж, бурханлагаар өөрийгөө танихуй үйлэндээ өсч хөгждөг. Кршңа энэ бүх ведийн бүтээлүүдийг хайрлсан бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар хүн Түүнтэй холбоотой өөрийн холбоо харьцаагаа

ойлгож чадах ба үүнтэй тохирсон үйлийг хийж чадна. Учир нь Тэрээр Өөрийн чин бишрэлтэнд үргэлжид өршөөнгүй байдаг. Тийнхүү хүнд амьдралын цэсийн зорилгыг хайрладаг.

Үнэн хэрэгтээ амьд оршнол бүр Дээд Бурханд хүрэхээр урьдчилан тодорхойлогдсон. Үнэхээр хүн бүр Бүхний Дээдтэй холбоотой өөрийн холбоо харьцагаа ойлгож чадна. Төгс төгөлдөрт хүрэхээр чиглэгдсэн үүргийг гүйцэтгэхийг чин бишрэлээр үйлчлэн зүтгэх гэдэг ба боловсорч гүйцэхээрээ тэрхүү чин бишрэл зүтгэл нь амьд оршнол бүрийн амьдралын жинхэнэ зорилго болсон Бурханыг хайрлах хайр болно. Чухамдаа амьд оршнол нь шашны ритуаллаг зан үйлийг гүйцэтгэх, эдийн засгийн хөгжил, мэдрэхүйн цэнгэл зэрэгтээ амжилт олохын тулд зориулагдаагүй. Амьд оршнол нь ангижралд ч хүрэхээр тэмүүлэх ёсгүй бөгөөд шашин, эдийн засаг, мэдрэхүйн цэнгэлийн талаар ярих ч хэрэггүй юм. Жинхэнэдээ хүн зөвхөн нэг л зүйлийг буюу Бурханд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйн түвшинд хүрэхийг л хүсэх ёстой. Бурхан Кршңагийн бүхнийг татагч шинж чанар энэхүү трансцендент үйлчлэлд хүрэхүйд туслах ба Кршңагийн ухамсар дахь тийм зүтгэлээр хүн, тэрээр Кршңатай холбоотой холбоо харьцаагаа ухамсарлаж чадна.

Өөрийн амьдралын эцсийн зорилгыг хайгч хүний эрэл хайгуулийн тухай өгүүлээд Чаитанья Махāпрбаху *Шрїмад-Бхāгаватамын* Тавдугаар Дуулалд Мадхвын(Мадхва-бхāцїа, 5.5.10-13) өгсөн тайлбар доторхи нэгэн түүхийг өгүүлсэн. Энэ түүхэнд түүн рүү өөрийн ирээдүйгээ мэдэхээр ирсэн ядуу хүнд зурхайч Сарважñагийн өгсөн сургаалын тухай өгүүлдэг. Энэ хүний төөргийг хараад Сарважñа энэ хүнийг тийм ядуу яваад маш ихэд гайхаж түүнд хэлсэн нь: “Яагаад чи тэгтлээ ихээр гуниглана вэ? Чиний төөрөгнөөс би эцгийн тань чамд үлдээсэн дармал эрдэнэс бий гэдгийг харж байна. Гэвч төөрөгнөөс харж байхад эцэг тань эцэг тань энэ тухай чамд хэлээгүй нь тодорхой байна. Учир нь тэрээр өөр улс гүрэнд нас нөгчжээ. Гэвч харин одоо чи энэ эрдэнэсийг олж, аз жаргалтай болж чадна”. Амьд оршнол нь Дээд Эцэг, Кршңагийн нуусан эрдэнэсийг өөрийн мунхагаас мэдэхгүй зовдог учраас тэрээр энэ түүхийг ярьжээ. Энэ эрдэнэс нь Бурханыг хайрлах хайр бөгөөд бүх ведийн судар бичгүүд түүнийг хайж олохыг зөвлөдөг. *Бхагавад-гїтāд*, хэдийгээр амьд оршнол нь бүхнээс баян Бурханы Бодгалийн хүү бөгөөд өгүүлсэн байдаг ба тэрээр үүнийг ухамсарладаггүй. Ийм учраас ведийн бүтээлүүд түүний өөрийн эцгээ болон түүний эцэгт харьяалагдах өмч хөрөнгийг хайх эрэлд нь тусладаг.

Үүний дараагаар зурхайч Сарважñа ядуу эрд зөвлөсөн нь: “Эрдэнэсийг хайж гэрийнхээ өмнө зүгээс бүү ух. Учир нь энэ тохиолдолд чамайг хортой шар зөгий хатгаж азгүйтэл чамтай учрах болно. Зүүн зүгт хай. Тэнд жинхэнэ гэрэл бий ба түүнийг чин бишрэл буюу Кршңагийн ухамсар гэж нэрэлэдэг. Өмнө зүгт ведийн ритуаллаг зан үйл бий бөгөөд баруун зүгт цэцэрхийллийн мэтгэлцэл, харин хойд зүгт бясалгалын йог оршдог”.

Хүн бүр Сарважñын зөвлөгөөг маш няхуур дагах ёстой. Хэрэв хүн амьдралын эцсийн зорилгыг зан үйл гүйцэтгэхийн тусламжтайгаар хайвал гарцаагүй азгүйтэл түүнийг дагалдах болно. Энэ арга нь тусгай тахилгачийн удирдлаган доор

үйлдэхийг сануулсан байдаг ба тахилгач энэхүү үйлчилгээнийхээ хариуд мөнгө авдаг. Хүн энэ зан үйлийг гүйцэтгэх нь түүнийг аз жаргалтай болгоно гэж бодож болох юм. Гэвч үнэн хэрэгтээ хэрэв тэрээр үүгээр ямар нэг үр дүнд хүрсэн бол энэ нь зөвхөн цаг зуурхных юм. Үүний оронд түүний материаллаг зовлон шаналал улам улам өсөн нэмэгдэх болно. Мөн ийм үр дүнг эрдэнэсийг хойд зүгээс хайх буюу бясалгалын йогийн тусламжтайгаар хайх үйлэн дээр ч хэлж болно. Энэ процессын үед хүн Дээд Бурхантай нэгдэнэ гэж найддаг ч амьд оршнолын хувьд Дээд Оршнолтой нэгдэх нь ааварга том могойнд залгиулахтай адил. Заримдаа том могой жижгийгээ залгчихдаг. Бүхний Дээдийн бурханлаг ахуйд уусах нь үүнтэй адил юм. Жижиг могой төгс төгөлдрийг эрж хайж байтал түүнийг залгчихна. Энэ нь аесуудлыг шийдэхгүй гэдэг нь тодорхой байна. Баруун зүгээс ухахад эрдэнэсийг хамгаалж байдаг муу буг *йакицууд* дүрт саад тотгор бий. Хэргийн учир нь эрдэнэсийг эрж хайхад *йакицийг* туслуулахаар хандвал тэрээр хэзээ ч түүнийг тавихгүй бөгөөд үүний үр дүнд харин хүн түүнд алагдах болно. *Йакца* нь энэ тохиолдолд цэцэрхийлэлд дуртай ухаан ба өөрийгөө танин ухамсарлахуйн цэцэрхийлэх процесс буюу *жнāны* зам нь амиа хорлохтой адил.

Тийм байдлаар цорын ганц боломж нь Кршңагийн бүрэн ухамсарт чин бишрэл зүтгэлийн зам дээр гарч дармал эрдэнэсийг зүүн талаас нь хайх юм. Үнэндээ чин бишрэл зүтгэлийн зам нь шавхагдаж дуусашгүй эрдэнэ ба хүн түүнийг олсон цагт хэмжээгүй их эд баялагийн эзэн болно. Харин Кршңагийн ухамсарт ядуухан нэгний хувьд цаг үргэлж ямар нэг материаллаг эд баялаг шаардагдаж байдаг. Заримдаа тэрээр хортой амьтдын хатгалтаас болж зовох ба заримдаа найдвар горьдлого нь нуран унадаг; заримдаа тэрээр монизмын гүн ухааныг дагаж, тийнхүү өөрийн бие даасан тусгаар байдлаа алддаг, заримдаа түүнийг аварга том могой залгиж орхидог. Зөвхөн энэ бүгдийг хаяж орхиж байж, Бурханд чин бишрэлээр үйлчлэхүйд буюу Кршңагийн ухамсарт батжиснаар амьдралын төгс төгөлдөрт жинхэнээрээ хүрч болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бурханд хэрхэн ойртон дөтлөх вэ

Чухамдаа бүх ведийн утга зохиолууд хүнийг чин бишрэлийн төгс төгөлдөр түвшинд хүргэхэд чиглэдэг. Кармын үйлийн, цэцэрхийлэн танин мэдэхүйн, бясалгалын замууд хүнийг төгс төгөлдөрт хүргэдэггүй ч чин бишрэл зүтгэлийн тусламжтайгаар үнэхээр Бурханд ойртон дөтлөж болно. Ийм учраас ведийн бүх

утга зохиолууд бүгдийг энэ зам дээр гарахыг зөвлөдөг. Үүнтэй холбогдуулан Чаитанья Махāпрабху *Шрїмад-Бхāгаватам*д Уддхавад өгсөн Бурханы сургаалын шүлгээс иш татсан:

на сādхайати мām його

на сāнкхйам дхарма уддхава

на свāдхйāйас тапас тйāго

йатхā бхактир маморжитā

“Эрхэм Уддхава минь ээ, гүн ухааны цэцэрхийлэл ч, бясалгалын йог ч, тэвчил наминчлал ч чин бишрэл зүтгэлийг үйлдэн буй амьд оршнолын Надад өгдөг шиг ханамж таашаалыг өгч чадахгүй”. (Бхāг.11.2.37) Кршᅇна зөвхөн чин бишрэлтэнд эрхэм ба Түүнд зөвхөн чин бишрэл зүтгэлээр л хүрч чадна. Хэрэв доорд гарал бүхий хүн чин бишрэлтэн болвол тэрээр аяндаа бүхий л бохирдол бузардлаас ангижирдаг. Чин бишрэл зүтгэл нь цорын ганцхан зам бөгөөд түүгээр замнаснаар Дээд Бодгальд хүрч чадна. Энэ нь бүх бүх ведийн бүтээлүүд хүлээн зөвшөөрдөг цорын ганц төгс төгөлдөр юм. Ямар нэг эрдэнэстэй болсноор ядуу хүн аз жаргалтай болдог шиг хүн чин бишрэл зүтгэлийн зам руу хүрэлцэн ирвэл түүний материаллаг зовлон зүдгүүр аяндаа арилдаг. Чин бишрэл зүтгэлдээ өсч хөгжиснөөр хүн Бурханыг хайрлах хайрыг олж авах ба энэ хайр хөгжихийн хирээр хүн материаллаг боолчлолоос ангижирдаг. Гэвч ядуу хоосон байдал үгүй болох, боолчлолоос ангижрах нь Кршᅇнаг хайрлах хайрын эцсийн үр дүн хэмээн бодох хэрэггүй. Кршᅇнаг хайрлах хайр нь зөвхөн харилцсан цэнгэл дээр суурилдаг бөгөөд чин бишрэл зүтгэлд л Кршᅇна хариу өгдөг. Бүх ведийн бүтээлүүдээс чин бишрэл зүтгэлийн зорилго нь Дээд Бурхан ба амьд оршнол хоёрын хоорондох хайрын харилцаанд хүрэх гэдгийг олно. Бидний жинхэнэ зорилт бол чин бишрэл зүтгэл ба бидний эцсийн зорилго бол Бурханыг хайрлах хайр юм. Кршᅇна бол бүх зүйлсийн төгсгөлийн цэг гэдэг дээр бүх ведийн бүтээлүүд дуу нэгтэй байдаг. Учир нь Кршᅇнаг танин ойлгох нь амьдралын бүхий л асуудлыг шийдвэрлэдэг.

Чаитанья Махāпрабху, хэдийгээр(*Падма Пурāнд* өгүүлснээр) янз бүрийн сахиулсан тэнгэрүүдэд мөргөхөд зориулагдсан олон янзын Судар бичгүүд байдаг ч тиймэрхүү заавар сургамж нь хүмүүсийг төөрүүлэн самууруулдаг ба тэд сахиулсан тэнгэрүүд нь дээд эрх мэдлийг эзэмшдэг гэж тооцож эхэлдэг хэмээн онцлон тэмдэглэсэн. Хэрэв хүн маш няхуур байдлаар *Пурāнуудыг* задлан дүгнэж, судалвал тэрээр Кршᅇна нь Бурханы Дээд Бодгаль бөгөөд мөргөл залбирлын цорын ганц объект юм гэсэн дүгнэлтэнд хүрнэ. Жишээ нь, *Мārкандея Пурāнд* дурдсанаар, Девйд мөргөх буюу өөрөөр хэлбэл Дурга эсвэл Кālйд мөргөх нь, мөнхүү тэр чаңдикад ч батлан өгүүлснээр бүхий л сахиулсан тэнгэрүүд Дурга байна уу, Кālй байна уу ялгаагүй бүгд Дээд Бурхан Вишᅇнугийн янз бүрийн эрчим гэсэн байдаг.

Тийнхүү *Пурāныг* судлах нь мөргөл залбирлын цорын ганц объект болох Бурханы Дээд Бодгаль, Вицнуг нээн өгдөг. Эндээс мөргөл залбирлын бүх хэлбэр нь шууд ба шууд бус байдлаар их бага ямар нэг хэмжээгээр Бурханы Дээд Бодгаль Кршнад зориулагдсан байдаг. *Бхагавад-гītāд* (Бг.7.20-23, 9.23) мөн батласнаар, тиймэрхүү мөргөл нь буруу хэмээжээ. *Шрīмад-Бхāгаватам* ч үүний зүй бусын тухай батлаж, “Янз бүрийн сахиулсан тэнгэрт мөргөх нь ямар зорилготой юм бэ?” гэсэн асуулт тавьсан байдаг. Ведийн бүтээлүүдэд ёслол мөргөлийн үйлийн хэд хэдэн бүлэг агуулагдаж байдаг. Тэдний нэг нь *карма-кāнда* буюу цэвэр ёслол мөргөлийн үйл, нөгөө нь *жйāна- кāнда* буюу Дээд Туйлын Үнэний тухай эргэцүүлэн бодох юм. Тэгвэл ёслол мөргөлд зориулагдсан ведийн утга зохиолын энэ салбарын зорилго юунд орших вэ, төрөл бүрийн сахиулсан тэнгэрүүдэд зориулагдсан янз бүрийн мантра, дууллын зорилго юу вэ? Туйлын Үнэний талаар цэцэрхэн маргадаг гүн ухааны цэцэрхийллийн зорилго юу вэ? Ведүүдэд тодорхойлогдсон энэ бүх аргууд нь үнэн хэрэгтээ Дээд Бурхан Вицнуд мөргөх мөргөлийг заадаг хэмээн *Шрīмад-Бхāгаватам* хариулж байна. Өөрөөр хэлбэл тэд бүгд цөмөөрөө Бурханы Дээд Бодгальд мөргөх тойруу арга юм. Эдгээр Судар Бичгүүдийн ёслол мөргөлийн тухай өгүүлсэн хэсэг дэхь тахилга өргөлүүд нь Дээд Бурхан Вицнугийн тааллыг хангахад зориулагдсан байдаг. Чухамдаа йажна буюу тахил өргөл нь Вицнугийн тааллыг хангахад тусгайлан зориулагдсан учраас Вицнугийн өөр нэгэн нэрийг Йажнешвара буюу өргөл тахилгын Эзэн гэдэг.

Эхлэгч бүхэн нэгэн адил трансцендент түвшинд байдаггүй учраас тэдэнд материаллаг байгалийн янз бүрийн гунуудад орших тэдний байр суурьтай тохирсон олон төрлийн сахиулсан тэнгэрүүдэд мөргөхийг зөвлөдөг. Үүний утга нь аажмаар тэрхүү эхлэгч нар нь трансцендент түвшинд хүрч, Бурханы Дээд Бодгаль Вицнуд үйлчлэн зүтгэж чадна. Жишээ нь, махан хоолонд дур сонирхолтой зарим нэг эхлэгч нарт *Пурāнууд*, махыг эхлээд Кāли Шүтээнд өргөсний дараагаар идэхийг зөвлөдөг.

Ведийн дуоллуудын гүн ухааны салбарууд нь хүнд Дээд Бурханыг *мāйāгаас* ялгаж салгах боломжийг өгдөг. *Мāйāгийн* байр суурийг ойлгоод хүн цэвэр чин бишрэл зүтгэлээр Дээд Бурханд ойртон дөхөж чадна. Үүнд л гүн ухааны эргэцүүллийн жинхэнэ зорилго оршино. Үүнийг *Бхагавад-гītāд* батлан:

бахūнāм жанманāм анте

жйāнавāн мām прападйате

вāсудевах сарвам ити

са махātмā судурлабхах

“Олон, олон төрөлт, үхлийн дараагаар жинхэнээр мэдлэгийг олж, Намайг оршин буй бүхний шалтгаан, шалтгаан бүхний шалтгаан гэдгийг танин ойлгосон хүн нь

Надад өөрийгөө даатгамуй. Гэвч ийм аугаа сүнснүүд нь маш ховор тааралдьюу ”
(Бг.7.19)

Тийм байдлаар бүх ведийн ёслол мөргөл, янз бүрийн мөргөлийн хэлбэрүүд, цэцэрхийллийн гүн ухааны эргэцүүлэл зэрэг нь эцсийн дүндээ Кршṇа хэмээх өөрийн зорилготой.

Дараа нь Чаитанйа Махāпрабху Санāтана Госвāмйд Кршṇагийн олон янзын дүр хэлбэрүүд, Түүний хязгааргүй эд баялагийн тухай өгүүлсэн. Тэрээр мөн бурханлаг илрэлийн, материаллаг илрэлийн, амьд оршнолуудын илрэлийн мөн чанаруудын талаар өгүүлэв. Мөн Тэрээр Санāтана Госвāмйд Ваикунṭхийн гэж нэрлэгдэх бурханлаг тэнгэрийн гаригууд ба материаллаг ертөнцийн орчлонгууд нь чухамдаа илрэлийн янз бүрийн хэлбэрт хамаардаг тухай тайлбарласан. Учир нь энэхүү материаллаг болон бурханлаг хэмээх хоёр янзын эрчмээс бүтсэн илрэл юм. Кршṇагийн Өөрийнх нь тухайд гэвэл Тэрээр Өөрийн бурханлаг эрчимд шууд орших ба тодруулж хэлвэл өөрийн дотоод эрчимдээ оршин байдаг. Материаллаг болон бурханлаг эрч хүчний ялгааг бидэнд ойлгуулахын тулд *Шрймад-Бхāгаватамын* Хоёрдугаар Дуулалд энэхүү хоёр эрчмийн аль алиных нь тухай дэлгэрэнгүй дүн шинжилгээ агуулагддаг. Тэдгээрт *Шрймад-Бхāгаватамын* Аравдугаар Дууллын нэг дэхь шүлгэнд өгсөн Шрйдхар Свāмийн тайлбарт тодорхой дүн шинжилгээ хийсэн байдаг. Бурхан Чаитанйа Шрйдхар Свāмийг *Шрймад-Бхāгаватамын* нэр хүндтэй, баттай тайлбарлагч хэмээн хүлээн зөвшөөрч байсан. Тэрээр түүний бүтээлээс иш татаж, *Бхāгаватамын* Аравдугаар Дуулалд Кршṇагийн амьдрал, үйлийг өгүүлсэн байдаг тухай тайлбарласан. Учир нь Кршṇа нь бүхий л илрэлүүдийн өмөг түшиг юм. Энэ тухай мэдээд, Шрйдхар Свāмй Кршṇад мөргөн залбирч байсан бөгөөд бүхий л оршин буй зүйлсийн өмөг түшиг хэмээн Кршṇад өөрийн хүндэтгэл бишрэлээ илэрхийлжээ.

Энэ ертөнцөд хоёр зарчим үйлчилдэг: нэг нь эх үүсвэр буюу бүхий л оршин буй бүхний өмөг түшиг, нөгөө нэг зарчим нь энэ анхдагч зарчмаас үүсэн гардаг зарчим. Дээд Үнэн нь бүхий л илрэлийн өмөг түшиг ба Түүнийг *āшрайа* гэдэг. Туйлын Үнэн буюу *āшрайа-таттвын* хяналтанд байдаг бусад бүх зарчмуудыг *āшрита* буюу захирагдагч шууд үр дагавар буюу хариу урвал гэнэ. Материаллаг илрэлийн зорилго нь болзолт сүнсэнд ангижралд хүрэх, *āшрайа-таттва* буюу Туйлын Үнэний зүгт буцах боломжийг олгоно. Сансрын бүтээл дотор орших бүх зүйл *āшрайа-таттва*-бүтээлийн илрэл буюу янз бүрийн сахиулсан тэнгэрүүд, эрч хүчний илрэл болсон Вицṇугийн илрэлээс хамаардаг болохоор амьд оршнолууд, бүх материаллаг элементүүд Кршṇагаас хамаардаг. Учир нь Кршṇа бол Дээд Үнэн юм. Тийнхүү Шрймад-Бхāгаватам, Кршṇа шууд ба шууд бус байдлаар оршин буй бүгдийн өмөг түшиг нь болдог гэдгийг зааж байна. Эндээс төгс төгөлдөр мэдлэгийг

Бхагавад-гītā батлан айлдсанчлан, Кршṇаг зөвхөн аналитик байдлаар судалснаар олж болно.

Дараа нь Бурхан Чаитанья Санātанаг онцгой анхааралтай сонсохыг хүсээд, Кршṇагийн олон янзын онцлог шинжүүдийн тухай өгүүлэв. Үүний дараагаар Тэрээр түүнд Махārāja Нандын хүү Кршṇа нь Дээд Туйлын Үнэн, шалтгаан бүхний шалтгаан, бүхий л илрэл, хувилгаадын эх үүсвэр юм гэдгийг тайлбарлалаа. Чингэвч Вражад буюу Голока Врндāванд Тэрээр үргэлж залуухан хүү мэт байдаг ба Махārāja Нандын хүү болдог. Түүний энэ дүр хэлбэр нь мөнх, цэнгэл жаргал, туйлын мэдлэгээр дүүрэн. Тэрээр оршин буй бүхний өмөг түшиг, түүний эзэн нь юм.

Чаитанья Махāпрабху мөн Бурхан Кршṇагийн бие, трансцендент чанаруудын тухай өгүүлсэн *Брахмā-самхитын* нотолгоо, баталгаанаас иш татсан:

йшварах парамāх криṇāх
сач-чид-āнанда-виграхах
анāдир āдир говиндах
сарва-кāраṇа-кāраṇам

“Говинда хэмээн нэрлэгдсэн Кршṇа нь Дээд Бурхан билээ. Түүний бурханлаг бие махбодь эрдэм мэдлэг, цэнгэл жаргалаар дүүрэн хийгээд мөнх юм. Тэрээр бүх зүйлсийн анхдагч эх үүсвэр ба Түүнд ямар нэг өөр эх үүсвэр үгүй билээ. Тэрээр мөн шалтгаан бүгдийн шалтгаан юм” (*Брахмā-самхитā*, 5.1). Тийнхүү Чаитанья Махāпрабху, Кршṇа нь зургаан гоц чанараар дүүрэн, анхдагч Бурханы Бодгаль гэдгийг батлав. Түүний оршин суух газар нь Голока Врндāван гэж нэрлэгдсэн бурханлаг тэнгэрийн дээд гаригийн систем юм.

Түүнээс гадна Бурхан Чаитанья *Шрīмад-Бхāгаватамын* (1.3.28) шүлгээс иш татсан:

эте чāмшиа-калāх пумсах
криṇас ту бхагавāн свайам
индрāри-вийāкулам локам
мрдāанти йуге йуге

Бүхий л хувилгаад нь нэг бол Кршṇагийн шууд илрэл, нэг бол шууд бус буюу Кршṇагийн илрэлийн илрэл байдаг. Гэвч “Кршṇа” хэмээх нэр нь анхдагч Бурханы Бодгалийг заадаг. Тэрээр, цаг үргэлж сахиулсан тэнгэрүүдийн зариргаа эрхшээлийг тасалдуулахыг оролдож байдаг демон буюу чөтгөрүүдийн буруугаас болж эмх

замбараагүй байдал үүсэхэд энэ Дэлхий дээр, энэ орчлон дээр, эсвэл аль нэг өөр орчлон дээр илрэн заларна.

Гурван төрлийн арга бий бөгөөд тэдгээрийн туслалцаатайгаар Крш᳚аг танин ойлгож чадна: гүн ухааны цэцэрхийллийн туршилтын арга, ид шидийн йогтой тохирох бясалгалын арга, чин бишрэл зүтгэлийн буюу Крш᳚агийн ухамсрын арга. Гүн ухааны цэцэрхийллийн аргаар Крш᳚агийн бодгаль бус төлөв-Брахманыг танин ойлгодог. Бясалгалын буюу ид шидийн йогоор Дээд Сүнс буюу Крш᳚агийн бүхэнд нэвтрэгч илрэлийг танин ойлгодог. Харин бүрэн дүүрэн Крш᳚агийн ухамсар дахь чин бишрэл зүтгэл нь анхдагч Бурханы Бодгалийг таних боломжийг олгодог. Бурхан Чаитанья нь мөн *Шр᳚мад-Бх᳚гаватамын* (1.2.11) дараахь шүлгээс иш татсан:

*вадант᳚ тат таттва-видас
таттва᳚ йаж ж᳚᳚анам адвайам
брахмети парам᳚тметри
бхагав᳚н ити шабд᳚йате*

“Туйлын Үнэнийг танин ойлгосон нэгэн нь Туйлын Үнэнийг гурван төлөвт оршин буйг өгүүлдэг: бодгаль бус Брахман, бүхэнд нэвтрэн оршигч Дээд сүнс, Бурханы Дээд Бодгаль, Крш᳚а”. Өөрөөр хэлбэл бодгаль бус илрэл Брахман, бүхэнд оршигч Дээд Сүнс, Бурханы Дээд Бодгаль Бхагав᳚н нь мөн чанарын хувьд нэг юм. Гэвч ямар замыг замыг сонгосноос хамаарч Түүнийг нэг бол Брахман, нэг бол Парам᳚тм᳚, Бхагав᳚н байдлаар танин ойлгоно.

Бодгаль бус Брахманыг таниад хүн ердөө л Крш᳚агийн трансцендент биеэс цацрах цацрал туяаг танин ойлгодог. Энэ цацралыг нарны гэрэлтэй адилтгаж болно. Нарын бурхан, нар өөрөө, энэхүү анхдагч нарны бурханы гэрэл цацарсан туяа болсон нарны гэрэл гэж бий. Үүнтэй адил бурханлаг цацраг туяа (брахмажйоти), бодгаль бус Брахман нь Крш᳚агийн биеийн цацарсан туяанаас өөр юу ч биш. Энэ харьцуулалтыг батлан Бурхан Чаитанья *Брахм᳚-самхитын* нэгэн чухал шүлгийг иш татсан. Энэ шүлгэнд Брахм᳚ Тэнгэр:

*йас᳚а прабх᳚ прабхавато жагада᳚да-ко᳚ти-
ко᳚тиц᳚в ашеца-васудх᳚ди-вибх᳚ти-бхиннам
тад-брахма ницкалам анантам ашеца-бх᳚там
говиндам ᳚ди-пуруца᳚м там ахам бхаж᳚ми*

“Би вээр Бурханы Дээд Бодгаль таны өмнө мөргөн залбримуу. Түүний биеийн цараг туяа нь хязгааргүй брахмажйотийг илрүүлэн бүрдүүлмүй. Энэхүү

брахмажйотид үй олон орчлонгууд орших ба тэдгээрт тус бүрт нь тоогүй олон тооны гаригсууд оршмуй”.

Бурхан Чаитанья цааш нь, Парамāтмā буюу бүгдийн биед орших, бүхэнд нэвтрэгч төлөв нь Кршṇагийн илрэл буюу хэсэгчилсэн илрэл боловч Кршṇа нь бүхий л сүнснүүдийн сүнс учраас Түүнийг Парамāтмā буюу Дээд “Би” гэдэг. Үүнтэй холбогдуулж Чаитанья *Шрїмад-Бхāгаватамын* шүлгээс буюу Махāрāжа Парїкшит, Шукадева Госвāmї нарын харилцан ярианаас иш татсан. Врндāван дахь Кршṇагийн трансцендент тоглоом наадмын тухай сонсоод Махāрāжа Парїкшит өөрийн номын багш Шукадева Госвāmїгаас, яагаад чухам Врндāваны оршин суугчид тэгж ихээр Кршṇад уягдан татагддаг тухай асуусан. Энэ асуултанд Шукадева Госвāmї хариулсан нь:

кршṇам энам авехи твам

ātмāнам акхилātманām

жагаддхитāйа со нї атра

дехївāбхāти мāйайā

(Бхāг. 10.14.55)

“Кршṇаг бүхий л сүнснүүдийн сүнс хэмээн ойлгох хэрэгтэй. Учир нь Тэрээр бүхий л бие даан оршигч сүнснүүдийн сүнс нь юм. Түүнчлэн бүхэнд оршигч Парамāтмын ч сүнс нь юм. Врндāванд Тэрээр хүмүүсийг татахын тулд, мөн Тэрээр дүр хэлбэргүй бус гэдгийгээ харуулахын тулд яг эгэл хүн мэтээр үйл хийж байсан”.

Дээд Бурхан нь бусад амьд оршнолууд шиг тийм л бие даасан боловч Тэрээр Дээд гэдгээрээ тэднээс ялгардаг ба бусад бүх амьд оршнолууд Түүнд захирагддаг. Түүний хүрээлэлд байх бусад бүх амьд оршнолууд мөн л бурханлаг цэнгэл жаргал, мөнхийн амьдрал, бүрэн дүүрэн мэдлэгээр цэнгэж чадна. Бурхан Чаитанья Бхагавад-гїтāгийн шүлгээс иш татсан. Энэ шүлгэнд Кршṇа Аржунад Өөрийн янз бүрийн эд баялагийн тухай өгүүлж, Тэрээр Өөрөө энэ орчлонд Өөрийн өргөн дэлгэр эрчмийн нэг Гарбходакашāйї Вишṇу дүрээр нэвтрэн ордог ба мөн орчлон бүрд Кцїйродакашāйї Вишṇу дүрээр орж, дараа нь Өөрийгөө Дээд Сүнс хэлбэрээр тархаан амьд оршнол бүрийн зүрхэнд залардаг тухай өгүүлсэн байна. Бурхан Кршṇа Өөрөө хэн бээр Дээд Туйлын Үнэнийг төгс төгөлдрөөр танин ойлгохыг хүсэгч нь бүрэн дүүрэн Кршṇагийн ухамсарт чин бишрэл зүтгэлийн процессыг хүлээн авах ёстой. Зөвхөн тэр цагт л тэрээр Туйлын Үнэний эцсийн үгийг ойлгож чадна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Түүний бүх дүр хэлбэрүүд нь мөн чанарын хувьд нэг

Чин бишрэл зүтгэлийн тусламжтайгаар Кршңа эхлээд Өөрийгөө *свайам-рӯна* буюу Түүний бодгаль хэлбэрээр, дараа нь *тадекātма- рӯна*, дараа нь *āвеша- рӯна* дүрээр илрүүлдэг гэдгийг ойлгож чадна. Тэрээр Өөрийн трансцендент дүрээр илрэх үеэр чухам энэ гурван дүрээр илэрдэг. *Свайам-рӯна* төлөв гэдэг нь түүний тусламжтайгаар Кршңаг Түүний өөр бусад төлвүүдийг ойлгохгүй байсан ч танин ойлгож чадах тэр дүр юм. Өөрөөр хэлбэл тэр хэлбэрт Кршңаг шууд танин ойлгож чадах тэр дүрийг *свайам-рӯна* буюу Түүний бодгаль хэлбэр гэж нэрлэдэг. *Тадекātма- рӯна* гэдэг дүр хэлбэр нь *свайам-рӯна* хэлбэртэй маш төстэй ч биеийн бүтцийн онцлогоороо түүнээс хэд хэдэн ялгаатай байдаг. *Тадекātма- рӯна* нь хоёр илрэлд хуваагддаг: бодгаль илрэл(*свāмша*) ба тоглоом цэнгэлийн илрэл(*вилāса*). Харин *āвеша- рӯнын* тухайд Кршңа тохирохоуиц ямар нэг амьд оршнолыг Түүнийг төлөөлөх итгэмжлэл олгоход энэ амьд оршнолыг *āвеша- рӯна* буюу *шактйāвеша- аватār* гэж нэрлэдэг.

Кршңагийн бодгаль хэлбэр нь *свайам-рӯна* ба *свайам-пракāша* ангилалд хуваагдана. Түүний *свайам-рӯна* буюу тоглоом цэнгэлийн дүр хэлбэр нь Тэрээр үргэлжид Врндāванд Врндāваны оршин суугчидтай хамт байх тэр дүр юм. Энэ бодгаль дүр хэлбэр нь (*свайам-рӯна*) цаашаа *прāбхава*, *ваибхава* хэлбэрүүдэд хуваагдана. Жишээ нь, *рāса* бүжгийн үеэр энэ *рāса* бүжигт оролцож байсан *гопй* бүртэй бүжиглэхийн тулд Кршңа Өөрийгөө маш олон хэлбэрт хувиран тархаасан. Үүнтэй адилаар, Дваракад Тэрээр Өөрийн 16108 эхнэр тус бүрийг баясал тааллыг хангахын тулд Өөрийгөө 16108 хэлбэрт хувиран тархаасан. Аугаа ид шидтэнүүд мөн түүнчлэн өөрийн биеийг янз бүрийн байдлаар хувиран тархаадаг ч Кршңа Өөрийгөө ямар нэг йогийн арга хэрэгслийн туслалцаагүйгээр тархаан хувилдаг.

Кршңагийн илрэл бүр бие даасан тусгаар байдалтай. Ведийн эрт дээр үеийн мэргэн Саубхарй Рҗци *йогийн* аргын тусламжтайгаар өөрийгөө найман дүр хэлбэрт хувиран тархаасан ч Саубхарй Рҗци ганцаараа л үлдэж байсан. Харин Кршңагийн хувьд Тэрээр Өөрийгөө янз бүрийн байдлаар илрүүлэх үед тэд бүгд тус тусдаа бие даасан тусгаар байдалтай байдаг. Нāрада Муни Кршңатай Түүний Двāрака дахь янз янзын ордуудад уулзах үедээ тэрээр үүнээс болж маш их гайхашралд орсон. Гэтэл *йогчийн* биеийн илрэл хувирлыг хараад тэрээр огт гайхдаггүй. Учир нь түүнд өөрт

нь энэ арга мэх тов тодорхой байдаг. Чингэвч *Шрїмад-Бхāгаватамд* өгүүлснээр, Нāрада Муни Кршᅇагийн илрэл хувирлыг хараад үнэхээр гайхсан байдаг. Бурхан ямархан байдлаар 16108 ордондоо Өөрийн хатан болгонтой хамт байсанд ихэд гайхсан. Хатан болгонтой Кршᅇа өөр өөр дүрээр хамт байж, янз бүрийн өөр байдлаар үйлдэл хийж байв. Нэг дүр хэлбэртээ Тэрээр хүүхдүүдтэй тоглож, нөгөө дүр хэлбэртээ өөр ямар нэг гэр бүлийн үйл хийж байлаа. Эдгээр янз бүрийн үйлийн хэлбэрүүдийг ваибхава-пракāша гэж алдаршсан Өөрийн “эмоцилог” дүр хэлбэрт оршин байх үедээ Бурхан гүйцэтгэж байв. Үүнтэй адилаар, Кршᅇагийн өөр бусад хязгааргүй олон тооны илрэлүүд байдаг ч тэд хязгааргүйгээр хуваагдах юм уу эсвэл хувилан тархах үед тэд бүгдээрээ нэг л байдлаар үлддэг. Түүний ийм болон өөр бусад дүр хэлбэрийн хооронд ямар ч ялгаа үгүй. Энэ нь Бурханы Дээд Бодгалийн туйлын мөн чанар юм.

Шрїмад-Бхāгаватамд өгүүлснээр, Акрūra, Кршᅇа, Баларāма нарыг Гокулаас Матхурт дагалдан явах үед тэрээр Йамуна мөрний усанд орсон ба түүнд/Йамуна мөрний усанд/ тэрээр бурханлаг тэнгэрийн бүх гаригуудыг харсан. Тэрээр мөн Бурханыг Вишᅇу Бурханы дүр хэлбэрт нь харсан бөгөөд түүнчлэн Түүнд мөргөн буй Нāрада, дөрвөн Кумāруудыг харсан байна. *Бхāгавата-Пурāнд* батласнаар:

анйе ча самскртātмāно

вибхинāбхихитена те

йажанти тван-майās твām ваи

бахумūrтй-эканамūrтикам

(Бхāг. 10.40.7)

Янз бүрийн мөргөлийн хэлбэрийн тусламжтайгаар ариусан цэвэршсэн олон олон мөргөгчид байдаг. *Ваишᅇнавууд*, *ārй* гэх мэт мөргөгчид мөн өөрсдийн итгэл үнэмшил, бурханлаг ойлгоцын түвшинтэйгээ тохируулан Дээд Бурханд мөргөдөг. Мөргөлийн арга хэлбэр бүр нь Судар бичгүүдэд дурдсан Бурханы янз бүрийн дүр хэлбэрийг ойлгон танихыг илтгэдэг ч бүгдийн эцсийн зорилго нь Дээд Бурханд Өөрт нь мөргөх юм.

Ваибхава-пракāша дүрдээ Бурхан Өөрийгөө Баларāма дүрээр илрүүлдэг. Баларāмын төлөв нь чухамдаа Кршᅇа Өөрөө юм; тэдгээрийн хоорондох цорын ганц ялгаа нь Кршᅇагийн бие нь бараан өнгөтэй, харин Баларāмын бие нь цайвар өнгөтэй. *Ваибхава-пракāшийн* дүр хэлбэрээ шууд энэ ертөнцөд нэвтрэн орсны дараагаар Кршᅇа Өөрийн эх Девакййн өмнө дөрвөн мутарт Нārāйāны дүрээр залрах үед илрүүлсэн. Гэвч өөрийн эцэг, эхийн хүсэлтээр Тэрээр хоёр мутарт дүрд шилжин хувирсан. Ингэж Тэрээр заримдаа дөрвөн мутарт, заримдаа хоёр мутарт дүрээр илэрдэг. Үнэн хэрэгтээ хоёр мутарт хэлбэр нь ваибхава-пракāша ба дөрвөн

мутарт хэлбэр нь *пṛābhava- prakāsha* юм. Өөрийн бодгаль дүр хэлбэртээ Кṛшṇа малчин-жаалтай адилхан ба чухамхүү Тэрээр Өөрийгөө тэгж л боддог. Гэвч Тэрээр Вāsудевын дүрд орших үедээ Тэрээр Өөрийгөө кшатрийн хүү хэмээн бодож, хаанчлагч удирдагч мэтээр үйл ажлаа явуулдаг.

Кṛшṇа Өөрийн аугаа байдал, дүр, гоо үзэсгэлэн, эд баялаг, дур татам байдал, тоглоом наадгайгаа Махārāja Нандын хүү, хоёр мутарт малчин жаалын дүрээр бүрнээ илрүүлдэг. Үнэн хэрэгтээ ваицṇавын утга зохиолд өгүүлснээр, Тэрээр заримдаа Вāsудевын хэлбэртээ Вṛндāванд Говиндын дүр хэлбэрээр бусдыг соронздон татдаг. Тийнхүү хэдийгээр Говинда, Вāsудевын дүр мөн чанарын хувьд адил ч, Тэрээр Вāsудевын чанарт шингэж заримдаа Говинда нэрт малчин-жаал болж цэнгэхийг хүсдэг байна. Үүнтэй холбогдуулж *Лалита-мāдхавын* дөрөвдүгээр бүлэгт(4.19) нэгэн газарт өгүүлснээр, Кṛшṇа Уддхавад дараахь үгийг хэлсэн тухай гардаг: “Миний эрхэм найз минь ээ, малчин-жаал, Говиндын дүр хэлбэр нь Намайг соронздон татдаг. Үнэндээ, Вражийн бүсгүйчүүд шиг л байхыг хүсдэг, тэднийг мөн Говиндын дүр хэлбэр татдаг”. Үүнтэй адилаар наймдугаар бүлэгт Кṛшṇа: “Ай энэ үнэхээр гайхамшигтай! Энэ хэн бэ? Рādхикā шиг би Түүнийг тэврэхийг одоо хүсч байна. Тэгж ихээр Түүний байдал төрх намайг татаж байна” .

Бага зэргийн ялгаатай Кṛшṇагийн дүр хэлбэрүүд байдаг. Эдгээр дүрүүдийг *тадекātма- rūpa* гэдэг. Тэд мөн цаашаа *вилāса, свāmша* дүр хэлбэрүүдэд хуваагддаг ба тэд мөн олон янзын төлвүүдтэй бөгөөд *пṛābhava, ваибхава* дүр хэлбэрүүдэд хуваагдаж болно. *Вилāса* дүрийн хувьд тоо томшгүй олон *пṛābhava-вилāса* дүрүүдтэй бөгөөд тэдгээрээр дамжуулан Кṛшṇа Өөрийгөө Вāsудева, Саṅкарṣаṇ, Прадйумна, Анируддха дүрээр хувиран тархаана. Заримдаа Бурхан Өөрийгөө малчин хэмээн боддог, заримдаа кшатрийн-хаан Вāsудевын хүү байдлаар боддог. Кṛшṇагийн эдгээр “эргэцүүллийг” Түүний “толоом наадам” гэдэг. Үнэн хэрэгтээ *ваибхава-пṛākāша, пṛābhava-вилāсад* Тэрээр нэгэн адил дүр хэлбэрт оршдог ч энэ үедээ Тэрээр янз бүрээр харагддаг: Кṛшṇа, Баларāма гэх мэтээр. Түүний илрэлүүд болох Вāsудева, Саṅкарṣаṇ, Прадйумна, Анируддха нар нь анхдагч *чатур-виūха* буюу дөрвөн мутарт хэлбэртэй байдаг.

Янз бүрийн гаригууд дээр, янз бүрийн газар оронд тоолшгүй олон дөрвөн мутарт илрэлүүд байдаг ба тэд мөнхөд Двāрака, Матхурт илрэн байдаг. Үндсэн дөрвөн мутарт хэлбэрүүдээс (Вāsудева, Саṅкарṣаṇ, Прадйумна, Анируддха) *ваибхава-вилāса* гэж нэрлэгдэх хорин дөрвөн үндсэн хэлбэр илрэн гардаг; тэд гартаа барьсан янз бүрийн бэлэг тэмдгүүд(дун, шийдэм, бадамлянхуа, галт хүрд)-ийн байршлаас хамааран янз бүрийн нэр зүүдэг. Кṛшṇагийн үндсэн гол илрэл нь

бурханлаг тэнгэрт гариг бүр дээр байдаг ба эдгээр гаригуудыг Нārāйаṅалока буюу Ваикунтхалока гэж нэрлэнэ. Ваикунтхалока дээр Тэрээр дөрвөн мутарт Нārāйаṅа дүрээр илрэх бөгөөд Нārāйаṅа тус бүрээс Вāsудева, Саṅкарцаṅ, Прадйумна, Анируддхын дүрүүд бий болдог. Тийнхүү Нārāйаṅа бол төв нь ба Вāsудева, Саṅкарцаṅ, Прадйумна, Анируддха хэмээх дөрвөн дүр хэлбэр Нārāйаṅагийн дүр хэлбэрийг хүрээлж байдаг. Энэ дөрвөн дүр хэлбэр тус бүр цааш гурван хэлбэрт тэлэн өргөжих ба тэд бүгд Кешава гэх мэтээс эхлээд янз бүрийн нэр авдаг. Энэ бүх дүрүүд бүгд нийлээд арван хоёр, тэд бүгд гартаа барьсан бэлэг тэмдгүүдийн байршлуудаас хамааран янз бүрийн нэртэй байна.

Вāsудевын хэлбэрийн хувьд Түүнээс үүсэн бий болсон гурван илрэл задрал нь Кешава, Нārāйаṅа, Мādхава нар юм. Саṅкарцаṅы гурван хэлбэрийг Говинда, Вицṅу, Шрй Мадхусūdана гэж нэрлэдэг. (Гэвч энэхүү Говиндын дүр хэлбэр нь Нанда Махārāжийн хүү болон Врндāванд заларсан Говиндын дүр хэлбэр биш юм). Үүнтэй адилаар Прадйумна нь мөн Тривикрама, Вāмана, Шрйдхара хэмээн алдаршсан гурван хэлбэрт хуваагдан задрана; Анируддхын гурван хэлбэр нь Хрцйкеша, Падманāбха, Дāмодара нэртэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бурханы хязгааргүй хэлбэрүүд

Ваицṅавуудын хуанлиар бол жилийн арван хоёр сарыг Бурхан Кршṅагийн Ваикунтхийн арван хоёр дүрийн нэрээр нэрлэдэг ба эдгээр дүрүүдийг жилийн арван хоёр сарын ивээгч-Шүтээнүүд гэж тооцдог. Хуанли арван сарын сүүлч, арван нэгдүгээр сарын эхэнтэй таарах Мārгашйрша сараас эхлэнэ. Арваннэгдүгээр сарын үлдэж буй хэсгийг ваицṅавуудын хуанлиар Кешава гэнэ. Арванхоёрдугаар сарыг Нārāйаṅа, нэгдүгээр сарыг Мādхава, хоёрдугаар сарыг Говинда, гуравдугаар сарыг Вицṅу, дөрөвдүгээр сарыг Шрй Мадхусūdана, тавдугаар сарыг Тривикрама,

зургаадугаар сарыг Вāмана, долдугаар сарыг Шрїдхара, наймдугаар сарыг Хрїйкеша, есдүгээр сарыг Падманāбха, арван сарын эхийг Дāмодара. (Дāмодара нэрийг Түүний эх нь олсоор Түүнийг хүлэх үед Кршṇад өгсөн нэр боловч арван сарын Дāмодарын дүр хэлбэр нь өөр илрэл юм). Жилийн арван хоёр сарыг Дээд Бурханы арван хоёр өөр нэртэй харгалзуулан нэрлэдэг шиг биеийн арван хоёр хэсгийг ваишṇавуудын хүрээнд эдгээр нэрүүдийг харгалзуулан тэмдэглэдэг. Жишээ нь, духан дээрхи *тилакийн* тэмдгийг Кешава гэж нэрлэдэг. Гэдэс, цээж, гар зэрэгт өөр өөр нэрүүдийг өгдөг. Эдгээр нь саруудад өгсөн тэрхүү нэрүүд байна.

Дөрвөн хэлбэр нь (Вāсудева, Саṅкарṣаṇ, Прадйумна, Анируддха) мөн вилāса-мўртид хувилан тархана. Эдгээр хэлбэр нь нийтдээ найм бөгөөд тэд Пуруцоттама, Ачйута, Нрсимха, Жанāрдана, Хари, Кршṇа, Адхокṣажа, Упендра нэрүүдтэй. Эдгээр наймаас Адхокṣажа, Пуруцоттама нь Вāсудевын *вилāса*-дүрүүд юм. Үүнтэй адилаар Упендра, Ачйута нь Саṅкарṣаṇы хэлбэрүүд; Нрсимха, Жанāрдана нь Прадйумны хэлбэрүүд, Хари ба Кршṇа нь Анируддхын вилāса-дүрүүд юм. (Энэ Кршṇа нь анхдагч Кршṇагаас ялгаатай).

Энэхүү хорин дөрвөн дүр хэлбэр нь *прāбхава*(дөрвөн мутарт) хэлбэрийн *вилāса* илрэл ба тэдгээрийг тэдгээрийг бэлэг тэмдгүүдийн (дун, шийдэм, бадамлянхуа, галт хүрд) байршлаас хамааруулан янз бүрээр нэрлэдэг. Энэхүү хорин дөрвөн дүр хэлбэрийн дотор *вилāса* ба *ваибхава* хэлбэрүүд бий. Энд дурдсан Прадйумна, Тривикрама, Вāмана, Хари, Кршṇа нь мөн Өөр Өөрсдийн дүрээр ялгардаг. Дараа нь Кршṇагийн(Вāсудева, Саṅкарṣаṇ, Прадйумна, Анируддха нарыг оролцуулаад) *прāбхава- вилāса*д шилжин ирэх үед ерөнхийдөө хүндрэн хорин хувилбартай болдог. Энэ бүх хэлбэрүүд нь бурханлаг тэнгэр дэхь Ваикунṭхийн гаригуудад байх ба найман зүгт оршин байдаг. Хэдийгээр тэд бурханлаг тэнгэрт мөнхөд оршдог ч тэдний зарим нь материаллаг ертөнцөд илрэнэ.

Бурханлаг тэнгэрт Нārāяṇы дүр хэлбэрийн нөлөөн дор орших бүх гаригс мөнх. Бурханлаг тэнгэрийн дээд гаригийг Кршṇалока гэдэг ба тэрээр мөн гурван өөр хэсэгт хуваагддаг: Гокула, Матхурā, Двāракā. Матхурт үргэлж Кешавын дүр хэлбэр оршин байдаг. Тэрээр энэхүү дэлхий гариг дээр харагдаж байна. Матхурт (Энэтхэгийн) Кешава-мўртид мөргөн залбирдаг ба үүнтэй адилаар Ориссын Жаганнāтха Пурїд Пуруцоттамын дүр хэлбэр бий. Āнандāраṇїд Вишṇугийн дүр байдаг ба Бурхан Чаитанйагийн төрсөн газар Мāйāпурт Харигийн дүр хэлбэр байдаг. Өөр бусад олон дүр хэлбэр энэ Дэлхийн олон янзын газар нутгуудад оршин бий юм. Зөвхөн энэ орчлон төдийгүй өөр бусад орчлонгуудаар ч хаа сайгүй Кршṇагийн дүр хэлбэрүүд тархсан байдаг. Энэ дэлхий нь долоон тив болсон долоон аралд хуваагдсаныг тэмдэглэсэн байдаг ба арал бүрд ийм дүрүүд байх нь

ойлгомжтой. Гэвч одоо цаг үед тэдгээрийг зөвхөн Энэтхэгт л харж болно. Хэдийгээр ведийн утга зохиолуудаас ертөнцийн өөр бусад хэсэгт эдгээр хэлбэрүүд байдаг тухай олж мэдэж болох ч одоо үед бидэнд эндгээр газруудын тухай мэдээлэл байхгүй.

Крш᳚агийн янз бүрийн дүр хэлбэрүүд нь чин бишрэлтнүүдээ баярлуулан талархуулахын тулд бүх орчлонгоор тархан түгсэн байдаг. Чин бишрэлтэнгүүд нь зөвхөн Энэтхэгт төрдөг хэмээн тооцох хэрэггүй. Чин бишрэлтнүүд нь ертөнцийн өнцөг булан бүрд бий ч тэд зүгээр л өөрсдийн жинхэнэ мөн чанараа мартчихсан юм. Эдгээр хэлбэрүүд нь чин бишрэлтнүүдэд баясал таашаал өгөхийн тулд бус харин чин бишрэл зүтгэлийг эргэн сэргээх, Бурханы Дээд Бодгальд байвал зохихуйц өөр бусад үйлүүдийг гүйцэтгэхийн тулд л байдаг. Эдгээр хэлбэрүүдийн зарим нь Судар Шастирүүдэд дурдагдсан байдаг. Жишээ нь Виц᳚угийн хувилгаан, Тривикрамын хувилгаан, Нрсим᳚хын хувилгаан, Вāманы хувилгаан гэх мэт.

Сиддхāртха-сам᳚хита᳚ Виц᳚угийн хорин дөрвөн дүр хэлбэрийн тухай өгүүлсэн байдаг ба эдгээр хэлбэрүүд нь Түүний дөрвөн гартаа барьсан бэлэгдлийн байршлаас хамааран нэрлэгддэг. Виц᳚у-м᳚ртигийн гарт байх зүйлсийн байршлыг өгүүлэхдээ баруун доод гараас эхлэх хэрэгтэй. Дараа нь баруун дээд, зүүн дээд, эцэст нь зүүн доод гэж. Ийм өгүүлэмжээр бол Вāсудева нь шийдэм, дун, бадамлянхуа цэцэг, галт хүрд барьсан байдаг. Анируддха нь галт хүрд, шийдэм, дун, бадамлянхуа цэцэг барьсан байдаг. Бурханлаг тэнгэрт нийтдээ Нāрāйа᳚ны хорин төлөөлөл бий. Тэднийг дараахь байдлаар дүрсэлдэг: Шрī Кешава (цэцэг, дун, хүрд, шийдэм), Нāрāйа᳚ (дун, цэцэг, шийдэм, хүрд), Шрī Мāдхава нь (шийдэм, хүрд, дун, цэцэг), Шрī Говинда нь (хүрд, шийдэм, цэцэг, дун), Виц᳚у-м᳚рти нь (шийдэм, цэцэг, дун, хүрд), Мадхус᳚дана нь (хүрд, дун, цэцэг, шийдэм), Тривикрама нь (цэцэг, шийдэм, хүрд, дун), Шрī Вāмана (дун, хүрд, шийдэм, цэцэг), Шрīдхара (цэцэг, хүрд, шийдэм, дун), Хр᳚йкеша нь (шийдэм, хүрд, цэцэг, дун), Падманāбха нь (дун, цэцэг, хүрд, шийдэм), Дāмодара (цэцэг, хүрд, шийдэм, дун), Пуру᳚оттама (хүрд, цэцэг, дун, шийдэм), Ачйута (шийдэм, цэцэг, хүрд, дун), Нрсим᳚ха (хүрд, цэцэг, шийдэм, дун), Жанāрдана (цэцэг, хүрд, дун, шийдэм), Шрī Хари (дун, хүрд, цэцэг, шийдэм), Шрī Крш᳚а (дун, шийдэм, цэцэг, хүрд), Адхок᳚ажа (цэцэг, шийдэм, дун, хүрд), Упендра (дун, шийдэм, хүрд, цэцэг).

Хайашīр᳚а-пайчарāтра᳚ өгүүлснээр арван зургаан дүр хэлбэр байдаг ба эдгээр хэлбэрүүд нь хүрд ба шийдмийн байршлаас хамааран янз бүрээр нэршдэг ажээ. Дүгнэлт-Бурханы Дээд Анхдагч Бодгаль бол Крш᳚а гэдэг. Түүнийг *лīлā-пуру᳚оттама* гэж нэрлэдэг бөгөөд голчон Врндāванд Нандын хүү байдлаар оршдог. *Хайашīр᳚а-пайчарāтрагаас* бид мөн Матхурā Пурī, Двāракā Пурī гэж нэрлэгдсэн тус тус хамгаалж байдаг есөн хэлбэр байдгийг мэдэж авч болно:

Вāсудева, Са̄нкарца̄н, Прадйумна, Анируддха нар нэгийг нь, Нāрāйана, Нрсим̄ха, Хайагрйва, Варāха, Брахмā нар нөгөөг нь хамгаалж байдаг. Энэ бүгд нь Бурхан Крш̄нагийн пракāша, вилāса дүрүүдийн илрэлүүд юм.

Бурхан Чаитанйа мөн Санāтана Госвāмйд *свāмшийн* өөр бусад хэлбэрүүд байдаг тухай мэдээлэв. Тэд Са̄нкарца̄ны болон хувилгааны гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Эхний төрөл нь Кāра̄нодакашāйи- Виц̄ну, Гарбходакашāйи Виц̄ну, Кц̄йродакашāйи Виц̄ну *пуруца-аватāруудын* эхлэлийг тавьдаг. Харин нөгөөдөх нь Бурханы загас, яст мэлхий дүрт хувилгаадүүд гэх мэт *лйлā- аватāруудын* эхлэлийг өгдөг.

Хувилгаадын зургаан хэлбэр янз байна: (1) *пуруца-аватāрууд*, (2) *лйлā-аватāрууд*, (3) *гуна-аватāрууд*, (4) *манвантара-аватāрууд*, (5) *йуга-аватāрууд*, (6) *шактйāвеша-аватāрууд*. Крш̄нагийн зургаан илрэлийн *вилāса* нь Түүний насан дээр суурилан хоёр төрөлд хуваагддаг ба *бāлийа*, *пауга̄нда* гэж нэрлэдэг. Нанда Махāрāжийн хүү Крш̄на Өөрийн анхдагч хэлбэрээр *бāлийа*, *пауга̄нда* хэмээх хүүхэд насны хоёр төлвөөр хоёлунгаар нь цэнгэн жаргадаг.

Тийнхүү Крш̄нагийн илрэл задрал болон хувилгаадад төгсгөл үгүй гэсэн дүгнэлтэнд баттайгаар хүрч болно. Бурхан хэрхэн Өөрийгөө тархаан түгээдэг, хэрхэн цэнгэн жаргадаг тухай бага сага төсөөлөл өгөхийн тулд Бурхан Чаитанйа тэдгээрийн заримыг нь Санāтанад тайлбарлаж байна. Энэ дүгнэлтийг *Шр̄ймад-Бхāгаватамд* (1.3.26) баталсан байдаг. Тэнд далайн усны давалгаа нь төгсгөл үгүй байдаг шиг Дээд Бурханы хувилгаадад төгсгөл үгүй гэсэн байдаг.

Эхлээд Крш̄на *пуруца-аватāр* хэмээх гурван төрөлд хувилна. Энэ нь Махā-Виц̄ну буюу Кāра̄нодакашāйи-аватāрууд, Гарбходакашāйи аватāрууд, Кц̄йродакашāйи аватāрууд юм. Үүнийг мөн *Сāтвата-тантрад* баталсан байдаг. Крш̄нагийн эрч хүчийг мөн гурван бүлэгт хуваадаг: эргэцүүллийн эрч хүч, мэдрэмжийн эрч хүч, үйлдэхүйн эрч хүч. Тэрээр эргэцүүллийн эрч хүчээ илрүүлэн гаргах үед Тэрээр Дээд Бурхан; Тэрээр мэдрэмжийн эрч хүчээ илрүүлэх үед Тэрээр Бурхан Вāсудева, Тэрээр үйлдэхүйн эрч хүчээ илрүүлэх үед Са̄нкарца̄н-Баларāма юм. Бурханлаг ертөнцийн гаригууд нь эхлэл байдаггүй болохоор хэдийгээр тэнд бүтээл гэж байдаггүй ч тэр нь энэ материаллаг ертөнцөд байдаг. Гэвч аль ч тохиолдолд бурханлаг ба материаллаг ертөнцүүд нь Крш̄нагийн Са̄нкарца̄н ба Баларāмын дүрээр үйлдэл хийдэг үйлийн эрчмийн илрэл юм.

Бурханлаг ертөнцийн Ваикунтхийн болон дээд гариг Крш̄налокийн гаригс нь Түүний эргэцүүллийн эрчимд оршдог. Хэдийгээр мөнх орших бурханлаг ертөнцөд бүтээ үгүй ч Ваикунтхийн гаригууд нь Дээд Бурханы эргэцүүллийн эрчмээс хамаардаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Түүний эргэцүүллийн эрчмийг *Брахма-*

самхита(5.2)-д өгүүлснээр, энэхүү Голока гэж нэрлэгдэх дээд өлгий нутаг нь зуу зуун дэлбээтэй бадамлянхуа цэцэгтэй адил илэрдэг. Тэнд бүх зүйл Сайнкарцаң буюу Баларāмын илрэл Анантагаар илрэн тодордог. Материаллаг сансар огторгуй ба түүний олон янзын орчлонгууд нь мāйā буюу материаллаг эрч хүчний тусламжтайгаар илрэн тодордог. Гэвч энэ материаллаг байгаль буюу материаллаг эрч хүч нь энэ сансрын илрэлийн анхдагч шалтгаан хэмээн бодох хэрэггүй. Эсрэгээр түүний шалтгаан нь Өөрийн янз бүрийн илрэл задралаа материаллаг байгалиар дамжуулан ашигладаг Дээд Бурхан юм. Өөрөөр хэлбэл, ямар ч бүтээл Дээд Бурханы зүгээс хяналтгүйгээр явагдах боломжгүй. Бүтээлийн шалтгаан болсон материаллаг байгалийн эрч хүчний хэлбэрийг Сайнкарцаң гэж нэрлэх ба энэхүү сансрын илрэл нь Дээд Бурханы хяналтан доор бүтээгддэг гэдэг нь тодорхой.

Шрймад-Бхāгаватамд (10.46.31)-д өгүүлснээр, Баларāма ба Кршңа нь бүхий л амьд оршнолуудын эх үүсвэр ба энэ хоёр бодгаль нь бүгдэд нэвтрэн ордог. Хувилгаадын жагсаалт нь *Шрймад-Бхāгаватамд* (1.3)-д агуулагдаж байдаг. Тэнд дурдсанаар: (1)Кумāрууд, (2) Нāрада, (3) Варāха, (4) Матсйа, (5) Йажñа, (6) Нара-нāрāйаңа, (7) Кāрдамын Капила, (8) Датгāтрейя, (9) Хайашйрша, (10) Хамса, (11) Дхруваприйя буюу Пршнигарбха, (12) Рñабха, (13) Пртху, (14) Нрсимха, (15) Кūrма, (16) Дханвантари, (17) Мохинй, (18) Вāмана, (19) Бхāргава, (20)Рāгхавендра, (21) Вйāса, (22) Праламбāри Баларāма, (23) Кршңа, (24) Буддха, (25) Калкй. Эдгээр хорин таван *лйла-аватār* бараг бүгд *калта* хэмээн нэрлэгддэг Брахмын нэг өдөрт багтан илрэн тодордог. Заримдаа тэднийг *калта-аватāрууд* хэмээн нэрлэх нь бий. Тэдгээрээс Хамсын болон Мохинийн хувилгаад нь тогтмол бус ч Капила, Датгāтрейя, Рñабха, Дханвантари, Вйāса энэ тав нь мөнхийн дүр хэлбэр нь юм. Тэд маш хамгийн нэр цуутай нь юм. Мэлхий хувилгаан Курма, загас хувилгаан Матсйа, Нара-нāрāйаңа, Варāха, Хайашйрша, Пршнигарбха, Баларāма нарыг *ваибхава* хувилгаад гэж тооцдог. Үүнтэй адилаар гурван *гуңа-аватār* гэж байдаг ба байгалийн шинж чанарын гол төлөв байдлыг хувилгаад болсон Брахмā, Вицңу, Шива нар юм.

Манвантара-аватār нь арван дөрөв байдаг: (1)Йажñа, (2)Вибуху, (3)Сатйасена, (4)Хари, (5)Ваикунтха, (6)Ажита, (7)Вāмана, (8)Сāрвабхаума, (9)Рñабха, (10) Вицваксена, (11)Дхармасету, (12)Судхāмā, (13)Йогешвара, (14)Брхадбхāну. Эдгээр арван дөрвөн *манвантара-аватāруудаас* Йажñа, Вāмана нар нь *лйла-аватāрууд* бөгөөд бусад үлдсэн нь манвантара-аватāрууд юм.

Дөрвөн *йуга-аватāрын* тухай *Шрймад-Бхāгаватамд* өгүүлсэн байдаг. Сатйа-йугад цагаан өнгөтэй Бурханы хувилгаан, Третā-йугад улаан өнгөтэй, Двāпара-

йугад бараан өнгөтэй, Кади-йугад мөн бараан боловч заримдаа онцгой Кали-йугад Тэрээр шар өнгөтэйгээр (Чайтанья Махāпрабху шиг) залардаг. *Шактйāवेशа-аватāрын* тухайд гэвэл түүнд Капила, Р̄цабха, Ананта, Брахмā ордог(заримдаа Бурхан Өөрөө Брахмā болдог), Нāрада(чин бишрэл зүтгэлийн хувилгаан), Пртху хаан(гүйцэтгэх засаглалын хувилгаан), Парашурāма (муу муухай болгоныг хүчээр номхотгон дарагч хувилгаан).

НАЙМДУГААР БҮЛЭГ

Аватāрууд

Бурхан Чайтанья, энэ материаллаг бүтээлд *аватāрууд* буюу хувилгаад гэж нэрлэгддэг Бурхан Кршṇагийн задралуудын тухай Санāтана Госвāmид үргэлжлүүлэнтайлбарласан. Аватār хэмээх үг нь “Буун заларсан нэгэн” гэсэн утгатай ба энэ тохиолдлын хувьд энэ үг нь бурханлаг ертөнцөөс буун заларсныг тов тодорхой зааж байна. Бурханлаг ертөнцөд Ваикунṭхийн үй олон гаригууд орших ба Бурханы Дээд Бодгалийн илрэлүүд эдгээр гаригуудаас энэ орчлонд морилон залардаг.

Сайкарцааны илрэлээс эхлэлтэй Бурханы Дээд Бодгалийн анхдагч *аватār* нь *пуруца* хувилгаан Махā- Вицṇу юм. *Шрймад-Бхāгаватамд* (1.3.1) баталснаар, Бурханы Дээд Бодгал нь материаллаг бүтээлийн анхдагч *пуруца* хувилгаан дүрээр буун залардаг ба Тэрээр тэр даруй арван зургаан хялбар эрч хүчийг илрүүлэн гаргадаг гэжээ. Түүнийг Махā- Вицṇу гэж нэрлэдэг бөгөөд Учир Шалтгааны далай

дээр хэвтэж байдаг. Чухамхүү Тэрээр материаллаг ертөнц дэхь анхдагч хувилгаан юм. Тэрээр цаг хугацаа, байгаль, шалтгаан ба үр дагавар, ухаан, эго, таван махбодь, байгалийн гурван *гуна*, мэдрэхүй, орчлонгийн дүр хэлбэрийн Эзэн нь юм. Хэдийгээр Тэрээр материаллаг ертөнцийн хөдлөгч ба үл хөдлөгч бүхий л объектуудын эзэгнэгч нь гэлээ ч Тэр бүрэн дүүрэн үл хамааралтай оршдог.

Материаллаг байгалийн нөлөөлөл нь Вираща буюу Учир Шалтгааны далайн хил хязгаараас чинагш гарч чаддаггүй ба *Шрїмад-Бхāгаватамд* (2.9.10) ч үүнийг баталсан байдаг. Материаллаг байгалийн *гуууд* (буяны, шунал тачаалын, мунхаг харанхуйн) материаллаг цаг хугацаа Ваикунтхгийн гаригуудад нөлөөлөл үзүүлдэггүй. Эдгээр гаригууд дээр Крш᳚агийн ангижирсан чөлөөт дагуулууд мөнхөд амьдран байх ба тэдэнд сахиулсан тэнгэрүүд хийгээд демон буюу чөтгөрүүд мөргөн залбирдаг.

Материаллаг байгаль нь хоёр шинж чанартайгаар үйлдэл хийдэг: *майā* ба *прадхāна*. *Майā* нь шууд шалтгаан ба харин *прадхāна* нь материаллаг илрэлийн махбодиудийг илтгэнэ.

Анхдагч *пуруща-аватār* Махā- Виц᳚у материаллаг эрчим рүү харц илгээхэд материаллаг эрч хүч сэрэн сэргэдэг. Тийнхүү *пуруща-аватār* нь материйг амьд оршнолуудаар үр тогтоодог. Ухамсар нь зүгээр л Махā- Виц᳚угийн харцаар бүтээгдэх ба энэ ухамсрыг *махат-таттва* гэнэ. *Махат-таттвын* удирдагч Шүтээн Бурхан нь Вāсудева юм. Энэ бүтээгдсэн ухамсар нь дараа нь гурван *гуна* буюу материаллаг байгалийн гол чанаруудтай тохирсон үйлийн хэлбэрүүдэд хуваагддаг. Буяны *гунад* орших ухамсрыг *Шрїмад-Бхāгаватамын* Арваннэгдүгээр дуулалд өгүүлсэн байдаг. Буяны *гуны* удирдагч Шүтээн Бурханыг Анируддха гэж нэрлэдэг. Материаллаг шунал тачаалын *гунад* орших ухамсар нь оюун ухааныг төрүүлдэг бөгөөд удирдагч Шүтээн Бурхан нь энэ тохиолдолд Прадйумна болно. Тэрээр бүхий л мэдрэхүйн эзэн юм. Мунхагийн *гунад* орших ухамсар нь эфир буюу огторгуй, сонсох мэдрэхүй үүсэхийн шалтгаан болдог. Сансрын илрэл тодрол нь эдгээр *гууудын* холимог бх тийнхүү тоо томшгүй олон орчлонгууд бүтээгддэг. Орчлонгуудын тоог тодорхойлж чадах хэн ч үгүй.

Эдгээр тоо томшгүй олон орчлонгууд нь Махā- Виц᳚угийн бие дэхь шар үсний сүвээс үүсэн гардаг. Шигшүүрийн нүхээр тоогүй олон тоосонцрууд нэвтрэн гардаг шиг Махā- Виц᳚угийн биеийн шар үсний сүвээр тоогүй олон орчлонгууд үүсэн гардаг. Түүнийг амьсгалаа гаргахад тоо томшгүй олон орчлонгууд үүсдэг ба Түүнийг амьсгалаа авахад тэд устаж байдаг. Махā- Виц᳚угийн бүхий л эрч хүч нь бурханлаг бөгөөд тэд материаллаг эрч хүчтэй ямар ч холбоо хамааралгүй. *Брахма-самхитад* өгүүлснээр, орчлон болгоны удирдагч шүтээн Брахмā нь Махā- Виц᳚угийн зөвхөн нэг амьсгал гаргах зуурт л амьдарна. Тийнхүү Махā- Виц᳚у нь бүхий л орчлонгуудын анхдагч Дээд сүнс ба мөн тэдгээрийн захирагч юм.

Хоёрдогч Вицнугийн хувилгаан Гарбходакашайй Вицну нь орчлон бүрд нэвтрэн ордог ба Биеэсээ ус ялгаруулан энэ усан дээрээ хэвтэн байдаг. Түүний хүйснээс бадамлянхау цэцэг ургаж, энэ лянхуа дээр анхны бүтээл Брахма төржээ. Энэ лянхуан ишин дотор Брахмын бүтээсэн гаригуудын системийн арван дөрвөн анги давхарга оршино. Орчлон бүрд Бурхан Гарбходакашайй Вицну хэлбэрээр оршин байна. Тэрээр энэ орчлонг тэтгэн барьж, түүний хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулж байдаг. Хэдийгээр Тэрээр материаллаг орчлон бүрийн дотор оршдог ч материаллаг эрч хүчний нөлөөлөл нь Түүнд халдаж чаддаггүй. Шаардлага гарвал энэхүү Вицну нь Өөрөө Шива Бурханы дүр хэлбэрийг аваад сансрын бүтээлийг устгадаг. Гурван хоёрдогч хувилгаан болох Брахма, Вицну, Шива нар нь материаллаг байгалийн гурван *гунагийн* удирдагч шүтээн бурхад юм. Гэвч орчлонгийн эзэн нь Гарбходакашайй Вицну ба Түүнд Хираңйагарбха Дээд Сүнс хэмээн мөргөн залбирцгаадаг. Ведийн дуоллууд мянган тэргүүнтэй хэмээн өгүүлдэг. Хэдийгээр Тэрээр материаллаг байгальд оршин байдаг ч материаллаг байгаль Түүнд халдан хүрэлцэж чаддаггүй.

Вицнугийн гурав дахь хувилгаан нь Кцйродакашайй Вицну ба мөн буяны *гунын* хувилгаан юм. Тэрээр мөн бүхий л амьд оршнолуудын Дээд Сүнс ба энэ орчлон дахь сүүн далай дээр оршин байдаг. Тийнхүү Чаитанья Махāпрабху *пуруца-аватāруудын* тухай өгүүлэв.

Дараа нь Бурхан Чаитанья *лйлā-аватāрууд* буюу “тоглон наадагч” *аватāруудын* тухай өгүүлсэн. Үүний хамт Бурхан тэдгээрт төгсгөл үгүй юм гэдгийг онцлон тэмдэглэв. Гэвч Тэрээр тэдгээрээс заримыг нь буюу Матсай, Кўрма, Рагхунātха, Нрсимха, Вāмана, Варāха нарын тухай өгүүлсэн.

Гуна-аватāрууд буюу Вицнугийн шинж чанарыг төлөөлсөн хувилгаадын тухайд гэвэл тэдгээр нь Брахма, Вицну, Шива гурав юм. Брахма нь жирийн амьд оршнолуудын нэг боловч өөрийн чин бишрэл зүтгэлийн ачаар маш их хүч чадлыг олсон. Энэ нь анхдагч амьд оршнол бөгөөд материаллаг шуналын гунын эзэн юм; тэрээр тоо томшгүй олон амьд оршнолуудыг бүтээхээр Гарбходакашайй Вицнуг шууд төлөөлдөг. *Брахма-самхитад* (5.49), Брахмаг нарны гэрлийн туяан доор орших үнэт эрдэнийн чулуутай зүйрлэсэн байдаг. Нарыг энэ тохиолдлын хувьд Дээд Бурхан Гарбходакашайй Вицнутаг адилтгасан байдаг. Хэрэв аль нэг *калтад* Брахмын үүргийг гүйцэтгэхэд тохирохуйц бодгаль эс олдвоос Гарбходакашайй Вицну Өөрөө Өөрийгөө Брахмын дүрээр илрүүлж тохирох байдлаар үйл гүйцэтгэдэг.

Үүнтэй адилаар Шива Бурханы хэлбэрийг авч Дээд Бурхан нь орчлонг устгах шаардлага гарах үед үйлдэл хийнэ. Шива Бурхан нь *майāтай* холбоотой маш олон дүр хэлбэртэй. Ерөнхийдөө тэднийг арван нэг гэж тооцдог. Шива Бурхан нь амьд

оршнолуудын нэг биш юм; Тэрээр бараг л Кршңа Өөрөө юм. Үүнтэй холбогдуулж сүү ба тарагны жишээг байнга иш татдаг. Таргийг сүүнээс гарган авдаг ч түүнийг сүү мэтээр ашиглах боломжгүй. Үүнтэй адилаар Шива Бурхан нь Кршңагийн илрэл задрал бөгөөд гэвч тэрээр Кршңа шиг үйл хийж чадахгүй, Кршңа шиг бидний Кршңагаас утган авдаг шиг бурханлаг сэргэлт мандалтыг бидэнд авч ирж чадахгүй. Тэдний хоорондох үндсэн ялгаа нь, Шива Бурхан нь материаллаг байгальтай холбоотой хийгээд Вицңу буюу Бурхан Кршңа нь материаллаг байгальтай ямар ч холбоо байдаггүй. *Шрїмад-Бхāгаватамд* (10.88.3) баталснаар, Шива Бурхан нь *ваикāрика, таијаса, тāмаса* гэж нэрлэгдсэн хувирмал гурван төрлийн ухамсрын хосмог юм гэсэн байна.

Вицңугийн хувилгаан нь хэдийгээр орчлон болгоны буяны гуңы эзэн ч гэсэн ямар нэг байдлаар материаллаг байгалийн нөлөөнд автдаггүй. Вицңу нь Кршңатай адилхан ч Кршңа анхдагч эх үүсвэр юм. Вицңу нь хэсэг ба Кршңа нь бүрэн бүтэн. *Брахмā-самхитад* түүнээс хоёрдогч лааг асаадаг үүсгүүр лааны жишээг иш татдаг. Хоёр лаа хоёулаа хүчин чадлын хувьд ижил ч тэдний нэгийг эх үүсгүүр лаа хэмээн тооцдог. Нөгөөгийнх нь тухайд гэвэл анхдагч лаанаас асаагдсан гэж ярьдаг. Вицңугийн илрэл нь хоёр дахь лаатай адил юм. Тэрээр яг Кршңа шиг л хүчирхэг ч эх үүсгүүр Вицңу нь Кршңа юм. Брахмā, Шива Бурхан нар нь Дээд Бурханы дуулгаварт зарц нар ба Вицңугийн дүрт Дээд Бурхан нь Кршңагийн илрэл юм.

Лїлā ба *гуңа-аватāруудыг* өгүүлсний дараагаар Бурхан Чаитаня Санāтана Госвāмїд *манвантара- аватāруудыг* тайлбарлав. Нэг *калпын* туршид буюу Брахмын нэг өдөрт арвандөрвөн Ману илрэн залардаг. Брахмын нэг өдөр нь 4 тэрбум 320 сая жилтэй тэнцэх ба Брахмā нь энэ хэмжээсээр зуун жилийн турш амьдарна. Ийнхүү хэрэв Брахмын нэг өдөрт арван дөрвөн Ману залардаг юм бол Брахмын нэг сарын туршид 420 Ману ирэх ба Брахмын нэг жилд 5040 Ману ирдэг. Брахмā нь ийм зуун жил амьдардаг болохоор Брахмын амьдралын туршид 504000 Ману илрэн залардаг. Тоогүй олон орчлонгууд байдаг болохоор *манвантара- хувилгаануудын* ерөнхий тоо хэмжээг тооцоолох чадваргүй. Бүх орчлонгууд Махā-Вицңугийн амьсгал гаргах зуурт нэгэн зэрэг илэрдэг учраас нэгэн зэрэг бий болсон Манугийн тоог ямар нэг байдлаар ойролцоогоор тооцоолох ч боломжгүй. Гэвч үүний хамт Ману бүр өөр өөрийн нэртэй. Анхны Мануг Свāйамбхува гэх бөгөөд тэрээр Брахмын хүү юм. Хоёр дахь Ману нь Свāрочица-галыг ивгээгч тэнгэрийн хүү. Гурав дахь Ману нь Прияврата хааны хүү Уттама. Дөрөв дэхь Ману нь Уттамын ах Тамаса. Тав дахь Ману нь Раивата. Зургаа дахь Ману нь Чāкшүца ба тэд хоёул Тамасын ах дүүс юм. Гэвч Чāкшүца нь Чāкшүгийн хүү. Долоо дахь Ману нь Ваивасвата ба тэрээр нарны бурханы хүү юм. Найм дахь Мануг Сāварңа

гэдэг ба тэрээр нарны бурханы эхнэр Чхэйигаас төрсөн хүү юм. Ес дэхь Ману нь Упашлокийн хүү Брахмасаварни юм. Чухамхүү үлдсэн дөрвөн Ману нь болох Рудрасаварни, Дхармасаварни, Девасаварни, Индрасаварни нар болно.

Манугийн хувилгаануудын тухай өгүүлээд Бурхан Чаитанья Санātана Госвāmид йуга- аватāруудын тухай тайлбарлав. Дөрвөн йуга буюу дөрвөн галав байдаг. Тэдгээр нь Сатйа, Третā, Двāпара, Кали юм. Дээд Бурхан энэ бүх галвуудад хувилан залардаг. Йугаас хамаарч Түүний хувилгаад нь янз бүрийн өнгөтэй байна. Сатйа-йугад голлох хувилгааны өнгө цагаан байдаг ба, Третā-йугад улаан, Двāпара-йугад хар бараан(Кршṇа), Кали-йугад гол хувилгааны өнгө нь шар(Чаитанья Махāпрабху). Үүнийг мөн *Шрīмад-Бхāгаватамд* (10.8.13) Гаргамуни зурхайч баталсан байдаг. Тэрээр Нанда Махāрāжийн гэрт Кршṇагийн хувь төөргийг зурж байв.

Сатйа-йугад өөрийгөө танин ухамсарлахуйн аргачлал нь бясалгал байсан ба энэ аргад Бурханы цагаан өнгөт хувилгаан сургаж байв. Энэ хувилгаан нь Кардама мэргэнд адислалаа хайрласан бөгөөд тэр адислалаар бол Бурханы Дээд Бодгалийн хувилгаан болсон хүүтэй болох учиртай ажээ. Сатйа-йугад бүгд л Кршṇаг бясалгадаг байсан ба бүх амьд оршнолууд бүрэн мэдлэгийг шингээсэн байдаг байв. Энэ галавт буюу Кали-йугад хүмүүс бүрэн мэдлэгийг огтхон ч эзэмшээгүй авч тэд өнгөрч одсон галавт зориулагдсан энэ бясалгалын аргаар хичээллэх гэж оролдоцгоож байна. Третā-йугад зориулагдсан өөрийгөө танин ухасарлахуйн арга нь тахилга өргөл үйлдэх ба энэ аргад Бурханы улаан өнгөт хувилгаан сургаж байв. Двāпара-йугад Кршṇа Өөрөө дэлхий дээр заларсан ба хүн бүр түүнд дараахь мантраны тусламжтайгаар мөргөн залбирч байлаа:

намас те вāсудевāйа

намах санкарцанāйа

прадйумнāйāнируддхāйа

тубхйām бхагавате намах

“Би Бурханы Дээд Бодгаль Вāсудева, Санкарцан, Прадйумна, Анируддха нарбн өмнө хүндэтгэлтэйгээр мөргөн залбирмуу”. Энэ бол Двāпара-йугад зориулагдсан өөрийгөө танин ухамарлахуйн арга байв. Дараагийн галав буюу одоогийн үргэлжилж буй Кали-йугад Бурхан Кршṇагийн ариун нэрийг давтан дуулахыг номлохын тулд хувилан заларчээ. Энэ галвын Бурхан нь шар өнгөтэй(Чаитанья Махāпрабху) ба Тэрээр Кршṇагийн ариун нэрийг давтах ба дуулахын тусламжтайгаар Бурханыг хайрлах хайранд хүмүүсийг сургаж байв. Кршṇа Өөрөө биечлэн энэ сургаалыг дагаж, Түүнийг дагалдагч зуу зуун хүмүүсийн хамт

Кршңагийн нэрийг давтан, дуулан бүжиглэж Бурханыг хайрлах хайрыг илрүүлэн үзүүлж байлаа. Бурханы Дээд Бодгалийн энэхүү хувилгааны тухай *Шрїмад-Бхāгаватамд* (11.5.32) зөгнөсөн байдаг:

кршңа-варнам твицїкршңам

сāнгопāнгāстра-пāршāдам

йажнāицх сāнкїртана-прāйаир

йажанти хи сумедхасах

“Калийн галавт Бурхан шар өнгөт чин бишрэлтний дүрээр хувилан заларна. Тэрээр Харе Кршңа, Харе Кршңа, Кршңа Кршңа, Харе Харе, Харе Рāма, Харе Рāма, Рāма Рāма, Харе Харе мантраг үргэлж давтана. Хэдийгээр Тэр Өөрөө Кршңа гэвч Түүний арьс Двāпара-йугад заларсан бараан бус, харин алтлаг өнгөтэй. Зөвхөн Кали-йугад Бурхан сāнкїртаны хөдөлгөөний тусламжтайгаар Бурханыг хайрлах хайрыг номлох үйлийг үйлдэж байв. Оюун ухаант амьд оршнолууд нь энэхүү өөрийгөө танин ухамсарлахуйн аргыг хүлээн авна”. *Шрїмад-Бхāгаватамд* (12.3.52)-т мөн өгүүлсэн нь:

крте йад дхїйāто вицнум

третāйāм йажато макхаицх

двāпаре паричарїйāм

калау таддхари-кїртанāt

“Өөрийгөө танин ухамсарлахуйн түвшинд Сатйа-йугад бясалгалын тусламжтайгаар, Третā-йугад янз бүрийн тахилга өргөхийн тусламжтайгаар, Двāпара-йугад Бурхан Кршңад мөргөж, Кали-йугад Харе Кршңа ариун нэрийг давтсанаар хүрч болно”. Үүнийг мөн Вицнү-Пурāнд(6.2.17) батлан өгүүлсэн нь:

дхїйāиан крте йажан йажнāиц

третāйāм двāпаре рчайан

йад āпноти тад āпноти

калау сāнкїртйа кешавам

“Энэ галавт бясалгал ч, тахилга өргөл ч, сүмд мөргөл үйлдэх ч үр ашиг авчрахгүй. Өөрийгөө танин ухамсарлахуйн төгс төгөлдөрт ердөө л Кршңагийн ариун нэрүүд болох Харе Кршңа, Харе Кршңа, Кршңа Кршңа, Харе Харе, Харе Рāма, Харе Рāма, Рāма Рāма, Харе Харе-г давтахын тусламжтайгаар хүрч болно”.

Бурхан Чаитанья энэ Калийн галвын хувилгааны тухай өгүүлэх үед цагтаа засгийн газрын ерөнхий сайдын суудалд сууж явсан, үнэлэлт дүгнэлт хийх онцгой цадвартай Санātана Госвāmй Бурханаас шууд асуусан нь: “Бурханы хувилгаан бууж ирснийг хэрхэн яаж таниж болох вэ?”. Калийн галвын хувилгааны тухай өгүүлэмжээс Санātана Госвāmй ирээдүйд Бурханн Чаитаньяг дууриахаар оролдон хичээх олон хүмүүс гарч ирнэ гэдгийг ойлгосон. Учир нь Бурхан Түүний чин бишрэлтэнгүүд Түүнийг Бурханы хувилгаан хэмээн хүлээн зөвшөөрснийг үл анзааран жирийн нэг *брāхманы* дүрд тоглож байлаа. Санātана хожим хойно олон олон хуурамч дүр эсгэгчид бий болохыг мэдэж байсан учраас тэрээр Бурханаас асуусан нь: “Ямар шинж чанараар нь Бурханы хувилгааныг таньж болох вэ?” гэв.

“Энэ Калийн галвын Бурханы хувилгааныг янз бүрийн галвуудад янз бүрийн хувилгаануудыг таньж байсан шиг ведийн Судар бичгүүдтэй тулган нягталж таньж болно” – хэмээн Бурхан хариуллаа. Өөрөөр хэлбэл хэн нэгнийг Бурханы хувилгаан гэж өөрийн дур хүслээр бус, харин үүний тулд судар шастирт тулгуурлан хувилгааны шинж чанарыг танин ойлгохыг оролдох нь чухал. Дээд Бурханы хувилгаан нь хэзээ ч Өөрийгөө хувилгаан хэмээн зарладаггүй. Гэвч Түүний дагалдагсад хэн нь хувилгаан бэ, хэн нь дүр үзүүлэгч вэ гэдгийг нэр хүндтэй Судар шаструудад тулгуурлан тогтоох ёстой.

Ямар ч ухаалаг хүн бодгаль буюу хязгаарын онцлог шинж гэж нэрлэгдсэн зарчмын онцгой ялгарах хоёр шинж төрхийг танин ойлгоод аватāруудын шинж чанаруудыг ойлгож чадна. Судар бичгүүдэд хувилгааны бие ба үйлийн онцлогийг өгүүлсэн байдаг. Бие махбодийн тухай өгүүлэмж нь зарчмын ялгарах шинж төрх нь бөгөөд түүгээр дамжуулан Бурханы хувилгааныг таньж болно. Хувилгааны үйл нь хязгаарын ялгарах шинж төрхийг бүрдүүлдэг. Үүнийг *Шрймад-Бхāгаватамын* бүр эхэнд (1.1.1) батлан аватāруудын ялгарах шинж төрхийг сайтар дүрслэн өгүүлсэн байна. Энэ шүлгэнд парам, сатйам хэмээх хоёр нэр томъёог ашиглажээ. Бурхан Чаитанья эдгээр үгүүдэд Кршṇагийн зарчмын ялгарах шинж төрхийг нээн таниулсан хэмээн зааж байна. Тэрээр ведийн эрдэм мэдлэгийг Брахмад заан сургаж, сансрын илрэл тодролыг бүтээхийн тулд *пуруца-аватār* дүрээр хувилан заларсанд хязгаарын ялгарах шинж төрхийн онцлог оршино. Энэ нь ямар нэг онцгой зорилгод хүрэхийн тулд илрүүлэн тодруулсан Түүний онцгой шинж чанарууд юм. *Аватārын* зарчмын ба хязгаарын ялгарах шинж төрхийг ойлгох болон ялган слагаж чаддаг байх нь зайлшгүй чухал. Хэн ч энэхүү хоёр ялгарах шинж төрхийг заалгүйгээр өөрийгөө Бурханы хувилгаан хэмээн зарлах эрхгүй. Оюун ухаант хүн нь зарчмын болон хязгаарын ялгарах шинж төрхүүдийг судлалгүйгээр хэнийг ч *аватār* гэж хүлээн зөвшөөрдөггүй. Бурханн Чаитаньягийн хувийн шинж чанар нь энэ галвын Бурханы хувилгаанд байх ёстой чанаруудтай таарч байна хэмээн Санātана Госвāmйг хэлэхийг оролдож байтал Бурхан Чаитанья Өөрөө түүний үгийг тойруугаар батлан, “Энэ асуудлыг хойш тавьж, дараа үргэлжлүүлвэ. Одоо харин *шактйāवेशа-āватарын* тухай өгүүлэмж рүү шилжиге” хэмээн энгийн тайвуу өгүүлэв.

Үүний дараагаар Бурхан *шактйāवेशа-āватарууд* төгсгөлгүй ба тэднийг тооцоолох боломжгүй гэж хэллээ. Гэвч тэдний заримыг нь жишээ болгон дурьдаж болно. *Шактйāवेशа* хувилгаанууд нь хоёр төрөл анги байдаг: шууд ба шууд бус гэсэн. Бурхан Өөрөө буун заларсан бол *сāкциāt* буюу шууд *шактйāवेशа-āватар* гэж нэрлэх ба харин Тэрээр ямар нэг амьд оршнолд Түүнийг Өөрийг нь төлөөлөхийг даалгасан бол энэ амьд оршнолыг шууд бус хувилгаан буюу *āवेशа* хувилгаан гэнэ. Шууд бус *āватаруудын* жишээ гэвэл дөрвөн Кумār, Нāрада, Пртху, Парашурāма нар юм. Үнэн хэрэгтээ эдгээр нь амьд оршнолууд авч Дээд Бурхан тэдэнд тодорхой хүчин чадлыг шингээсэн байдаг. Дээд Бурханы ямар нэг тодорхой гоц чанарыг тодорхой нэг оршнолд шингээвэл түүнийг *āवेशа-āватарууд* гэж нэрлэдэг. Чухамдаа дөрвөн Кумār нь Дээд Бурханы эрдэм мэдлэгийн санг төлөөлдөг байхад Нāрада нь Дээд Бурханд чин бишрэлээр үйлчлэн зүтгэхүйг илтгэн төлөөлдөг. Чин бишрэл зүтгэлийг мөн чин бишрэлийн бүрэн хувилгаан дүр гэж тооцогддог Бурхан Чаитанйа төлөөлдөг. Брахмад Дээд Бурханы өөр нэгэн гоц чанар болох бүтээх эрч хүчээ шингээсэн байхад, Пртху хаанд бүхий л амьд оршнолыг тэтгэн тогтоох Бурханы чадварыг шингээсэн байна. Үүнтэй адилаар Парашурāмад муу муухайг тээгчдийг устган дарах чадварыг шингээсэн. Вибхўти буюу Бурханы Дээд Бодгалийн онцгой адис ивгээлийн тухайд гэвэл *Бхагавад-гītāгийн* аравдугаар бүлэгт өгүүлсэнчлэн, хэрэв амьд оршнол нь онцгой хүчирхэг юмуу эсвэл гайхамшигтай сайхан мэт санагдвал үүнийг Дээд Бурхан Түүнд Өөрийн онцгой адис ивгээлээ хайрлажээ хэмээн ойлгох хэрэгтэй.

Сāкциād-āватар буюу шууд хувилгаануудын жишээ нь Шеца хувилгаан, Ананта хувилгаан нар юм. Анантад тодорхой эрч хүчийг шингээн өгсөн байдаг ба түүний тусламжтайгаар бүх гаригсыг тогтоон барьж байдаг ба харин Шеца хувилгаанд Дээд Бурханд үйлчлэх эрч хүчнийг шингээн өгчээ.

Шактйāवेशа хувилгаадын тухай өгүүлээд Чаитанйа Махāпрабху Дээд Бурханы насны талаар өгүүлэв. Тэрээр өгүүлэхдээ, Дээд Бурхан Кршṇа нь үргэлжид арван зургаан настай залуу хүү мэт байдаг ба Тэрээр энэхүү орчлонд орохыг хүсэх үед Тэрээр эхлээд нааш нь Түүний чин бишрэлтэнгүүд болсон Өөрийн эцэг, эхийг илгээх ба дараа нь Өөрөө хувилгааны дүрээр залрах буюу биечлэн хүрэлцэн ирдэг. Пўтана шулмыг устган дарснаас эхлээд Түүний бүх үйлүүд нь тоо томшгүй олон орчлонгуудаар илрэн тодорч байдаг ба тэдгээрт төгсгөл гэж үгүй. Агшин бүрд, секунд бүрт Түүний илрэл ба олон янзын тоглоом наадам нь янз бүрийн орчлонгууд(*брахмāндүүд*) дээр үзэгдэнэ. Тийнхүү Түүний үйл нь Гангын мөрний давалгаан мэт юм. Гангын давалгааны түрлэгт төгсгөл үгүй байдаг шиг янз бүрийн орчлонгууд дээрхи Кршṇагийн хувилгаануудын урсгал цутгалан тасран зогсдоггүй. Хүүхэд ахуйгаасаа эхлэн Тэрээр Өөрийн олон олон тоглоом наадмуудыг илрүүлэн үзүүлсээр эцэст нь *рāса* бүжгээр наадах хүртэл тоглоом наадмаа үзүүлж харуулсан юм.

Кршңагийн бүхий л тоглоом наадам нь мөнх гэж ярьдаг ба үүнийг ч бүх Судар бичгүүд баталдаг. Ихэвчлэн хүмүүс Кршңа чухам хэрхэн яаж Өөрийн тоглоом наадмаа үйлдэж байсныг ойлгож чаддаггүй ч Бурхан Чаитанья үүнийг Дэлхий Нарыг тойрон эргэх тоглоом наадгайтай адилтган зүйрлэж тайлбарласан. Ведийн зурхайн тооцооллоор бол хорин дөрвөн цагаас тогтдог хоног нь зургаан *дандаас* тогтоно. Дараагийн хоногийг хуваах хэмжээс 3600 *пал* юм. Нарны дугуй нь жаран *пал* болгоноороо ялгарч болох ба тэрхүү хугацаа нь нэг *палыг* бүрдүүлнэ. Найман *данд* нь нэг *прахараг* бүрдүүлэх ба нар шингэх ба жаргахын хоорондох хугацаа нь дөрвөн *парахараас* тогтдог. Түүнчлэн нар жаргах ба ургах хоёрын хоорондох шөнө нь дөрвөн *прахараар* хэмжигддэг. Үүнтэй адилаар Нар ба түүний хөдөлгөөнийг 3600 *палын* турш харж болдог шиг Кршңагийн бүх тоглоом наадмуудыг орчлонгуудын алин дээрээс ч харж болно.

Бурхан Кршңа энэ орчлон дээр зөвхөн 125 жилийн туршид оршин байсан ч энэ үед үйлдэж байсан бүх тоглоом наадмууд нь орчлон бүр дээр илрэн тодордог. Эдгээр тоглоом наадмууд нь өөртөө Түүний илрэл залрал, Түүний хүүхэд ахуйн тоглоом наадамууд, Түүний залуу идэр үе ба Түүний Двāракад үйлдэж байсан тоглоом наадмыг хүртэлх үеүдийг багтаадаг. Энэ бүх тоглоом наадмуудыг үй түмэн орчлонгуудын аль нэгэн дээр ямар ч цаг мөчид үргэлжилж байдаг болохоор тэдгээрийг мөнхийн хэмээн нэрэлэнэ. Нар нь бидний хардгаар бол ургаж, шингэж, энэ гариг дээрхи бидний байр суурьтай харгалзан илэрч, алга болж байдаг ч тэрээр мөнхөд оршдог. Үүнтэй адилаар Бурханы тоглоом наадмууд үргэлжилж байдаг. Тэдгээр нь энэхүү тодорхой нэг орчлон дээр тодорхой цаг хугацааны мөчлөгт илэрдгийг хэдийгээр бид харж буй ч гэсэн. Түүний орших өлгий нутаг нь Голока Врндāван гэж нэрлэгдлэх дээд гариг ба Түүний тааллаар энэхүү Голока Врндāван нь манай энэ орчлон дээр бусад орчлонгууд дээр илэрч тодордог шиг илрэн залардаг. Тийнхүү Бурхан үргэлжид Өөрийн дээд өлгий нутаг Голока Врндāван дээр оршин байж, Түүний дээд тааллаар Түүний үйл нь тоолшгүй олон орчлонгууд дээр илрэн тодорч байдаг. Тэрээр илрэн залрахдаа тодорхой нэг газар нутагт илрэн залрах бөгөөд Түүнийг залрах бүрд Түүнтэй хамт Түүний зургаан гоц байдал хамт илрэн тодордог.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Кршңагийн гоц чанарууд

Бурхан Чаитанья гэм зэмгүй, заль мэх үгүй хүмүүст онцгой өршөөнгүй учраас Түүнийг мөн Патита-пāвана буюу хамгийн унан доройтсон сүнснүүдийг аврагч хэмээн нэрлэдэг. Тэр ч байтугай хэрэв болзолт сүнс нь хамгийн доод түвшинд хүртэл унасан байлаа ч хэрэв тэр гэм зэмгүй бол тэрээр бурханлаг эрдэм ухаандаа өсөн хөгжиж чадна. Индуизмын нийгмийн системийн талаас нь авч үзвэл

Санātана Госвāmī нь унан доройтсон хүн байсан ба учир нь тэрээр мусульманы засаг төрд үйлчилж байсан юм. Чухамдаа үүний улмаас тэрээр бүр брахманы үе давхаргаас ч хасагдсан байв. Гэвч тэрээр үнэнч бишрэлтэй сүнс байсан болохоор Бурхан Чаитанйа түүнд бурханлаг мэдлэгийн эд баялагийг хайрлаж, түүнд онцгой адислалаа хайрласан юм.

Бурханы түүнд тайлбарлан өгсөн дараагийн зүйл бол бурханлаг тэнгэр дэхь янз бүрийн бурханлаг гаригсын тухай байв. Бурханлаг гаригуудыг мөн Ваикунтхийн гаригууд гэж нэрлэдэг. Материаллаг бүтээлийн орчлонгууд нь өргөн ба уртаараа ялгаатай. Харин Ваикунтхийн гагигууд хэмжээний хувьд хязгааргүй ба учир нь тэд бурханлаг юм. Бурхан Чаитанйа, Ваикунтхийн гариг бүр нь урт ба өргөнөөрөө сая сая, тэрбум тэрбум милийн эзэлдэг гэж Санātана Госвāmīд мэдээлсэн. Эдгээр гариг бүр нь төгсгөлгүйгээр өргөжин тэлж байдаг ба тэдгээрийн оршин суугч бүр нь бүхий л зургаан гоц чанар болох эд баялаг, хүч чадал, мэдлэг, гоо үзэсгэлэн, алдар нэр, огоорол зэргийг бүрэн шингээсэн байдаг. Эдгээр гариг бүр дээр Кршṇагийн ямар нэг илрэл задрал оршин байдаг ба харин Кршṇа Өөрөө Кршṇалока буюу Голока Врндāван гэж нэрлэгдэх анхдагч мөнхийн өлгийг нутагтай.

Энэхүү орчлон дээр ч хамгийн томоохон гаригууд нь ч гадаад орон зайд тийм ч том бус байр суурийг эзэлж байдаг. Нар нь хэдийгээр Дэлхийгээс мянга дахин том ч ялгаагүй тэрээр гадаад орон зайд багахан орон зайг эзлэдэг. Үүнтэй адилаар бурханлаг тэнгэрт орших тоо томшгүй гариг бүр нь хэдийгээр урт өргөнөөрөө хил хязгаар үгүй боловч брахмажйоти гэж нэрлэгддэг бурханлаг тэнгэрт багахан орон зайг эзэлнэ. *Брахмā-самхитад* энэхүү *брахмажйотиг ницкалам анатам ашеца-бхүтам* буюу хуваагдашгүй, хязгааргүй, байгалийн материаллаг *гуңуудын* ул мөр ч үгүй хэмээн өгүүлсэн байдаг. Ваикунтхийн бүх гаригууд нь бадамлянхуа цэцгийн дэлбээтэй адил ба энэ лянхуан үндсэн хэсэг нь бүхий л Ваикунтхийн төв болсон Голока Врндāван гэж нэрлэгддэг. Тийнхүү энд өгүүлсэнчлэн олон янзын дүр хэлбэрт Кршṇагийн илрэл задралын тухай болон Түүний бурханлаг тэнгэр дэхь бурханлаг гаригууд дээрхи янз бүрийн өлгий нутгуудад нь төгсгөл үгүй байдаг тухай өгүүлжээ. Тэр ч бүү хэл Брахмā, Шива гэх мэт сахиулсан тэнгэрүүд ч Ваикунтхийн гаригуудын хэмжээг үзэж чадахгүй, бүр үнэлж цэгнэж ч чадахгүй. Үүнийг *Шрīмад-Бхāгаватамын* (10.14.21): “Ваикунтхийн бүхий л гаригуудын урт ба өргөнийг хэн ч хэмжиж чадахгүй” хэмээн баталсан байна. Тэнд мөн Брахмā, Шива гэх мэтийн сахиулсан тэнгэрүүд ч үүнийг хийж чадахгүй, бүр Бурханы гоц чанаруудын нэг хүч чадлын биелэл болсон Ананта ч Бурханы эрч хүчний хил хязгаар болон Ваикунтхийн янз бүрийн гаригсын талбай хэмжээг тодорхой тайлбарлан хэлж чадахгүй гэж баталжээ.

Нэн бат ноттой нотолгоо нь *Шрīмад-Бхāгаватамд* (10.14.21) Брахмын өргөсөн мөргөл залбирал юм. Учир нь тэнд Брахмā өгүүлсэн нь:

*ко ветти бхуман бхагаван парамман
йогешваротир бхаватас три-локйам
ква в̄а катхам̄ в̄а кати в̄а кадети
вистарайан кридаси йога-майам*

“Ай миний эрхэм Бурхан минь ээ, ай Бурханы Дээд Бодгаль минь ээ, ай ДээдСүнс минь ээ, ай бүхий л ид шидийн хүчнүүдийн эзэн минь ээ, Та Өөрийн *йогамййā* эрч хүчний тусламжтайгаар илрэн тодордог Таны илрэл задралыг хэн ч тайлбарлаж, таньж чадахгүй билээ. Эдгээр илрэл задралууд нь гурван тивээр түгэн тархмуй”.
Брахмā мөн өөрийн мөргөлдөө цааш өгүүлсэн нь:

*гуна̄тманас те пи гуна̄н виматӯм
хита̄ватирна̄сйа ка йшире сйа
калена йаур в̄а вимита̄х сукалтаур
бхӯ-п̄амсавах кхе михика̄ дйубх̄асах
(Бхāг 10.14.7)*

“Эрдэмтэй мэргэн, боловсролтой хүмүүс нь нэг гаригийн атомлаг бүтцийг ч үнэлж цэгнэж чаддаггүй. Тэр ч бүү хэл хэрэв тэд тэнгэр дэхь цасны молекул, сансар огторгуй дахь оддыг тоолж чаддаг байлаа ч тэд Та хэрхэн энэ Дэлхий дээр залран бууж ирдэг, энэ орчлонд хэрхэн яаж Өөрийн тоогүй олон трансцендент эрч хүч, эрчим, шинж чанаруудын хамтаар буун залардгийг шүн хэлэлцэж чадахгүй”.
Бурхан Брахмā Нāрадад, түүнийг өөрийг нь оролцуулаад аугаа мэргэдүүдийн хэн нь ч Дээд Бурханы потенциал эрч хүч, хүч чадлыг үнэлж цэгнэж чадахгүй хэмээн мэдэгдэв. Тэрээр тэр ч байтугай хэрэв Ананта Өөрийн мянган хэлээр Бурханы эрч хүчнийг үнэлж цэгнэхийг оролдсон ч Тэрээр амжилтанд хүрч чадахгүй хэмээн хүлээн зөвшөөрсөн. Ийм учраас Биелсэн Ведүүд залбирсан нь:

*дйупатайа эва те на йайур антам анантатайй
твам апи йад антаранда-ничайй нану с̄авара̄нāх
кха ива ражй̄мси в̄анти вайас̄а саха йач чхрутайас
твайи хи пхалантий атаннирасанена бхаван-нидханāх
(Бхāг 10.87.41)*

“Бурхан минь ээ, Та хязгаар үгүй. Хэн ч Таны эрч хүчний хил хязгаарыг тогтоогоогүй. Тэр ч байтугай Та ч Өөрийн потенциал эрч хүчний хил хязгаарыг үл мэднэм билээ. Атомын адил тоо томшгүй олон том том гаригууд тэнгэрт хөвдөг ба

Таныг эрж хайх эрэлд автсан ведантистууд бүх зүйл Танаас ялгаатай гэдгийг олж мэднэ. Тийнхүү тэд эцсийн дүндээ Та бол бүх зүйл юм хэмээх дүгнэлтэнд хүрнэ”.

Бурхан Крш᳚аг энэ орчлонд байх цагт Врндāван дахь малчин жаал хүү үнэхээр Крш᳚а Өөрөө гэдгийг батлахын тулд Брахмā Түүгээр тоглоом шоглоом хийжээ. Өөрийн ид шидийн хүчээ гаргаж Брахмā бүхий л үхэр, тугал, Крш᳚агийн найз малчин жаалуудыг хулгайлаад тэднийг нууж орхисон байна. Гэвч харин тэрээр Крш᳚а ганцаараа юу хийж байгааг харахаар эргэж ирээд хартал Крш᳚а урьдын адил нөгөө л үнээд, тугалууд, малчин жаалуудтайгаа тоглож байв. Өөрөөр хэлбэл Өөрийн Ваикун᳚тхийн эрч хүчний туслалцаатайгаар Бурхан Крш᳚а Өөрийгөө хувилан тархааж, хулгайлагдсан үнээд, тугалууд, найзууд болон хувирсан. Үнэхээр ч Брахмā сая сая, тэр бум тэр бум үнээд хийгээд малчдыг харсан ба мөн сая сая тэр бум тэр бум чихрийн нишингэ, жимснүүд, бадамлянхуа цэцэг, малчны урам зэргийг харав. Малчин жаалууд янз янзын хувцас хунар, чимэглэлтэй байсан бөгөөд хэн ч тэд хэд хичнээн байсныг тоолж чадамгүй байлаа. Дараа нь Брахмā эдгээр малчин жаалууд бүр брахмāнда бүрийг ноёлож байдаг дөрвөн мутарт Нарāйа᳚а болохыг харав. Мөн тоо томшгүй олон Брахмууд Бурханы өмнө хүндэтгэн залбирч буйг ч харав. Тэрээр энэ бүхэн цөм Крш᳚агийн биеэс үүсэн гараад хормын зуурт буцаад Түүний биед нэвтрэн орж байлаа. Брахмā Бурхан гайхсандаа болж хөшин зогссон бөгөөд өөрийн залбиралдаа, дурын ямар ч хүн Крш᳚аг мэддэг гэж хэлж болох ч харин түүний хувьд буюу Брахмын хувьд Түүний тухай юу ч мэддэггүй болохоо хүлээн зөвшөөрсөн байна. “Миний эрхэм Бурхан минь ээ”- хэмээн тэрээр өгүүлээд, - Таны одоо үзүүлж буй хүч чадал, эд баялаг миний ухаанд нэг л багтаж өгөхгүй байна” гэжээ.

Цааш нь Бурхан Чаитанйа Крш᳚алокрын эрчмийг үнэлж цэгнэх боломжгүй ба тэр ч байтугай энэ гариг дээрхи Бурхан Крш᳚агийн өлгий нутаг Врндāваныг ч үнэлж цэгнэж чадахгүй. Нэг талаас Врндāван нь гучин хоёр квадрат миль нутаг дэвсгэрийг эзэлдэг ба Врндāваны энэхэн өчүүхэн хэсэгт бүхий л Ваикун᳚тхийн гаригс оршдог. Орчин үеийн Врндāваны газар нутаг нь арван хоёр ойгоос тогтдог ба наян дөрвөн кроша буюу 168 квадрат миль газар үргэлжилдэг. Тэдгээрээс Врндāван хот нь арван зургаан кроша буюу гучин хоёр милийг нь эзэлдэг. Материаллаг тооцооллын туслалцаатайгаар хэрхэн яаж бүх Ваикун᳚тх энд багтан оршдогийг ойлгох боломжгүй. Ийм учраас Чаитанйа Махāпрабху, Крш᳚агийн эрчим ба эд баялагийг хязгааргүй хэмээн нэрлэсэн. Түүний Санāтана Госвāmид өгүүлсэн бүхэн өчүүхэн хэсэг ба гэвч тиймэрхүү өчүүхэн хэсэгчилсэн төсөөллөөр бүрэн бүтнийг төсөөлөхийг оролдож болно.

Бурхан Чаитанйа Санāтана Госвāmид Крш᳚агийн эд баялагийн талаар өгүүлж байх зууртаа Тэрээр гүн гүнзгий онгод хөөрөлд орсон. Энэ трансцендент төлөвтөө

Тэрээр *Шрїмад-Бхāгаватамд* (3.2.21) Кршᅇаг буцан одсоны дараагаар Уддхава Видурад өгүүлсэн хэсгийн шүлгээс уншсан:

свайам̄ тв асāмйāтишайас трийадхйшах

сварāжйа-лакшмйāпта-самаста-кāмах

балим̄ харадбхиш чира-локапāлаих

кирйта-котйедута-пāдапйтхх

“Кршᅇа нь Брахмā, Шива Бурхан болон энэ орчлон дахь Вишᅇугийн илрэл задралуудыг оролцуулаад бүх сахилусан тэнгэрүүдийн эзэн захирагч нь юм. Ийм учраас Түүнтэй адил тэнцүү хийгээд Түүнийг давж гарах нь үгүй. Тэрээр зургаан гоц чанараар дүүрэн бөгөөд орчлон(*брахмāнда*) бүрийг удирдах үйлэнд автан байдаг бүх сахиулсан тэнгэрүүд Түүний өмнө хүндэтгэлтэйгээр мөргөн залбирч байдаг. Үнэхээр тэдний толгой дээрхи дуулга нь үзэсгэлэнтэй сайхан ба учир нь тэдгээр нь Дээд Бурханы бадамлянхуан өлмийн ул мөрөөр чимэглэгдсэн байдаг”. Үүнтэй адил нотолгоо *Брахмā-самхита* (5.1)-д өгүүлснээр, Кршᅇа нь Бурханы Дээд Бодгаль ба Түүнтэй эн тэнцүү хийгээд Түүнийг даван гарах хэн ч үгүй хэмээн өгүүлсэн байдаг. Хэдийгээр Брахмā, Шива, Вишᅇу нар орчлон бүрийн удирдан залуурдагч нар гэлээ ч тэд Дээд Бурхан Кршᅇагийн албат зарц нар юм. Эцэст гарах дүгнэлт ийм. Шалтгаан болгоны шалтнаан болсон Бурхан Кршᅇа нь энэ материаллаг бүтээлийн эзэн, анхдагч хувилгаан Махā- Вишᅇугийн шалтгаан нь юм. Махā- Вишᅇу нь Гарбходакашāйй Вишᅇу, Кᅇйродакашāйй Вишᅇу нарт эх үүслийг нь өгдөг. Тийнхүү Кршᅇа нь Гарбходакашāйй Вишᅇу, Кᅇйродакашāйй Вишᅇу нарын эзэн нь болж байна. Тэрээр орчлон дотор орших амьд оршнол бүрийн дотор оршдог. *Брахмā-самхита* (5.48)-д, Махā- Вишᅇугийн амьсгал нь тоо томшгүй олон орчлонгуудыг бий болгодог гэжээ. Орчлон бүрт тоолшгүй олон Вишᅇу-таттва байдаг ч тэд бүгдээрээ ердөө л Кршᅇагийн хэсэгчилсэн өргөн дэлгэр илрэл гэдгийг ойлгох нь чухал.

Бурханыг танихуй судар бичгүүдээс Кршᅇа нь гурван трансцендент газарт амьдардаг гэжээ. Кршᅇагийн орших хамгийн нандин газар орон нь Голока Врндāван юм. Чухамхүү тэнд Тэрээр Өөрийн эцэг, эх, найз нөхөдтэйгөө хамт амьдарч Өөрийн трансцендент харилцаагаа илрүүлэн тодруулдаг ба Түүний мөнхийн тойрон хүрээлэлд орсон бүхэнд адис ерөөлөө хайрладаг. Тэнд *йогамйā* нь *рāса-лйла* бүжигт үйлчлэгчийн дүрд тоглож байв. Вражабхūмийн оршин суугчид: “Бурханыг Түүний трансцендент өршөөл, хайрын хэсгүүд алдаршуулдаг ба бид Врндāваны оршин суугчид өчүүхэн ч түгшүүр амсдаггүй. Учир нь Тэрээр өршөөнгүйгээр оршин байдаг” хэмээн боддог. *Брахмā-самхита* (5.43)-д

өгүүлсэнчлэн, бурханлаг тэнгэр дэхь Ваикунтхгийн бүх гаригууд(Вишнулока гэж нэрлэгддэг) Кршңалока буюу Голока Врндāван нэртэй гаригт оршдог. Энэхүү дээд гариг дээр Бурхан олон дүр хэлбэрүүдэд трансцендент цэнгэл жаргалаар цэнгэн байна. Ваикунтхгийн бүх баялагууд нь энэ ганц гариг дээр бүрэн дүүрнээр илрэн байдаг. Кршңагийн тойрон хүрээллүүд мөн зургаан гоц чанараар дүүрэн. *Падмоттара-кханда*(225.57)-д баталснаар, материаллаг ба бурханлаг эрч хүчнүүд нь Виразā гэж нэрлэгдсэн голын усаар тусгаарлагддаг. Энэ гол нь анхдагч пуруща-хувилгааны хөлсөөр тэжээгдэж байдаг. Виразā голын нэг эрэг дээр бурханлаг тэнгэр гэж нэрлэгддэг хязгааргүй, цэнгэлээр дүүрэн, мөнхийн байгаль оршин байдаг ба энэ нь бурханлаг хаант улс буюу Бурханы эзэнт улс юм. Бурханлаг гаригуудыг Ваикунтхууд гэж нэрлэдэг. Учир нь тэнд харамсал, гашуудал, айдас хүйдэс үгүй. Тэнд бүх зүйл мөнх. Тооцооллоор бурханлаг ертөнцөд Дээд Бурханы эрчмийн дөрөвний гурав оногддог ба харин материаллаг ертөнцийн хувьд тэрээр Түүний эрч хүчний дөрөвний нэг хэсгийг эзэлдэг гэж ярьдаг. Гэвч хэн ч дөрөвний гурав гэдэг нь чуха юу болохыг хэн ч ойлгож чадахгүй. Учир нь тэр ч байтугай дөрөвний нэг хэсгийг эзэлдэг энэ материаллаг орчлонг ч дүрслэн өгүүлэх боломжгүй. Кршңагийн эрч хүчний энэхүү дөрөвний нэг хэсгийн тухай Санātана Госвāmид тайлбарлахыг оролдон Чаитанйа Махāпрабху Шрймад-Бхāгаватамд өгүүлэгдсэн нэгэн тохиолдлыг ярив. Нэгэн удаа энэ орчлонгийн эзэн Брахмā Двāракад заларч байсан Кршңа тийш зорин ирсэн. Брахмāг Кршңагийн ордон тийш ойртон ирэх үед хаалгач нь Кршңад Түүн рүү Брахмā ирж тухай мэдээлэв. Харин Кршңа чухам ямар Брахмā ирээд буйг сонирхон лавлав. Хаалгач буцан Брахмā дээр ирж асуусан нь: “Чи чухам ямар Брахмā нь вэ? гэж Кршңа асууж байна” гэв.

Брахмā туйлын их гайхав. Яагаад Кршңа ингэж асуух болов? Тэрээр хаалгачд хэлсэн нь: “Дөрвөн Кумāрын эцэг, дөрвөн тэргүүнт Брахмā ирээд буйг Кршңад дамжуул” гэлээ.

Хаалгач ч энэ тухай Кршңад мэдээлсэн ба дараа нь Брахмāг дотогш орохыг хүсэв. Брахмā ч Кршңагийн бадамлянхуан өлмийд сунан мөргөж Кршңа ч түүнд бүхий л бололцоот хүндэтгэлийг үзүүлээд ирсэн зорилгынх нь тухай лавлалаа.

“Би яах гэж наашаа ирсэн тухайгаа Танд дуулгая,- хэмээн Түүнд Брахмā хариулаад, - гэвч би нэг зүйлийг асууж эргэлзээ тээнэглзээгээ арилгамаар байна. Танай хаалгач надад, Та түүнээс чухам ямар Брахмā Тантай уулзахаар ирсэн тухай асуусан гэсэн. Тэгэхээр надаас өөр бусад ямар нэг Брахмууд байдаг юм уу гэж би асууж болох уу?”.

Үүнийг сонсоод Кршңа инээмсэглэж, үй олон орчлонгуудаас олон тооны Брахмуудыг дуудав. Дөрвөн тэргүүнт Брахмā, Кршңад бишрэл хүндэтгэлээ

илэрхийлэхээр ирсэн өөр бусад олон тооны Брахмуудыг харлаа. Тэдний зарим нь арван тэргүүнтэй, зарим нь хорь, зарим нь зуу, зарим нь бүр сая тэргүүнтэй ч байлаа. Түүнээс гадна Брахма чухам хичнээн Брахма Кршнад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхээр ирснийг тоолж чадахгүй байв. Дараа нь Кршна янз бүрийн орчлонгуудаас олон тооны сахиулсан тэнгэрүүдийг дуудан ирүүлсэн ба тэд бүгдээрээ Бурхандаа өөрсдийн хүндэтгэлээ илэрхийлэв. Энэхүү гайхалтай үзэгдлийг хараад дөрвөн тэргүүнт Брахма мэгдэн сандрав. Тэрээр өөрийгөө олон тооны заан доторхи шумуулаас дээрдэх юмгүй мэт л саналаа. Төдий хэмжээний сахиулсан тэнгэрүүд Кршнагийн бадамлянхуан өлмийд сөхөрснийг үндэслэн Брахма Кршнагийн хязгааргүй бололцоог хэмжих боломжгүй гэсэн дүгнэлтэнд хүрэв. Энэ цуглаан дээрхи янз бүрийн тэнгэрүүд болон Брахмуудын дуулга нь хурцаар гэрэлтэн байсан ба сахиулсан тэнгэрүүдийн өргөж буй мөргөл залбирал нь асар их чимээ шуугианыг дэгдээж байлаа.

“Эрхэм хүндэт Эзэн минь ээ, - гэж сахиулсан тэнгэрүүд өгүүлээд, -Та биднийг нааш дуудаж аугаа их өршөөл нигүүлслийг бидэнд хайрлалаа. Танд ямар нэг онцгой тушаал захирамж бий юм уу? Тийм бол бид түүнийг тань тэр даруй биелүүлэх болно” гэв.

“Үгүй. Надад та нараас хүсэх онцгой зүйл үгүй, - гэж Кршна хариулаад, - Би зүгээр л тан нарыг нэгэн дор харахыг хүссэн юм. Би та бүгдийг адислая. Чөтгөр шулмуудаас бүү айтугай” гэв.

“Таны өршөөлөөр бидний бүх зүйл хэвийн байна” гэж нэгэн дуугаар хариуллаа. “Одоо биднийг хэн ч түгшээхгүй. Учир нь Та энд заларсан бөгөөд бүх таагүй болгоныг ялан дийлэх билээ” гэгцгээв.

Тийнхүү бүх Брахмууд Кршнаг харсан ба бүгд л Тэрээр Түүний орчлонд оршин байна хэмээн бодоцгоожээ. Энэ үйл явдлын дараагаар Кршна бүх Брахмуудыг Түүнтэй салах ёс гүйцэтгэхийг хүсэв. Тэд дахин Түүнд хүндэтгэн мөргөөд өөр өөрсдийн орчлон руу буцав. Энэ бүгдийг харсан дөрвөн тэргүүнт Брахма тэр даруй Кршнагийн өлмийд сөгдөн унаад өгүүлсэн нь: “Миний урьд өмнө бодож байсан бүхэн туйлын тэнэг зүйл байжээ. Бүгд л Таныг төгс мэднэ гэж ярьж болох ч миний хувьд би Та ямархан аугаа болохыг төсөөлөх төсөөллөөс хэдий хир болохыг хэлж мэдэхгүй байна. Та миний бодож төсөөлж чадахаас даван гарах билээ” хэмээв.

“Энэ орчлонгийн урт нь ердөө дөрвөн тэрбум миль” гэж үүний дараагаар Кршна түүнд өгүүлээд “гэвч үүнээс хамаагүй том сая сая, тэр бум тэрбум орчлонгууд бий билээ. Тэдний зарим нь хэдэн триллион миль үргэлжилдэг. Иймд тэдгээрт ердөө дөрвөн тэргүүнт бус хүчтэй Брахмууд шаардагддаг” гэв. Цааш нь Кршна Брахмад: “Энэ материаллаг бүтээл нь Миний бүтээлч эрчмийн ердөө дөрөвний нэг илрэл билээ. Миний бүтээлийн эрчмийн дөрөвний гурав нь бурханлаг хаант улсад оршдог” гэж мэдээлэв. Хүндэтгэлтэйгээр мөргөн залбирч дөрвөн тэргүүнт Брахма Кршнатай салах ёс гүйцэтгэсэн ба тэрээр Бурханы эрчмийн “дөрөвний гурван хувь” гэж юу болохыг ойлгов. Тийм учраас Бурханы нэрүүдийн нэг нь Трийадшвара юм. Энэ нэр нь Түүний гурван гол өлгий нутаг болох: Гокула,

Матхура, Двāракаг зааж байгаа хэрэг. Энэ гурван өлгий нутаг нь бүхий л төрлийн эд баялагаар элбэг баян ба Бурхан Кршңа энэ бүхий л трансцендент эрчмийн эзэн нь юм. Өөрийн трансцендент эрчимдээ оршин байхдаа Бурхан Кршңа бүхий л трансцендент эрч хүчнүүдийн эзэн нь байдаг. Тэрээр зургаан гоц шинж чанартай. Тэрээр бүхий л эд баялагийн эзэн учраас бүх ведийн бүтээлүүд Кршңаг Бурханы Дээд Бодгаль хэмээн магтан алдаршуулдаг.

Дараа нь Бурхан Чаитанйа Кршңагийн эд баялагийн тухай гайхамшигтай дуу дуулсан бөгөөд Санāтана Госвāmй Түүнийг сонсов. “Кршңагийн бүхий л тоглоом наадмууд нь хүмүүсийн үйлдэж буйтай яг адил”-, хэмээн Эзэн Бурхан дуулж байлаа. “Ийм учраас Өөрийн хэлбэр дүрээрээ хүнтэй эгээ адилхан гэдгийг ойлгох хэрэгтэй. Чухамдаа хүн Түүний дүр хэлбэрийг дууриаснааи илүү юмгүй. Кршңа яг л малчин жаалху шиг хувцасласан бөгөөд Тэрээр идэр залуу мэт харагдана. Тэр үргэлжийн хөгжилтэй, наргианч ба жирийн нэг жаал шиг тоглон наадна”. Дараа нь Бурхан Чаитанйа Санāтана Госвāmйд Кршңагийн гоо үзэсгэлэн хэрхэн илэрдэг талаар өгүүлэв. Хэн бээр Кршңагийн энэхүү гоо үзэсгэлэнг танин ойлгож чадна вэ тэрээр бал мэт рашааны далайд цэнгэн жаргана гэж тэр хэлсэн. *Йогамййā* гэж нэрлэгдэх Кршңагийн эрчим нь трансцендент ба материаллаг эрч хүчтэй хүрэлцдэггүй ч Бурхан Өөрийн трансцендент эрчмийг энэ материаллаг ертөнцөд ч илрүүлэн тодруулдаг. Үүнийг зөвхөн Өөрийн ойр дотнын чин бишрэлтэнгүүдийн таалалд нийцүүлэхийн тулд л хийдэг. Ийм учраас Тэрээр Өөрийн чин бишрэлтэнгүүдээ баясал тааламж авчрахын тулд л энэ материаллаг ертөнцөд илрэн залардаг ба Түүний чанар нэн дур татам бөгөөд тэр ч байтугай Кршңа Өөрөө ч Өөрийгөө танин ойлгохыг шунан хүсч байдаг. Тэрээр Өөрийн биеэ гурван газарт нугалаад Өөрийн чамин тансаг зогсолтоор зогсох бөгөөд хөмсөг нь байнга хөдлөнө. Нүд нь дур сэтгэл татам ба Түүнийг ширтэн харсан бүх *гонй* нар гөлрөн зогсох ажээ. Түүний бурханлаг өлгий нутаг бурханлаг тэнгэрийн оргилд орших бөгөөд Тэрээр тэнд Өөрийн дагуулууд, малчин-жаалууд, *гонй* нар, бүх цэцэглэн мандахын дарь эх нартай хамт амьдран суудаг. Чухамхүү тэнд л Түүнийг Мадана-мохона гэж нэрлэдэг билээ.

Васудевын, Саңкарцаңы дүр хэлбэр дэхь Кршңагийн олон янзын тоглоом наадмууд бий ба материаллаг тэнгэрт Түүний тоглоом наадмуудыг анхдагч *пуруща-хувилгаан* буюу энэ материаллаг ертөнцийн бүтээгч үргэлжлүүлдэг. Мөн Тэрээр загас болон яст мэлхийн дүрд хувирч асан тоглоом наадмууд бий. Мөн материаллаг шинж чанаруудын хувилал болсон Бурхан Брахмын болон Шива Бурханы дүр хэлбэрийг авч байсан тоглоом наадмууд бий. Онцгой төлөөлөл хайрлагдсан хувилгаанууд оролцсон тоглоом наадмууддаа Тэрээр Пртху хааны дүрийг авч байсан. Түүнээс гадна Тэрээр бүгдийн зрхэнд орших ДээдСүнс хэлбэрээр тоглоом наадмуудаа өрнүүлдэг. Мөн бодгаль бус Брахман хэлбэрээр ч. Түүний тоглоом наадмууд тоо томшгүй ч тэднээс Кршңагийн хүний дүрд хувирч

Врндāванд дэггүйтэн сахилгагүйтэж, гопī нартай бүжиглэж байсан, Курукшетрын тулааны талбарт Пāндавуудтай тоглож байсан, Матхурт, Двāракт тоглож байсан зэрэг тоглоом наадмууд хамгийн чухал нь юм. Хүний дүрд хувирсан Түүний энэ чухал тоглоом наадмуудаас нэн чухал нь Тэрээр лимбэн дээр тоглогч малчин жаалхүүгийн дүрд тоглож буй тоглоом нь юм. Голока, Матхур, Двāракт өрнүүлж байсан Түүний тоглоом наадмуудын хэсэгхэн илрэл нь л бүх орчлонг Бурханыг хайрлах хайраар бялхуулж чадна. Кршңагийн гайхамшигт чанарууд нь ямар ч амьд оршнолыг соронздон татаж чадна.

Түүний дотоод эрчим нь Бурханы хаант улс буюу Ваикунтхийн гаригууд дээр ч илэрдэггүй хэдий ч Тэрээр Өөрийн ойлгогдошгүй өршөөлөөр Өөрийн өлгий нутгаас буун заларч ирэхүйд Тэрээр түүнийг энэ орчлон дээр илрүүлэн тодруулдаг. Кршңа нь маш гайхамшигтай, үзэсгэлэнтэй ба Тэрээр тэр ч байтугай Өөрөө Өөрийнхөө гоо үзэсгэлэнд татагддаг ба энэ нь Тэрээр ойлгогдошгүй боломжуудаар дүүрэн болохыг баталж байгаа хэрэг билээ. Кршңагийн гоёл чимэглэлийн тухайд тэднийг хэрэв Түүний биенээс авлаа ч тэдгээр нь Түүнийг тэгтлээ сайхан болгож байгаагүй мэт санагддаг. Иймээс харин гоёл чимэглэл нь Түүний биенд байснаар тэднийг улам гоё харагдуулдаг. Тэрээр биеэ гурван газарт нугалан зогсож байхуйд Түүнд сахиулсан тэнгэрүүдийг оролцуулаад бүх амьд оршнолууд татагддаг. Үнэндээ бол Тэрээр бүр Ваикунтхийн бүх гаригуудыг захиран байдаг Нāрāйаңа хувилгаануудыг ч соронздон татдаг билээ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Кршңагийн гоо үзэсгэлэн

Кршңаг Мадана-мохана гэж нэрлэдэг. Учир нь Тэрээр Купидоны ухааныг ч булаадаг. Мөн Тэрээр Вражийн бүсгүйчүүдийн чин бишрэл зүтгэлийг хүлээн авч, тэднийг адислан ерөөдөг учраас Түүнийг Мадана-мохана гэх нь бий. Купидоны бардам занг ялан дийлээд Бурхан шинэ Купидон мэтээр *рāса-бүжгээр* бүжиглэн наадсан. Тэрээр эмэгтэй хүний ухааныг Өөрийн таван сум болох дүр хэлбэр, амт, үнэр, дуу авиа, хүрэлт шүргэлтүүдийн тусламжтайгаар ялан дийлж чаддаг учраас мөн Мадана-мохана нэрээр алдаршсан. Түүний хүзүүндээ зүүсэн сувдан зүүлтүүд нь **хөтөвч мэт** цасан цагаан, Түүний тэргүүнийг чимсэн тогосын өд нь солонго мэт өнгө алаглан туяарна. Түүний шаргал өнгийн хувцас нь тэнгэрт цахилах цахилгаан мэт агаад, Кршңа Өөрөө хуралдсан үүл мэт. *Гопī* нар Түүний хөл дэхь хонх мэт ба үр тариа найгасан талбай дээр үүл хур бороо асгах нь Кршңа *гопī* нарын зүрхэнд хоол хүнсийг хайрлаж Өөрийн тоглоом наадмын өршөөлөөр тэдний дээрээс бороо асгаруулан буй мэт санагдана. Үнэн хэрэгтээ нугаснууд борооны улирлын цагаар тэнгэрт нисч байдаг ба мөн энэ үед тэнгэрт солонгыг харж болно. Кршңа

Врндāваны малчин, Өөрийн найз нарын дунд тайванхан алхаж байдаг ба Тэрээр Өөрийн лимбэн дээр тоглох үед бүхий л хөдлөгч ба үлд хөдлөгч амьд оршнолууд онгод хөөрлөөр дүүрэн бялхана. Тэд чичрэн дагжиж, нүднээс нь нулимс асгарна. Кршңагийн янз бүрийн гоц чанаруудаас дээд зэргийнх нь Түүний амраг сэтгэлийн хайр юм. Тэрээр бүхий л эд баялаг, бүхий л хүч чадал, бүхий л алдар нэр, бүхий л гоо сайхан, бүхий л эрдэм мэдлэг, бүхий л огоорлын эзэн ба энэ бүгдээс Түүний гоо сайхны төгс төгөлдөр байдал нь амрагийн хайрын дур татам байдал юм. Кршңагийн дүр хэлбэр, хайр сэтгэлийн гоо үзэсгэлэн, зөвхөн ганцхан Түүнд л мөнхөд оршдог. Харин бусад бүх зүйл Түүний эд баялаг нь мөн Түүний Нārāяна хэлбэрт ч оршин байдаг.

Бурхан Чаитанйа Кршңагийн амрагийн дур татам байдлын дээд давуу чанарыг өгүүлэхүйд Тэрээр трансцендент онгод хөөрлийг мэдэрч, Санātана Госвāmийгийн гарыг зууран барьж, *Шрїмад-Бхāгаватамын* (10.44.14) шүлгээс иш татан Вражийн бүсгүйчүүдийн аз хийморийг магтан дуулж эхэлсэн:

*гопйас тапах ким ачаран йад амуцйя рўпам
лāванйя-сāрам асамордхвам ананйя-сиддхам
дргбхих пибанти анусавāбхинавам дурāпам
экāнта-дхāма йашасах шрийя ашшварасйа*

“Хэрэв одоо тэд биеийн цацраг туяа нь бүхий л гоо үзэсгэлэнгийн үндэс болсон хийгээд бүхий л гоо үзэсгэлэн, бүхий л эд баялаг, бүхий л алдар гавъяанаас тогтох Кршңагийн рашааныг ууж чадаж буй тул Врндāваны бүсгүйчүүд ямархан аугаа тэвчил, наминчлалыг үйлдсэн юм бол”.

Гоо үзэсгэлэнгийн давалгаанд ганхах мөнхийн залуу гоо сайхны далай Кршңагийн биеийг харж болно. Түүний лимбэний дуу авиан доторр хуй салхины дуун сонсогдном. Энэхүү давалгаад, энэ хуй салхи нь гопй нарын зүрхийг модны хатсан навч чичрүүлэн хийсгэх ба энэхүү навчис Кршңагийн бадамлянхуа өлмий дор унахад тэд дахин босох тэнхэл үгүй болсон байдаг. Кршңагийн гоо үзэсгэлэнтэй зүйрлүүлж болох гоо үзэсгэлэн гэж үгүй билээ. Учир нь хэн ч Түүнийг даван гарах, Түүнтэй эн тэнцэх гоо үзэсгэлэн үгүй юм. Тэрээр Нārāяны хэлбэрийг оруулаад бүхий л хувилгаадын эх үндэс учраас Нārāянагаас хэзээ ч салдаггүй цэцэглэн мандахын дарь эх Нārāянагийн дэргэдээс хөндийрч Кршңатай харьцах боломж олж авахын тулд тэвчил үйлдэж эхэлдэг. Энэ бол дуусаж дундаршгүй гоо үзэсгэлэнгийн уурхай болсон Кршңагийн юутай ч зүйрлүүлэшгүй үзэсгэлэн гоогийн аугаа байдал юм. Чухам энэ гоо үзэсгэлэнгээс бүхий л гайхамшигтай сайхан бүхэн эхлэлээ авдаг.

Гони нарын эзэлж буй байр суурь нь мөч тутамд Кршңагийн гоо үзэсгэлэнгийн тусгалыг харж болох тольтой адил юм. Агшин тутамд Кршңа ба *гони* нар өөрсдийн трансцендент гоо үзэсгэлэнгээ нэмэгдүүлж байдаг ба тэдний хооронд үргэлж трансцендент тэмцэлдээн өрнөж байдаг. Хэн ч өөрт оногдсон үүрэг хариуцлагыг сайн дураараа хийж гүйцэтгэхийн тусламжтайгаар, тэвчил наминчлалаар, ид шидийн йогийн тусламжтайгаар, мэдлэгээ бататган хөгжүүлснээр, залбирал мөргөлөөр Кршңагийн гоо үзэсгэлэнг хангалттайгаар үнэлж цэгнэж чадахгүй. Харин зөвхөн Бурханыг хайрлах хайрын трансцендент түвшинд оршигч болон хайраар чин бишрэлээр үйлчлэн зүтгэгсэд Кршңагийн гоо үзэсгэлэнг жинхэнэ ёсоор үнэлж чадна. Энэ гоо үзэсгэлэн нь бүхий л гоц чанаруудын охь ба түүнийг зөвхөн Голока Врндāван дээр ойлгож чадах ба өөр хаана ч биш. Нārāйаңы дүр хэлбэртээ Кршңа өршөөл адислалын, алдар хүндийн гэх мэтийн гоо сайхнаа шингээсэн хэдий ч Нārāйаңад Кршңагийн зөөлөн сэтгэл, өгөөмөр байдал үгүй. Тэдгээрийг зөвхөн Кршңагаас Өөрөөс нь олж болно.

Бурхан Чаитанйа Санāтанад тайлбарлаж өгсөн шүлэг болгоноос асар их цэнгэл таашаалыг амсаж байсан ба өөр нэгэн шүлгийг иш татсан(Бхāг 9.24.65):

*йасйāнанам макара-кундāла-чāру-карңа-
бхрāжат-капола-субхагам савилāса-хāсам
нитйотсавām на татрпур дршибхих пибантйо
нāрийо нарāш ча мудитāх купитā нимеша ча*

“Ерөнхийдөө *гони* нарын хувьд Кршңагийн гоо үзэсгэлэнгээр цэнгэх нь эцэс төгсгөлгүй жаргалын ёслол байсан. Тэд Кршңагийн үзэсгэлэнт царай, Түүний чихэн дэхь гайхамшигт ээмэг, Түүний өргөн дух, сайхан инээмсэглэл зэргээр цэнгэн жаргаж байсан ба Кршңагийн гоо үзэсгэлэнг харж цэнгэхийн ялдамд тэд ихэвчлэн Кршңагийн дүр төрхийг сормуусны цавчилтаар халхалж байдгаас нь болж бүтээгч Брахмад гомдон гасалж байсан билээ”.

Кāмā-гāйатрй гэж нэрлэгдэх ведийн нэгэн дуулал нь Кршңагийн нүүр царайг бүхий л сарны хаан гэж өгүүлсэн байдаг. Олон янзын сар байдаг гэж зүйрлүүлэн хэлвэл тэд бүгд ганц Кршңад оршдог. Түүний амны, сормуусны сар гэж байна, Түүний бие дэхь зандан модны өтгөрүүлсэн шингэний саран бидэр, Түүний гарын хурууны үзүүрийн сарнууд, хөлийнх нь хурууны үзүүрийн сарнууд байдаг. Тиймэрхүү байдлаар хорин дөрвөн тал саран тоологддог ба Кршңа тэд бүгдийн төв нь юм.

Бүжиглэх үед нь Кршңагийн ээмэг, нүд, хөмсөг Вражийн бүсгүйчүүдийн хувьд нэн дур татам байдаг. Юуны тулд бидэнд хоёр нүд заяасан хэрэг вэ, Кршңагийн

нүүр царайг харахын тулд биш гэж үү? Кршнаг харахад хоёр нүд хангалттай биш болохоор хүн өөрийн бүрэн дүүрэн бус байдлыг мэдэрдэг. Тийнхүү түүнд ямар нэг юм дутуу мэт мэдрэмж төрдөг. Тэрээр бүтээгчийн бүтээх чадварыг муулан буруушааснаар энэ мэдрэмж нь бага зэрэг намждаг. Кршнагийн нигуурыг толидон харж үл чадах хүн нь: “Надад яагаад мянган нүд заяасангүй, хоёрхон нүд заяагаа вэ? Сормуусны байнгын цавчилт байнга надад саад болох юм. Эндээс харахад энэ биеийг маань бүтээгч өндөр оюун ухаанаар ялгарах зүйлгүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Тэрээр онгод хөөрлийн урлагийг тийм ч сайн мэддэггүй нь тодорхой байна. Харин ердийн нэг жирийн бүтээгч ажээ. Хүн зөвхөн Кршнаг л харж чадахаар бүгдийг зохицуулах хэрэгтэйг самуурсан тэр мэдээгүй аж”.

Гопи нарын ухаан Кршнагийн биеийн амтлаг байдлаар цэнгэн жаргахад байнгад автсан байлаа. Тэрээр гоо үзэсгэлэнгийн далай ба Түүний гайхалтай нүүр царай, инээмсэглэл, Түүний биеэс цацрах цацраг туяа зэрэг нь *гопи* нарын ухааныг тэр чигээр нь соронздон татна. *Кршна-карнамртад* Түүний нүүр, инээмсэглэл, Түүний биеийн цацрал туяаг амтлаг, маш их амтлаг бүгдээс амтлаг хэмээн өгүүлсэн байдаг. Кршнагийн төгс төгөлдөр чин бишрэлтэн нь Кршнагийн биеийн цацраг туяа, Түний нигуур, инээмсэглэл зэргийн сайхныг толидон харахад үргэлж автсан байдаг ба тэрээр трансцендент татвалзлын далайд шунган байдаг. Ердийн шөрмөс таталтыг эмч үргэлжил байхыг нь зөвшөөрч өвчнийг хөнгөлөхийн тулд аяга ус уухыг ч зөвшөөрдөггүй шиг Кршнагийн гоо үзэсгэлэнгийн өмнө энэхүү татвалзлууд үргэлжид ямар ч эмчилгээгүй үлддэг.

Чин бишрэлтэн нь Кршнагийн үгүй байхыг улам улам хүчтэй мэдрэх ба учир нь Түүнгүйгээр тэрээр Түүний гоо үзэсгэлэнгийн рашааныг ууж чадахгүй. Кршнагийн лимбэний трансцендент авиаг сонсмогц энэ лимбэний дууг үргэлжлүүлэн сонсохыг маш ихээр хүсдэг. Энэ нь түүнийг материаллаг ертөнцийн бүрхүүлийг нэвтлэн гарч, лимбэний трансцендент дуу *гопи* нарын залгамлагч нарын нэврэн орж буй бурханлаг тэнгэрт оруулна. Кршнагийн лимбэний авиа нь *гопи* нарын чихэнд мөнхөд орших ба тэдний онгод хөөрлийг нэмэгдүүлдэг. Тэд түүнийг сонсмогц өөр ямар ч авиа тэдний чихэнд нэвтэрч орж чаддаггүй ба гэр бүлийнхнийхээ дунд байхдаа энэ гайхамшигт авиа тэдний чихэнд сонсогдсоор байдаг учраас тэдний асуултуудад ч хариу өгч чаддаггүй.

Ийнхүү Бурхан Чаитанья Кршнагийн трансценденталь мөн чанар, Түүний илрэл задралууд, Түүний биеийн цацраг туяа, ер нь Түүнтэй холбоотой бүх зүйлийг тайлбарласан. Товчхон хэлбэл, Бурхан Чаитанья Кршнаг чухам Тэрээр хэн болохыг тайлбарласан юм. Тэрээр түүний тусламжтайгаар Түүнд ойртон дөтлөж болох аргыг мөн тайлбарлан таниулсан. Үүнтэй холбогдуулж Бурхан Чаитанья Кршнад чин бишрэлэр үйлчлэх нь цорын ганц арга ба түүгээр Түүнд ойртож болохыг цохон тэмдэглэсэн. Энэ бол ведийн утга зохиолын дүгнэлт. Мэргэдүүд: “Хэрэв хэн нэг нь ведийн утга зохиолд өөрийн асуултууддаа хариултыг хайн хандвал трансцендент ухамсарлалын ямар арга буюу эсвэл хэрэв *Пурянуудыг* судлавал/түүхэн бичээс гэж

тооцдог/ тэрээр тэд бүгд Бурханы Дээд Бодгаль, Кршңа нь мөргөлийн цорын ганц объект гэдэг дүгнэлтэнд хүрдэг” хэмээн магтан дуулдаг.

Кршңа нь Туйлын Үнэн, Бурханы Дээд Бодгаль бөгөөд Тэрээр *сварүпа-шакти* буюу *ātma-шакти* гэж нэршиж, *Бхагавад-гītā*д өгүүлэгдсэн Өөрийн дотоод эрчимд оршин байдаг. Тэр Өөрийгөө янз бүрийн дүрүүдээр тархаан түгээх ба тэдний зарим нь Түүний бодгаль дүрүүд ба зарим нь тусгаар дүрүүд юм. Тийнхүү Тэрээр бүхий л бурханлаг гаригууд ба материаллаг орчлонгууд дээр Өөрөө цэнгэн жаргадаг. Түүний тусгаар хэлбэрүүдийн илрэлийг амьд оршнолууд гэх ба эдгээр амьд оршнолууд нь Бурханы эрч хүчтэй нийцэн ангилагддаг. Тэднийг мөнхийн ангижирсан, мөнхийн болзолдсон гэж хоёр ангид хуваагдана. Мөнхийн ангижирсан амьд оршнолууд нь хэзээ ч материаллаг байгальтай хүрэлцдэггүй ба иймээс тэдэнд материаллаг амьдралын ямар ч туршлага байдаггүй. Тэд мөнхөд Кршңагийн ухамсарт буюу Бурханд чин бишрэлээр үйлчлэн зүтгэхүйд автан байдаг ба тэд Кршңагийн дагуулуудын тоонд багтдаг. Тэдэнд баясал таашаал авчрах цорын ганц зүйл, тэдний амьдралын цорын ганц цэнгэл жаргал нь Кршңад трансцендент хайраар үйлчлэн зүтгэх юм. Нөгөө талаас мөнхийн болзолдсон сүнснүүд нь Кршңад трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйгээс цаг үргэлж хол хөндий байж, иймээс ч материаллаг оршнолын гурвалсан зовлонгд шаналан байдаг. Болзолт сүнс нь Кршңагаас хол хөндий байр суурийг эзэлдгээс материаллаг эрчмийн илбэ нь түүнийг таван махбодиос тогтох бүдүүн бие, ухаан, оюун ухаан, эго зэргээс тогтох нарийн бие гэсэн биеийн оршихуйн хоёр хэлбэрээр шагнадаг. Энэхүү хоёр биеэр хучигдсан болзолт сүнс нь мөнхөд гурвалсан зовлон гэж нэрлэгдэх материаллаг оршихуйн зовлонг амсдаг. Түүнээс гадна тэрээр зургаан дайсны(шунал тачаал, уур хилэн гэх мэт) нөлөөнд байдаг. Энэ нь болзолт сүнсний зуурдын бус өвчин юм.

Өвчилсөн, болзолт амьд оршнол нь нэг биеэс нөгөө биед шилжин бүх орчлонгоор хэрэн хэсүүчилдэг. Заримдаа тэд дээд гаригийн системд, заримдаа доод гаригийн системд төрдөг. Тийнхүү түүний болзолт амьдрал урсан өнгөрнө. Тэрээр хэрэв туршлагатай эмч буюу жинхэнэ номын багштай учирч, түүний сургаалыг дагавал өөрийн өвчнөө эмчилж чадна.

Болзолт сүнс нь жинхэнэ номын багшийн бүх сургаалыг нарийвчлан дагавал түүний материаллаг өвчин эмчлэгдэх ба тэрээр ангижралын түвшинд хүрч дахин Кршңад чин бишрэлээр үйлчлэн зүтгэхүйд хүрэн, буцаад өөрийн гэр орондоо, Кршңа тийш буцдаг. Болзолт амьд оршнол нь өөрийн жинхэнэ байр суурийн талаар мэдэх ёстой ба Бурханаас: “Хэдий болтол би шунал тачаал, уур хилэн гэх мэт энэ бүх бие махбодийн төлөв чиглэлүүдийн нөлөөнд байсаар байх вэ?” гэж мөргөн залбирдаг. Бүх болзолт сүнсийг эрхшээлдээ оруулж аваад шунал тачаал, уур хилэн нь өршөөл энэрлийг мэддэггүй. Үнэндээ болзолт сүнс нь хэзээ ч эдгээр өрөвдөх сэтгэлгүй эздүүдэд үйлчлэхээ болидоггүй. Гэвч тэр жинхэнэ байр суурь буюу Кршңагийн ухамсрыг олвол тэрээр эдгээр муу муухай эздийг орхиж, Түүнийг өөрийн өмөг түшгээ болгохын тулд цэвэр ариун, нээлттэй зүрхээр Кршңад ханддаг. Энэ үед тэрээр Түүнд трансцендент хайраар үйлчлэн зүтгэхэд автахуйд мөргөн залбирдаг.

Заримдаа ведийн бүтээлүүд нь кармын үйл, өөрийгөө танин ухамсарлахуйн ид шидэт йог, мэдлэгийг цэцэрхийллийн аргаар хайх гэх мэт янз бүрийн зам мөрүүдийг магтан алдаршуулдаг хэдий ч бүхий л бүтээлүүдийн эдгээр магтаалууд нь хамгийн дээд зам мөр нь чин бишрэлийн зам мөр гэдэг дээр санал нэгддэг. Өөрөөр хэлбэл Бурхан Кршнад чин бишрэлээр үйлчлэхүй нь өөрийгөө танин ухамсарлахуйд хөтлөх дээд, хамгийн төгс төгөлдөр зам мөр ба түүгээр шуудхан хичээллэхийг зөвлөжээ. Кармын үйл, ид шидийн бясалгал, гүн ухааны цэцэрхийлэл нь өөрийгөө танин ухамсарлахуйн тойруу аргууд юм. Эдгэр аргууд нь яагаад тойруу вэ гэвэл тэдгээрт чин бишрэлээр үйлчлэн зүтгэл байдаггүй учраас өөрийгөө танин ухамсарлахуйн дээд төгс төгөлдөрт хүргэж чаддаггүй. Үнэн хэрэгтээ өөрийгөө танин ухамсарлахуйн бүх зам мөрүүд эцсийн дүндээ чин бишрэлийн зам мөрөөс л хамаатай байдаг.

